

Манай нутгаар зочлоорой



Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд
зориулсан гарын авлага

Хэрэгжүүлэгч:

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Хамтран хэрэгжүүлэгч:



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАЙ
ГАЗАР



Манай нутгаар зочлоорой

Улаанбаатар хот



Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) нь ХБНГУ-ын засгийн газрын тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь дэмжин ажилладаг.

Нийтэлсэн: Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), ХБНГУ-ын Бонн, Эшборн хотуудад оффистой

Төслийн нэр:

"Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь" (SPACES) төсөл

Төслийн удирдагч: Др. Михаэл Трокенбродт
michael.trockenbrodt@giz.de

GIZ SPACES төсөл:

Найман зовхис барилгын III давхар,
Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар 14251, Монгол улс
Утас: +976 11 312282
+976 70117180
Цахим хаяг: spaces@giz.de
Цахим хуудас: www.giz.de

ХТБХ ТББ:

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 23-р
байр, 3-31 тоот, Улаанбаатар 14251
Утас: +976 9990 1138
+976 9916 5110
Цахим хаяг: nyansanjav@yahoo.com
Цахим хуудас: www.pcc.mn

Зохиогч: Сабин Шмидт, Х.Түмэндэлгэр, Ч.Оюун-Эрдэнэ, Г.Нямсүрэн,
М.Нарангэрэл, С.Болортуяа, Д.Содномсамдан

Хянан тохиолдуулсан: Т.Болдбаатар, Н.Лхамдулам, Я.Нарангэрэл, Б.Сувд

Орчуулагч: Я.Нарангэрэл, Б.Эрдэнэчимэг

Зураач: Б.Төрмөнх

Эх бэлтгэсэн: Г.Лхагвадорж
Адмон принт ХХК-д хэвлэв.

Энэхүү номыг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ны даалгавраар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран хэрэгжүүлж буй "Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь" (SPACES) төслийн дэмжлэгтэйгээр Хүн төвтэй байгаль хамгаалал ТББ боловсруулав.

Энэхүү номын агуулгыг зөвхөн зохиогчид хариуцах бөгөөд GIZ-ийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Захиалагч: ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)

| | |
|---|-----------|
| ГАРЧИГ | 3 |
| Өмнөх үг | 7 |
| Танилцуулга | 8 |
| Товчилсон үг | 10 |
| | |
| ХЭСЭГ 1. БИД ЖУУЛЧДЫГ ЮУГААРАА ТАТДАГ ВЭ? | 11 |
| Нүүдэлчин ахуй жуулчдын зүрх сэтгэлийг огшоодог | 11 |
| Дэлхийн аялал жуулчлалын хандлага ба нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал | 14 |
| Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ) гэж юу вэ? | 16 |
| Олон улс болон дотоодын аялагчдын хүлээлт | 17 |
| Аялал жуулчлалд баримтлах ёс зүйн хэм хэмжээ, нутгийн иргэдийн эрх | 18 |
| Монголын аялал жуулчлалын хөгжилд тулгарч буй бэрхшээл | 20 |
| Монголд аялж буй гадаадын жуулчид | 21 |
| | |
| ХЭСЭГ 2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ, НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ | 22 |
| Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг | 23 |
| Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежмент | 25 |
| Орон нутгийн хамгаалалттай газар | 28 |
| Тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд НИТАЖ хөгжүүлэх боломж | 29 |
| | |
| ХЭСЭГ 3. НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ | 30 |
| Байгаль хамгаалал ба нутгийн иргэд | 30 |
| Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежмент | 31 |
| НИТАЖ нутгийн иргэдийн байгууллага болох нь | 34 |

| | |
|---|-----------|
| ХЭСЭГ 4. НИТАЖ ЭРХЛЭХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙН ҮНЭЛГЭЭ | 38 |
| НИТАЖ-ыг амжилттай эрхлэх өөрсдийн нөөц боломж, саад бэрхшээлээ бодитоор үнэлээрэй! | 38 |
| НИТАЖ эрхлэх боломж, бэрхшээлээ бие даан үнэлж үзэх | 42 |
| ХЭСЭГ 5. НИТАЖ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АЛБАН ЁСООР ЭРХЛЭХ | 45 |
| Байгууллагын хэлбэр: Хуулийн этгээд эсхүл орон нутгийн иргэдийн байгууллага | 46 |
| Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл байгуулах | 50 |
| Бизнес төлөвлөгөө боловсруулах | 53 |
| ХЭСЭГ 6. НИТАЖ-Н БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ХҮРГЭХ НЬ | 54 |
| НИТАЖ-ын зорилтот зах зээл | 56 |
| Орон нутгийн зах зээлээс хэрэглэгчдийг хэрхэн татах вэ? | 56 |
| Дотоодын зах зээл буюу УБ хот, аймгуудын хэрэглэгчдэд хэрхэн хүрэх вэ? | 58 |
| Олон улсын зах зээл буюу гадаадын жуулчдад хүрэх | 60 |
| Танд тохиолдож болзошгүй бэрхшээл ба шийдэл | 62 |
| Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тогтоох | 63 |
| ХЭСЭГ 7. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР | 65 |
| Өөрсдийн нөөц боломжоо дайчлах | 66 |
| Дундын сан | 67 |
| Орон нутгийн хөгжлийн санд хандах | 68 |
| Жижиг дунд үйлдвэрлэлийн санд хандах | 70 |
| Хоршоо | 70 |
| Хандивлагч байгууллага, төсөл хөтөлбөрт хамрагдах | 71 |
| ХЭСЭГ 8. ГАЗАР АШИГЛАХ, ЭЗЭМШИХ ЭРХИЙГ ОЙЛГОЖ МЭДЭХ, ГАЗРЫН ЭРХ БАТАЛГААЖУУЛАХ | 72 |
| Хамгаалалттай газар нутгийн эргэн тойрон | 73 |
| Хамгаалалттай газар нутгийн бүсэд | 74 |

| | |
|---|------------|
| Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах тухай | 74 |
| Хуулийн хэрэгжилт, бэрхшээлүүд | 77 |
| ТХГН-ийн газар ашиглагчийн эрх үүрэг | 78 |
| ХЭСЭГ 9. НИТАЖ ЭРХЛЭХ УР ЧАДВАРАА НЭМЭГДҮҮЛЭХ НЬ | 80 |
| НИТАЖ эрхлэхэд шаардагдах ур чадвар | 80 |
| Сургалтын байгууллагуудын мэдээлэл | 84 |
| ХЭСЭГ 10. НИТАЖ-ЫН БАГАА УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ | 85 |
| Ажлаа үргэлж урьдчилан төлөвлөөрэй | 86 |
| Эрсдэлээ урьдчилан харж зохицуулаарай | 86 |
| Бүх гишүүдийн хурлыг тогтмол хийж заншаарай | 86 |
| ХЭСЭГ 11. НИТАЖ-ЫН ГЭР КЭМПИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА | 90 |
| Гэр кэмп байгуулж, тогтвортой ажиллахад анхаарах ерөнхий зарчмууд | 90 |
| Орчиндоо зохицсон өнгө төрхийг буй болгох | 93 |
| Байгальд зохицсон уламжлалт монгол загвар | 95 |
| Шилдэг үйлчилгээг хэрхэн үзүүлэх вэ? | 96 |
| ХЭСЭГ 12. САНАЛ БОЛГОХ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ | 100 |
| Аялал жуулчлалын үйл ажиллагаа, хөтөлбөр боловсруулах | 101 |
| Жуулчдад зориулж үйл ажиллагаагаа төлөвлөхдөө анхаарах ерөнхий зарчмууд | 102 |
| Аяллын хөтөлбөр боловсруулах | 103 |
| Бэлэг дурсгалын зүйлс хийх, худалдан борлуулах | 103 |
| ХЭСЭГ 13. ОРОН НУТГИЙН ИДЭЭ УНДАА, ЭРҮҮЛ АХУЙН СТАНДАРТ | 109 |
| Жуулчдын хооллох зуршлыг ойлгож мэдэх | 110 |
| Зочдод хоол хийж, үйлчлэх | 111 |
| Гал тогооны ариун цэвэр, аюулгүй байдал | 116 |

| | |
|---|------------|
| ХЭСЭГ 14. АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ, БИЕ ЗАСАХ ГАЗАР | 120 |
| Аюулгүй, ариун цэврийн шаардлага хангасан жорлон | 120 |
| Тусгай хамгаалалттай газар нутгийн дотор байгуулах жорлонгийн зөвшөөрөл ба батлагдсан стандартууд | 122 |
| Хээрийн аяллын жорлон, ариун цэвэр | 126 |
| | |
| ХЭСЭГ 15. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ба БАЙГАЛЬ ОРЧНЫ БУСАД АСУУДЛУУД | 129 |
| Хаягдлаа багасга, дахин ашигла, дахин боловсруул | 130 |
| Хог хаягдлыг ангилж, ялгах | 133 |
| Органик хүнсний хаягдал, саарал ус | 134 |
| Байгаль орчинд ээлтэй бусад сайн туршлага | 136 |
| | |
| ХЭСЭГ 16. ХӨТӨЧ ХИЙХ | 138 |
| Орон нутгийн хөтөч таны үүрэг | 138 |
| Төлөвлөлт, цагийн менежмент | 139 |
| Гадаад байдал, хандлага, ур чадвар | 140 |
| Жуулчдыг угтан авч, үдэн мордуулах | 142 |
| Орон нутгийн хөтчөө сонгон сургах | 145 |
| | |
| ХЭСЭГ 17. АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ | 146 |
| Анхан шатны тусламжийн мэдлэг, баталгаажуулах гэрчилгээ | 146 |
| Гэр кэмп, аяллын анхан шатны тусламжийн хэрэгсэл | 147 |
| Онцгой байдал, яаралтай тусламжийн үед мэдээлэл хийх | 148 |
| Галын аюулгүй байдал | 149 |
| Зочны гэрийн аюулгүй байдал | 150 |
| Эд зүйлээ хулгайд алдсан, айж сандарсан жуулчныг тайтгаруулах | 151 |
| Аялалд гарахаас өмнө аюулгүй байдлаа хангаарай | 152 |
| Морь, тэмээн аяллын үеэрх аюулгүй байдал | 153 |
| Адал явдалт, спорт аялал | 155 |
| | |
| ХАВСРАЛТУУД | 157 |

Өмнөх үг

Монгол Улсын Засгийн Газрын зүгээс аялал жуулчлалыг уул уурхайгаас гадна эдийн засгийг солонгоруулах чухал стратегийн салбар гэж үзэж байна. Нүүдлийн соёл уламжлал, онгон байгаль нь жуулчдыг хамгийн их татдаг зүйл. Энэ утгаараа тусгай хамгаалалттай газар нутаг, түүний биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалж, тогтвортой байдлыг хангахад тэнд амьдарч буй орон нутгийн иргэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Манай оронд сүүлийн 20-иод жилийн хугацаанд байгаль хамгаалах төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ) хэд хэдэн төрлөөрөө хөгжсөөр байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдал, үнэ цэнэ, экосистемийг доройтуулахад малын тоо толгойн өсөлтөөс шалтгаалсан бэлчээрийн талхагдал болон хариуцлагагүй аялал жуулчлал нөлөөлж байна.

SPACES төслийг ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газартай хамтран 2019 оноос хойш хэрэгжүүлж байна. Төслийн үндсэн зорилго нь "ТХГН-ийн тогтвортой хөгжил, менежментийн суурь нөхцөлийг сайжруулах" бөгөөд төслийн хүрээнд ТХГН-ийн биологийн олон янз байдлыг хамгаалах, орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, цаашлаад тогтвортой аялал жуулчлал, НИТАЖ-ыг хөгжүүлэх чиглэлээр дэмжин ажиллаж байна.

НИТАЖ-ын энэхүү дэлгэрэнгүй гарын авлага нь GIZ SPACES төслийн санаачилга дэмжлэгээр аялал жуулчлалын салбарт орон нутгийн иргэдтэй хамтран 20 гаруй жил ажиллаж туршлагажсан үндэсний мэргэжилтэн, судлаачдын оролцоотой бүтээгдэж, НИТАЖ-ын үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн иргэдийн төлөөллөөр хянагдаж та бүхний гарт хүрч байгааг хэлэхэд таатай байна.

Тус гарын авлага нь та бүхэнд аялал жуулчлалын үйл ажиллагаагаа эхлүүлж, амжилттай хөгжүүлэн авч явахад тань нэмэр болох амьдралд ойр заавар зөвлөгөөг шат дараалан өгнө гэдэгт итгэлтэй байна. Үр дүнд нь та бүхний амьжиргаа дээшилж, өөрсдийн амьдарч буй газар орон, ТХГН-гаа тогтвортойгоор хадгалан хамгаалах юм.

Үүгээр зогсохгүй уг гарын авлага нь аймгуудын БОАЖГ, түүний мэргэжилтнүүд, сургагч багш нар, тур операторуудын хувьд ажилдаа ашиглах чухал материал болох юм. Басхүү хамгийн чухал нь энэ бүтээл малчин иргэдэд хүрснээр эх орныхоо ТХГН-ийг хадгалан хамгаалж хойч үедээ бүрэн бүтнээр нь өвлүүлэн үлдээх бидний нөр их хичээл зүтгэлд зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Тиймээс Монгол улсын БОАЖЯ-ны нэрийн өмнөөс GIZ SPACES төслийн хамт олон, мэргэжилтнүүд, энэ номыг бүтээхэд хувь нэмэр оруулсан бүх хүнд талархлаа илэрхийлье.



БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын
газрын дарга Д.Батмөнх

Танилцуулга

Та аялал жуулчлал эрхлэх юмсан гэж боддог ч юунаас эхэлж, хэрхэхээ мэдэхгүй байна уу? Эсхүл оролдож байгаад үргэлжлүүлж чадалгүй гацсан уу? Тийм бол энэ гарын авлага танд зориулагдсан гэсэн үг.

Энэхүү **Манай нутгаар зочлоорой** гарын авлага нь бодит туршлагад суурилсан бөгөөд орон нутгийн нөхөрлөл, бүлэг, хувь хүмүүс эрхэлж буй аялал жуулчлалын үйл ажиллагаагаа үнэлэн цэгнэж, боломж чадвараа өргөжүүлж, цаашлаад үйл ажиллагаагаа хэрхэн хууль эрх зүй, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зарчмуудын хүрээнд эрхлэн явуулахад тус нэмэр болох зорилготой боловсруулагдсан юм.

Уг гарын авлагад Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал гэсэн ухагдахууны талаар нарийн тайлбар өгөлгүй, энэ талаар сонирхсон нэгэнд зориулж нэмэлт мэдээлэл хэсэгт оруулсан. Харин "Тогтвортой Аялал Жуулчлал", "Хариуцлагатай аялал жуулчлал"-ын тодорхойлолтуудыг багтаалаа. Тэрчлэн дан ганц нөхөрлөл, бүлгүүдээр зогсохгүй энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх хүмүүст зориулж мэдээлэл, зөвлөмж өгөхийг зорьсон. Мөн нутгийн иргэдэд түшиглэсэн байгууллагын үйл ажиллагаа, түүнийг хэрхэн байгуулах талаар орууллаа.

Гарын авлагад манай оронд НИТАЖ-тай холбоотой гарсан санал, санаачилгууд, тэдгээрийн амжилт ололт, алдаа оноо, саад бэрхшээлийг тусгасан сургамжит кейсүүдийг шигтгэн оруулж өгсөн нь сонирхолтой, сургамжтай байх болов уу.

Манай нутгаар зочлоорой нь олон хүний хичээл зүтгэлээр боловсруулагдан, GIZ SPACES¹ төслийн санаачилга санхүүжилтээр бүтээгдэн таны гарч хүрч байна. Гарын авлагыг төслийн багийнхан орон нутгийн иргэдтэй аялал жуулчлалын чиглэлээр олон жил хамтран ажиллаж арвин их туршлага хуримтлуулсан энэ салбарын мэргэжилтнүүдтэй хамтран бүтээлээ. Ном бүтээх явцад хэд хэдэн удаагийн уулзалтыг зохион байгуулж, агуулга, бүтэц, загварыг хамтран хэлэлцэж, саналаа нэгтгэн ажиллаа. Эцэст нь хэсэг бүрийг эмхэтгэн нэгтгэж, засварлан, Монгол, Англи хэлээр хянан тохиолдуулж хэвлэн гаргаад байна.

Уншигч танд зориулан шаардлагатай нэмэлт мэдээллийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр хавсралтад багтаасан.

¹Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, "Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах" төсөл

Гарын авлага нь нийт 17 хэсгээс бүтсэн. 1-ээс 3-р хэсгүүдэд Монгол оронд яагаад жуулчид ирдэг, байгаль хамгаалал, тусгай хамгаалалттай газрын ангилал, орон нутгийн хамгаалалттай газрууд, нутгийн иргэдийн байгууллагуудын байгаль хамгаалал, аялал жуулчлал дахь үүрэг хариуцлагын тухай багтаасан.

Харин 4-өөс 10-р хэсгүүдээс та аялал жуулчлал эрхлэх өөрийн боломж, бэрхшээлээ хэрхэн үнэлэх, цаашлаад хууль ёсны дагуу бизнесээ бүртгүүлж, баг хамт олноо удирдан залах тухай олж мэдэх болно. Номын 11-ээс 17-р хэсгүүд танд жуулчин хүлээн авах газрын зохион байгуулалт, аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ бэлтгэн боловсруулах, холбогдох стандарт шаардлагуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа аюулгүй, байгальд ээлтэй явуулах зөвлөмжүүдийг өгнө.

Гарын авлагад орсон амьдрал практикт ойр зөвлөмжүүд нь таны мөрөөдлийг амьдруулж, танд аялал жуулчлал эрхлэх урам зориг, эрч хүч өгнө гэж найдаж байна. Ингээд танд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалдаа амжилт гаргахыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

***Гарын авлагын Монгол хэл дээрх хувилбарыг
QR CODE-г уншуулж татаж авна уу.***



***Гарын авлагын Англи хэл дээрх хувилбарыг
QR CODE-г уншуулж татаж авна уу.***

Товчилсон үгийн тайлбар

- БАГ** - Бэлчээр ашиглагчдын гэрээ
- БАХ** - Бэлчээр ашиглагчдын хэсэг
- БНХМ** - Байгалийн нөөцийн хамтын менежмент
- БНХМН** - Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл
- БОАЖГ** - Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- БОАЖЯ** - Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- БОЯБК** - Биологийн олон янз байдлын тухай конвенц
- ГГСБЦГ** - Говь гурван сайханы Байгалийн цогцолборт газар
- ГЗБГЗЗГ** - Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
- ДНБ** - Дотоодын нийт бүтээгдэхүүн
- ЖАЙКА** - Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
- ЖДҮ** - Жижиг, дунд үйлдвэрлэл
- ЗДТГ** - Засаг даргын тамгийн газар
- ИТХ** - Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- МАА** - Мал аж ахуй
- МХААХҮХ** - Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо
- НАЖГ** - Нийслэлийн аялал жуулчлалын газар
- НИТАЖ** - Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал
- НИТБНМ** - Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент
- НҮБ** - Нэгдсэн үндэсний байгууллага
- НҮБХХ** - Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
- ОНХС** - Орон нутгийн хөгжлийн сан
- ТББ** - Төрийн бус байгууллага
- ТХБНУГ** - Тусгай хамгаалалттай бус нутгийн удирдлагын газар
- ТХГН** - Тусгай хамгаалалтай газар нутаг
- ХТБХ ТББ** - Хүн төвтэй байгаль хамгаалал төрийн бус байгууллага
- ХТТ ТББ** - Хомын талын тахь төрийн бус байгууллага
- ХХК** - Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- ЮНЕСКО** - НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
- GIZ SPACES** - Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), "Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь" (SPACES) төсөл
- ИССА** - Уугуул болон нутгийн иргэдийн хамгаалалттай газар
- IUCN** - Байгаль хамгаалах олон улсын холбоо
- TNC** - Дэ Нэйче Консерванси байгууллага Монгол дахь хөтөлбөрийн газар



ХЭСЭГ 1. БИД ЖУУЛЧДЫГ ЮУГААРАА ТАТДАГ ВЭ?

Нүүдэлчин ахуй жуулчдын зүрх сэтгэлийг огшоодог

“Тэртээх говь цөлийн элсэн манхан, Алтай таван богдын Хүйтний оргилын хаа нэгтээ Монгол орны баялаг, үнэ цэнийг та жинхэнэ утгаар нь мэдрэх болно. Газар нутаг, хүн ард, ахуй соёл маань бидэнд заяасан хувь хишиг билээ.”¹



Монгол улс 2015 онд Берлин хотноо зохион байгуулагдсан дэлхийн хамгийн нэр хүнд бүхий аялал жуулчлалын Ай Ти Би² үзэсгэлэнд эх орноо “Nomadic by Nature” буюу утгачилбал “Төрөлх нүүдэлч” гэсэн уриагаар сурталчилсан билээ. Гадаадын жуулчдыг татдаг зүйлс нь яах аргагүй манай орны байгаль, нүүдлийн соёл, ахуй уламжлал юм.

¹<https://www.mcgroup.com/campaigns/mongolia-tourism>

²Internationale Tourismus Boerse = German for “International Tourism Fair”



Дэлхийгээр аялагчдын дунд өргөн хэрэглэгддэг Lonely Planet³ гэгдэх тайлбар номд “Хатуу ширүүн уур амьсгалтай Монгол орон нь жуулчдад өргөн уудам тал, хүний гар хүрээгүй газар нутгаар аялж, нүүдлийн соёлоос суралцах боломж олгодог” гэжээ. Харин Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс (ЖАЙКА) гаргасан Монгол орны танилцуулгад “Нүүдэлчийн зүг-Онгон байгаль, Нүүдэлчдийн өлгий нутаг”, “Go Nomadic - The Country of Nature and Nomads” гэжээ. Энэ мэт олон жишээ дурдаж болох ч тур операторууд Монгол орны аяллыг сурталчлахдаа энэ 2 түлхүүр үгийг л олонтоо хэрэглэдэг.

Иймээс жуулчид юун түрүүнд малчин тантай уулзаж, нутгийн айлаар зочилж, нүүдлийн уламжлалт ахуй соёлоос суралцах гэж ирдэг гэдгийг дээрх мэргэжлийн хүмүүс хэрхэн онцолж буйгаас ойлгож болно. Олон зуун жил өвөг дээдсийн маань хайрлан хамгаалж, өвлүүлж ирсэн нүүдлийн малчин ахуй амьдрал, хүний гар хүрээгүй онгон дагшин уул хад, ой мод, уудам цэлгэр тал, баян бүрд нь аялагчдын мөрөөдөл билээ. Тэд манай оронд энэ бүхнийг өөрийн биеэр харж, мэдэрч, чимээ аниргүй нам гүм талд түм бумар ярайх шөнийн оддыг харж баясах гэж ирдэг.

Хэрэв та өөрийгөө “би 5 одтой зочид буудалтай том компанитай өрсөлдөж чадахгүй” гэж бодож байвал үгүй юм. Та “5 сая одтой зочид буудал” болох уудам цэлгэр нутаг, мөнх хөх тэнгэрийн доорх эх нутагтаа зочдыг хүлээн авч буйгаа санаарай. Тэрчлэн аялал жуулчлалыг эх орондоо хөгжүүлэхэд та болон танай гэр бүл, ахан дүүс маш чухал үүрэгтэй. Учир нь та нүүдлийн амьдрал ахуйн талаарх мэдлэгээ хуваалцан, жуулчдыг гэртээ урин зочлуулж, тэдэнд байгаль дэлхийн зэрлэг онгон байдал, нутгийнхаа үүх түүхээс суралцах боломж олгож байна шүү дээ.

Өдөр бүр хардаг хязгааргүй үргэлжлэх бэлчээр нутаг, уул ус, цэлмэг тэнгэр, амьдрал ахуйгаа жуулчдад сонирхолгүй байх болов уу гэж та бүү бодоорой. Дэлхийг туурайгаараа тамгалсан эртний түүхт монгол морийг унаж үзэн, хил зааг, хашаа хамгаалалт байхгүй цэлгэр уудам талаар зугаалахыг хүсэхгүй хэн байхсан билээ.

Олон жуулчид Монгол орны гайхамшигт тал нутаг, байгаль, соёлын өвийн тухай ном, кино үзэж гайхан биширсэн байдаг. Монголын говиос олдсон динозаврын үлдэгдэл, түүний тухай нээлтүүд, хэвлээр явагчид, жигүүртэн шувууд, сүүн тэжээлтэн амьтны үүсэл, хувьсал, эдгээр нээлтүүдийн шинжлэх ухаанд оруулсан ач холбогдол зэрэг нь алдартай ном туурвилд олонтоо дурдагдсан байдаг.

³<https://www.lonelyplanet.com/mongolia>



Монголын газар нутаг, зэрлэг онгон байгаль яагаад жуулчдын сэтгэлийг татдаг вэ?

Монгол орны газар нутгийн тогтоц нь гадаадын жуулчдын хувьд үнэхээр гайхалтай санагддаг. Үүнээс гадна хэдэн зууныг дамжсан нүүдэлч малчдын өлгий нутаг, хүний гар хүрээгүй, онгон дагшин байгаль, цэлгэр уудам нутагт амьдран суух цөөн хүн ам зэрэг нь үнэхээр гайхшируулам билээ.

Зүүн Европоос Манжуур хүртэл сунаж тогтсон тал нутгаас эхлэлтэй, Еврозидаа хамгийн сүүлд үлдэж хоцорсон өргөн уудам нутаг бол Монгол. Энэ бэлчээр нутаг олон ховор амьтны өлгий нутаг юм. Тухайлбал 2 сая орчим зээр энд нутагладаг. Монгол орны зээр дэлхийн бөмбөрцгийн хойд хэсгийн хамгийн олноороо нүүдэллэн явдаг амьтны зүйл анги юм.⁴

Монгол орны говь нутгийн зарим хэсэг нь дэлхий дахинд хөндөгдөөгүй үлдсэн хамгийн том нутаг хэр нь хамгийн цөөн хүн ам оршин суудаг гэдгээрээ алдартай⁵. Говь хээрийн экосистем нь зэрлэг амьтан хамгааллын хувьд хамгийн чухал бүс нутгийн нэгт тооцогддог. Ялангуяа манай орны говь нутгийн өмнөд хэсэг нь хулан (asiatic wild ass), хар сүүлт зээрийн (black-tailed gazelle) нутагладаг чухал газар. Дэлхий даяар ховордон устаж буй амьтны зүйлүүд, тухайлбал говийн 6 гайхамшиг гэж нэрлэгддэг тэмээ, мазаалай, тахь, хулан, бөхөн, хар сүүлт нь говийн экосистемийн эрүүл, сайхан нөхцөлийн бэлэг тэмдэг болсон амьтад юм. Үүгээр зогсохгүй Монгол орон нь цоохор ирвэсийн тоогоор дэлхийд хоёрт ордог бөгөөд энэ нь манай орны газар шороо эрүүл байгаагийн нэг том шалгуур үзүүлэлт. Тэрчлэн жуулчдыг хамгийн их татдаг зэрлэг амьтан нь цоохор ирвэс өөрөө. Монгол орны ус намгархаг газар нүүдэллэн ирдэг шувуудыг харахаар жуулчид бүлэг бүлгээрээ ирдэг.

Дэлхийн байгаль, соёлын өв нутаг

ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн газар манай оронд 5 байдаг.

Үүнд:

“Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”, “Орхоны хөндийн соёлын дурсгалт газар”, “монгол алтай нурууны хадны зургийн цогцолбор”, “Дагуурын ландшафт” болон “Увс нуурын ай сав газар” орно.

⁴<https://www.lonelyplanet.com/mongolia>

⁵https://mongolia.panda.org/en/our_work/grassland_steppe/



Дэлхийн аялал жуулчлалын хандлага ба нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал

Малчин та бүхний хувьд газар нутаг, байгаль дэлхийтэйгээ харьцдаг амьдралын хэмнэл тань байдаг л хэвийн зүйл ч жуулчдын сонирхлыг хамгийн ихээр татдаг. Сэтгэлд хоногших дурсамжтай үлдэж, ертөнц болоод амьдралыг цоо шинээр танин мэдэх хүсэл тэмүүлэлтэй жуулчдын тоо маш их болжээ. Тэд аялж буй газар нутгийнхаа хэл яриа, соёл уламжлалд уусахыг хүсдэг.

Одоо цагт дэлхийн өнцөг булан бүрээс ирэх жуулчид үйлчлүүлж буй жуулчны байгууллагуудынхаа байгаль, нийгэмд оруулж буй хувь нэмрийг нухацтай авч үздэг болсон. Танай нутагт ирж буй жуулчдын хувьд ч гэсэн "цоо шинийг танин мэдэх", "туршлага суух"-ыг сонирхох явдал хамгаас чухал нь эргэлзээгүй.

Тиймээс танайд ирж буй жуулчид та бүхний амьдрал ахуйг танин мэдэж, суралцаж, өвөрмөц туршлага хуримтлуулахыг хүсэж байгаа. Үүгээр зогсохгүй нутгийн хоол хийж сурах хүсэлтэй олон жуулчид байдаг. Жуулчид нутгийн үлгэр домог, ам дамжсан яриа, онцгой сонин газрыг ихэд сонирхдог. Дэлхий дахинд гарч буй эдгээр хандлагыг "Тогтвортой аялал жуулчлал", "Хариуцлагатай аялал жуулчлал", "Эко аялал" зэргээр голдуу нэрлэдэг. Энэ нь та бүхэнд байгаль орчин, өв соёлоо хамгаалангаа аялал жуулчлал эрхэлж (НИТАЖ) орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломж олгож байна.

Тогтвортой аялал жуулчлал, хариуцлагатай аялал, эко аялал жуулчлал гэж юу вэ ?

Тогтвортой аялал жуулчлал нь аялагчдын үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулж, эерэг нөлөөг ихэсгэхийг зорьдог. Сөрөг үр дагавар үзүүлэх гэдэгт байгаль орчин, газар нутгийг гэмтээж, хүний бөөгнөрөл үүсгэж, орон нутгийн эдийн засгийг алдагдалд оруулахыг хэлнэ. Харин эерэг нөлөө гэдэгт ажлын байр буй болгож, соёлын өвийг хамгаалж, ач холбогдлыг нь дэлгэрүүлэх, зэрлэг амьтан, онгон байгалийг хадгалж үлдэх, газар нутгийг нөхөн сэргээх зэргээр хувь нэмэр оруулахыг хэлж буй юм⁶.

Тогтвортой аялал жуулчлал гэдэг нь НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тодорхойлсноор "Одоо болон ирээдүйн эдийн засаг, нийгэм, байгальд үзүүлэх үр нөлөө, аялагчдын хэрэгцээг бодолцсон, үйлдвэрлэл, байгаль орчин, хүлээн авч буй ард иргэд гээд бүхий л холбогдох зүйлсийг цогцоор нь авч үзэх"-ийг хэлнэ гэжээ.

⁶Encyclopedia of the World's Biomes, Goldstein, M. and DellaSala, D. (eds.), 2020, ISBN 978-0-12-816097-8



Хариуцлагатай аялал жуулчлалыг жуулчны биеэ авч явах байдал, хэв маягтай холбож тайлбарладаг. “Энэ нь аялж буй газар орондоо сөрөг бус эерэг нөлөө буй болгохыг хэлж буй юм.”⁷ Хариуцлагатай аялал жуулчлалын төв байгууллагаас энэ талаар тайлбарлахдаа “Хариуцлагатай аялал жуулчлалын оруулж чадах эерэг хувь нэмэр бол соёлын болон биологийн олон янз байдлыг хамгаалан сахиж буй нутгийн иргэдийг дэмжих үйл ажиллагаа юм” гэжээ⁸.

Эко аялал жуулчлал

Олон улсын эко аялал жуулчлалын нийгэмлэгээс эко аяллыг “Байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулдаг, орон нутагт хариуцлагатай аялж, нутгийн иргэдийн амьдралд эергээр нөлөөлж, тэднийг ойлгож, тэднээс суралцах байгалийн аялал юм” гэж тодорхойлжээ. Эко аялал жуулчлалын нэвтэрхий тольд энэ төрлийн аялал жуулчлалын дараах 3 шинжийг онцолжээ.

1. Байгальд түшиглэсэн.
2. Байгаль орчны мэдлэг олгох.
3. Тогтвортой менежменттэй.

Эко аялал жуулчлал нь дэлхий нийтийн жуулчлалын 20 хүртэлх хувийг эзэлдэг байна. Үүгээр зогсохгүй энэ төрлийн аялал нь олон оронд нутгийн иргэдийн орлогын гол эх үүсвэр, тусгай хамгаалалттай газруудын үндсэн санхүүжилт болж байна.⁹

Монголд байгалийн аялал жуулчлал их хөгжсөн учраас “эко аялал жуулчлал” гэдэг нэр томъёо их хэрэглэгддэг болж байна. Гэсэн хэдий ч шалгуур үзүүлэлтүүдийг хангахаас илүүтэйгээр “эко” гэдэг үгийг зар сурталчилгааны зориулалтаар нэр төдий ашиглах болсныг анхаарах нь зүйтэй.

⁷<https://www.gstcouncil.org/what-is-sustainable-tourism/>

⁸<https://www.gstcouncil.org/what-is-sustainable-tourism/>

⁹<https://www.gstcouncil.org/what-is-sustainable-tourism/>



Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ) гэж юу вэ?

Энэхүү гарын авлагын хүрээнд НИТАЖ гэдгийг албан ба албан бусаар байгуулагдсан нутгийн иргэдийн бүлэг, хувь хүн, айл өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатайгаар явуулж буй аялал жуулчлалын үйлчилгээ хэмээн тодорхойлов. НИТАЖ-ыг тухайн нутаг орноос шалтгаалан олон янзаар тодорхойлдог ч нийтлэг зарчмуудыг энд дурдлаа.



НИТАЖ нь “Нутгийн иргэд амьдрал ахуй, соёл уламжлал, газар нутгаа аялагчдад нүүр бардам, дуртайяа үзүүлэх сонирхолтой бөгөөд үүн дээрээ тулгуурлан аяллын хөтөлбөр зохиохыг хэлж буй юм. НИТАЖ нь аялагчдад нутгийн иргэдтэй уулзан, нутгийн соёл уламжлал, амьдрал ахуйгаас газар дээр нь суралцан мэдрэх онцгой боломжийг олгодог”.

“НИТАЖ нь орон нутгийн иргэдийн гардан явуулж буй ажил учир жуулчид нутгийн хүмүүстэй уулзан учирч, үүгээр дамжуулж иргэд өөрсдийн түүх соёлыг дэлхийтэй

хуваалцахаас гадна нутгийн иргэд тэдний гэр бүлийнхэнд туслах өвөрмөц боломжийг аялагчдад өгч чаддаг. НИТАЖ нь мөн байгалийн сайхныг бишрүүлээд зогсохгүй хүн байгалийн харилцан хамааралтай оршихуйг харуулж мэдрүүлдэг”¹⁰.

Тэрчлэн “Аялал жуулчлалаас нутгийн иргэд хэрхэн ашиг хүртэх вэ?” гэхээсээ илүүтэйгээр “Аялал жуулчлал орон нутгийн хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулах вэ?” хэмээн өргөн хүрээгээр нь харж ойлговол зохилтой. Хамгийн чухал анхаарах зүйл нь нутгийн иргэд, тэдний оршин тогтнож буй байгальд аялал жуулчлал зохих нөлөө үзүүлдэг учир НИТАЖ-ийн үйл ажиллагаанд маш сайн бэлтгэлтэй оролцох хэрэгтэй.¹¹

¹⁰<https://www.unwto.org/node/12238>

¹¹Community Based Tourism Handbook, 2003. Published by REST (Responsible Ecological Social Tour), Thailand.



Тайланд улсын НИТАЖ-ын гарын авлагад орсон зарчмууд:

- Аялал жуулчлал эрхэлдэг нутгийн иргэдийг хүлээн зөвшөөрөх, дэмжих болон олонд таниулах
- Эхнээс нь бүх зүйлд орон нутгийн иргэдийг оролцуулах
- Орон нутгийнхны бахархлыг сурталчлах
- Амьдралын чанарыг сайжруулах
- Байгаль орчны тогтвортой байдлыг хангах
- Орон нутгийн өвөрмөц шинж чанар, соёлыг хадгалах
- Соёл бүрээс суралцахыг хөхүүлэн дэмжих
- Соёлын ялгаатай байдал, хүн ёсыг хүндлэх
- Нутгийн иргэдийн дунд ашгийн тэгш хуваарилалт хийх
- Нутгийнхаа үйл ажиллагаанд зориулж орлогоосоо тогтсон хувийг хандивлаж байх

Эх сурвалж: НИТАЖ гарын авлага, 2003 он.

Тайландын REST (Нийгэм, экологийн хариуцлагатай аялал) эрхлэн хэвлэсэн.

Олон улс болон дотоодын аялагчдын хүлээлт

Гарын авлагын энэхүү хэсэгт гадаадын жуулчид Монголд ямар зорилго өвөрлөн ирдэг тухай голчлон тайлбарласан. Гэвч дотоодын аялагчид ч гэсэн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын зах зээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг байж болно. Магадгүй танай нутгийн газар зүйн байрлалаас шалтгаалан дотоодын аялагчдын тоо нь гадаадын жуулчдынхаас хавьгүй их ч байж болно. Гадаадын жуулчид Монголд аялахад саад болдог нэг зүйл нь манайд ирэх нислэгийн тоо цөөн байдаг. Иймээс дотоодын жуулчдыг авах нь бас нэг боломж гэдгийг харах хэрэгтэй.

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй таны хувьд гадаад болон дотоодын жуулчдын хэрэгцээ ялгаатай гэдгийг мэдэх хэрэгтэй болж байна. Дотоодын аялагчид ихэнхдээ гэр бүл, найз нөхөд, хамт олноороо бас хувийн унаагаар явдаг. Тэрчлэн сүүлийн үед тэд өөрсдийн бүрэн аяны хэрэглэлтэйгээ явах нь ихсэж, хөтөч гэх мэт бусад үйлчилгээг нутгийнхнаас авахгүй, харин сүү цагаан идээ, мал мах худалдан авах нь элбэг байдаг.



Гадаадын жуулчид ганц нэгээрээ эсхүл цөөн тоогоор хамт аялдаг. Ялангуяа Европын орнууд, Хойд Америк, Шинэ Зеландын жуулчид нам гүмийг илүүд үзэн, хоноглох байр, газар нутаг үзэхдээ аль болох олноороо яваа хүмүүсээс зайлсхийж хөтөчтэй явахыг хүсдэг. Мэдээж энэ бол танд өгч буй ерөнхий зөвлөмж. Иймд жуулчин бүр нэг хүсэл сонирхолтой гэсэн үг биш юм.

Аялал жуулчлалд баримтлах ёс зүйн хэм хэмжээ, нутгийн иргэдийн эрх



Хэдийгээр та аялагч, жуулчдад мэдлэгээсээ хуваалцаж, зан заншил, амьдрал ахуйгаа таниулах хэрэгтэй ч өөрийн зарчим, нутгийнхны ёсыг дагаж үзүүлж болохгүй газар, зүйлс байгаа бол ҮЗҮҮЛЭХГҮЙ байж болно. Жуулчдад энэ талаар учирлан тайлбарлаж, зарим нэгэн зүйлийг нутгийнхнаас асуух нь дэмий гэдгийг хэлж өгөх хэрэгтэй байдаг. Ихэнх жуулчид тухайн газар орны ёс заншлыг хүндэтгэн мөрдөхийг хичээдэг учир үүнийг талархалтайгаар

хүлээн авна. Зарим нэг нь заавал хариулт сонсох гээд байсан ч хариулахгүй байх нь таны бүрэн эрх билээ. Тэрчлэн ховор ан амьтан нь үргэмтгий, хэт эмзэг онгон байгальд жуулчдыг зөвхөн зураг авхуулах, зугаацуулахын тулд аваачихаас зайлсхийх нь зүйтэй.

Дэлхий нийтээр баримтлах аялал жуулчлалын ёс зүйн хэм хэмжээг НҮБ-ын дэлхийн аялал жуулчлалын байгууллага боловсруулсан. Үүний зорилго нь аялал жуулчлалын байгаль орчин, соёлын өвд оруулах сөрөг үр дагаврыг багасган, аялал жуулчлал эрхэлж буй газруудын иргэдэд хүрэх ашиг тусыг нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү ёс зүйн хэм хэмжээний 10 зүйл ангийг 2001 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаар албан ёсоор баталсан юм. Энэ бичиг баримт нь хууль биш ч гэсэн аялал жуулчлалтай холбоотой хэн ч бай, жуулчид, жуулчлалын үйлчилгээнийхний даган мөрдөх зарчмууд юм. Олон улсын аялал жуулчлалын ёс зүйн зарчмуудтай Хавсралт 1-ээс танилцана уу.

Олон улсын аялал жуулчлалын ёс зүйн зарчмуудтай QR CODE-ыг уншуулж танилцана уу.





Монголын аялал жуулчлалын хөгжлийн товч түүх

1954 онд Монгол оронд Аялал жуулчлалын товчоо байгуулагдан зөвхөн социалист системийн орнуудаас солилцоо, ан, агнуурын шугамаар жуулчид ирж эхэлжээ. Монгол улс 1963 оноос хөдөө орон нутагт жуулчны баазуудыг байгуулж эхэлсний нэг нь алдарт Ёлын ам, Баянзаг, Хонгорын элсийг жуулчдад үзүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байгуулсан Жуулчин говь бааз юм. 1990 он хүртэл төрийн өмчит Жуулчин компани хувьчлагдах хүртлээ бүхий л аялал жуулчлалын үйлчилгээг үзүүлдэг байв.

1991 оноос хойш Монгол улсад социалист дэглэм устаж, дэлхийд нээлттэй болсноор олон арван аялал жуулчлалын компани бий болсон. Одоогийн байдлаар Монголд нийт бүртгэлтэй 571 тур оператор, 526 жуулчны бааз байна. Өнөөдөр аялал жуулчлалын салбарт 55,220 хүн ажиллаж байна.

Энэ зууны эхэн үеийн гадаадын аялагчид нь хайгуулч, судлаач, адал явдалд дурлагсад байлаа. Магадгүй Рой Чапмен Андрыус барууны орнуудад хамгийн нэртэй аялагч байсан болов уу. Тэрээр 1922-1930 оны хооронд Бээжингээс Монголын чиглэлд хийсэн хэд хэдэн аяллыг ахалж, хамгийн анхны авто машинтай аяллыг тэмээн жингийн дагуултайгаар хийж байжээ. Түүний хийсэн эдгээр аялал нь Баянзагийг дэлхийд таниулсан юм. Учир нь динозаврын чулуужсан яс, өндөг, динозаврын шинэ зүйл, тухайн үед зэрэгцэн оршиж байсан эртний сүүн тэжээлтнүүдийн үлдэц зэрэг нь тэр үед олдож, ил болсон байдаг. Сүүлд Рой Чапмен Андрыус Америкийн Байгалийн түүхийн музейн захирал болжээ.

Харин 1946 онд Оросын хайгуулчид Монгол мэргэжилтнүүдийн хамт паленталогийн судалгааг Говьд хийсэн байна. 1990 оноос хойш Америкийн Байгалийн түүхийн музей манай говь нутагт Монгол мэргэжилтнүүдээр ахлуулсан паленталогийн судалгааг хийхэд дэмжин ажиллаж байна. Өнөөдөр Баянзаг шинэ Мэдээллийн төвтэй болж, улсын хамгаалалтад орж Монгол орны хамгийн их жуулчид очдог газрын нэг төдийгүй дэлхийн паленталогийн үнэт цэг болжээ.



Монголын аялал жуулчлалын хөгжилд тулгарч буй бэрхшээл¹²

Аялал жуулчлал бол уул уурхайгаас гадна орлого нэмэгдүүлэх, Монгол улсын эдийн засгийг солонгоруулах чухал стратегийн салбарт тооцогдож байна. Аялал жуулчлалын салбар ДНБ-ний 7%, нийт ажлын байрны 8%-ийг эзэлж байгаа ч энэ салбарыг хөгжүүлэхэд нэлээдгүй саад тулгарч байна.

Аялал жуулчлал ганц Монголд гэлтгүй дэлхий дахинд үүссэн онцгой үйл явдлаас ихээхэн шалтгаалдаг. Жишээ нь сүүлийн 20 жилийн тухайд 2001 онд болсон Нью Йорк хотын Дэлхийн худалдааны төвийн халдлага, 2003 онд тархсан CAPC (SARS), 2008-2009 онуудын дэлхийн эдийн засгийн хямрал, 2014, 2015 онуудад Монголд гарсан улаан бурхан өвчин, 2020, 2021 онд тархаад буй КОВИД-19 цар тахал зэрэг болно. Үүнээс гадна Монголын аялал жуулчлалд тулгарч буй бэрхшээл их байна.

Тур операторууд, зочид буудлуудад тулгамдаж буй 10 бэрхшээл:

1. Олон улсын нислэгийн тоо цөөн
2. Олон улс болон орон нутгийн нислэгүүд үнэтэй
3. Аялал жуулчлалын улирал богино
4. Эдийн засгийн дэмжлэг муу
5. Үндэсний хэмжээний аялал жуулчлалын бодлогын хэрэгжилт сул
6. Аялал жуулчлалын салбарын зохион байгуулалт, зохицуулалт муу
7. Орон нутгийн нислэгийн үнэ өндөр
8. Орон нутгийн нислэгийн олдоц муу
9. Бохирдол ихтэй, байгаль орчны хамгаалалт муу
10. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадвар сул

Монголд аялаад буцаж буй гадаадын жуулчдын хэлдэг нийтлэг бэрхшээл:

- Нийтийн бие засах газар ховор, ариун цэврийн шаардлага хангаагүй
- Зам, замын засвар үйлчилгээ муу, хотын замын бөглөрөл их
- Баазуудын өрөө, үйлчилгээ жигд биш. Жишээ нь, ор дэрний даавуу солих, хог хаягдлын менежмент гэх мэт
- Гадаад хэлний мэдлэг султай, сайн бэлтгэгдээгүй ажилчид
- Хот хоорондын болон хотын хувийн таксины үйлчилгээ ховор
- Орон нутгийн интернэтийн сүлжээ хүртээмжгүй
- Хоолны цэс цөөн, цагаан хоолны сонголт муу

¹²World Bank (2021). Mongolia: Fostering Inclusive Tourism Development in the Aftermath of COVID-19.



Монголд аялж буй гадаадын жуулчин¹³

Хаанаас, хэдэн жуулчид ирдэг вэ?

1995 оноос хойш манай оронд ирэх жуулчдын тоо нэмэгдсэн. Энэ тоо 1995-2011 онуудад огцом өсөж, 2012-2019 онуудад аажмаар буурсан байдаг. 2019 он хамгийн их жуулчин ирсэн онцгой жил байлаа. Үүний дараа КОВИД-19 цар тахлын улмаас Монголд ирэх жуулчдын тоо эрс буурч, 2023 он хүртэл сайжрах төлөвгүй байна.

2019 он хүртэлх өмнөх 10 жилийн хугацаанд жуулчдын тооны өсөлт дараах бус нутгаас ирсэн жуулчдын тооны өсөлттэй шууд холбоотой. Зүүн өмнөд Азиас ирсэн жуулчид +245% болж нэмэгдэж, нийт амарч зугаалахаар ирсэн жуулчдын 64 хувийг бүрдүүлсэн. Харин Европоос ирсэн жуулчид +87%-аар өсөж, нийт гадаадын жуулчдын 28%-ийг эзэлж байсан бол Хойд Америкаас ирсэн жуулчдын тоо +80%-аар өсөж, нийт гадаадын жуулчдын 5%-ийг эзэлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос харна уу.



Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ны¹⁴ "ТХГН-ийн аялал жуулчлал ба аялагчийн менежмент–Тогтвортой хөгжлийн удирдамж" (2018)-д тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын шилдэг туршлагаудын гол шинж чанаруудыг тодорхойлсон. Эдгээр нь бүх улс оронд хамааралтай бөгөөд Монгол Улсын, тусгай хамгаалалттай газар нутгуудад бүрт хэрэгжүүлэх боломжтой.

Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчийн удирдлага, зохион байгуулалтын олон улсын шилдэг туршлага, зарчмыг Хавсралт 3, Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)-ийг Хавсралт 4-өөс дэлгэрэнгүй харна уу.

¹³World Bank (2021). Mongolia: Fostering Inclusive Tourism Development in the Aftermath of COVID-19.

¹⁴IUCN нь байгаль хамгаалах олон улсын холбоо бөгөөд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр судалгаа, хээрийн төсөл, дэмжлэг, боловсрол олгох чиглэлээр идэвхтэй ажилладаг олон улсын байгууллага юм.


ХЭСЭГ 2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ, НУТГИЙН ИРГЭДЭД
ТҮШИГЛЭСЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ





Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Тусгай хамгаалалттай газар нутаг байгаль хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Монгол улсад ирэх жуулчдын сонирхлыг татдаг. Жуулчдын очих газрын 80 хувь нь цогцолборт газарт байдаг. Цогцолборт газар байгалийн тогтоц, зэрлэг амьтдыг хамгаалдаг бөгөөд тэдгээр ховор амьтдын зарим нь төрөл зүйлийнхээ хувьд дэлхий дээрх хамгийн хүчирхэг популяцыг төлөөлдөг тухай өмнөх бүлэгт үзсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн ой мод, ус намгархаг газар болон бусад байгалийн тогтцууд нь нүүрсхүчлийн хийг шингээж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.



Монгол Улс 2030 он гэхэд газар нутгийнхаа 30 хувийг улсын хамгаалалтад авах үндэсний хэмжээний том зорилт тавьсан бөгөөд Биологийн олон янз байдлын тухай конвенц (БОЯБК) зэрэг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцуудтай нийцүүлэн тус үүрэг амлалтыг авсан.

Улсын ТХГН-ийн мэдээллийн сангаас QR CODE-г уншуулж дэлгэрэнгүй мэдээлэл аварай.



Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяанд байдаг. Тусгай хамгаалалттай газар бүрийг хамгаалалтын захиргаа удирддаг. Зарим тохиолдолд газарзүйн хувьд ойролцоо орших хоёр болон хэд хэдэн тусгай



хамгаалалттай газар нэг хамгаалалтын захиргаанд харьяалагддаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа аялал жуулчлал хариуцсан нэг мэргэжилтэнтэй. Үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд, олон улсын хандивлагчид тусгай хамгаалалттай газрын сүлжээг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Аялал жуулчлалын тааруухан үйлчилгээ байгаль орчин, хамгаалалттай газар нутагт хор нөлөө үзүүлдэг, харин эсрэгээрээ бүх талыг оролцуулж сайн хөгжүүлж чадвал байгаль, зэрлэг амьтан, хамгаалалттай газар нутагт эерэг нөлөө үзүүлнэ. Ерөөс аялал жуулчлал бол нутгийн иргэд, бизнесүүдэд ашиг олох боломж бүрдүүлдэг. Гэхдээ алс хол нутагт аялал жуулчлал эрхэлж орлого олох нь тун хэцүү. Тийм ч хурдан биелэх ажил биш учир хэт их хүлээлт үүсгэн төөрөгдөх хэрэггүй.

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг менежментийн төлөвлөгөөний дагуу удирддаг. Менежментийн төлөвлөгөөг бүх оролцогч талууд, ялангуяа орон нутгийн оролцоотойгоор боловсруулдаг. Уг төлөвлөгөөнд тухайн газар нутгийг улсын хамгаалалтад авсан байгаль хамгааллын гол үнэт зүйлсэд үндэслэн удирдлагын арга хэмжээ, хариуцлага зэргийг тусгасан байдаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүйг QR CODE-г уншуулж татаж авна уу.



Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэл нь менежментийн төлөвлөгөөний чухал элемент юм. Тусгай хамгаалалттай газарт нэвтэрч байгаа гадаад, дотоодын зочид бүгд хураамж төлдөг. Аялал жуулчлалын компани, хөтөч, орон нутгийн хөтөч нарын зүгээс энэхүү хураамжийг төлсөн эсэхийг нягталж байх хэрэгтэй. Олон улсын жуулчид ийм хураамж дуртайяа төлнө. Учир нь тэд өөрсдийн орны дархан цаазат газруудаар аялахдаа ингэж заншсан байдаг ба төлбөр нь хамгаалалтын үйл ажиллагаанд зориулагдаад зогсохгүй Монгол орны байгаль, соёлын өвийг хамгаалах ажилд нэмэр болж байгаа гэдгийг сайн мэддэг. Тэр бүү хэл төлбөрөө төлөхийг тэдэнд сануулахад талархалтайгаар хүлээн авч, дүрэм журмыг сайн сахиж байгааг хараад сэтгэл ханамжтай байх болно. Энэ нь хариуцлагатай аялал жуулчлалын чухал хэсэг юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэлд зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг QR code-ыг уншуулж харна уу.





Байгалийн баялгийг тогтвортой ашиглах, хамгаалах, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын талаар нутгийн иргэд ямар эрх, үүрэгтэй байх нь тодорхойгүй байна. Гэсэн хэдий ч албан ёсоор байгуулагдсан нутгийн байгууллага эсхүл уламжлалт нийгмийн бүлэг, гишүүд гэх мэт нутгийн иргэд тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежментийн идэвхтэй түншүүд юм.

Тусгай хамгаалалттай газар нутагт амьдардаг нутгийн иргэдийн дагаж мөрдөх хууль, эрх зүйн хэм хэмжээ одоо хүртэл тодорхойгүй байсаар байна. Иймд нутгийн иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө боловсруулахдаа хамгаалалтын захиргаа, сумын захиргаа хоёулантай нь хамтарч ажиллаж нэгдсэн ойлголтод хүрч, тэдний дэмжлэгийг авах хэрэгтэй юм.

2022 оны 6-р сарын байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ТХГНТХ-ийг QR CODE-оор татаж авна уу.



Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежмент

“Тусгай хамгаалалттай газрын хамтын менежмент” гэдэг нь холбогдох олон янзын оролцогч талууд тухайн газрын менежментийн үйл ажиллагаа, эрх үүргийг хувааж хариуцах эсхүл хамтын менежментийг хэрэгжүүлэх хүсэл сонирхол бүхий төрийн байгууллагатай хамтарч ажиллах түншлэл юм¹⁵.

Хамтын менежментийн аргыг Монгол улсын тусгай хамгаалалттай газрын орчны бүс болон хамгаалалтын бүсдашигладаг. Монгол Улсын бусад олон орноос ялгарах онцлог бол тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар нүүдэлч малчдыг Байгалийн цогцолборт газрын ихэнх бүсэд уламжлалт газар ашиглалтын хэлбэр буюу бэлчээр ашиглахыг зөвшөөрдөг.

¹⁵Borrini, G. (1996): Collaborative management of protected areas: tailoring the approach to the context. IUCN, Gland. ISBN: 978-2-8317-0350-32-8317-0350-6





Хамтын ажиллагааны арга барилаар нутгийн иргэд болон бусад оролцогч талууд ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцдог. Менежментийн төлөвлөгөөг боловсруулах батлагдсан аргачлал, үе шатанд нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын оролцоог тусгасан байдаг.

Зарим тохиолдолд нутгийн иргэд өөрсдийн байгуулсан нөхөрлөлүүдээрээ дамжуулан ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахаас гадна хэрэгжүүлэх идэвхтэй хамтрагчид болдог. Жишээ нь Хэнтий аймгийн Хэрлэн тоонотын Байгалийн цогцолборт газарт иргэдийн байгуулсан нөхөрлөл цогцолборт газрын удирдлагатай хамтран менежментийн төлөвлөгөөг боловсруулж, аргал (*Ovis ammon*) зэрэг зэрлэг амьтдад хяналт тавих, хулгайн ангаас сэргийлэх менежментийг хариуцдаг.

Монголын хамгийн том байгалийн цогцолборт газар болох Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар болон орчны бүсэд 20 орчим жилийн өмнө нөхөрлөлийн хамгаалалттай газрыг анх удаа байгуулж эхэлсэн. Үүнийг малчдын нөхөрлөл, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, орон нутгийн засаг дарга нарын гурван талт гэрээгээр (15 жилийн хугацаатай) баталгаажуулсан. Гэрээнд Байгалийн цогцолборт газрын дотор болон гаднах газрыг багтаан тодорхой хэсэг газар нутагт малчдын хамтын бэлчээрийн эрх, байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг тодорхойлж, харилцан хүлээн зөвшөөрсөн.

Говь гурван сайханы Байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэр (2006 онд) дээр 25 байгаль хамгаалах нөхөрлөлийн хариуцан хамгаалах талбай байрлаж байсан. Энэхүү нөхөрлөлүүдийн нийт 27,000 хавтгай дөрвөлжин километр талбай нь тус цогцолборт газрын 25 орчим хувийг эзэлж байв. Тухайн үед нөхөрлөлийн хариуцан хамгаалах бүх газар нутаг албан ёсоор баталгаажуулаагүй байсан. Анхны нөхөрлөлийн бүлгүүд үүнээс хойш бэлчээр ашиглалтын томоохон бүлгүүдэд нэгдсэний гурав нь цогцолборт газрын нутаг дэвсгэрт байрладаг. Бэлчээр ашиглагчдын бүлгүүдийн (БАХ) бэлчээр ашиглах гэрээнд (БАГ) Байгалийн цогцолборт газрын цөм бүсийн гаднах бүсэд бэлчээрийн талбайг хамруулж болно гэж заажээ. Энэхүү гэрээнд ТХГН-ийн захиргааны эрх бүхий төлөөлөл гарын үсэг зурсан байдаг.



Бодит жишээ

Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг-Улалзах цонж хөгжлийн төв ТББ нь дэлхийн шинжлэх ухааны түүхэнд нэн чухал үлэг гүрвэлийн олдворт газар Баянзагт орон нутгийн хөрөнгөөр мэдээллийн төв, мэдээллийн төвийн ажилтнуудын ажиллаж амьдрах байр, үлэг гүрвэлийн олдворт газраар аялах зориулалтын зам, нэвтрэх цэгийг байгуулсан. Байгууллагын удирдах зөвлөл нь мэргэжлийн судлаач эрдэмтэд, аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдээс бүрддэг. Тус зөвлөл нийт байгууллагын ажилтнуудад заавар, зөвлөгөө өгч ажиллаж байгаа нь түүх соёлын дурсгалт газрыг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан хамгаалж, ашиглаж байгаа анхны загвар болно.

2019 оноос Ёлын ам орчмын гэр буудал, бэлэг дурсгалын дэлгүүр, хоол унд, морь унуулах үйлчилгээ эрхэлдэг иргэд нэгдэж Зүүн сайхан эх нутаг нөхөрлөл байгуулсан. Тэд Говь гурван сайхны Байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээ байгуулж орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх, Ёлын аман дахь нийтийн бие засах газрын үйлчилгээ, арчилгааг хариуцан ажиллаж байна. Энэ нөхөрлөлд Хүрмэн, Баяндалай, Даланзадгад, Ханхонгор сумын 16 өрхийн 18 иргэд нэгдэн ажилладаг. Эдгээр иргэдийн жилийн дундаж орлого 5-8 сая төгрөг байдаг.

*Эх сурвалж: "Зүүнсайхан эх нутаг"
нөхөрлөлийн ахлагч Б. Отгонжаргал. 2021*

Монгол Улсын Засгийн Газрын "төрийн чиг үүргийг төрийн бус байгуулагаар гүйцэтгүүлэх тухай" 2014 оны 2-р сарын 21-ний өдрийн 49 дугаар тогтоолоор ТББ-д гэрээгээр хариуцуулахыг зөвшөөрдөг болсон. Ийм анхны тохиолдол нь Хустайн Байгалийн цогцолборт газар бөгөөд хариуцан удирдаж буй ТББ нь нутгийн нүүдэлч малчидтай нягт хамтран ажилладаг. Малчид цогцолборт газар, орчны бүсэд амьдарч, байгалийн нөөцийг урьдын адил ашигладаг. Харин сэргээн нутагшуулсан дэлхийн хамгийн ховор зүйл зэрлэг адуу - тахь (Przewalski Horse, Equus przewalskii) ийн голомтод малаа бэлчээрлэхгүй байх гэрээ байгуулжээ.



Шинээр байгуулагдсан Хомын талын тахь Байгалийн цогцолборт газрын менежментийг БОАЖЯ-наас Монголын Хомын талын тахь ТББ-тай харилцан тохиролцож, хамгаалалтын менежментийг хариуцуулахаар ажиллаж байна.

ТХГН-ийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулах зөвлөмжийг QR CODE-оор татаж авна уу.



Орон нутгийн хамгаалалттай газар

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь аймаг, сумын засаг захиргаа, нийслэл, дүүргийн удирдлагын харьяанд байдаг бөгөөд ихэвчлэн нутгийн удирдлага, нутгийн иргэд хамтран удирддаг. Зарим тохиолдолд нөхөрлөл эсхүл бусад нутгийн иргэдийн бүлэг оролцдог. Бусад тохиолдолд нутгийн иргэд, ихэвчлэн нутгийн малчид хяналт-мониторинг, менежментэд үүрэг гүйцэтгэдэг, ялангуяа байгаль хамгаалагчид тэр дундаа сайн дурын байгаль хамгаалагч нар ажилладаг. Орон нутгийн засаг захиргааны хамгаалалтад байгаа нийт газар нутгийн хэмжээ сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж байгаа бөгөөд 2021 оны байдлаар нийт 27 сая га талбайг эзэлж байна. Энэхүү албан ёсны орон нутгийн хамгаалалттай газарт уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох боломжгүй тул бэлчээрийн эрх болон бусад уламжлалт нөөц ашиглалтыг баталгаажуулах хэрэгсэл болдог.

Байгаль, соёлын үнэт зүйлсийг хамгаалахын тулд байгуулсан орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Та гадны аялагчдад хөтөч хийвэл нутгийн хүн учраас өөрийн бодол, өвөрмөц санаагаа тэдэнтэй хуваалцах нь дамжиггүй. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нь нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг (НИТАЖ) хөгжүүлэхэд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгэн адил чухал юм; орон нутгийн тусгай хамгаалалттай газар нь малчдын амьжиргааг тэтгэдэг бэлчээрийг хамгаалахаас гадна НИТАЖ-ын хөгжилд чухал ач холбогдолтой ландшафт, түүх, нутгийн соёлын бусад үнэт зүйлсийг хамгаалж чадна.

Нутгийн иргэдийн хувиар та бүхэн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг байгуулахад санал дэвшүүлж болно. Орон нутгийн хамгаалалтад авах шаардлага буюу үндэслэл, хил заагийг тодорхойлон бичихэд мэргэжлийн хүний зөвлөгөө, туслалцааг авч болно. Сумын иргэдийн хурал батлах шийдвэр гаргаж, ГЗБГЗЗГ-т бүртгүүлсэнээр эцсийн шат дуусч баталгааждаг.



Тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд НИТАЖ хөгжүүлэх боломж

Монгол Улсын ихэнх тусгай хамгаалалттай газар нутагт гарч болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн амьжиргааг дэмжих зорилгоор түүний эргэн тойронд орчны бүсийг тогтоосон байдаг. Хуульд зааснаар орчны бүсийг дархан цаазат газрын гадна байгуулах бөгөөд байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсийн гадна эсхүл давхцаж болно. Мөн сум, хорооны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газруудын эргэн тойронд орчны бүс тогтоож болно. Та бүхэн өөрсдийн орон нутгийн ИТХ-д сонгогдсон гишүүнээрээ дамжуулан орчны бүс байгуулах, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явцад мэдээлэлтэй, идэвхтэй оролцох нь чухал. Энэ чиглэлээр олон нийтийг хамруулах зорилгоор хийгдэж буй уулзалт цуглаанд манлайлан оролцох хэрэгтэй. Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах зорилгод нийцсэн орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлдог бөгөөд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал үүнд чухал байр суурийг эзэлнэ.

Та, танай нутгийн иргэдийн төлөөлөл орчны бүсийн зөвлөлийн гишүүнээр сонгогдож болно. Орчны бүсийн сан нь орчны бүсийг хөгжүүлж, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилготой. Иймд таны болон танай нутгийнхны явуулж буй НИТАЖ-г дэмжин хөгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой юм.

ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийг
QR CODE-оор татаж авна уу.





ХЭСЭГ 3. НУТГИЙН ИРГЭДЭД ТУШИГЛЭСЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ

Байгаль хамгаалал ба нутгийн иргэд

Өнөөдөр дэлхий дахинд тусгай хамгаалалттай газар нутаг дотор байгаагаас илүү тооны биологийн төрөл зүйлийг уугуул болон нутгийн иргэд хамгаалж байгааг олон судалгаа харуулж байна¹⁶. Мөн нутгийн иргэд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд хамтран оролцож, тэдний амьжиргаанд нэмэр болж буй тохиолдолд илүү үр дүнтэй байдаг гэдгийг олон судалгаа харуулаад байна¹⁷.



¹⁶New estimates suggest that Indigenous peoples and local communities conserve at least a fifth of all land on Earth. The UN Environment Programme World Conservation Monitoring Centre/ICCA Consortium

¹⁷Johan Oldekop and others, "A Global Assessment of the Social and Conservation Outcomes of Protected Areas", Conservation Biology, Vol. 30, (2015)



Олон улсын хэмжээнд хамтын эдэлбэр болон уламжлалт ёс жаягаар зохицуулж буй газар нутгийг нийтэд нь "Уугуул болон нутгийн иргэдийн хамгаалалттай газар" (ICCA) гэж нэрлэдэг. Саяхнаас "Амин нутаг" буюу "Territories of Life"¹⁸ гэсэн нэршил гарч ирсэн. Энэ нь уугуул, нутгийн иргэд олон арван үеэр нутаглаж ирсэн газар нутагтаа хэрхэн зохицуулалт хийж, уламжлалт мэдлэг хуримтлуулж, байгалийн нөөц, биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглан, хамгаалж байгаа олон янзын хэлбэр юм.

Өнөө үед нутгийн уугуул болон суугуул иргэдийн байгаль хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг онцлон үздэг болсон төдийгүй тэдний газар, байгалийн нөөцийг ашиглах уламжлалт эрхийг хүндэтгэх явдал их болж байна. Сүүлийн 10-аад жил орчин үеийн шинжлэх ухаан болон олон улсын байгаль хамгаалах салбарынхны зүгээс малчдын бэлчээр сэлгэж ашигладаг арга ухааныг бэлчээр тогтвортой ашиглах чухал арга юм гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрөөд байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежмент

Манай орны малчид нүүдэл хийж бэлчээрээ хамгаалдгаас гадна газар, ус, зэрлэг амьтан, ариун дагшин газрыг хамгаалж ирсэн уламжлалтай. Сүүлийн хэдэн арван жил нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежмент албан ёсжиж, нутгийн иргэдийн олон янзын байгууллагууд бий болж байна. Тухайлбал нөхөрлөл нь байгаль хамгаалах хамтын ажиллагааг голчилдог бол бэлчээр ашиглагчдын бүлэг (БАХ) нь уламжлалт бэлчээр ашиглах хуваарийг үндэслэн, томоохон бэлчээр нутгийн менежмент хийх зорилгоор нэгддэг. Харин ойн нөхөрлөл ой, тэрчлэн ойн дагалдах баялгийг хамгаалах, зохицуулалт хийх зорилгоор байгуулагдаж байна.

Байгаль хамгаалах нутгийн иргэдийн байгууллага

Нөхөрлөл байгаль хамгаалах, бэлчээрийн менежмент, орлого нэмэгдүүлэх хамтын үйл ажиллагаа голчлон явуулж байна. Нөхөрлөл сумын засаг даргатай гэрээ хийж, нөхөрлөлийн гэрчилгээ авна. ГГСБЦГ-т байгуулагдсан анхны нөхөрлөлүүдийн дундаас "Нутгийн иргэдийн менежменттэй газар" -г зураглаж нөхөрлөл, хамгаалалтын захиргаа, сумын захиргаатай гурван талт гэрээ хийн ажиллаж байлаа.

¹⁸ ICCA Consortium – Territories of Life - www.iccaconsortium.org



Нөхөрлөлийн үүрэг хариуцлагыг хуульд тодорхой тусгах, тэдний газар эдэлбэрийн эрхийг баталгаажуулах ажлууд алгуур хийгдсээр байна. Одоогийн хүчин төгөлдөр Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нутгийн иргэдийн газар эдэлбэрийн баталгаат байдал, тэдний байгалийн нөөцийг ашиглах эрх үүрэг тодорхой тусгагдаагүй.

БОАЖЯ-нд нутгийн иргэдийн байгууллага хариуцсан нэг мэргэжилтэн ажилладаг. Цар тахлаас өмнө 2 жил тутам нэг удаа Нөхөрлөлүүдийн үндэсний чуулганыг БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг байсан. Энэ үеэр үзэсгэлэн худалдаа, төрийн болон олон нийтийн байгууллага, иргэдийн төлөөллүүдийн дунд туршлага судлах уулзалт, зөвлөгөөн зохион байгуулагдсан нь Улаанбаатар хотын томоохон арга хэмжээ байсан юм. Нөхөрлөлүүдийн дээвэр байгууллага болох Нөхөрлөлүүдийн үндэсний холбоо байгуулагдан ажиллаж байна.¹⁹

2021 оны байдлаар 21 аймгийн 176 суманд 1692 нөхөрлөл идэвхтэй үйл ажиллагаа явуулж, хамгаалалтад албан ёсоор авсан газрын хэмжээ 8,3 сая га-д хүрээд байгаа ч бодит байдал дээр нөхөрлөлийн хариуцан хамгаалж буй газрын хэмжээ үүнээс хамаагүй их байгаа ба Газрын Агентлагт албан ёсоор бүртгэгдээгүй байна. Ойн нөхөрлөлүүдийг нь нөхөрлөл нэрээр бүртгэдэг тул дээрх тоонд багтсан болно.

Одоогийн байдлаар нөхөрлөл байгуулах, менежмент явуулах, тэдний амжилтын үндэс, нөхөрлөлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, засаг даргатай байгуулах гэрээний маягт зэргийг багтаасан хэд хэдэн гарын авлага гарсан.

TNC Монгол дахь хөтөлбөрийн газраас гаргасан БНХМНөхөрлөлийн гарын авлагыг QR CODE уншуулж татаж авна уу.



Говийн нөхөрлөлүүд нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежмент, ядуурлыг бууруулсан туршлагаас гарын авлагыг QR CODE уншуулж татаж авна уу.

¹⁹Нөхөрлөлүүдийн Үндэсний Холбоо - www.facebook.com/nukhurlul.mongolia, info@nukhurlul.mn



Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын эрх зүйн орчин

1995 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 2017 онд нэмэлт өөрчлөлт орсон. Тус хуулийн 8-р бүлэгт байгалийн нөөцийн хамтын менежментийн эрх зүйн үндэслэлийг тусгасан. Үүнд байгалийн нөөцийн хамтын менежмент гэдгийг нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэд байгалийн нөөцийг дундаа хариуцан, хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх үйл явц гэж заажээ. Энэ үйл явцыг ил тод, ардчилсан зарчимд нийцүүлэн зохион байгуулж, нөхөрлөлийн гишүүд нь нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэх эрхтэй гэжээ. Мөн хамтын менежментэд оролцогч талуудад нөхөрлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга, байгаль орчны байцаагч, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байж болно.



Нөхөрлөл сумын засаг даргатай гэрээ хийх бөгөөд нөхөрлөлийн хариуцан хамгаалах газар нутгийн хэмжээ гишүүдийн тоонд харгалзан тогтооно. Талууд гэрээнд гарын үсэг зурснаар засаг дарга нөхөрлөлийг дэмжин ажиллах нөхөрлөлийн гэрчилгээ олгогдоно. Нөхөрлөл байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулаагүй, эсхүл гишүүд нь үйл ажиллагаагаа зогсоохоор санал нэгдсэн бол дуусгавар болно. Нөхөрлөл үйл ажиллагааны тайлангаа сумын захиргаанд танилцуулна. Хэрвээ нөхөрлөлийн хариуцан хамгаалдаг байгалийн нөөцийг өөр этгээд доройтуулж, үгүй хийсэн бол нөхөрлөл эргэн төлүүлэх, нөхөн төлбөр авах эрхтэй. Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг бүх гишүүдийн оролцоотой хийнэ.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент, нутгийн иргэдийн байгууллагыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, тогтвортой байдлыг хангахын тулд баталгаажуулах шаардлагатай. Хууль эрх зүйн орчин шинэчлэгдэн боловсруулагдаж байгаа энэ үед орон нутгийн түвшинд нутгийн иргэдийн байгууллагын бэлчээрийн менежмент, байгалийн бусад нөөцийн менежмент, хамгаалалтад оруулж буй үүрэг хариуцлагыг малчид, сумын захиргаатай хамтран ажиллаж тодорхой болгох хэрэгтэй байна.



Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)

БАХ нь үндэсний хэмжээнд хамгийн их тархсан малчдын байгууллагын хэлбэр болоод байна. Бэлчээр ашиглагчдын хэсэг нь газар орны байрлалтай шууд хамааралтай, нөхөрлөлтэй харьцуулахад олон гишүүнтэй зарим тохиолдолд нэг баг бүхэлдээ нэг БАХ болох явдал бий. БАХ-ийн гишүүнчлэл, бэлчээр нутгийн хэмжээг нутгийн бүх малчин өрхийг оролцуулан оролцооны аргаар тодорхойлдог. БАХ-ийг бэлчээрийн менежмент хийх гол зорилгоор байгуулдаг ч байгаль хамгаалал, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд бүлэг хэсгээрээ эсхүл ганц нэгээрээ оролцож болохгүй гэх үндэсгүй билээ.

БАХ сумын захиргаатай бэлчээр ашиглах гэрээг 15 жилээр хийдэг. Бэлчээр ашиглах гэрээг ГЗБГЗЗГ-ын үндэсний кадастрт бүртгэж авдаг. Хэрвээ БАХ-ийн бэлчээр ашиглах гэрээнд заасан нутаг дэвсгэр тусгай хамгаалалттай газар нутагтай давхацсан тохиолдолд ТХГН-ийн захиргаа, БАХ-ийн бүх гишүүн өрх гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

2021 оны 7 дугаар сарын байдлаар 18 аймгийн 170 суманд 1522 БАХ байгуулагдан нийт 80 сая га газрын бэлчээр ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна. ГЗБГЗЗГ-т нийт 140 сумын 50 сая га газрын 930 бэлчээр ашиглалтын гэрээ бүртгэлтэй байна.

НИТАЖ нутгийн иргэдийн байгууллага болох нь

Энэхүү гарын авлага зөвхөн албан ёсоор байгуулагдсан НИТАЖ-ын үйл ажиллагаа явуулж буй нутгийн иргэдийн байгууллагад зориулагдаагүй юм. Харин аялал жуулчлал эрхлэх сонирхолтой албан ба албан бус нутгийн иргэдийн байгууллага, бүлэг, хувь хүмүүст зориулан гаргасан.

Гэхдээ аялал жуулчлал эрхлэх сонирхолтой нутгийн иргэдийн байгууллагад бизнесийг амжилттай, тогтвортой явуулахад шаардлагатай дотоод удирдлага, зохион байгуулалт, харилцан итгэлцэл бий болсон байх нь чухал.

Нөхөрлөлүүдийн туршлагаас харахад дотоод удирдлага, зохион байгуулалтыг сайн хөгжүүлэх хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн

8-р бүлэгийг QR CODE-оор харна уу.





- » Нээлттэй шийдвэр гаргадаг сайн ахлагч
- » Нөхөрлөлийн ахлагчаа дэмжин тусалдаг зөвлөл
- » Бүх гишүүдийн оролцоотой шийдвэр гаргалт (Эрэгтэй/эмэгтэй, ахмад/ залуу, чинээлэг/ буурай)
- » Тогтмол хуралддаг
- » Нөхөрлөлийн дундын сан бүрдүүлсэн
- » Нөхөрлөлийн үйл ажиллагаанаас гарсан нийгэм, амьжиргаа, байгаль орчны өөрчлөлтийг хэмжих оролцооны хяналт- үнэлгээний системтэй

Нөхөрлөлийн гишүүн бие дааж эсвэл хэд хэдээрээ нэгдэн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгуулж болно. Хүмүүсийн сонирхол, авьяас, чадвар харилцан адилгүй учир гишүүн бүрийг аялал жуулчлал эрхэл гэж албадаж болохгүй шүү дээ. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд айл өрх дангаараа, эсхүл хэдэн айлууд нэгдэж явуулах тохиолдол их байдаг. Үүнийг ХХК, Нөхөрлөл (Байгаль хамгаалах нөхөрлөлөөс өөр гэдгийг санаарай) эсхүл хувиараа эрхлэх аж ахуйн хэлбэрээр эрхэлж болох юм. *Бизнесийн хэлбэрүүдийн тухай 5-р хэсгээс дэлгэрэнгүй харна уу.*

Монголын аялал жуулчлал дахь нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын жишээ:

Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үндсэн үзэл баримтлал бол нутгийн иргэдийн өөрсдийн хүчин зүтгэлээр байгалиа хамгаалж, орлогыг нь нэмэгдүүлэх явдал. Мэдээж энэ амаргүй ажил боловч амжилттай, хөлөө олж байгаа хүмүүс, нөхөрлөлүүд байна. Баруун бүсийн гурван нөхөрлөлийн жишээг танилцуулъя:

Анхлан 2016-аас 2020-иод оны хооронд нутгийн иргэдийн аялал жуулчлалаас олох өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Өмнөговь аймагт "Аялал жуулчлал-Өрхийн орлого" хөтөлбөрийг²⁰ хэрэгжүүлж зохион байгуулсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн ИТХурлаас аймгийн нутаг дэвсгэрт "Монгол гэр ажиллуулах журам"²¹ -ыг батлан гаргасан.

²⁰Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 1 сарын 25-ны 09 тоот тогтоол.

²¹Аймгийн ИТХурлын 2019 оны 12 сарын 04-ны 9/11 тоот тогтоол

Эх сурвалж: Аймгийн БОАЖГазрын Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Н. Бурмаа. 2021 он



Өмнөговь аймагт одоогийн байдлаар 61 гэр буудал, морь тэмээгээр жуулчдад үйлчилгээ үзүүлдэг 56 малчин, Ёлын аманд гэр дэлгүүр ажиллуулдаг 6 өрх байна. Сэврэй сумын захиргаа нутгийн аялал жуулчлал эрхлэгсэдтэй байнгын харилцаатай ажиллаж жил бүрийн жуулчны улирлын эхэнд ГГСБЦГ-ын хамгаалалтын захиргаа, орон нутгийн жуулчны баазууд, гэр буудлуудтай хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулан ажиллаж байна. Уг зөвлөгөөнөөр жуулчны баазууд, гэр буудлуудын хариуцан хамгаалах газрыг тогтоодог.

Малчид аялал жуулчлалд цоохор ирвэс (*Uncia uncia*), мануул (*Otocolobus manu*), эрээн хүрнэ (*Vormela peregusna*) зэрэг ховор амьтдыг үзүүлэх орон нутгийн хөтөч хийн оролцож байна.

Тэрчлэн жуулчны компаниуд малчидтай гэрээ хийн хамтран ажиллаж, зэрлэг амьтны байршил, нүүдлийн талаарх мэдээллийг авдаг. Компаниуд нутгийн айл өрхүүдээс морь уналга хөлслөн, нутгийн хөтөч авч ажиллуулан, цагаан идээ худалдан авч, жуулчдыг байрлуулах зорилгоор илүү гэрийг нь хөлслөн авдаг.

Эдгээр санаачилга нь дан ганц нутгийнхны амьжиргаанд нэмэр болоод зогсохгүй иргэдийг байгаль хамгаалалд татан оролцуулж, тэдний байгаль, зэрлэг амьтны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд түлхэц болж байна. Зэрлэг амьтан харах 10 хоногийн аялалд 3-7 малчин оролцож нэг малчин 1-4 хүртэл сая төгрөгийн орлого олж байгаа нь тэдний ноолуур, мах, арьсны жилийн борлуулалтын орлоготой тэнцэж байгаа юм²². Иргэд орлого олсноор зэрлэг амьтнаа үргээлгүй, хайрлан хамгаалж, ингэснээр аялал жуулчлалаас олох ашиг тогтвортой байх юм.

²²Эх сурвалж: Өмнөговь аймгийн Түм-эко тур компани



Орон нутгийн баяр, өв соёлын наадам

Манай оронд орон нутгийн баяр наадам, тэмдэглэлт үйл явдал ихэсч, эрчимтэй хөгжиж байна. Тэрчлэн өвөл, хавар тохиодог арга хэмжээнүүд аялал жуулчлалын улирлыг уртасгаж байгаа нь олзуурхуштай. Орон нутгийнхан баяр наадмын ерөнхий зохион байгуулалт, жагсаал парад, уралдаан тэмцээн төдийгүй ур чадвар болон үзүүлбэр, шилдэг мал, үндэсний хувцас, гар урлал, хоол хүнс бэлтгэхэд гардан оролцдог.



Түмэн тэмээний баяр – Өмнөговь аймаг
 Сарлагийн баяр – Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгууд
 Бүргэдийн баяр- Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хот орчим²³
 Түмэн адууны баяр – Хэнтий аймгийн Батноров сум
 Нүүдэлчдийн нэг өдөр – Улаанбаатар, зарим аймгууд
 Цайны зам-Өв соёлын наадам - Ховд аймаг
 Мөнгөлөг шагшуурга – Ховд аймаг
 Хөх сувд- Мөсний баяр –Хөвсгөл аймаг
 Элсэн манхны баяр - Өмнөговь аймаг
 Тогорууны баяр – Хэнтий аймаг

Та нутгийнхаа соёл уламжлалыг дэлгэрүүлэх зорилгоор ямар баяр, наадам, эвэнт зохион байгуулж чадах вэ?

²³Бүргэдийн баяр нь томоохон баяр наадмуудын нэг байсан боловч зарим тур операторууд хэт олон жуулчид, зурагчид цуглардаг хэмээн жуулчдаа авч очихоо байсан. Тэрчлэн бүргэдээр ан хийлгэдэг үзүүлбэрийг зарим жуулчид тийм ч их таашаан сонирхдоггүй байна.



ХЭСЭГ 4. НИТАЖ ЭРХЛЭХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙН ҮНЭЛГЭЭ

НИТАЖ-ЫГ амжилттай явуулах өөрсдийн нөөц боломж, саад бэрхшээлээ бодитоор үнэлээрэй!

Аялал жуулчлал эрхлэх чин хүсэл өвөрлөн хоёргүй сэтгэл гаргаж байгаа хүнийг магтан дуулмаар. Угтаа хүн ямар ч бизнес эрхэлсэн түүндээ хайртай, дуртай байх ёстой байдаг. Тэгж байж л бэрхшээлийг сөрж, бизнесээ цогцлоож чадна. Гэсэн хэдий ч дан ганц чин хүсэл, дур сонирхол хангалтгүй. Танай нутгийн иргэд, нөхөрлөлийнхөн нутгийнхаа сонин сайхан тогтоц, үзэсгэлэнт газарт хөтөч хийж, ёс заншил, уламжлалт баяр, үндэсний хоол зэргийг жуулчдад сонирхуулах талаар ярьж хөөрч буй байх. Энэ бүгд аялал жуулчлал хөгжүүлэхэд чухал хүчин зүйлс яах аргагүй мөн. Гэвч зах зээлд хүрч чадахгүй бол та нэг их хол явахгүй.





Аялал жуулчлал эрхэлж эхлэнгүүт таны санаанд ороогүй олон бэрхшээл тохиолдож магадгүй. Сэтгэлээр унах, алдагдалд орох, улмаар зөрчил маргаанд ч хүргэж болно. Тиймээс албан ёсоор бизнесээ бүртгүүлэх, гэр кэмп барих гэх мэт хөрөнгө оруулалт хийж эхлэхээс өмнө өөрсдийн бололцоог цэгнэж, цаашлаад нарийвчилсан нөхцөл боломжийн үнэлгээ хийх хэрэгтэй. Энэ хэсгээс та хэрхэн өөрсдийн нөөц боломж, саад бэрхшээл, цаашлаад давуу болон сул талуудаа, байгаа болон байхгүй нөөцөө үнэлэн тодорхойлоход суралцана. Тэрчлэн өөрт хэрэгтэй ур чадвараа тодорхойлж, ямар сургалт авах, үүнд хэр их цаг, мөнгө зарцуулахаа ч тооцоолоход тань тус болно.

Хэрвээ та өөрийн эрхлэх НИТАЖ-аа тогтвортой хөгжүүлэхийг хүсэж буй бол таны аялал жуулчлалын үйл ажиллагааны төлөвлөгөө дараах 2 үндсэн зорилго дээр үндэслэгдэн боловсруулагдах ёстой. Нэгдүгээрт нутаг орныхоо байгаль, соёлын өвийг хамгаалах, хоёрдугаарт орлого нэмэгдүүлэх юм.

Нөхцөл боломжоо үнэлэх талаар нарийвчлан үзэхээс өмнө НИТАЖ хөгжүүлэх үндсэн үе шатуудтай танилцъя. Дараах 10 алхмаар нэгтгэн харуулж байна.

НИТАЖ хөгжүүлэх 10 алхам

1. Жуулчин хүлээн авах газраа сонгох

Жуулчин хүлээн авах баг, сум, ТХГН гэх мэт газраа сонгоно. Жуулчдын сонирхлыг татах, тэдэнд үзүүлж болох нутгийн бүх өвөрмөц онцлогийг жагсаан бичнэ. Үүнд: байгалийн тогтоц, зэрлэг амьтан, түүх, соёл, уламжлалт дуу хуур, гар урлалын зүйлс гэх мэт орно.

2. Хүчин чадлыг үнэлэх

Нөөц хүчин чадлаа бүрэн утгаар нь үнэлэхийн тулд нутгийн иргэд, нөхөрлөл, бүлэг, сум, аймгийн мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, ТХГН-ийн мэргэжилтнүүд, ТББ, төсөл хөтөлбөр, тур операторууд, бусад мэргэжилтнүүдийг оролцуулах хэрэгтэй.

Байгаль орчин, зэрлэг амьтан, нутгийн иргэд, соёл уламжлалд гарч болзошгүй сөрөг үр дагаврыг сайтар нягтлаарай.



3. НИТАЖ-ын алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг тодорхойлох

Алсын хараа бол та бүхний мөрөөдөл²⁴. Энэ нь ямар нэгэн саадгүй боломжтой нөхцөлд НИТАЖ-ыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлбэл ямар байх вэ гэсэн та бүхний төсөөлөл гэж ойлгож болно. Алсын хараа нь танай нутгийн иргэд, нөхөрлөлд мөрөөдөлдөө хүрэх урам зориг өгч байх ёстой.

Эрхэм зорилго нь алсын хараанд хүрэх бодит алхмуудыг тусгадаг. Өөрөөр хэлбэл юуг, яагаад хийж байгааг тайлбарладаг. Эрхэм зорилго тань та бүхэнд урам зориг өгч хөдөлгөх учиртай.²⁵

Үүний дараа та бүхэн дараагийн хоёр жилд хүрэх зорилтуудаа тодорхойлж болно. Урдаа тавьсан зорилтдоо хүрсэн эсэхээ шалгаж хийсэн ажлаа тогтмол дүгнэж сураарай. Хоёр жилийн дараа дахин шинэ зорилт тавин ажиллаарай. Төлөвлөлт аль болох бодитой, биелэхүйц байх хэрэгтэй. Гэхдээ өөрсдийн чадлыг сорьсон томоохон зорилт тавьж, гүйцэтгэх явцдаа ур чадвараа хөгжүүлбэл сайн. Энэ нь та бүхэнд амжилт, баяр цэнгэл авчирна.

4. НИТАЖ-ын үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө боловсруулах



Алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудаа тодорхойлсны дараа төлөвлөгөөгөө боловсруулж, бусдын ололт амжилт, алдаа онооноос суралцаарай.

Бүлэг, нөхөрлөлийн бүх гишүүдээ төлөвлөлтөд жигд оролцуулаарай. Хамт олны ур чадваруудыг тодорхойлж, шинээр ямар ур чадвар хөгжүүлэх хэрэгтэйг олж илрүүлж, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулаарай. Ур чадвар хөгжүүлэх тухай 9-р хэсгээс харна уу

Бүх гишүүдтэйгээ ярилцан хэн ямар хувь нэмэр оруулж чадахыг тодорхойлоорой. Тухайлбал, дундын санд хувь нэмэр оруулах гэр, мал, унаа хөсөг гэх мэт.

²⁴<https://ctb.ku.edu/en/table-of-contents/structure/strategic-planning/vision-mission-statements/main>

²⁵www.ctb.ku.edu/en/table-of-contents/structure/strategic-planning/vision-mission-statements/main



5. Нутгийн иргэдийн байгууллагын дотоод дүрэм боловсруулах, сайжруулах

Хэрвээ та бүхэн нөхөрлөл эсхүл өөр ямар нэгэн нутгийн иргэдийн байгууллага байгуулсан бол итгэлцэл сайн, хамтын оролцоотой, нээлттэй шийдвэр гаргадаг, сайн ахлагчтай байх учиртай. Энэ нь дан ганц НИТАЖ гэлтгүй ямар ч бүлэг, иргэдийн хамтын ажиллагааны үндэс болдог. Анхнаасаа тохирсон дүрэм журамгүй бол асуудал, үл ойлголцол гарч, сүүлдээ хамт олон задран бутрахад нөлөөлдөг.

Дотоод дүрэм боловсруулахдаа гишүүн бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, үндсэн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, бүх гишүүдийн хурлын хуваарь, хамтын хөрөнгө оруулалтын гэрээ, санхүүгийн менежмент, ашиг хуваарилалт зэргийг тохирсон байх ёстой. Энэ тухай гарын авлагын 10-р хэсгээс хараарай.

6. Зочдоод үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулах

Хүний нөөц, тэдний туршлага, материалын нөөц, нэг удаад хүлээн авах зочдын тоо, зардал, үр ашигтай, аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах зэргийг харгалзан үзэж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайтар боловсруулаарай. Тэрчлэн нутгийн өвөрмөц уламжлал, соёлыг харгалзан үзэхээ бүү мартаарай. Энэ талаар гарын авлагын 12-р хэсгээс хараарай.

7. Багийн гишүүдээ сурган, дадлагажуулах

Бүх гишүүдийн ур чадварыг дээшлүүлэхийн зорилгоор хөтөч, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сургалт, мэдээллийн төвийг судлаарай.

Аймгийн Аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын хэлтэстэй холбоо тогтоож, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг танилцуулан, сургалт, сурталчилгааны талаар тусламж хүсээрэй. Гарын авлагын 9-р хэсгээс нэмэлт мэдээлэлтэй танилцаарай.

8. Маркетингийн төлөвлөгөөгөө боловсруулах

Танай бизнес төлөвлөгөөний хамгийн чухал хэсэг бол зах зээлд хүрэх төлөвлөгөө юм. Үүнд төсөв хуваарилаарай!

Аялал жуулчлалын холбоо, аймгийн аялал жуулчлалын хэлтэстэй холбогдож, маркетингийн төлөвлөлт хийх, зах зээлтэй холбогдох тал дээр тусламж аваарай. Зах зээлд хүрэх тухай 6-р хэсгээс үзээрэй.



9. Туршилтын аялал зохион байгуулах

Туршилтын аялал хийж үзэх их хэрэгтэй. Танай бүлгийн гишүүд эсхүл гадны хүмүүс жуулчид болж тоглосны дараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн сайжруулах талаар тэдний саналыг сонсоно гэсэн үг юм. Энэ тухай гарын авлагын 12-р хэсгээс хараарай.

10. Амжилт ололт, ажлын хяналт

Та бүхний жуулчдад үйлчилгээ үзүүлэх гол зорилго бол тэдний амьдралд цор ганц тохиох сэтгэгдэл төрүүлэх гэдгийг санаарай. Бүх ажлыг чанарын өндөр түвшинд хийж буй эсэхээ байнга үнэлж, шалгаж байгаарай. (аюулгүй байдал, ариун цэвэр, үнэн зөв, сонирхолтой мэдээллээр хангасан эсэх гэх мэт)

Жуулчдаас сэтгэгдлийг асуух нь чухал. Санал сэтгэгдлийн дэвтэртэй байвал их сайн. Тэдний өгсөн эерэг сайхан сэтгэгдлийг зар сурталчилгаандаа ашиглаж, өгсөн шүүмжийг нь ажилдаа тусгаж, болж өгвөл хариу өгч хэвшээрэй.

НИТАЖ эрхлэх боломж, бэрхшээлээ бие даан үнэлж үзэх

1. Өөрсдөөсөө ингэж асуугаарай:

Бид байгалиа хамгаалангаа аялал жуулчлал эрхлэхийг чин сэтгэлээсээ хүсэж байна уу? Бидэнд нутгийнхаа ёс заншил, байгалийн сайн сайхныг гадаад, дотоодын хүмүүст үзүүлэх сонирхол байна уу?

Эсхүл НИТАЖ-ыг зөвхөн орлогын эх үүсвэр гэдэг талаас нь илүү харж байна уу?

2. Та бүхэн нутгийнхаа байгалийг хамгаалах сонирхолтой, газар орон, өв соёлыг аялагчдад дуртайяа үзүүлнэ гэж бодож байгаа бол дараах асуултыг өөрсдөдөө тавиарай:

Танай нутгаар аялагчид байнга ирдэг үү?

Хэрэв тийм бол :

- Тэд яагаад манай нутгийг үзэх гэж зорин ирдэг вэ?
- Жуулчдад үйлчилгээ үзүүлдэг ямар газар байдаг, тэд жуулчдад юу санал болгодог вэ?
- Жуулчдад өөр, нэмэлт үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй юу? Бидэнд бусдаас илүү ямар давуу тал байна бэ?
- Бид хэрхэн жуулчдыг татах вэ? Яаж өөрсдийгөө сурталчлах вэ? Зах зээлтэйгээ хэрхэн холбогдох вэ?
- Нэг газар хэтэрхий олон жуулчид төвлөрч нутгийн байгаль орчин, иргэдэд сөрөг үр нөлөө үзүүлж байна уу?



Хэрэв жуулчид олноор ирдэггүй бол:

- Нутгийн байгаль, тусгай хамгаалалттай газар, соёл уламжлал, баяр наадам зэргээс юу үзүүлбэл зүгээр вэ?
- Манай нутагт жуулчид хүрч очиход амархан уу?
- Манай нутгийг үзэж, үйлчилгээг авахаар жуулчид энэ хүртэл ирэх үү?
- Аймаг сумын хөгжлийн стратеги, төлөвлөгөөнд аялал жуулчлал хөгжүүлэх талаар тусгагдсан уу? (дэд бүтэц, унаа тээвэр)
- Манай нутаг Улаанбаатар, бусад аялал жуулчлалын цэг, гол аяллын маршрутуудаас хэр хол вэ?
- Орон нутгийн онгоцны нислэгтэй юу?
- Зам ямар вэ? Жилийн хэдэн сард, аль улиралд очиж болох вэ? Бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхэд ямар улирал хамгийн тохиромжтой вэ? Манайхтай ойр нийтийн тээвэр бий юу?

3. Таны бодлоор жуулчид танайд ирэх боломжтой гэж үзвэл:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх миний, бидний чадавх хэр вэ? Бидний ур чадвар, мэдлэг, туршлага хэр вэ? Бид юу сурах хэрэгтэй байна бэ?
- Жуулчны улиралд ажиллах хангалттай хүн хүч бидэнд бий юу? Хотод сурдаг хүүхэд залуучууд зун ирж бидэнд туслах болов уу?
- Цахилгаан, усны хангамж хэр байгаа вэ? Утасны сүлжээ хэр сайн бэ? Интернэт?
- Үйл ажиллагаагаа эхлэхэд бидний нөөц хүрэлцэх үү? Санхүүгээ хэрхэн босгох вэ?
- Хэрхэн жуулчдаа татах вэ? Хэрхэн сурталчлах вэ? Зах зээлтэй хэрхэн холбогдох вэ?
- Бизнесээ хамтран эхлүүлэх хүчтэй баг хамт олон бид мөн үү?

4. Та бүхэн НИТАЖ эрхлэн явуулах дотоодын боломж бэрхшээлээ хангалттай дүгнэнцэгнэлээ. Хараахан ингэж хийж амжаагүй бол зөвлөгөө тусламж аваарай. Аймгийнхаа аялал жуулчлалын мэргэжилтнүүд, аялал жуулчлалын холбоо, ТХГН, тур операторууд болон бусад холбогдох газруудтай холбоо тогтоож, өөрсдийн санаа оноогоо ярилцан илүү нарийвчилсан, нухацтай үнэлгээ хийгээрэй.

Б. Нутгийн иргэд, мэргэжилтнүүдтэй хамтран нөхцөл боломжоо үнэлэх

Нөхцөл боломжийг хамтарч үнэлбэл хамгийн бодит үнэлгээ болдог. Бүх гишүүн, тэрчлэн боломжтой бол сум аймгийн энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд, ТХГН, Аялал жуулчлалын холбоо, ТББ-тай хамтран үнэлээрэй. Танай бүлгийн ахмад настнууд, залуучууд, хүүхэд ялгаагүй чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Залуучууд нь ахимаг настнуудаас сонирхолтой түүх, ёс заншлыг асууж мэдэх их чухал. Ингэж хамтын хичээл зүтгэлээр нутгийн түүх, соёл уламжлал, байгаль орчноо мэдэж аван үнэлнэ. Түүнчлэн орон нутгийн сургууль ч оролцуулж болно.



- ◇ **Танай нутгийн онцлог.** Та нутгийнхаа ямар соёлын болон байгалийн өвөрмөц онцлог, ёс уламжлалыг жуулчидтай хуваалцах боломжтой вэ? Бусдаас ялгарах ямар онцлог та бүхэнд байгаа вэ гэдгийг судлах хэрэгтэй. Үүнд түүх соёлын дурсгалт газар, алдартай хүмүүс, түүхийн дурсгалт явдлын гэрч, ул мөр юу байна бэ? Мөн нутгийн шашин шүтлэг, үлгэр домог, уламжлалт мэндчилгээ, үг хэллэг, нутгийнхны болно, болохгүй гэсэн зан үйл зэргийг харуулсан баяр наадам, өв соёлын арга хэмжээнд жуулчдыг оролцуулж болно. Орон нутгийнхны амьдрал ахуйн сонин содон зүйлс, мал ахуй, газар тариалан эрхлэх нутгийн арга хэлбэр, нутгийн гар урлал, нарийн хийц, нутгийн хоол хүнс, бэлтгэх арга нь хүртэл аялагчдад сонин байдаг.
- ◇ **Орон нутгийн байгалийн нөөц, тогтвортой ашиглалт.** Орон нутгийнхаа байгалийн нөөц, өнөөгийн нөхцөл байдал, үнэ цэнийг мэдэж байх хэрэгтэй. Үүн дээр үндэслэж та бүхэн төлөвлөгөөгөө гаргана. НИТАЖ эрхлэхийн зорилго нь нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж, байгаль хамгаалахад хувь нэмэр оруулах явдал юм. Аялал жуулчлалаас унаган байгаль, зэрлэг амьтад, бусад байгалийн нөөцөд хохирвол аялал жуулчлал хэзээ ч тогтвортой хөгжиж чадахгүй.

Үнэлгээ хийж байхдаа та бүхэн болж өгвөл сумын газрын даамал, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран ажиллаж байгалийн ямар нөөц хомсдоод байгаа, хэрхэн ариг гамтай ашиглаж хамгаалах, цаашлаад аль хэсэгт огт үйл ажиллагаа явуулж болохгүйг сайтар зөвлөлдөн шийдэх хэрэгтэй. ТХГН болон Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайтар судлаарай.

Тэрчлэн Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө НИТАЖ эрхлэн явуулахад үнэтэй сурвалж болж чадна. Энэ төлөвлөгөөнөөс сумын байгалийн нөөцийн зураглал, сумын ерөнхий хөгжлийн стратеги зэргийг харж болно. Харин бэлчээрийн менежментийн төлөвлөгөө нь хадлан, бэлчээрийн сэлгэх газрыг тусгасан байдаг. Энэ мэт арга аргачлалаар нүүдлийн мал аж ахуйг хэрхэн эрхлэн явуулдаг тухай жуулчид сонирхдог.

- ◇ **НИТАЖ-ыг хөгжүүлэхэд шаардлагатай та болон танай бүлгийн чадвар.** Аялал жуулчлалын талаарх өөрсдийн мэдлэг чадвар, санхүүгийн нөөц, хүн хүч, ажлын ачаалал зэргийг тооцож үзэх нь чухал.



ХЭСЭГ 5. НИТАЖ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АЛБАН ЁСООР ЭРХЛЭХ

Та бүхэн дотоод нөөц бололцоогоо үнэлэн, хэлэлцэж ярилцсаны үндсэн дээр аялал жуулчлал эрхлэхээр шийдсэн бол юун түүрүүнд эрхэм зорилго, алсын хараагаа тодорхойлох хэрэгтэй юм. Ингэснээр бизнесийнхээ богино, дунд, урт хугацааны зорилгоо олж харснаар урам зоригтой ажлаа хийх болно. Өмнөх хэсэгт дурдсанчлан алсын хараа бол таны мөрөөдөл, харин эрхэм зорилго нь түүнд хүрэх бодит алхам юм.





Алсын хараа, эрхэм зорилгоо хамт олноороо, хамтрагч талуудтайгаа харилцан ярилцаж боловсруулах хэрэгтэй. Ингэснээр баг бүрдүүлэх суурь тавигдаж, хамтдаа нэг зорилгын төлөө тэмүүлэх эрч хүчтэй болдог. Бүх гишүүн идэвхтэй оролцож, илэн далангүй, санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах хэрэгтэй. Тэрчлэн ингэж хийснээр багийн бүх гишүүн юуны төлөө хамтран ажиллахаа ойлгож, их ажлын гарааг эрч хүчтэйгээр эхлүүлэх болно.

Хэлэлцсэн зүйлсээ том цаасан дээр буулган, протокол хөтөлж бүх гишүүдэд тараах хэрэгтэй. Үүн дээр үндэслэн ойрын болон жилийн төлөвлөгөөг гаргахад хялбар байдаг. Нэгэн нөхөрлөлийн тодорхойлсон алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг жишээ болгон хайрцагт орууллаа.

Загвар жишээ: Нэгэн нөхөрлөлийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл

- **Эрхэм зорилго:** Байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх замаар эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, Захчин түмний соёлыг хадгалах, ердийн хөсөгтэй нүүдлийг сэргээсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлж нөхөрлөлийн гишүүдийг нэмэлт орлогын эх үүсвэртэй болгоно.
- **Алсын хараа:** Өөрийн нутгийн байгалийн баялгийг хамгаалан онгон дагшин байдлаар нь хойч үедээ үлдээхийн зэрэгцээ нүүдлийн соёлын онцлогийг хадгалж хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- **Үнэт зүйл:** Тогтвортой аялал жуулчлалын стандартыг судалж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг эрхэм зорилго болгож багаараа үнэнч шударга, хариуцлагатай ажиллана.

Байгууллагын хэлбэр: Хуулийн этгээд эсхүл орон нутгийн иргэдийн байгууллага

Та бүхэн үйл ажиллагаагаа зөв зүйтэй явуулахын тулд байгууллагын хэлбэрээ сонгох хэрэгтэй. Хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж үү? Хариуцлагатай Хувьцаат Компани (ХХК) эсхүл ашгийн төлөөх нөхөрлөл хэлбэрээр байгуулах уу? Эсхүл байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу БНХМНөхөрлөл байгуулах уу?



Та бүхэн нөхөрлөл, эсхүл ойн нөхөрлөлд харьяалагддаг бол танай зарим гишүүд хамтран НИТАЖ эрхлэх бүлэг, аж ахуйн нэгж байгуулж болно. Эсхүл та томоохон бэлчээр ашиглагчдын хэсгийн (БАХ) гишүүн бол дотроо НИТАЖ-бүлэг эсхүл нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөл байгуулж болно. Хэрэв та хоршооны гишүүн бол аялал жуулчлалын үйл ажиллагааг хоршооныхоо нэрэн дор явуулж болно. Компани, нутгийн иргэдийн байгууллагын хэлбэрүүд, хоорондын ялгааны тухай дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас харна уу.

НИТАЖ эрхлэхийн тулд ямар хэлбэрийн байгууллага байх хэрэгтэй талаар нарийн дүрэм байхгүй. Гэвч хамгийн тохиромжтой хувилбар нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгуулдаг Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл юм.

Нөхөрлөл дотоод дүрэм журмаа боловсруулж, харилцан итгэлцэлтэй, дундын сан гэх мэт дэмжих механизмтай байх нь НИТАЖ-ын үйл ажиллагааг эхлүүлэхэд нэлээд дөхөм болдог.

Нөхөрлөлийн зорилго анхнаасаа байгаль хамгаалах, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг сайжруулах нь нутгийн байгаль, өв соёлыг хамгаалах гэсэн НИТАЖ-ын зорилготой дүйж байна. Сургамж өгөх үүднээс Ховд, Хөвсгөл аймгуудын бодит жишээг орууллаа.

Бодит жишээ

1. Буурлын Магнай нөхөрлөл

Ховд аймгийн Манхан сумын Баянгол багийн нутаг дэвсгэрт Жаргалант хайрхан уулын бэлд амьдардаг малчид Буурлын Магнай нөхөрлөлийг 2010 онд байгуулсан. Нөхөрлөл 10 өрхийн 21 гишүүнтэй.

Тус нөхөрлөл байгаль хамгаалал, аялал жуулчлал, газар тариалан, эсгий эдлэлийн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулахыг зорьж байна. 2012 онд Баруун таван аймгийн хүнсний ногооны чиглэлээр Шилдэг нөхөрлөл болж байсан.

2012-2013 онд нөхөрлөлийн гишүүд ирвэс болон бусад ховор ан амьтад, малчдын амьдралын тухай баримтат киноны зураг авах Солонгосоос ирсэн багтай хамтран ажиллажээ. Мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн судлаачидтай хамтран ирвэсийн судалгаанд оролцдог.

Ирвэс хамгаалах сантай эсгий бүтээгдэхүүний гэрээ байгуулж захиалгат бүтээгдэхүүн нийлүүлдэг.



2020 оноос Байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөл болсноор зундаа гэр буудал ажиллуулж, газарчин хөтчөөр явах, гадаад дотоод жуулчдад тэмээн жингийн аялал зохион байгуулах, нөхөрлөлийн гишүүд гар урлалын бүтээгдэхүүнийг байгууллагуудын захиалгаар хийж худалдан борлуулдаг байна.

Ховд аймгийн Манхан сумын засаг даргатай байгалийн нөөцийн менежментийн гэрээ байгуулж гэрчилгээ авсан. Жил бүр өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажил, байгаль хамгааллын үйл ажиллагааны тайлан илгээдэг.

2. Цаст-Ундарга нөхөрлөл

Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хаг багт орших Цаст-Ундарга нөхөрлөл анх 2008 онд НҮБХХ-ийн Алтай саяны төслөөр байгуулагдсан ба байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Байгалийн үзэсгэлэнтэй тогтоц бүхий газарт оршдог бөгөөд зэрлэг амьтан, ховор ургамал ихтэй өндөр уулын бүс юм.

Тус байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь 2018 оноос хойш 13 өрхийн 30 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Зуны улиралд гадаад, дотоод жуулчид хүлээн авдаг 12 ортой, эко ариун цэврийн байгууламжтай гэр кэмптэй байна. Нөхөрлөлийн гишүүд хуваарь гарган гэр кэмпээ ажиллуулах, морин аялал зохион байгуулах, Мөнххайрхан уул руу уулын газарч, хөтөч хийх зэргээр аялал жуулчлалд оролцдог.

3. Цаачны нөхөрлөл

Анх 1990 оны үед нэгэн гадны иргэн Хөвсгөл аймгийн Цагаан нуур, Улаан-Уул сумын баруун, зүүн тайгад амьдардаг цаа буга маллаж, урцанд амьдардаг тува иргэдийн тухай баримтат кино хийж таниулснаас хойш тэд дэлхийн аялал жуулчлалын анхааралд өртсөн юм.

Энэ үйл явдлаас хойш тэднийг сонирхох ганц нэгэн групп аялал ирж эхэлсэн бөгөөд 2005 онд тайгад аялж явсан жуулчдын санаачилгаар "Итгэл" нэртэй ТББ байгуулагдаж тэднийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулах үндэс суурь тавигдсан.

Төслийн зүгээс Цагаан нуур сумын төвд Цаачин мэдээллийн төвийн байшинг бариулж Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоотой хамтран цаачдад морь, цаа бугын аялал зохион байгуулах, анхны тусламж үзүүлэх, анхан шатны англи хэл, гар доорх материалаар



жуулчны хоол унд бэлтгэх, жуулчныг халамжлах, хог хаягдлын менежментийн сургалтад хамруулжээ.

Хамгийн чухал нь баруун, зүүн тайгын цаачин иргэдийн дунд хурал зохион байгуулж хэрхэн аялал жуулчлалаар ирэх хүмүүсээ айл бүрт хүртээмжтэй буулгах, цаашлаад дундын сангийн ойлголтыг өгч чадсан юм. Тэдний энэ амжилтыг сурталчлан түгээж тайгын аяллыг тогтмол зохион байгуулах суурь тавигдсан. Жишээ нь нэг аяллын компани төв рүү холбогдож захиалгаа өгөхөд төвөөс хуваарь гарган баруун, зүүн тайгын аль руу нь явуулахыг зохицуулж, морь, хөтчийг урьдчилан бэлдэж холбож өгдөг байв. Энэ нь аль аль тайгын иргэдийн хувьд тэгш байх нөхцөл бололцоог бүрдүүлж өгсөн явдал байв.

Мөн аяллын компаниуд Цагаан нуур суман дахь Цаачин нөхөрлөлийн төвд захиалгаа өгч, морь болон хонох урцны захиалгыг өгч төлбөр тооцоогоо шилжүүлдэг болсон нь холбоо барих боломжгүй аглаг тайгад амьдарч байгаа иргэдтэй харилцах чухал арга байв. Тур оператор компаниуд дундын санд орлогыг төвлөрүүлж төлдөг бөгөөд нөхөрлөлийн менежер орлого бүрээс тохирсон хувийг авч үлдэн хурал хийж тухайн жилдээ цаачин иргэдийн нийгэм, эрүүл мэнд боловсролын асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулж эхэлсэн. Нөхөрлөлийн менежерээ цаачид өөрсдөө сонгодог. Харамсалтай нь амжилттай эхэлсэн энэхүү нөхөрлөл нь гишүүдийн итгэлийг алдан дундын санг






үрэн таран хийсэн нөхөрлөлийн менежерээс болж задарсан байна.

Одоогоор мэдээллийн төв болох байшинг нэг өрх хариуцан хамгаалж зундаа буудлын зориулалтаар ашигладаг байна. Өнөөдөр баруун зүүн тайгын зарим иргэд жилийн 4 улирал гадаад, дотоодын жуулчин хүлээн авдаг. Хамгийн богино жуулчны улиралтай манай улсад хамгийн урт хугацаанд тасралтгүй ажиллаж орлого олдог цор ганц угсаатны бүлэг тайгад байна.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл байгуулах

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 8-р бүлэгт заасан БНХМНөхөрлөл байгалийн ямар нөөцийг ямар эрх, үүрэгтэй ашиглан хамгаалах нь хуулийн хүрээнд тодорхойгүй байсаар байна. Гэсэн хэдий ч байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүдийн туршлагаудад үндэслэн цаашид хууль эрх зүйн орчин сайжрах юм. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудыг хялбарчлан хүснэгт хэлбэрээр оруулсантай танилцана уу.







Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө
Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж батална. (БОТХ-52 зүйл)

1. Нөхөрлөлийн хариуцан, хамгаалж буй байгалийн нөөц, баялгийн мэдээлэл, нутаг дэвсгэрийн хил хязгаарыг баталгаажуулсан зураг.

2. Нөхөрлөлийн хариуцан хамгаалах байгалийн нөөцийн тархац, тоо хэмжээ, даац, чанар

3. Одоо, ирээдүйд эдийн засаг, нийгмийн хувьд ашиг тусаа өгөх нөхцөл, арга хэмжээ

4. Байгалийн нөөцийн менежмент тохирох арга хэлбэр

5. Нөхөрлөлийн хариуцан хамгаалж байгаа байгалийн нөөцийн төлөв байдлын хяналт шинжилгээний хөтөлбөр

6. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нөхөрлөлийн гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүрэг, бусад талтай хамтран ажиллах

7. Санхүүгийн төлөвлөгөө

8. Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаас тогтоосон бусад зүйл



Бизнес төлөвлөгөө боловсруулах

НИТАЖ-ын үйл ажиллагаа явуулж орлогоо нэмэгдүүлэх, ашигтай ажиллах гэж зорьж буй учраас та бизнес төлөвлөгөө гаргах хэрэгтэй.

Хэрвээ та анх удаа бизнес төлөвлөгөө боловсруулж байгаа бол сургалтад хамрагдах, эсхүл туршлагатай хүнээс зөвлөгөө авах хэрэгтэй. Та сумынхаа ЖДҮ хариуцдаг мэргэжилтнээс асууж болох ба тэр танд хангалттай зөвлөгөө өгч чадахааргүй бол өөр байгууллага, мэргэжлийн хүнтэй холбож өгнө.

Нөөц боломж үнэлэх хэсгээс НИТАЖ-ыг эхлүүлэхэд анхаарах зүйлсийг олж мэдсэн байх гэж найдаж байна. Харин бизнесийн төлөвлөгөө нь үйл ажиллагаагаа нарийн, шат дараалалтай боловсруулахад тусалдаг. Та бизнесээ эхлүүлэхдээ зээл авах гэж байгаа бол таны бизнес амжилттай явагдана гэдгийг харуулах бизнес төлөвлөгөө чухал.

Бизнес төлөвлөгөөтэй байх нь хэд хэдэн давуу талтай. Үүнд хийх ажлаа нарийвчлан зөв дэс дараатай төлөвлөж, хөрөнгө оруулалтын хэмжээг мэдэж авна. Цаашлаад бүтээгдэхүүн хөгжүүлэхийн тулд та үйлчлүүлэгчдээ сайтар судлах боломж гарна. Бизнесээ өргөжүүлэхэд хамтран ажиллах хувь хүмүүс, ТББ, олон улсын байгууллага, банк, төрийн байгууллагуудтай холбоо тогтоосноор таны нийгмийн идэвх сайжирч, мэдээлэлтэй болно.

Бизнес төлөвлөгөө боловсруулахад тань хэрэг болох зөвлөмжийг Хавсралт 6-аас харна уу.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн бүрэн эхийг QR CODE-г уншуулж татаж авна уу.





ХЭСЭГ 6. НИТАЖ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ХҮРГЭХ НЬ

Энэ хэсгээс та үйлчлүүлэгчдээ хэрхэн татах, танд ямар боломж байгаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрхэн зах зээлтэй холбох аргуудыг мэдэж авна.

Юун түрүүнд та хэнд бүтээгдэхүүн үйлчилгээгээ зориулж буйгаа тодорхойлох нь хамгийн чухал. Ингэснээр зорилтот үйлчлүүлэгчдээ татах боломжуудаа гаргаж чадна.



Аялал жуулчлалын зах зээлд төрөл бүрийн сегмент байдаг. Жуулчдыг газар зүйн байрлалаар буюу хаанаас ирсэн, нас, хүйсээр, орлогын хэмжээгээр, тусгай сонирхол, хобби болон адал явдалт аяллын зорилго зэргээр ангилж авч үздэг.



Өөрийн үйлчлүүлэгчдийг ангилж үзвэл тэдний онцлогийг мэдэж тэдний хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, тохирсон үнэ тогтооход тус болно. Энэ нь танд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ амжилттай борлуулахад туслах юм.

Дараах шалгуураар жуулчдыг хэд хэдэн бүлэгт хувааж болно. Үүнд:

• **Газарзүй** – Жуулчин хаанаас ирснээс шалтгаалж тэдний хэрэгцээ янз бүр байдаг. Тухайлбал Улаанбаатар хотынхны хэрэглээ Ховдынхноос өөр байдаг шиг европ азиуд ч ялгаатай.

• **Хүн ам зүй** – Жуулчдын нас, хүйс, ажил мэргэжил, орлого, боловсрол, шашин шүтлэг гэх мэт зүйл орно.

• **Хандлага, төлөвшил, аяллын сонирхол** – Жуулчдын мэдлэг, хандлага, сонирхол, хүлээлт нь өөр өөр байдаг.

Өмнө дурдсанчлан байгаль орчин, нийгмийн асуудалд хариуцлагатай ханддаг аялагчдын тоо улам бүр нэмэгдэж байгаа билээ. Тэд "экотуризм" сонирхож, өөрсдийгөө "хариуцлагатай аялагчид" гэж үздэг; мөн тэд байгаль хамгаалах үйлсийг дэмжихэд бэлэн байдаг. Жуулчид орон нутгийн соёл, амьдралын хэв маягийг сонирхож, хэрвээ би малчин байсан бол гэсэн үүднээс туршиж үзэхийг илүү хүсдэг.

Явган, дугуйн, морин аялал, онцгой адал явдалт аялал (экстрим аялал), уулын дугуйн аялал зэргийг сонирхдог хүмүүс байдаг. Харин зарим нь зураг авч, зэрлэг амьтан, шувуу ажиглаж, од харахыг илүүд үздэг. Зөвхөн авто хэрэгслээр бие даан аялж Монголыг хөндлөн гулд тойрох сонирхолтой хүмүүс байхад тогтсон маршрутаар тансаг буудал, жуулчны баазуудаар буудаллахыг илүүд үздэг жуулчид ч байна.

Жуулчдын төсөв, мөнгөний зарцуулалт

Жуулчид аяллаа орлого, хуримтлуулсан мөнгөндөө тохируулан янз бүрээр төлөвлөдөг. Хямд үнээр амрах хүсэлтэй нэгэн байхад дунд зэргийн үнэ төлж чаддаг нь бий. Зарим нь дээд зэрэглэлийн тансаг байранд, чанартай үйлчилгээ авахын тулд өндөр үнэ төлөхөд бэлэн байхад үнэ ихтэй онцгой сэтгэгдэл үлдээх арга хэмжээг сонирхдог нь ч бий.

Ихэнх гадаадын жуулчид тэтгэврийн насны хүмүүс байдаг. Тэд олон жил ажиллаж хуримтлуулсан мөнгөөрөө мөрөөдөж явсан газраа очиж үзэх боломжтой болсон байдаг. Энэ төрлийн жуулчид нүүдэлчдийн соёл, НИТАЖ-ын үйлчилгээг сонирхох нь түгээмэл.



Түүнчлэн боломжийн ажил хийдэг залуу, дунд насныхан ээлжийн амралтаараа аялах сонирхолтой бөгөөд бие дааж аялахыг илүүд үздэг. Бусад оронд эдгээр аялагчдыг “үүргэвчтэй аялагчид” гэдэг боловч энэ зах зээлийг тоолгүй өнгөрч болохгүй. Учир нь тэд зочид буудалд бага мөнгө төлдөг ч адал явдалт, туршлага судлах аялалд илүү их мөнгө зарцуулах хандлагатай байдаг.

Харин хямд өртгөөр аялахын тулд нутгийн айлд хоноод бага мөнгө төлдөг эсвэл мөнгө төлдөггүй буруу хандлагатай жуулчид байдаг. Тийм хүмүүсийг үүргэвчтэй аялагчид гэж нэрлэдэггүй. Аялал жуулчлал хөгжсөн оронд үүргэвчтэй аяллынхан мэдэгдэхүйц хувь нэмэр оруулдаг.

НИТАЖ-ын зорилтот зах зээл

Энэ хэсэгт НИТАЖ-ын зах зээлийг авч үзэхдээ жуулчдыг дараах газарзүйн байрлалаар ангилж үзлээ:

- **Орон нутгийн зах зээл буюу** аймаг, сум болон хөрш зэргэлдээ сумынхан
- **Үндэсний зах зээл буюу** Улаанбаатар болон холын аймгаас ирж буй дотоодын аялагчид
- **Олон улсын зах зээл буюу** манай оронд ирсэн гадаадын жуулчид

Орон нутгийн зах зээлээс хэрэглэгчдийг хэрхэн татах вэ?

Танай өрх, хот айл НИТАЖ-ын үйлчилгээ эрхэлж буй гэдгээ бусдад мэдэгдэх нь чухал байдаг. Тухайлбал Баянхонгор аймгийн, Бөмбөгөр сумын Галуут баг, Хайрхан уулын ар бэлийн Балдангийн хот айл жуулчид хүлээж авч байна гэсэн зар мэдээ нутгийнханд дуулгах.

Хаяг, байршил, үйлчилгээгээ олонд түгээж чадвал аялагчид урьдчилан мэдээлэл авч танайхыг зорино. Ингэж чадвал та өөрт хамгийн ойр зах зээлтэй холбогдож чадна.

Малчдын хувьд нүүдлийн мал аж ахуй, амьдралын хэв маягаас шалтгаалаад тогтсон нэг байршилд байх боломжгүй.

Иймд тухайн үеийн хаяг байршлаа мэдээлэх, холбоо барих гар утас, суурин утасныхаа дугаарыг аль болох солихгүй байх, сольсон ч сурталчилгаа мэдээлэл, фейсбүүк, нийгмийн сүлжээндээ тухай бүрд нь шинэчлэн оруулж байх нь чухал. Мөн технологи хурдтай хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд What3words гэдэг аппликэйшний тусламжтайгаар өөрсдийн байгаа хаяг, байршлаа ЖиПиЭс (GPS)-ийн солбилцлоор нь олох, зарлах боломжтой болсон.

Энэ үйлчилгээг ашиглан Хөвсгөлийн тайгад амьдардаг цаачин айл гадаадын жуулчдыг хүлээн авдаг туршлага бий.



Орон нутгийн хэрэглэгчдэд хүрэх сувгууд:



- Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, аймгийн аялал жуулчлалын вэб сайтуудад мэдээллээ байршуулж, шинэчилж байх
- Орон нутгийн хурал цуглааны үеэр хэвлэмэл мэдээлэл тараах
- Орон нутгийн баяр наадам зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр өөрсдийн үйл ажиллагааны тухай самбар байршуулж зарлах
- Зорилтот хэрэглэгчээсээ хамаарч бага, дунд, ахлах сургуулийн багш, сурагчдад хандсан үйлчилгээ, аялал санал болгох, танилцуулга яриа зохион байгуулах
- Албан байгууллага, хамт олонд зориулсан амралтын өдрийн аяллын хөтөлбөр санал болгох
- Танилын хүрээгээ ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлах
- Хэрэглэгчдийн сэтгэгдлийг ашиглаж шинэ хэрэглэгч олох. Танайд ирээд явсан жуулчин танай үйлчилгээний тухай ам дамжуулан ярих нь хамгийн сайн сурталчилгаа юм.

НИТАЖ нь өөрсдийн фейсбүүк хуудастай болж, мэдээллээ шинэчилж байх нь чухал.

Дараах мэдээллийг багтаах хэрэгтэй:

- Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, төрөл – зургаар үзүүлэх
- Үйлчилгээгээ үзүүлж эхэлсэн огноо
- Танайх руу очих газрын зураг – Гүүгл газрын зураг (Google map) дээр тэмдэглэх
- Холбоо барих мэдээлэл
- Сэтгэл хангалуун буцсан жуулчдын сэтгэгдэл
- Гоё сайхан зургууд

Фейсбүүк хуудсаа тогтмол шинэчилж бай! Боломж гарвал шинэ мэдээлэл тавиарай.



Дотоодын зах зээл буюу УБ хот, аймгуудын хэрэглэгчдэд хэрхэн хүрэх вэ?

2020 онд гарсан дэлхий нийтийг хамарсан цар тахлаас болж олон орон хилээ хаасантай холбогдуулан дотоодын аялал идэвхжсэн. Энэ үеэс эхлэн манай оронд дотоодын аялагчдын тоо эрс өссөн ч Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс хийсэн судалгаанаас харвал дийлэнх аялагчид өөрсдөө маршрутаа гарган хувийн унаа, майхантай, өөрсдөө хоолоо хийн аялах хандлагатай байна. Тиймээс дотоодын аялагчдыг татахдаа дараах сувгуудыг ашиглавал үр дүнтэй.



- Олон нийтийн цахим сүлжээг ашиглаарай. Фейсбүүк, Инстаграм нь үйлчилгээ, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ сурталчлах хамгийн хямд арга. Манай улсад фейсбүүк ашигладаг хэрэглэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. Цаашлаад та фейсбүүкийн бизнесийн хуудас нээснээр төлбөртэй зар сурталчилгаа явуулах боломжтой. Үйлчлүүлэгчдээсээ сэтгэгдлээ хуваалцахыг уриалаарай.
- Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын холбооны цахим хуудсуудыг ашиглан мэдээллээ идэвхтэй түгээгээрэй. Сүүлийн жилүүдэд аймгийн аялал жуулчлалын холбоодын үйл ажиллагаа идэвхжиж, бүх аймаг аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн сантай, цахим хуудастай, хэвлэмэл каталог зэргийг хийж тараадаг болсон. Мөн аймгуудын Иргэдийн хурал, ЗДТГ-ын үйл ажиллагааг мэдээлдэг цахим хуудсууд идэвхтэй ажилладаг. Тэдгээрийг ашиглан өөрийн НИТАЖ-ын үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлах боломжтой. Аймгийн аялал жуулчлалын холбоодын холбоо барих мэдээллийг Хавсралт 7-д орууллаа.



Аймгийн аялал жуулчлалын холбоо

Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын холбоод нь бүс нутгийн аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, дуу хоолойгоо нэгтгэж, төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг.

Аймгийнхаа Аялал жуулчлалын холбооны гишүүн болсноор тур операторуудтай холбогдох, аялал жуулчлалын мэдээлэл авах, санхүүгийн эрх ашгаа хамгаалахад дэмжлэг авах давуу талтай. Холбооны гишүүн болохоосоо өмнө холбооныхоо зорилго, удирдах зөвлөлийн гишүүд, мөрийн хөтөлбөр, хийсэн ажил, тайлантай нь танилцаарай. Тэрчлэн холбооны дарга болон хэд хэдэн гишүүнтэй ярилцаж дараа нь гишүүн болох эсэхээ шийдээрэй.

- Дотоодын аялагчид www.JoinMe.mn цахим хуудсыг ашигладаг болсон. Энэхүү цахим хуудсанд 21 аймгийн үзэсгэлэнт газрууд, аяллын маршрут зэрэг дотоодын аялалтай холбоотой мэдээлэл багтсан. Та энэ вэб сайтад мэдээллээ байршуулж аялагчид тантай холбогдох боломжтой.
- Монголд амьдардаг гадаадынхан буюу олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, элчин сайдын яаманд ажилладаг гадаад хүмүүсийг хүлээн авах боломж их байдаг. Тэд НИТАЖ-ын үйл ажиллагааг дэмжиж, жинхэнэ Монгол ахуйг үзэх сонирхол ихтэй. Иймээс тэдэнд хандсан и-мэйл илгээж албан захидлаар дамжуулан өөрсдийн үйлчилгээг таниулах боломжтой. Мөн Монгол дахь гадаадын иргэдийн нэгдсэн цахим сүлжээнүүдэд холбогдож мэдээллээ байршуулж болно. Төлбөртэй эсэхийг лавлаарай.
- Улаанбаатар хотноо жил бүрийн 5-р сард зохион байгуулагддаг дотоодын аяллын "Улаанбаатар экспо", 10-р сард "Ай Ти Эм (ITM - International Travel Market)" үзэсгэлэн яармагт оролцоорой. Өөрсдөө оролцох боломжгүй бол аймгийнхаа аялал жуулчлалын мэргэжилтнээр эвсэл үзэсгэлэнд оролцож буй өөр хүнээр дамжуулж мэдээлэл тарааж болно.
- Та аймгийнхаа бусад НИТАЖ эрхлэгч нартай нэгдэж, танилцуулгаа хамтран хийж болно. Танай аймгийн Аялал жуулчлалын хэлтэс, Аялал жуулчлалын холбооноос дэмжлэг авч болохыг асуугаарай.



Олон улсын зах зээл буюу гадаадын жуулчдад хүрэх

Гадаадын жуулчид манай орныг хэд хэдэн шалтгаанаар зорин ирдэг. Зарим жуулчид найз нөхөд, төрөл төрөгсөдтэйгөө уулзах эсвэл албан ажил, хурал цуглаанд оролцохоор ирдэг ч манай орны үзэсгэлэнт байгаль, нүүдлийн соёлтой танилцахыг хүсдэг.

Гадаад жуулчид хэд хэдэн маршрут сонгож аялахдаа ганцаараа эсхүл найз, гэр бүлээрээ бүлэг болж ирдэг. Ихэнх нь аяллын компаниар дамжуулан багц аяллыг сонгон үйлчлүүлдэг. Багц аялалд унаа, байр, хоол, хөтчийн төлбөр, үзвэр үйлчилгээ, малчин айлд зочлох ч багтсан байдаг. Зарим нь янз бүрийн тээврийн хэрэгсэл ашиглан, өөрийн сонирхолд нийцүүлэн аялдаг бие даасан аялагчид байдаг.

1.Багц аяллаар аялдаг жуулчид

Монгол улсад бүртгэлтэй 571 тур оператор байдгаас гадаадын хөрөнгө оруулалттай цөөн тур операторууд байдаг. Монголд ажилладаг тур операторууд ихэвчлэн гадаадын аялал жуулчлалын агентуудтай хамтран ажилладаг.

Тур оператор бүр тодорхой хэдэн улсаар дагнаж хэрэглэгчдээ татдаг. Тухайлбал нэг тур оператор зөвхөн Герман жуулчдыг хүлээж авдаг бол өөр нэг нь зөвхөн Солонгосын зах зээлд чиглэсэн байж болно. Зарим тур оператор нь зөвхөн морь унах аялал санал болгодог бол зарим нь зэрлэг амьтад үзэх эсхүл гэрэл зургийн аялалд мэргэшсэн байдаг.



Аялал жуулчлалын компаниуд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож эх орноо сурталчилдаг. Гэхдээ энэ төрлийн үзэсгэлэнд оролцох нь өртөг өндөр учир хамтран оролцдог. Тур операторуудын хувьд ч зах зээлийн хамгийн сайн суваг бол вэб хуудас, фейсбүүк, инстаграм зэрэг олон нийтийн сүлжээ юм.




Тур оператор нь танай НИТАЖ-ын үйлчилгээг аяллын багцдаа оруулж хамтран ажилласнаар жуулчид танайд ирэх маш сайхан боломж бүрдэнэ. Харин та жуулчин хүлээн авах бэлтгэлээ бүрэн хангасан байх хэрэгтэй. Тур оператортай тохиролцсоны дагуу ямар ч үед таны үйлчилгээ үргэлж чанартай байхад анхаарч ажиллаарай.

Тур операторын хувьд танайх руу жуулчдыг илгээх нь танд өндөр итгэл найдвар хүлээлгэснийг илэрхийлж байна. Туроператорууд үйлчлүүлэгчдээ хүрэхийн тулд маркетингийн зардалд их мөнгө зарцуулж цахим хуудсаараа дамжуулан жуулчдад гайхалтай аяллыг амладаг. Иймээс жуулчид танайд ирж сайхан үйлчлүүлсэн бол зөвхөн танд ч төдийгүй тур операторуудад эергээр нөлөөлдөг. Тиймээс тур операторууд хамтран ажилладаг НИТАЖ-ын гишүүдэд сургалт явуулж тэднийг дадлагажуулдаг.

Танай НИТАЖ тур операторуудын аяллын багцад багтахын тулд бусдаасаа өөр, онцлог үйлчилгээг санал болгох хэрэгтэй. Гэрт байрлуулж, морь тэмээ унуулаад зогсохгүй нүүдэлчин ахуйдаа татан оролцуулж Монгол дээл, хатгамал хийх, сур элдэх зэрэг үйлчилгээг санал болговол сонирхлыг нь татна. Та өдөр тутам хийдэг нутгийнхаа уламжлалт зан үйлээрээ арвижуулан бүтээлчээр сэтгэж ажиллаарай.

Та тур операторуудтай байнгын холбоотой байж мэдээлэл авч байр, хоол, үйл ажиллагаагаа төлөвлөөрэй.



2. Бие даан аялагчид

Зарим аялагчид бүлгээр аялахаас илүү ганцаар бие даан аялахыг илүүд үздэг. Монголд аялж байгаа гадаадын жуулчдын 60 гаруй хувийг бие даан аялагчид бүрдүүлдэг гэсэн судалгаа бий. Тэд ядуу учраас биш харин адал явдал, сониуч зандаа хөтлөгдөн аялдаг. Тэд Трип Эдвайзор (Trip Advisor), Эйр Би Н Би (AirBnB) зэрэг олон улсын түгээмэл платформууд дээр явсан газрын сонин, сэтгэгдлээ хуваалцах нь элбэг.

Тэдний ихэнх нь өөртэйгөө адил бие даан аялагчдын бичсэн сэтгэгдэл, нийтлэл, блог зэргийг уншиж явах газраа сонгодог. Иймд танайд ирсэн аялагчид өөрсдийн туршлага, зураг, цахим бичвэр зэргийг блог, нийгмийн сүлжээнд оруулж хуваалцдаг учраас тэднийг сэтгэгдлээ үлдээхийг хүсээрэй.

**Танд тохиолдож болзошгүй бэрхшээл ба шийдэл**

Та аялал жуулчлалын салбарт анхлан хөл тавьсан, туршлагагүй, гадаад хэлний мэдлэг тааруу учраас зах зээлд шууд хүрэх боломжгүй байж болно. Дараах хүснэгтэд тохиолдож бэрхшээлийг даван туулах зөвлөмжийг санал болголоо.

| Бэрхшээл | Боломжит шийдэл |
|---|--|
| Алслагдсан нутагт амьдардаг бол | Дотоод, гадаадын зочдод зориулан өвөрмөц соёл, уламжлал, байгалийн тогтоц дээр тулгуурлан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бий болгоорой. |
| Замын тэмдэг, самбаргүй бол | Та мод, чулуу гэх мэт гарын доорх материалыг ашиглаж бүтээлч самбар хийх боломжтой. Стандарт тэмдэгтэй болох талаар орон нутгийн засаг захиргаатай ярилцаарай. ЖиПиЭс (GPS), Гүүгл газрын зураг (Google map) зэрэг орчин үеийн технологийг ашиглаарай. Гүүгл газрын зураг (Google map)-ийг хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзээрэй. Мэдээлэл өөрчлөгдсөн даруйд нь холбоо барих мэдээлэл, байршил, утасны дугаараа шинэчлээрэй. |
| Бүтээгдэхүүн үйлчилгээ тань танигдаагүй бол | Чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангаарай. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлахын тулд дээр дурдсан бүх сувгийг ашиглаарай. Сайн төлөвлөсөн, тогтмол чанартай үйлчилгээ нь таныг таниулна. |
| НИТАЖ эрхлэх туршлага хомс бол | Үйл ажиллагаагаа амжилттай хөгжүүлэх тусам туршлагажна. Сургалтын хэрэгцээгээ тодорхойлж төлөвлөгөө гарган сургалтад хамрагдаарай. Аймгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүд, Аялал жуулчлалын холбооноос зөвлөгөө, дэмжлэг аваарай. |
| Гадаад хэлний мэдлэг дутмаг бол | Утасны апп, онлайн сургалт, гадаад хэлээр кино үзэж бие даан сурч болно. Гишүүдээ гадаад хэлний сургалтад хамруулж хэлний мэдлэгийг дээшлүүлээрэй. Хамтран ажилладаг тур операторуудаасаа дэмжлэг аваарай. |



Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тогтоох

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнээ зөв тогтоох нь чухал бөгөөд нэр төрөл, зорилтот үйлчлүүлэгчээ харгалзаж үзнэ. Бусад НИТАЖ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг харж баримжаа авч болно. Таны үнэ зах зээлд өрсөлдөхүйц, худалдан авагчдад боломжийн, танд ашигтай байх ёстой. Ингэхийн тулд үйлчилгээ тань өвөрмөц онцгой байх хэрэгтэй гэдгийг санаарай.

Үнэ тодорхойлохын тулд та хүнс, материал, түлш, төлбөр, зарцуулсан цаг хугацаа, цахилгаан гэх мэт зардлаа тооцоолж дээр нь ашгаа нэмнэ.

Үнэ бага байхын хэрээр өрсөлдөх чадвар дээшилнэ гэж үзвэл алдаа болдог. Энэ нь таныг хямдхан харагдуулж, үйлчлүүлэгчид таны үйлчилгээг үнэлж үзэхгүйд хүргэж болно. Чанартай, өвөрмөц бүтээгдэхүүн, үйлчилгээндээ тохирсон үнэ тогтоовол зөв стратеги болно. Аялагчид таны үзүүлж буй үйлчилгээний үнэ цэнэ, өвөрмөц байдлыг ойлгоод дуртайяа төлбөрөө төлнө.

Мэдээж хэрэг үндэслэлгүй өндөр үнэ тогтоож болохгүй. Ямар ч бизнест анхны хөрөнгө оруулалтаа нөхөхөд тодорхой хугацаа шаардагдана. Энэ бол бизнесийн жам. Харин та ажлаа чанарын өндөр түвшинд хийж, маркетингийн суваг бий болгож чадсан бол таны НИТАЖ-ын үйл ажиллагааны хэтийн төлөв амжилттай байх болно. Хэрэв та хөрөнгө оруулалтын зардлаа нөхөж чадахгүй, хэдэн жилийн дараа ч ашиг олж чадахгүй байгаа бол бүтээгдэхүүн, үйлчилгээгээ эргэн харах хэрэгтэй.

Монголын аялал жуулчлал хэт улирлын чанартай байдаг нь үнэ тогтооход нөлөөлдөг. Аялал жуулчлалын идэвхтэй үеийг 6-аас 10 сар хүртэл байдаг бол оргил үе нь 7, 8-аар сарууд юм. Аялал жуулчлалын улирлыг уртасгахын тулд өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, баяр наадмыг зохиодог болсон. Ихэнх жуулчид оргил үеэр ирдэг учир эдгээр саруудад бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ хамгийн өндөр байдаг. Бусад цагт аялагчдыг татахын тулд хямдрал зарлаж болно.

Багц үнийн санал нь үргэлж оновчтой байдаг. Энэ нь үйлчлүүлэгчдэд нэг үнэ төлөөд маш олон үйлчилгээ авч буй сэтгэгдэл төрүүлдэг. Тухайлбал байр, хоол, морь унах гэх мэт үйлчилгээг оролцуулж багц үнэ зохиож болно. Багц үнэ боловсруулахдаа оновчтой, бүтээлчээр хандаарай.



Та бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулах маркетингийн хамгийн сайн сувгийг олох хэрэгтэй. Давуу ба сул талуудыг нь судалж өөрт тохирох стратегийг сонгоорой.

НИТАЖ эрхлэгчид ихэвчлэн тур оператораар дамжуулан гадаадын аялагчдыг авахдаа зах зээлийн ханшид тохирсон үнийг тооцож үзсэнээр тантай гэрээ байгуулдаг. Энэ нь танд илүү ашигтай, өөрөө сурталчилгаа хийж цаг алдахгүй, зардал багатай байна.

Төлбөрийн нөхцөл

Та тур оператораар дамжуулсан ч, шууд зочин хүлээн авсан аль ч тохиолдолд төлбөрийн нөхцөл тодорхой, шударга байх ёстой. Тур оператортай гэрээ байгуулахдаа хоёр талын үүрэг хариуцлага болон төлбөрийн нөхцөлийг тодорхой тусгах хэрэгтэй.

Тур оператор, хувь хүнтэй хамтран ажиллах гэрээ байгуулахаасаа өмнө тэдний талаар сайн судалж үзээрэй. Гэрээ хийхдээ урьдчилгаа төлбөр (20-30%) авах тохиролцоо хийвэл сайн. Ингэснээр та бэлтгэл ажил хийх мөнгөтэй болохоос гадна жуулчид ирэх нь тодорхой болж, дараа нь төлбөрөө гүйцээж авах баталгаатай болно.

Санхүүгийн төлөвлөлт ба менежмент

Орлого, зарлагаа зөв, тогтмол тооцож сурах хэрэгтэй ба ингэснээр үнэ болон бизнес загвараа нягталж, өөрчлөх боломжтой болно. Орлого, зардлаа жилийн турш хянаж, ашгаа сайн тооцоолоорой.

Санхүүгийн бүртгэл хөтлөх нь бизнес хөгжүүлж менежмент хийхэд тустайгаас гадна тайлан хөтөлж, татвар төлөхөд хэрэгтэй. НИТАЖ-ыг амжилттай эрхэлснээр та татвараа төлж, нийгэмд хувь нэмэр оруулдаг хариуцлагатай бизнес эрхлэгч иргэн болох болно. *Бизнесийн тухай мэдээллийг 10-аар хэсгээс хараарай.*



ХЭСЭГ 7. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

Зочдод зориулж хамгийн багадаа гурван гэр, тохижуулалт, гал тогооны гэр, бие засах газар, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах гэх мэт зохион байгуулалтад хөрөнгийн эх үүсвэр хэрэгтэй болно. Тэр бүү хэл морь унуулах, морин аялал хийхэд зориулж тоног хэрэгслээ сайжруулах ч хэрэг гарна. Мэдээж энэ бүхнийг эхнээс нь шат дараалалтайгаар өргөжүүлэх нь зүйтэй.





Орон нутагт өрхийн хэрэглээнээс гадна гэнэтийн зүйл тохиолдох үед эсвэл бизнесийн жижиг зээл авахад бизнес төлөвлөгөө, барьцаа хөрөнгө гэх мэт зүйлсийг шаарддаг учир амаргүй байдгийг та бүхэн мэдэж байгаа. Тэрчлэн эргэн төлөлтийн нөхцөлийг хангах хүү өндөр, хугацаа богино зээл бол бүр ч ярвигтай.

Аялал жуулчлалын улирал богино учир НИТАЖ эрхлэгчид жилийн дөрвөн улиралд тогтмол орлого олох боломжгүй. НИТАЖ-н үйл ажиллагааг явуулах сонирхолтой болон эрхэлж буй нутгийн иргэд голдуу мал аж ахуй болон бусад эх үүсвэрээс үндсэн орлогоо олдог нь банкны зээл авахад баталгаат орлого болж чаддаггүй.

Гэсэн хэдий ч төлөвлөсөн ажлаа гүйцэлдүүлэхэд өөр олон арга байгаа гэдгийг санаарай. Санхүүгийн эх үүсвэр хайх явцад таны үйл ажиллагаанаас олох орлого, зарлагыг бодитоор боловсруулсан төлөвлөгөө хамгийн чухал. Энэ нь дан ганц санхүүгийн эх үүсвэр хайхад бус таны цаашдын НИТАЖ эрхлэх үйл ажиллагаанд тустай.

Өөрсдийн нөөц боломжоо дайчлах

НИТАЖ-ыг эхлүүлэхдээ жижиг зүйлээс эхлэн түүнийгээ өөрсдийн боломжоор санхүүжүүлэхийг хичээгээрэй. Та мал маллахаас гадна ногоо тарих, зөгий үржүүлэх зэрэг аж ахуй эрхэлдэг үү? Тийм бол энэ орлогоос аялал жуулчлал эрхлэхэд зориулж болохоос гадна ирсэн зочдод аж ахуйгаа танилцуулбал сонирхолтой байдаг. НИТАЖ-ын үйл ажиллагааг өөрийн хөрөнгө, гишүүдийн дэмжлэгтэйгээр эхэлж аажмаар тэлэх нь өр ширнээс зайлсхийх хамгийн сайн арга.




Хэрэв танд итгэл найдвартай хамтран ажилладаг тур оператор байдаг бол төлбөрөө боломжтой үедээ хийх нөхцөлтэйгөөр шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, материалаа авч болно.



Дундын сан

Санхүүгийн эх үүсвэр олох дараагийн нэг боломжит хувилбар бол нөхөрлөлийн дундын сан. Бүлэг, нөхөрлөлийн дундын сантай байх нь нутгийн иргэдийн байгууллагын амжилтын гол үндэс бөгөөд байгаль хамгаалах нөхөрлөл, ойн нөхөрлөл, БАХ дундын сантай байх нь нийтлэг болжээ. Дундын сангаа захиран зарцуулах дүрмийг бүх гишүүдийн оролцоотой, ил тод нээлттэй хэлэлцэж байж шийдэх нь хамгийн чухал. Нөхөрлөлийн нэг гишүүнийг сангийн менежерээр томилж, ахлагч, удирдах зөвлөлтэйгөө хамтран ажиллах талаар тохирох хэрэгтэй байдаг. Дундын сангаа тогтмол хянаж, бүх гишүүддээ тайлагнаж байх нь зүйтэй.

Дундын сан бол эргэлтийн сан. Гишүүд мал эсвэл бэлэн мөнгө хандивлан дундын сан үүсгэдэг. Гишүүдэд зээл олгох гэх мэт сангийн зарцуулалтын журмыг бүх гишүүдтэй хамтран тогтооно. Дундын санг ихэвчлэн нөхөрлөлийн байгаль хамгаалах үйл ажиллагаа болон гишүүдэд зээл өгөхөд зориулж байна.



Дундын сан байгуулж, амжилттай зохицуулснаар гишүүдийн дундах итгэлцэл сайжирч, нөхөрлөл дотроосоо улам бэхжиж байдаг. Тухайлбал яаралтай үед гишүүддээ хандив өгч, амьдрал ахуй тааруу нэгэндээ тусалдаг. Нөхөрлөлийн дундын сангийн жишээ дүрмийг Хавсралт 9-д оруулав.

Хэрвээ нөхөрлөлийн бүх гишүүд хамтран НИТАЖ эрхлэхээр шийдсэн бол дундын сангаасаа төсөвлөж гэр, бусад хэрэглэгдэх тоног төхөөрөмжөө авч болно. Танай нутгийн байгаль, онцлог газрууд, түүх соёлын дурсгалт газрууд, зэрлэг амьтанд жуулчид татагдан ирдэг тул унаган хэвээр нь хамгаалж хадгалснаар аялал жуулчлалын үйл ажиллагаа тань тогтвортой явагдана.

НИТАЖ-аас олсон ашгаа дундын сандаа хуримтлуулна. Жишээлбэл Тайландад дараах практик тогтсон байдаг. НИТАЖ эрхэлдэг бүлэг, нөхөрлөлүүд аялал жуулчлалын орлогынхоо тодорхой хувийг санд байршуулдаг. Санд хуримтлагдсан мөнгөөр жуулчдын хоол хүнс, хөтчийн



цалин, утас, хурал уулзалт, нягтлан бодох бүртгэл гэх мэтийн зардалд хуваарилахаас гадна орон нутгийнхаа нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, байгаль орчныг хамгаалах зэрэгт тодорхой хувийг зарцуулдаг.

Орон нутгийн хөгжлийн санд хандах

Санхүүгийн өөр нэг боломжит эх үүсвэр нь танай сумын орон нутгийн хөгжлийн сан байж болно. ОНХС-ийн зорилго нь орон нутгийн иргэдийн гаргасан тогтвортой хөгжлийн санаачилгыг дэмжихэд оршино. Тус сангийн зарцуулалтыг иргэдийн оролцоотой шийдвэрлэдэг. Шийдвэр гаргах үе шаттай танилцана уу.





Алхам 1: Иргэд саналаа өгөхдөө дараах 3 хэлбэрийн аль нэгээр оруулна

а/ Жил бүрийн 1-ээс 5-р сарын хооронд иргэд саналаа багийн даргад өгөгдсөн маягтын дагуу бичгээр хүлээлгэн өгөх.

б/ Сумын иргэдийн хэсэгчилсэн хурлаар орон нутгийн хөгжлийн сангийн жилийн зарцуулалтын тухай санал оруулах.

в/ Цахимаар санал өгөх <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/>

Алхам 2: Ирүүлсэн саналуудыг эрэмбэлэх олон нийтийн хэлэлцүүлэг Жил бүрийн 5-р сарын 31-ээс өмнө зохиогдох Сумын иргэдийн нийтийн хуралд та уригдах ёстой. Энэ хурлаар таны болон бусад иргэдээс ирүүлсэн саналуудыг хамтран хэлэлцэж эрэмбэлнэ.

Алхам 3: Эрэмбэлсэн саналуудыг Сумын ОНХС-ийн ажлын хэсэгт хүргүүлнэ.

Алхам 4: Тэргүүлэх саналуудыг сумын ИТХ-р батлуулж Засаг дарга нэгдсэн жагсаалтыг сум/дүүргийн ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ. Сумын ИТХ нэгдсэн жагсаалтыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн батална.

Алхам 5: Засгийн газраас сумд санхүүжилт хуваарилах Батлагдсан ажлуудыг гүйцэтгэх төсвийг засгийн газраас намар хуваарилна.

ОНХСангийн албан ёсны цахим хуудсаас QR CODE-ыг уншуулж мэдээлэл авна уу.



Орон нутгийн хөгжлийн сан гэж юу вэ?
QR CODE-р орж мэдээллийг үзнэ үү.



Жижиг дунд үйлдвэрлэлийн санд хандах

Монгол Улсын Засгийн Газраас жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд банкны хүүгээс доогуур хүүтэй зээл олгох зорилгоор ЖДҮ-ийг хөгжүүлэх сан байгуулсан юм. ЖДҮСанг аймгийн төвшинд удирдан зохицуулдаг. Санд хүсэлт гаргахын тулд нарийвчлан боловсруулсан бизнес төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Энэ сангаас зээл авах тухай дэлгэрэнгүй мэдээллийг аймаг, сумын ЖДҮ хариуцсан мэргэжилтнээс авч болно. Та өөрөө бизнесийн туршлагагүй бол бизнес төлөвлөгөө боловсруулах, санд өргөдөл гаргах, шаардлагатай материалуудыг хүргүүлэх талаар энэ чиглэлээр ажилладаг төрийн болон ТББ-ын мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах хэрэгтэй. *Мөн гарын авлагын 5-р хэсгээс бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийг хараарай.* Тэрчлэн зарим төсөл хөтөлбөр тус сангаас хэрхэн санхүүжилт авах талаар зөвлөдөг.

Хоршоо

Үйлдвэрлэл, борлуулалт эрхэлдэг хоршоо

1990 оноос хойш орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хоршоодыг байгуулахад олон саад бэрхшээл тулгарч ирсэн. Социализмын дараагаар хамтран үйл ажиллагаа явуулахаас хүмүүс хойш сууж, хоорондын итгэлцэл сул болсон. Тиймээс ч ихэнх хоршоо санхүү, ил тод байдал, орлого хуваах зэрэг асуудлаас болж тарж бутарсан. Харин өнөөдөр малчид хамтран хүчээ нэгтгэн өрхийн орлогоо нэмэгдүүлэх, үндэсний эдийн засагт тогтвортой хувь нэмэр оруулах зорилгоор мал аж ахуйд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт явуулахын ашиг тусыг бүрэн ойлгодог болжээ.

МАА салбарын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж буй хоршоодыг дэмжиж 2021 онд Хоршооны тухай хуулийг шинэчилсэн. Шинэ хуулиар хоршооны өөрийн хөрөнгийг хуулиар тодорхойлж зээл авахад барьцаа болж чаддаг болгосон. Тэрчлэн хоршоо дундын сан байгуулж, гишүүддээ бага хүүтэй зээл олгох явдал элбэг байдаг. Хоршоо нэмүү өртгийн татвараас чөлөөлөгддөг.

Та болон танай нөхөрлөл, БАХ-ын гишүүд хоршоонд нэгдсэн эсвэл хамтаараа хоршоо болохоор ярилцаж байгаа бол дэлгэрэнгүй мэдээллийг сумынхаа ЖДҮ, Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнээс аваарай. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо (МХААХХ)-той холбогдож мэдээлэл авахаас гадна, тус холбооноос зохион байгуулдаг олон төрлийн сургалтанд хамрагдаж болно.



МХААХХ-ны мэдээллийг QR CODE-оор орж авна уу.



Хадгаламж Зээлийн Хоршоо

Баян-Өлгий, Ховд зэрэг аймагт үлгэр жишээ ажиллаж байгаа хадгаламж зээлийн хоршоо олон байдгийг та бүхэн мэдэх байх. Тэд зохион байгуулалт сайтай ажилласнаар санхүүгийн хувьд өргөжин тэлж, тэр ч бүү хэл суман дахь арилжааны банкнуудаас илүү хадгаламжтай болсон байна. Тухайлбал, Ховд аймгийн Дарви сумын хадгаламж зээлийн хоршоо амжилттай ажиллаж, сумын иргэдэд жижиг зээл өгдөг, суман дахь ХААН банкны хадгаламжийн хэмжээг даваад байна.

Хандивлагч байгууллага, төсөл хөтөлбөрт хамрагдах

Төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагын төслийн хүрээнд жижиг зээлээс гадна буцалтгүй тусламж авах боломж ч байдаг. Заримдаа элчин сайдын яамд тогтмол хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөртэй байдгаас гадна цаг үеийн шаардлагаар төсөл зарладаг. Жишээ нь, Канадын элчин сайдын яам Канад сан байгуулан олон жил ажиллаж байгаа бөгөөд нутгийн иргэдийн санаачилсан төсөл хөтөлбөр, аж ахуй нэгжийг дэмжиж ажиллаж байна. Элчин сайдын яамдын холбоо барих мэдээллийг Хавсралт 10-т оруулав.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, байгаль хамгаалал, аялал жуулчлал, ялангуяа НИТАЖ-ыг хөгжүүлэх зорилгоор хэрэгждэг төсөл хөтөлбөрүүд сургалт хийхээс гадна зээл, тусламж өгдөг байж болно. Жишээ нь, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй SPACES²⁶ төслөөс энэхүү гарын авлагыг боловсруулахад дэмжин ажиллаж байна:

Төсөл хөтөлбөр, хандивлагч байгууллага, олон улсын болон үндэсний ТББ нь бизнес төлөвлөгөө боловсруулах, зээлийн материал бэлдэх энэ чиглэлийн сургалтад хамруулах дэмжлэг үзүүлэх боломжтой байдаг. Төсөл хөтөлбөрүүд дуусаж мэдээлэл хуучирдаг учир холбогдох хаягийг оруулаагүй болно. Харин энэ талаар санаачилга гарган сум орон нутгаасаа асууж, бусад байгууллагатай холбоо тогтоон хамтран ажиллаарай.

²⁶Supporting Protected Areas for the Conservation of Ecosystem Services project, GIZ—"Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь" (SPACES) төсөл.



ХЭСЭГ 8. ГАЗАР АШИГЛАХ, ЭЗЭМШИХ ЭРХИЙГ ОЙЛГОЖ МЭДЭХ, ГАЗРЫН ЭРХ БАТАЛГААЖУУЛАХ

НИТАЖ-ын гэрбуудал байгуулж, үйл ажиллагаа явуулах газартай болохыг зорьж буй бол таны газар эдэлбэрийн эрх тодорхой, баталгаатай байвал сайн. Хэрвээ таны үйл ажиллагаа явуулах газрын ашиглах, эзэмших, өмчлөх эрх тодорхойгүй бол бизнесийн нарийн төлөвлөгөө хийхэд хүндрэлтэй. Тухайн газарт цаг зав, хүч хөдөлмөр, хөрөнгө зарцуулсны дараа тэндээ үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүрвэл тун хэцүү.





Мөн та гэр кэмп байгуулан, жуулчин авч, үйлчлүүлэгчтэй болж танигдаж эхлээд байтал өөр хүмүүс таны ойр хавьд нүүн ирж, барилга байгууламж барьж, орчныг бохирдуулж, байгалийн сайхан төрхийг эвдэн хүн амын бөөгнөрөл үүсвэл таны бизнес цаашид хөгжиж чадахгүйд хүрнэ. Энэ үед ганц та биш бүгдээрээ хохирно гэсэн үг.

Хамгаалалттай газар нутгийн ойр хавь

Аймаг, сум, ТХГН-ийн захиргаа нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах газрын зохицуулалт хийх учиртай. Үнэлгээ, судалгаанд үндэслэн аялал жуулчлалын хэмжээ, хугацаа, жуулчдын тоо, зөвшөөрөх, хориглох арга хэмжээ зэргийг тодорхойлно. Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг газар ашиглалт болон бусад холбогдох зөвшөөрлийн үндэслэл болгон ашиглах ёстой.

Манай оронд энэ бүхэн хөгжих шатандаа явж байна. Олон аймаг хөгжлийн стратеги, төлөвлөгөөндөө аялал жуулчлалыг тусган, зарим нь аялал жуулчлалын тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь тухайн газарт эдийн засгийн ямар үйл ажиллагаа тохиромжтойг харуулсан байдаг учир газар ашиглалтын төлөвлөлтийн журам, бусад холбогдох албан ёсны баримт бичгийг тус төлөвлөгөөнд үндэслэн хийх хэрэгтэй юм.

Хэрвээ та ТХГН-ийн орчны бүсэд амьдардаг бол орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд аялал жуулчлал хөгжүүлэх боломжуудын тухай орсон байх учиртай.

ТХГН-ийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулах зөвлөмжийг QR CODE-оор татаж авна уу.



Та орчны бүсэд амьдардаг бол НИТАЖ хөгжүүлэх боломж өндөр гэсэн үг. ТХГН-т аялахаар ирсэн жуулчдад хөтөч хийх, байрлуулах зэрэг үйл ажиллагаа явуулах боломжтой. ТХГН-ийн гадна амьдарч байгаа учир хязгаарлах зүйл ч бага.

Төлөвлөгөө гаргаж, кэмп байгуулж ажиллаж эхлэхээс өмнө орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, журамтай танилцаарай. Сумын Засаг даргад төлөвлөгөөгөө танилцуулж ямар зөвшөөрөл авах ёстой байдгийг асууж болно. Танай нутагт аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө байхгүй бол энэ талаар идэвхтэй ажил хийх хэрэгтэй.



Тэрчлэн аялал жуулчлалын тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд зохицуулалт сайн байх хэрэгтэй гэдгийг тэдэнд тайлбарлаж өгөөрэй. Нэг газар хэт бөөгнөрч, олон янзын аялал жуулчлал эрхлэх, ялангуяа, бүгд гэр буудал ажиллуулах зэрэг нэгэн ижил үйл ажиллагаа явуулах нь байгаль орчин болон бизнест сайнаар нөлөөлөхгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Аялал жуулчлалаар мэргэшсэн туршлагатай хүмүүсийг оролцуулан дэмжлэг аваарай.

Хамгаалалттай газар нутгийн дотор

Хэрвээ та ТХГН-т үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байгаа бол мэдээж дүрэм журам ихтэй, чанга хатуу байна. Учир нь ТХГН-ын эрх зүйн орчин нь ТХГН-ын тухай хуулиас гадна Үндсэн хууль, Газрын тухай хууль зэрэг холбогдох хууль журам, актуудын хүрээнд зохицуулагддаг. Эдгээр хууль, дүрэм журмыг ойлгоход ярвигтай байж болох юм.

Хамгаалалттай газар нутаг дахь газар ашиглалтын журамд орсон гол зүйлсийг холбогдох хуулийн заалтуудын дагуу тайлбарлалаа.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33.1 зааснаар *Дарханцаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно гэжээ. Зөвхөн газар ашиглах эрх үүсэх бөгөөд эзэмших, өмчлөх эрх үүсэхгүй.*

ТХГН-ийн бүсчлэлд зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг QR CODE-ыг уншуулж харна уу.





Газар ашиглах тухай хүсэлт гаргах алхмууд

Алхам 1. ТХГН-н захиргаа эсхүл сумын Засаг даргад хүсэлт гаргана

Тус хуулийн VII бүлгийн 35.1 зүйлд зааснаар Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 44-р зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргана.

Үйл ажиллагаа явуулахыг хүссэн хувь хүмүүс болон ААН-үүд үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадвар, татвар болон банкны өргүйг нотолсон баримт бичиг, тэрчлэн явуулах үйл ажиллагааныхаа тухай, ТХГН-ын менежментийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байгааг бичгээр тайлбарласан байх ёстой.

БОАЖЯ-ны албан ёсны цахим хуудасны бүрдүүлэх бичиг баримт хэсэгтэй QR CODE-оор орж танилцана уу.



Алхам 2. ТХГН-н захиргаа эсхүл сумын Засаг дарга хүсэлтийг БОАЖЯ-нд уламжилна

Тус хуулийн 35.2-т зааснаар Хамгаалалтын захиргаа эсхүл Засаг дарга нь газар ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт болон түүний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад (БОАЖЯ) уламжилна.

Алхам 3. БОАЖЯ шийдвэр гаргана

Энэ хуулийн 36-р зүйлд зааснаар Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.

Тухайн газрыг хоёр буюу түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ.

Аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар ашиглах тухай хүсэлтийн материаллаг баазыг олон улсын стандарт, түвшинд хүргэсэн байдлыг нь харгалзан сонголт хийнэ.



Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахаар хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлт нь шаардлага хангаагүй тохиолдолд Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар (ТХБНУГ) нь татгалзсан шалтгаан, үндэслэлийг тодорхой бичсэн албан тоотыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ажлын 15 хоногийн дотор явуулна.

Алхам 4. Газар ашиглагч, Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, сумын Засаг даргын гурвалсан гэрээ

БОАЖЯамнаас зөвшөөрөл олгогдмогц Тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаа, сум/дүүргийн Засаг дарга, газар ашиглагч нарын хоорондын гурвалсан гэрээний төсөл боловсруулна.

ТХГН-ийн тухай хуулийн 37-р зүйлд заасны дагуу гурвалсан гэрээнд дараах чухал зүйлсийг тусгана:

1. Тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;
2. Газрын төлбөрийн хэмжээ, нөхцөл;
3. Газар ашиглах, хамгаалах талуудын эрх, үүрэг, хариуцлага;
4. Гэрээ дуусгавар болж газрыг эргүүлж авах үеийн нөхөн сэргээлт, засаж сайжруулах, хүлээлгэн өгөх нөхцөл, журам.

Алхам 5. Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газраас газар ашиглах гэрчилгээ олгоно

Газар ашиглах зөвшөөрөл, гурвалсан гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн БОАЖЯ-нд байрлах ТХБНУГ-аас газар ашиглалтын гэрчилгээг олгоно.

Алхам 6. Гурвалсан гэрээг Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар батална

Газар ашиглалтын гэрчилгээ авснаас 3 сарын дотор иргэн, ТХГН-ийн захиргаа, орон нутаг гурвалсан гэрээг эцэслэн боловсруулж ТХБНУГ-аар батлуулна.

ТХБНУГ-ын албан ёсны цахим хуудастай
QR CODE-оор орж танилцана уу.





Хуулийн хэрэгжилт, бэрхшээлүүд

2022 онд хэрэгжиж байгаа хуулийн дагуу Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байх бөгөөд нэг удаа сунгах хугацаа мөн 5 жилээс илүүгүй байна. Энэ нь тур оператор болон НИТАЖ эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа 10 жилээр төлөвлөсний дараа газар ашиглах гэрээ сунгагдах боломжгүй гэсэн үг.

Харин газар ашиглах зөвшөөрлийг менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, Байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээ дээр үндэслэн тав таван жилээр үргэлжлүүлэн сунгаж явах нь зөв зүйтэй гэж үзэж байна.





ТХГН-ийн газар ашиглагчийн эрх үүрэг

Тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмшиж байгаа аливаа иргэн, аж ахуйн нэгж нь Газрын тухай хуулийн 45-р зүйлд заасан ерөнхий үүргүүдээс гадна дараах үүргийг хүлээдэг. Үүнд:

1. Тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх
2. Ашиглахаар авсан газартаа тогтоосон замаар орж, гарах
3. Хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах
4. Газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээж, засаж тохижуулан, сайжруулж хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх
5. Гадаад улсын хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн газар ашиглах эрх. ТХГН-ын хуулийн 33.2т зааснаар *Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид тусгай хамгаалалттай газар ашиглуулахыг хориглоно.*

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг


QR CODE-оор орж харна уу.



Газрын тухай хуультай QR code-оор орж танилцана уу.



Тусгай хамгаалалттай газар нутаг дотор газар ашиглах зөвшөөрөл авах үе шат





ХЭСЭГ 9. НИТАЖ ЭРХЛЭХ УР ЧАДВАРАА НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

НИТАЖ эрхлэхэд шаардагдах ур чадвар

НИТАЖ-г амжилттай хөгжүүлж, тогтвортой, аюулгүй үйл ажиллагаатай явуулахын тулд танд өргөн хүрээний олон талын ур чадвар хэрэгтэй болно. Зөвхөн аялал жуулчлал хэрхэн явагддаг, жуулчид юу хүсдэг, зах зээлд хэрхэн гарах, хамтын ажиллагааны тухай мэддэг байх нь хангалтгүй юм.





Танд санхүүгээ төлөвлөж тайлан гаргах, баг удирдах гэх мэт ур чадварууд хэрэгтэй болно. Таны харилцааны ур чадвар тур оператортай хамтарч ажиллахад нэн чухал.

НИТАЖ-ын багийн гишүүн бүрийн ур чадвар нь тогтмол чанартай үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлдөг. Танай хамт олныг бүрдүүлэхэд жолооч, засварчин, гэр кэмгийн менежер, үйлчлэгч, тогооч, хөтөч, бэлэг дурсгал урлаач зэрэг олон янзын мэргэжлийн ур чадвартай хүмүүс хэрэг болно. Хүн бүр хариуцаж авсан ажлаа хийхийн тулд өөрийн ур чадварыг хөгжүүлэх хэрэгтэй. Харин бүх гишүүд аюулгүй ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх, жуулчидтай харилцах тал дээр нэгдсэн ойлголт хандлага, ур чадвартай байх ёстой.

Орон нутгаа судалж танилцуулах

Хэдийгээр та орон нутагтаа олон жил амьдарсан байж болох ч нутгийнхаа экологи, зэрлэг амьтан, геологи, палеонтологи, түүх домгийн тухай мэдлэгээ нэмэгдүүлээрэй. Энэ нь мал аж ахуй, газар тариалан эрхлэх, сүү цагаан идээ боловсруулах зэрэг таны үндсэн мэдлэг дээр нэмж мэдэх ёстой зүйлсийг хэлж байгаа юм.

Өдөр тутмын амьдралдаа ашигладаг ур чадвараа аялал жуулчлалтай уялдуулах

Малчин хүний хувьд морь, тэмээ унах, ачаалах зэрэг чадварыг та аль хэдийн эзэмшсэн байдаг. Харин эдгээрийг хэрхэн аюулгүй, жуулчдад сонирхолтойгоор үзүүлэхэд суралцах хэрэгтэй. Жуулчдын ихэнх нь амьдралдаа анх удаа морь, тэмээ унаж байж магадгүй. Орон нутгийн хөтчийн хувьд нутгийнхаа соёл, байгаль, түүхийг уран сайхнаар танилцуулж сураарай. Сайн хөтөч болохын тулд дадлага туршлага хэрэгтэй. *Хөтөч хийх тухай дэлгэрэнгүй мэдээллийг 16-р хэсэгт оруулав.*

Та сайн хоол хийдэг байж болох ч зочдод хоол хийж үйлчлэхдээ сайтар анхаарах хэрэгтэй. Гэр кэмп, аяллын үеэр хоол хийх хүн нутгийн хоолны жороо мэддэг байх хэрэгтэй. Та эрүүл ахуйн стандарт, хүнсний аюулгүй байдлын тухай сургалтад хамрагдах нь давуу тал болно. Хоолны цэс гаргах, тусгай хэрэгцээтэй зочны хоолыг бэлтгэхэд танд тодорхой мэдлэг хэрэгтэй. *Энэ талаар 13-р хэсгээс үзнэ үү.*

Та туршлагатай оёдолчин, эсгий урлаач, мужаан байж болно. Харин бэлэг дурсгалын зүйл урлахдаа нутгийнхаа өвөрмөц онцлогийг харуулсан нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох хэрэгтэй.



Өөрийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгохын тулд сургалтад хамрагдаж зөвлөгөө аваарай. *Бэлэг дурсгалын зүйлсийн тухай 12-р хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлав.*

Харилцааны ур чадвар

Та зочидтойгоо ойлгомжтой, сонирхолтой, эелдэг яриа өрнүүлэхийн тулд ярианы ур чадвараа хөгжүүлээрэй. Өөртөө итгэлтэй, өөрийнхөөрөө байх нь таатай байдаг. Орон нутгийнхан нутгийн түүх домгоо сэтгэлд хоногштол сайхан ярьж чаддаг шүү дээ. Ихэнх аялагчид олон орноор аялсан туршлага сайтай хүмүүс байдаг учир тэднийг хуурах гэж бүү оролдоорой.

Орчин үед мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглаж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчилж, зорилтот зах зээлд шууд хүрч болно. Хэрэв энэ бүгдийг хараахан мэдэхгүй бол ухаалаг утсан дээрээ нийгмийн сүлжээг ашиглаж фейсбүүкээр лайв хийж сурах хэрэгтэй. Танай нутгийн залуучууд энэ бүхнийг аль хэдийн сайн мэддэг учраас тэд нараар заалгах эсвэл тэд нарт шууд хариуцуулах хэрэгтэй.

“Нэг зураг мянган үгний дайтай” гэдэгчлэн фото зураг маш чухал. Зочид тантай хууч хөөрч байгаа, таны өдөр тутмын амьдрал, гэр бүл, байгалийн үзэсгэлэнт газруудын зургууд байх хэрэгтэй. Гэхдээ хүмүүсийн дүр төрхийг харуулсан зураг хамгийн чухал. Та өөрт байгаа боломжоороо сайхан зураг дараарай. Багийн зураг сайн авдаг нэг нь зураг авах өнцгөө олж засварласны дараа нийгмийн сүлжээнд тавьж болно. Зургийг хэт их засах нь хуурамч юм шиг харагддаг.

Холбогдох хууль, дүрэм журам, стандартын мэдлэг

Та аюулгүй ажиллагааны дүрэм журам, зөвлөмжийг мэддэг байх хэрэгтэй. Та эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал, ариун цэврийн стандарт гэх мэт дүрэм журмыг мэдэж, дагаж мөрдөх ёстой.

ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийг
QR CODE-оор орж харна уу.





Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн
8-р бүлгийг QR CODE-оор орж татаж авна уу.



MNS 5924:2015 стандартыг QR CODE
уншуулж татаж авна уу.

Шилдэг байхын төлөө хичээ

Гишүүн бүр хариуцсан ажилдаа шилдэг байхын төлөө хичээх ёстой. Ингэснээр зочдод анхны сэтгэгдлийг сайхан төрүүлж үлдсэн өдрүүдээ сэтгэл ханамжтай өнгөрүүлнэ. Та зочноосоо танай үйлчилгээний тухай нийгмийн сүлжээнд эергээр бичиж, бусдад санал болгоосой гэж хүсэж байгаа шүү дээ. Танай нэр хүндийг ганцхан муу сэтгэгдэл нурааж чадна. Иймд багийн гишүүн бүр хариуцлагатай, сэтгэл гарган ажиллаж чадвал жуулчид танайд өндөр үнэлгээ өгөх нь гарцаагүй юм.

Чадавх бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулах

Та НИТАЖ эрхлэгчийн хувьд гишүүн бүрийнхээ чадавхийг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж, үүрэг хариуцлагыг тэдний ур чадвар, авьяас, сонирхол дээр нь тулгуурлаж оноох нь зүйтэй. Та багийн бүх гишүүдтэйгээ хамтран ажлын ерөнхий гүйцэтгэл ямар байгаа, чанартай үйлчилгээ үзүүлэхийн тулд ямар мэдлэг, ур чадвараа сайжруулах шаардлагатай байгааг дүгнэн хэлэлцэж нэн түрүүний хөгжүүлэх шаардлагатай ур чадвараа тодорхойлоорой.

Ингэж ур чадвар хөгжүүлэх богино, дунд хугацааны сургалтын төлөвлөгөө гаргаарай. Сургалтын зардал, шаардагдах цаг хугацааны талаар харилцан тохирч болно. Сургалтаар сурсан ур чадвараа дадлага хийж хөгжүүлээрэй.

**Сургалтын байгууллагуудын мэдээлэл**

Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд аялал жуулчлал, бизнес, бусад шаардлагатай ур чадвар олгох сургалтын байгууллагууд байдаг. Хүснэгтэд сургалтын байгууллагуудын мэдээллийг сонирхуулж байна.

Мөн ерөнхий ойлголт авах боломжтой онлайн видео, гарын авлагатай танилцах хаяг холбоостой (линк) Хавсралт 11-с танилцаарай.

| | Сэдэв, агуулга | Сургалтын байгууллага | Вэб хаяг |
|----|--|---|--|
| 1. | Үйлчилгээний сургалт | Аялал жуулчлалын ур чадварын төв | www.tourismmastery.mn |
| 2. | Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчийн сургалт | Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо | www.mptga.org |
| 3. | Тогоочийн сургалт | Аймгуудын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд | |
| 4. | Мэдээлэл технологи, дижитал, маркетинг | Дижитал маркетингийн агентлагууд HORECA soft | www.sortlist.com//mongolia-mn www.horecasoft.mn |
| 5. | Та үйлчилгээнийхээ тухай зар оруулж, зах зээлд хүргэх онлайн платформууд | <i>iHotel</i> – зочид буудлуудын захиалгын нэгдсэн сан <i>JoinMe</i> – дотоодын аяллын нэгдсэн сан <i>Nathouse</i> – Сошиал суваг хөгжүүлэлт, онлайн худалдааны сургалт, зөвлөгөө | www.ihotel.mn www.joinme.mn/ www.nathouse.mn/social-media-surgalt |



ХЭСЭГ 10. НИТАЖ-ЫН БАГАА УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ

НИТАЖ-ыг амжилттай эрхлэх үндэс суурь бол үйл ажиллагаа, багаа зөв удирдан зохион байгуулах явдал. НИТАЖ нь хэдийгээр үйлчлүүлэгч, түнш зэрэг нийгмийн өргөн хүрээний харилцаанд түшиглэдэг ч арын албанд ажиллаж байгаа хамт олон маш чухал юм.

Та баг хамт олноо бэхжүүлж, дотоод соёлоо бий болгосноор үйл ажиллагааныхаа зорилго, түүнд хүрэх богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөг гишүүдтэйгээ хамтран боловсруулна. Тэрчлэн эерэг хандлагатай, ёс суртахуунтай баг бүрдүүлж, гишүүн бүр өөрийн үүрэг хариуцлагыг ухамсарласан байх хэрэгтэй.

Хэдийгээр энэ бүгдийг цогцлоох нь амаргүй ч дараах хэдэн чухал зарчмыг хэрэгжүүлснээр амжилттай ажиллах нөхцөл бүрддэг.





Ажлаа үргэлж урьдчилан төлөвлөөрэй

- Үйл ажиллагаагаа урьдчилан нарийн төлөвлө. Ажил, үүргийг хуваарилан, санхүүгийн нөөц, материал, тоног төхөөрөмжөө тооцоолоорой.
- Ажлаа жилээр эсхүл жуулчны улирлаар нарийвчлан төлөвлөж заншвал маш сайн. Ингэхдээ үйл ажиллагаа бүрийг нарийн гаргаж, гишүүдийнхээ үүрэг хариуцлагыг хуваарилаарай. Ажлаа үнэлж дүгнэх үүднээс энгийн шалгуур үзүүлэлт гарган амжилт, алдаа оноогоо цэгнээрэй. Ховд аймгийн Мөнххайрхан сумын Бортын Мандал нөхөрлөлийн аялал жуулчлалын үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт 12-оос танилцана уу.

Эрсдэлээ урьдчилан харж зохицуулаарай

- Та өөрийн орон нутагт гарч болзошгүй бүх эрсдэлийг жагсаан бичээрэй. Үүнд, цаг агаар, гишүүдийн боломж, мал аж ахуйн болон бусад ажлын ачаалал зэрэг орно. Ингээд багаараа эрсдэлийг туулах арга замын талаар хамтран хэлэлцээрэй.
- Төлөвлөсөн үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрвэл нөөц төлөвлөгөөтэй байгаарай. Мөнххайрхан сумын Бортын Мандал нөхөрлөлийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг Хавсралт 13-аас харна уу.

Бүх гишүүдийн хурлыг тогтмол хийж заншаарай

- Хамт олныхоо хурлыг тогтмол хийж, ажлаа төлөвлөж, үр дүнгийн үнэлгээ хийж, санхүүгийн болон бусад ажлаа тайлагнаж хэвшээрэй. Хурлын товыг хүн бүрт сануулна.
- Бүх гишүүдийг саналаа чөлөөтэй хэлж, асуулт асууж оролцоход нь урам өгч дэмжээрэй. Мөн хүмүүсээ залхаан, цагийг нь үрэхгүйн тулд хурлаа богино хугацаанд үр бүтээлтэй хийж сураарай.

Мөнгө санхүүтэй холбоотой асуудлыг ил тод хэлэлцээрэй

- Санхүүгийн мэдээллийг гишүүддээ тогтмол танилцуулж байх хэрэгтэй. НИТАЖ-ын дундын сан юм уу нөхөрлөлийн дундын сангийн орлого, зарлагыг ил тод, нээлттэй тооцож байх нь чухал.
- Сонгосон гишүүдээ санхүүгийн сургалтад хамруулж, тайлан тооцоогоо тогтмол бичгээр хөтлүүлж, бүх гишүүдийн хурал дээр танилцуулж байх
- Сарын нэг өдрийг санхүүгийн асуудлаа бүх гишүүдтэй хэлэлцэхэд зориулах



Нөхцөл байдалдаа таарсан менежментийн бүтэцтэй болоорой

- Нөхөрлөлийн ахлагч нь НИТАЖ-ыг эрхлэх явуулах хүн байх албагүй. Танай нөхөрлөл олон гишүүнтэй эсвэл бүх гишүүд НИТАЖ явуулахад оролцоогүй бол НИТАЖ эрхлэх менежер сонгож болно. Эс бөгөөс нөхөрлөлийн ахлагчийн ачаалал ихсэх талтай байдгийг санаарай. Гишүүдтэйгээ хэлэлцэн хамгийн боломжит хувилбарыг сонгоорой.
- Нөхөрлөлийн ахлагчийг дэмжиж ажиллах зөвлөл байгуулаарай.
- Бүх гишүүдийн итгэл хүлээлгэсэн нэгнээ нөхөрлөлийн дундын сангийн менежерээр сонгож болно.

Багийн гишүүддээ талархалтай хандаж, тэднийг ойлгож дэмжээрэй

- Нөхөрлөлийн ахлагч, НИТАЖ-ын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг хүн багийн гишүүддээ сайн мэдэж, НИТАЖ-ын үйл ажиллагаанд хэрэгтэй ур чадварыг таньсан байх хэрэгтэй.
- Тэдний давуу болон сул талыг таньж, хариуцах ажил үүргийг нь ярьж, тохироорой.
- Ур чадвар хөгжүүлэх ямар сургалт хэрэгтэй байгаа тухай, хэрхэн сургалтад хамрагдах, сургалтын төлбөрийг хэн төлөх, тэд хэрхэн хувь нэмэр оруулах гэх мэт зүйлсийг хамтран тодорхойлоорой.
- Ажил гүйцэтгэлийг нь үнэлж, асуудал гарвал эрт, нээлттэй хэлэлцэж сураарай. Тэднийг асуудлаа ярьж, саналаа хэлэхийг дэмжээрэй.
- Тэдний ажлыг үнэлж, талархаж байдгаа мэдрүүлээрэй.
- Хэрвээ хийсэн ажил нь хангалтгүй бол тодорхой хэлж, хэрхэн сайжруулах талаар хамтдаа ярилцаарай.

Урамшууллын систем бий болгоорой

- Өөрсдийн гаргасан шалгуураар гишүүдийн гүйцэтгэлийг үнэлж, ажлаа сайн хийсэн нэгнээ шагнаж урамшуулаарай.





- Гишүүн бүртэй хийх ажлын гэрээн дээрээ үүнийг дурдаж оруулах хэрэгтэй.
- Аялал жуулчлалын бизнес сайхан харилцаа, зөв хандлага дээр суурилдаг. Тиймээс эхнээс нь зөв хандлага, эерэг дадлыг гишүүдийнхээ дунд буй болгоорой.
- Урамшууллын хэлбэр хэд хэдэн төрөл байж болно. Тухайлбал, туршлага судлах аялал, сургалтад хамруулах, өөр газраар аялуулах гэх мэт.
- Урамшууллын систем ил тод, бүгдэд тэгш байх ёстой.
- Хэн нэгнийг байнга урамшуулах нь баг дотор атаархал үүсгэн, хандлага өөрчлөгдөх сөрөг зүйлсийг дагуулдаг.

Багийн гишүүн бүр хариуцаж авсан ажил бүртээ хариуцлагатай хандаарай

- Багийн гишүүн бүр өөрийн үүрэг хариуцлагаа сайтар мэддэг байх нь их чухал. Багийн нэгдсэн ажиллагааг сайтар ухамсарлаж, өөрийн оруулах хувь нэмрийг сайн ойлгосон байх хэрэгтэй.
- Гишүүд мэдэхгүй зүйлээ хэнээс асуух, хэнд тайлагнах зэргийг тодорхойлсон заавар журам байх хэрэгтэй.
- Жуулчдаас ирсэн гомдлыг хараад байхад багийн гишүүдийн үл ойлголцол, нэг нэгнийхээ ажил үүргийг мэдээгүй, ажлаа зөв сайн хуваарилаагүйгээс асуудал гарсан байдаг.

Онцгой байдлын үед хүн бүрийн мэдэж байх журмаа боловсруулаарай

- Онцгой байдлын үед баримтлах дүрэмтэй байвал сайн. Дүрэм боловсруулахад бүгд оролцож, сумын мэргэжилтнээс зөвлөгөө авч болно. Эрүүл мэнд, осол эндэгдэл, байгалийн гамшиг, тэрчлэн гэнэт ирсэн жуулчинд үйлчлэх зэрэгт тогтоосон горим байх хэрэгтэй.
- Гишүүддээ анхны тусламж үзүүлэх тухай болон өөр сургалтад хамруулж байх. *Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ ба бусад шаардлагатай дүрэм журамтай 17-р хэсгээс танилцаарай.*

Бичиг баримтаа цэгцтэй хөтлөөрэй

- Ажил үүргийн хуваарь, хариуцлага, гүйцэтгэлийг хэрхэн үнэлэх, цалин олговор зэргийг багтаасан ажлын гэрээг бичгээр хийх хэрэгтэй.
- Үйл ажиллагааны энгийн заавар гаргаж, хэзээ, хэн, юуг, яаж хийх зэргийг оруулж өгнө. Ярвигтай ажлын дэс дарааллыг бичсэн байх. Энэ зааврыг хэн ч, хэзээ ч харж болохоор ил байлгах хэрэгтэй.
- Тур операторуудтай гэрээгээ тодорхой хийх. Жуулчид, тур операторуудтай холбоотой бичиг цаасаа нямбай, системтэй хавтаслан



хөтлөх. Хэрвээ тур оператор захиалгаа цуцалсан бол төлбөрийн тодорхой хэсгийг суутгах хэрэгтэй. Учир нь та нар бэлтгэл ажил хийсэн байгаа шүү дээ. Өөрийн захиалга, орлого, зарлагын хуудастай болох. Захиалгын хуудасны загвар жишээг Хавсралт 14-өөс харна уу.

- Сарын нэг өдөр хамтдаа сууж орлого, зарлага, бичиг цаасны ажлаа цэгцэлж, тайлагнаж байх
- Нямбай, үнэн зөв санхүүгийн тайлан гаргах. Сэтгэлээсээ үнэн зөв хийсэн ажлыг нутгийн хүмүүс ойлгож, үнэлдэг бөгөөд сайн хүмүүсийн үйлдэл нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулдаг. Энэ нь урт удаан хугацаанд өгөөжтэй, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлдэг.
- Хэрэв нөхөрлөл бол байгалийн нөөцийн менежментийн тайлан зэргийг цаг хугацаанд нь холбогдох удирдлагад хүргүүлж байх хэрэгтэй.

Найрсаг эелдэг харилцааг хөгжүүлээрэй

- Зөв цагт, ойлгомжтой харилцаж сураарай.
- Хэрвээ тур оператортай хамтран ажилладаг бол захиалгын тал дээр цаг тухайд нь оновчтой санал сэтгэгдэл хэлж байгаарай.
- Багийн гишүүдтэйгээ төлөвлөгөө, болох гэж буй арга хэмжээ, гэнэтийн өөрчлөлт зэргийг цаг тухайд нь ярилцаж байгаарай.
- Бас сайн сонсогч бай.
- Утсаар холбогдох боломжтой байх хэрэгтэй. Холбогдох боломжгүй тохиолдолд түншүүддээ урьдчилан мэдэгдэж, өөр боломжтой гишүүний утсыг өгөх гэх мэт арга хэмжээ авах хэрэгтэй. Нөхөрлөлийн нэр дээр утасны дугаартай болж, үргэлж хэн нэг нь ашигладаг, нээлттэй байлгаж болно.
- Цахим хаяг, утасны болон бусад мессежээ байнга шалгаж, хурдан хариулж заншаарай.

Багийн гишүүдийнхээ ур чадварыг хөгжүүлж, залгамж халааг өвлүүлээрэй

- Залуу үеэ сургаж, залгамж халаагаа бэлтгэх нь чухал. Хариуцлагаа бага багаар шилжүүлэн, эцэст нь бүх үйл ажиллагаагаа хойч үедээ хүлээлгэн өгдөг болбол урт хугацаандаа үр ашигтай. Эс бөгөөс та бүхний олон жилийн хүч хөдөлмөр үргүйдвэл харамсалтай шүү дээ. Мэдээж залуу үеийнхэн өөрсдийн арга барилаар ажиллана. Тиймээс үүнийг хүлээн зөвшөөрөх бэлтгэлтэй байх, туршлагаа хуваалцан тэднийг дэмжээрэй.
- Багийн чадвараа хөгжүүлэх нь танд болон бүгдэд үр ашгаа өгдөг.



ХЭСЭГ 11. НИТАЖ-ЫН ГЭР КЭМПИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

НИТАЖ-ын үйл ажиллагаанд ихэнх тохиолдолд зочин байрлуулах, хонуулах үйлчилгээ багтсан байдаг. Та түүх соёлын газар, зэрлэг амьтан харуулах, нутгийн гар урлал тайлбарлах, гардан хийх боломж олгох, тэмээ, морь унуулах зэрэг олон үйлчилгээ санал болгож болно.

Та зочноо гэртээ эсвэл тусгайлан бэлдсэн гэр, модон байшинд байрлуулдаг. Танай гэр кэмпиин хэлбэр загвар, тав тух хэрэглээ, аюулгүй, цэвэр цэмцгэр байдал нь жуулчдад сайхан, тааламжтай дурсамж болж үлдэхээс гадна ах дүү, найз нөхдөдөө энэ талаар ярьж, олон нийтийн сүлжээнд хуваалцдаг нь бараг уламжлал болсон зүйл. Тэд нэг удаа тааруухан сэтгэгдлээ фейсбүүк дээрээ бичихэд л таны ажлын хичээл зүтгэл үгүй болох аюултай гэдгийг сайтар санаж байхад илүүдэхгүй.

Гарын авлагын энэ хэсгээс гэр кэмп байгуулах, байршил сонгоход анхаарах зүйлс, гэрт байршуулах эд хогшил, гэрэлтүүлэгт тавигдах шаардлага, хэрхэн орчин тойрны байгальтайгаа зохицуулах, үйл ажиллагааны аюулгүй байдлын талаар олж мэдэх болно.



Гэр кэмп байгуулж, тогтвортой ажиллахад анхаарах ерөнхий зарчмууд

- Аялал жуулчлал нь мэргэжлийн салбар, тиймээс кэмпиийг бас мэргэжлийн түвшинд удирдан, зохион байгуулж чадвал амжилтад хүрнэ.
- Та нэгэнт аялал жуулчлалаар ажиллахаар шийдсэн бол тэр санаагаа



мэргэжлийн хүмүүстэй хуваалцаж тэдний зөвлөмж, саналыг сайн сонсож, тусгаж авах хэрэгтэй.

- Туршлагатай хүмүүсээс суралцаж, алдаа оноог нь цэгнэх хэрэгтэй.
- Гэр кэмп жуулчны баазын адил том газар, талбай эзлэхгүй ч тэднээс дутахгүй тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөн бий болох учир байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар бодож төлөвлөх хэрэгтэй.
- Зарим зочид гэртээ дуулах, чанга дуугаар ярих зэргээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг учир гэрийн бүрээсийг давхарлах, гэрүүдийн хоорондын зайг хол байлгах, чимээ шуугиан гаргах хүмүүсийг захад салхин доор байрлуулахаар тооцох нь зөв.
- Гэрүүдийн гадуур намхан чулуун гортигон тэмдэглээ хийж, машин, мотоцикл замбараагүй явахаас сэргийлэх хэрэгтэй.
- Машины зогсоол нь нэг замаар орох гарах чиглэлтэй, гэрүүдийн салхин доор хамгийн ойрхондоо 30 метрийн зайтай байх нь чухал.

Гэр кэмпийн байршлыг зөв сонгох

Ямар ч бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд байршил хамгийн чухал. Ихэнх хүмүүс гэр кэмпээ байгалийн үзэмжит газар, түүх соёлын дурсгалт газарт ойрхон байгуулахыг хүсдэг. Гэвч энэ нь байгаль орчин, түүх соёлын дурсгалт зүйл, зэрлэг амьтан зэрэгт сөргөөр нөлөөлөхөөс гадна аялал жуулчлалын утга учрыг алдагдуулдаг. Доройтон талхлагдсан газар жуулчид дахин ирдэггүй гэдгийг санаарай.

Тиймээс гэр кэмпийн байршлыг сонгохдоо дараах зүйлсийг сайтар бодолцож үзээрэй.

- **Сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх:** Эхнээсээ газар, байгаль, соёлын өв зэрэг жуулчид аялагчдын сонирхлыг татдаг зүйлд сөргөөр нөлөөлөхгүй байршлыг сонгох хэрэгтэй. Байршил сонгохдоо мэргэжлийн хүний зөвлөгөөг авах хэрэгтэй. Хэрвээ танайх ТХГН-тай ойр байдаг бол ТХГН-ийн бүсчлэл, үйл ажиллагаа явуулах дүрэм журам бүрийг судалж үзээрэй. Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нар, байгаль орчны улсын байцаагч, газрын даамал, тур операторууд, хэрвээ боломжтой бол ТББ, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний зөвлөгөөг аваарай. Орон нутагт гарсан газар ашиглалт, байгаль хамгаалалтай холбоотой төлөвлөгөө, тухайлбал, ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө, сум орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.



- **Үзэгдэх байдлыг сайтар бодолцох.** Жуулчдын гэрийн хаалгаар харж баясах дүр зургийг сайн анхаарна. Ихэнх жуулчид нар мандах болон жаргахыг харах дуртай байдаг. Тэрчлэн шөнийн тэнгэрт түгэх түм буман одод, түүний наагуур зураих сүүн замыг харж баясахгүй хэн байх билээ. Жуулчид гэрийн хаалгаар харагдах уул, тал, ой модыг ажиглах дуртай байдаг. Мэдээж малчин ахуй амьдралыг харах дуртай ч жуулчны гэртэй хэт битгий ойртуулаарай. Мөн шувууд, жижиг хөхтөн амьтан наагуур цаагуур гүйлдэн харагдах нь байгалийн сайхныг харан баясах таатай мэдрэмж төрүүлнэ.
- **Дуу чимээ, бохирдол, машин зам, олон хүнтэй газраас зайдуу байрлуулах.** Дэд бүтэцтэй ойр байх нь та бүхэнд нэг талаараа дөхөм ч гэсэн манай оронд ирж буй жуулчид онгон байгаль, чимээ анир багатай хөдөө нутгийн амар тайван байдлыг хайн ирдэг. Тэд онгон байгальд амрахыг хүсдэг. Тиймээс зочдоо аль болох чимээ аниргүй, утаа тоосноос хол, машин тэрэгний замаас зайдуу, орчин үеийн хөгжил, дэд бүтэцээс хол байлгахыг хичээгээрэй.
- **Гэр кэмгийн бүтэц, зохион байгуулалт.** Анхнаасаа зочны гэр, өөрийн гэр, бие засах газар, авто зогсоол хаана байхыг сайн тооцож төлөвлөх хэрэгтэй. Энэ бүхнийг тооцоход тухайн газар орон дахь салхины зонхилох чиглэлийг анхаарч төлөвлөх хэрэгтэй. Салхины чиглэлийг буруу тооцвол бие засах газар, авто зогсоолоос ирэх үнэр, дуу чимээ зочны тань амрахад муугаар нөлөөлөхийг тооцоорой.
- **Цаг агаар, байгаль орчны нөхцөл байдал.** Гэр кэмп байрлуулах газар сонгохдоо улирлын салхины хүч, чиглэл, цасны хунгар, үерийн усны урсац, тогтоц зэргийг анхаарч сонгох нь нэн чухал. Гэрээ зуны халуунд үер уснаас хол, сэрүүхэн задгай газар барих хэрэгтэй.
- **Чимээ аниргүй шөнө.** Ихэнх жуулчид өндөр настай хүмүүс байдаг. Тэд шөнө нэг сэрвэл эргээд унтаж чаддаггүй. Иймд машин зам, зогсоол болон бусад дуу чимээтэй газраас зайдуу чимээгүй газрыг сонгох хэрэгтэй.
- **Гэр кэмгийн ойр орчмыг эмх цэгцтэй, цэвэр байлгах.** Жуулчны гэр гэлтгүй өөрсдийн амьдарч буй гэр, гадуурх орчноо эмх цэгцтэй, цэвэр цэмцгэр байлгах хэрэгтэй.



Орчиндоо зохицсон өнгө төрхийг буй болгох

Уламжлалт монгол гэр, жижиг модон байшин нь жуулчдыг хүлээн авч, байрлуулахад хамгийн тохиромжтой. Гэр, байшин ялгаагүй хийц загвар нь байгаль, нутгийнхаа өнгө төрхтэй уусан зохицсон байвал сайхан харагддаг. Байгальд сөрөг нөлөө учруулалгүйгээр мод чулуугаар байшин, хашаа хороогоо барьж болно. Хэрвээ жуулчин хүлээн авах гэр, байр нь байгальтай сайхан зохицсон байвал жуулчид дуртай бууж хонон, амарч тухлах болно.

Жуулчин хүлээн авах монгол гэр бэлтгэхэд доорх зүйлсийг анхаарна уу:

- Ихэнх гэр буудал 5 ханатай (заримдаа 4 хана) гэр байдаг. Нэг гэрт 3-аас дээш ор байвал доторх зай багасаж, аялагчдын тав тухыг бүрэн хангаж чаддаггүйг анхаарах хэрэгтэй.
- Орны өргөн 90 см, урт нь 2 метрээс багагүй, зориулалтын матраастай байх бөгөөд матраас нь хэт зөөлөн, хатуу байж болохгүйг анхаараарай.
- Орны даавуу цэвэр, угаасан байх хэрэгтэй. Зочид шөнөдөө даарч магадгүйг харгалзаж нэмэлт хөнжил, даавуутай байхаар тооцох нь зөв.
- Гар угаах энгийн угаалтуур байршуулах нь зүйтэй. Бохир усыг байнга асгаж цэвэрлээрэй. Бохирын ус тоссон хувинтай, дүүрэхээс нь өмнө асгах ёстой байдгийг зочиндоо сануулж хэлэхэд илүүдэхгүй. Учир нь жуулчин анх удаа ийм угаалтуур ашиглаж байж болно. Гар нүүрний цэвэр алчуур, саван тавьж өгөөрэй.
- Гэрийн суурийг цементлэхээс зайлсхийх. Уламжлалт байдлаар хийх нь байгальд ээлтэй сайхан харагддаг. Зүлгэн дээр шууд хулдаас эсхүл модон паркетэн шал зохимжтой. Хивс ашиглавал цэвэрхэн байлгах хэрэгтэй. Бохир, хуучин хивс нь өнгө үзэмжгүйгээс гадна, эрүүл мэндийн шаардлага хангахгүй байх нь олонтаа.
- Ихэнх хүмүүс гэрийг зуны улиралд ашиглахаар тооцож дан бүрээстэй хийдэг. Гэвч ийм гэр дулаан хадгалалт муу, хаврын салхи шуурганд тогтворгүй, гадна, дотроосоо дуу чимээ сонсогдох нь их, зарим тохиолдолд ус бороо нэвтэрдэг муу талтай байдаг учир давхар





бүрээстэй хийх нь чухал. Түүнээс гадна усны хамгаалалтгүй эсгий хур бороонд норохоороо хонины зунгаг үнэртэж аялагчдын сэтгэлд таатай бус байдаг. Гэрийн өрх заавал хийх хэрэгтэй.

- Говьд тоононд шороо тоосны хамгаалалт хийх шаардлагатай. Сүүлийн үед говийн гэр буудлууд тоонондоо зузаан гялгар хамгаалалт хийх болсон нь тоос шороо, бороо уснаас сайн хамгаалж байгаа ч агаар солилцох зай гаргаж өгөх хэрэгтэй.
- Сүүлийн үед гэрт “Дөл” зэрэг төслийн зуухыг ашиглах болсон нь монгол гэрийн дотоод тав тух, цэвэр байдлыг хангахаас гадна түлшний хэрэглээг эрс багасгаж, дулаан хадгалалтыг сайжруулсан байна. Ихэнх жуулчид гал түлэхийг мэддэггүй. Тиймээс гал түлэх, хэрхэн галаа унтраахгүй байх, агаарын солилцоо оруулах зэргийг хэлж өгөөрэй. Жуулчдаасаа хэр их гал түлүүлэх эсэхийг нь сайн асуух хэрэгтэй. Учир нь орон нутгийнхан хэт их гал өрддөг тал бий.
- Жуулчид өглөөний нар харан, наранд ээнгээ кофе уух, оройн нар жаргахыг харах дуртай байдаг тул гэрийн гадаа сандал, ширээ байрлуулбал тун зүгээр. Сандал ширээ нь зөөврийн эвхэгддэг, авч явахад хялбар бол та бүхэнд амар шүү дээ. Боломжтой бол модоор урт бандан ширээ хийж ч болно.
- Бие засах газар, хогны сав зэрэг нь гэр кэмпийн хувьд МАШ ЧУХАЛ зүйл. *Бие засах газар, ариун цэвэр хангамжийн талаар 14-р хэсгээс, харин 15-р хэсгээс хог хаягдал, байгаль орчны асуудлын талаар олж уншаарай.*

Гэрэлтүүлэг

Гадаадын жуулчид бараг бүгдээрээ шөнийн оддын үзэсгэлэнг харж биширдэг. Гэрлийн бохирдол дэлхийн асуудал болоод байгаа билээ. Ихэнх оронд Монгол шиг одод түгсэн тэнгэр харагддаггүй. Учир нь олон янзын хиймэл гэрэлтүүлгүүд шөнийн тэнгэрийн үзэгдэх байдлыг бусниулдаг. Ийм учраас гэр кэмпийн гэрэлтүүлгийг зөв тооцож сонгох хэрэгтэй. Гэрлийн бохирдлыг бууруулж аюулгүй, тухтай орчин үүсгээрэй.

Ихэнх жуулчны бааз, гэр буудлууд гаднаа хүний харааны түвшнээс өндөр, зарим нь хүний нүд рүү шууд тусах хурц гэрэл, гэрэлтүүлэг хийдэг нь гэрлийн бохирдол үүсгэдэг. Гэрлийн бохирдолгүй байх нь шөнийн цагаар од, галактикийг харах сайхан нөхцөл болдгийг тооцох хэрэгтэй.

Гадаа гудамж, замын гэрэлтүүлгийг хүний харааны түвшнээс доор, хүний өвдөгний орчимд, зөвхөн явган замыг гэрэлтүүлэх, доошоо тусгалтай малгай бүхий, хөдөлгөөн мэдрэгчтэй гэрэлтүүлгийг хооронд нь нэгээс нөгөөд дамжин алхахад гэрлээр тасрахгүйгээр байрлуулах нь зөв шийдэл болдог.




Гэрийн гэрэлтүүлгийг тус бүртээ бие даасан, нарны эрчим хүчээр ажилладаг төхөөрөмжийг сонгох нь зөв. Нэг төхөөрөмжөөс олон салаалж хол гэрүүдэд гэрэлтүүлэг оруулснаас шугамын уналт болж гэрэлтүүлгийн чадал буурч батарейн ашиглалтын хугацааг богиносгох, төхөөрөмжид гэмтэл үүсгэх магадлалтай.

Байгальд зохицсон уламжлалт монгол загвар

- Гэр кэмгийн гадна, дотно бүх загварыг гаргахдаа аль болох байгалийн өнгө төрхийг шингээсэн байлгахыг хичээгээрэй.
- Тухайн орчны элс шороо, мод чулууны өнгөний зохицлыг илүү анхаарах хэрэгтэй. Өнгө хоорондын зохицлыг олох хэрэгтэй ба олон янзын өнгө оруулах хэрэггүй.
- Монголын уламжлал, байгальтай зохицсон загвар гаргавал сайн. Орон нутгийн түгээмэл тархацтай мод, чулууг түлхүү ашиглаарай. Аль болох тухайн орчиндоо зохицсон хэт том, өндөр биш байхаар хийгээрэй.
- Бусад орны байгалийн аялал жуулчлал явуулдаг газруудын загвар, элстэй, уултай, модтой болон тусгай хамгаалалттай газар нутаг дотор барьсан байгууламжуудын тухай онлайнаар судалж үзэж болно. Хэрэв та байгалийн өнгө төрх, хад чулууг өөрчлөн эвдэх, ургаа мод бутыг хөндөхөд хүрсэн бол түүнийгээ эргүүлээд нөхөн сэргээгээрэй.

Тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбар

- Самбар дээр олон замын тэмдэг тэмдэглэгээг байршуулахаас татгалзаж, машин зогсоолын дэргэд байгалийн болон гэр кэмгийн харагдах байдлыг эвдэхгүй байх нь зөв. Тэмдэг, тэмдэглэгээг байгалийн материал ашиглан хийгээрэй.
- Тэмдэг нь харахад ойлгомжтой, энгийн загвартай, зөв найдвартай мэдээлэлтэй байх хэрэгтэй. Энэ талаарх зөвлөгөөг байгаль хамгаалагчид, аймаг сумын мэргэжилтнүүд, тур операторуудаас аваарай. Хэрэгтэй гэж гэвэл нутгийн зэрлэг амьтан, байгалийн тогтоц, тусгай хамгаалалттай газар, соёлын өв зэргийн тухай мэдээлэл оруулахдаа үнэн зөв, сонирхолтой эсэхийг шалгаж үзээрэй.





- Галын хор болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж, анхны тусламжийн хэрэгслийн байршил, гэрийн хаалга мөргөхөөс болгоомжилсон тэмдэг зэргийг хадаж өгөх хэрэгтэй.

Шилдэг үйлчилгээг хэрхэн үзүүлэх вэ?



Үйл ажиллагаагаа амжилттай явуулахад дараах үндсэн шалгуурууд хэрэг болно.

Танайд ирсэн зочдын анхны сэтгэгдэл хамгийн чухал. Танай барилга байгууламж, гэр кэмпиийг харахад эмх цэгцтэй, зөв төлөвлөлттэй, гадаах орчны харагдах байдал нь сэтгэл татам байвал зочны анхны сэтгэгдэл сайхан байна. Таныг зориод ирж буй зочдооо нутгийн соёл, үзэсгэлэнт байгалийн өнгө аяс бүхий тав тухтай, аюулгүй, цэвэрхэн орчинд угтан авбал сайхан биз дээ. Зочдыг найрсгаар угтан авч, кэмпиин үйл ажиллагааны хөтөлбөрөө танилцуулж сайхан хоолоор дайлах зэргээс анхны сэтгэгдэл төрдөг.

Цэвэр, эмх цэгцтэй байдал хамгийн чухал. Монгол дээлээ өмсөн зочдоо угтах нь яах аргагүй сайхан сэтгэгдэл төрүүлж, зочны хувьд цаашдаа сайхан амарч тухлан, сэтгэгдэл өндөр үлдэх алхмыг бүрдүүллээ гэж үзэж болно. Анхны сэтгэгдэл сайхан байсан зочин цаашид гарах болон гарч болзошгүй жижиг асуудлуудыг нэг их тоодоггүй. Харин анхны сэтгэгдэл таатай бус байсан зочид ихэнхдээ жижигхэн зүйлд ч гомдоллож, өөчилж эхэлдэг. Энэ нь танай нэр хүнд, цаашдын амжилтад сөргөөр нөлөөлөх учир ийм алдаа гаргахгүй байж анхны сэтгэгдлийг сайхан байлгахын төлөө ажиллах хэрэгтэйг санаарай.



Анхны сэтгэгдлийг сайн эхлүүлэх хамгийн эхний алхам нь танай угтах үйлчилгээ, мэндлэх, зочиндоо санаа тавихаас ихээхэн шалтгаална. Үүний тулд багийн гишүүн бүрийг зөв сайхан харилцаагаар хүнийг татах чадварт сургах хэрэгтэй болно. Ийм үйлчилгээ болон харилцааны зөв хандлагыг буй болгоход удаан хугацааны сургалт, туршлага хэрэгтэй. Гэсэн ч бид малчин түмнийхээ зочломтгой зангаар танигдсан ард түмэн шүү дээ.

Аялал жуулчлал нь хүнийг үргэлж хөгжүүлж байдаг салбар. Биднийг шинэ хамт олон хүрээлэлд оруулж, шинэ хүн, байгууллагатай танилцуулж, зөв харилцаа хандлага суулгадгаас гадна гадаад хэл сурахад түлхэц өгдөг салбар юм. Иймээс НИТАЖ-ын үйлчилгээ, үйл ажиллагаагаа түргэн шуурхай, үр дүнтэй явуулахад таныг өөрийн эрхгүй түлхэн хөгжүүлэх болно.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхэд олон янзын хувь хүмүүс, бизнесийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж гэрээ хийх шаардлагатай болдог. Та өөрийн бизнесээ амжилттай, элдэв асуудалгүй явуулахын тулд хамтын ажиллагааны зарчмуудаас суралцаж, дадлагажин, гэрээ хамтын ажиллагааны үндсэн дээр итгэлцэл, найдвар, зөв ойлголцлыг буй болгож ажиллах нь хамгийн чухал юм. Жуулчдаа татан бизнесээ амжилттай явуулахын тулд гэрээ хэлэлцээрээ сайн хийж, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг алдалгүй, чанартай, сайн үйлчилгээг байнга үзүүлж, улам сайжруулан ажиллах ёстой болно.

Манай орны аялал жуулчлалын салбарт мэргэшсэн, чадварлаг боловсон хүчний эрэлт хэрэгцээ их байна. Иймээс гэр кэмп ажиллуулдаг газрын ахлагч, дарга нар өөрсдөө үүнд суралцаж, шаардлагатай ур чадвар, мэдлэгийг эзэмших хэрэгтэй.

Багийн ахлагчийн хувьд та гишүүдтэйгээ ойр дотно байж, байгууллагынхаа дотоод журмыг хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй. Багийн бүх гишүүдийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, аюулгүйн дүрмийг чандлан мөрдөх хэрэгтэй.

Аливаа бизнесийн үнэ цэнэ нь ажиллаж буй хүн өөрөө байдаг. Иймээс гишүүдийнхээ ур чадвар, хандлагыг дээшлүүлэхэд хүчин чармайлт гарган, өөрийн харилцааны ур чадвар хандлагаа сайжруулж, байгууллагынхаа дотоод соёлыг бүрдүүлэн, "хийнгээ суралцах"-д тэмүүлсэн хамт олон болохын төлөө ажиллах нь чухал. Энэ нь үйл ажиллагааг тань улам бүр өргөжүүлж, амжилт гаргахад туслах болно. *Багийн гишүүдийн ур чадварыг хөгжүүлэх, нэг баг болж ажиллах талаар 9 ба 10-р хэсгээс олж уншаарай.*



Дотоодын жуулчин их байх тусам жуулчны улирал уртасна. Манай орны аялал жуулчлалын улирал хязгаарлагдмал, богино хугацаатай боловч НИТАЖ-ын үйлчилгээ үзүүлэх боломж сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Цар тахлын эерэг нөлөө бол дотоодын аялал жуулчлал хөгжүүлэхэд түлхэц болсон явдал юм. Иймээс та бүхэнд бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэх боломж гарч, аялал жуулчлалын улирал ч уртсаж байна. Гэвч хүйтний улиралд үйл ажиллагаа явуулах хүндрэлтэй байсаар байна. *Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөтөлбөрөө боловсруулах талаар олон санаануудыг 12-р хэсгээс олж мэдээрэй.*

Аюулгүй байдал

Гэр кэмпээ барих, төлөвлөх болон үйл ажиллагаагаа явуулахдаа аюулгүй байдал нэн түрүүнд гэдгийн байнга санаж ажиллаарай. Энэ талаар дараах хэдхэн зүйлийг дурдлаа. *Дэлгэрэнгүй мэдээллийг 17-р хэсгээс үзээрэй.*

Уламжлалт монгол гэрт анхаарах нэг зүйл нь жуулчид гэрийн хаалганы тотгыг мөргөх асуудал их гардаг. Иймд хаалга мөргөхөөс болгоомжилсон бичиг байрлуулахаас гадна тотгоны дотор хүн их мөргөдөг хэсэгт эсгий эсвэл хатуу порлон гэх мэт материалаар зөөлөвч хийж өгч болно.

Ихэнх гадны жуулчид, ялангуяа Хойд Америк, Европ, Австрали, Шинэ Зеланд, Сингапур, Солонгос зэрэг орны аялагчдын нохойд хандах хандлага манайхнаас тэс өөр байдаг. Эдгээр оронд нохойг гэрийн тэжээвэр амьтан, гэр бүлийн нэг гишүүн гэж үзэн гэртээ байлгадаг. Тэр ч бүү хэл гэрт шинэ хүүхэд төрөхөд гөлөг авч тэжээн хүүхэдтэйгээ хамт өсгөдөг. Тиймээс жуулчид нохойг илж эрхлүүлдэг бөгөөд манайхны нохой ямар орчинд байж, юу иддэгийг мэддэггүй. Нохой манай оронд ихэнхдээ хамгаалах үүрэгтэй учир илэх, эрхлүүлэхэд тийм ч дуртай биш гэдгийг зочиндоо хэлж зарим ноход догшин гэдгийг сайн сануулах хэрэгтэй. Мөн нохойд хүрсний дараа гараа заавал ариутгахыг хэлж өгөөрэй.





Хэрэв танайд зөөлөн ааштай, эрхлэх дуртай нохой, гөлөг, муур байдаг бол жуулчид хамт тоглож эрхлүүлж болно шүү дээ. Хамгийн чухал нь аюулгүй байдлыг сахиж, мэдрэмжтэй байхад л болно.

Ихэнх орон амьтанд зэрлэгээр хандахыг эсэргүүцдэг, тэр бүү хэл амьтдыг хамгаалдаг хуультай байдаг. Тиймээс нохой болон бусад амьтдад ширүүн хандвал жуулчид дургүй гэдгийг мэдэхэд илүүдэхгүй.

Зочны гэр, хоол хийх хэсэг зэрэг газарт гал унтраах хэрэгсэл байршуулаарай. Та болон бусад гишүүд гал унтраах хэрэгслийг хэрхэн ашиглах, хаана байгааг мэдэж байх ёстой.

Гэр кэмпэдээ анхан шатны тусламж үзүүлэх хэрэгслийг байнга байлгаж хэвшээрэй. Та болон бусад гишүүд анхны тусламжийн хэрэгслийг хэрхэн ашиглаж тусламж үзүүлэх, яаралтай үед хаана байгааг мэдэж байх ёстой. *Аюулгүй байдлын талаар 17-р хэсгээс дэлгэрэнгүй мэдэж аваарай.*



ХЭСЭГ 12. САНАЛ БОЛГОХ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Өмнөх хэсэгт гэр кэмпээ байгуулахын чухлыг дурдсан бол жуулчдадаа санал болгох сонирхолтой бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх нь түүнтэй эн тэнцүү чухал зүйл юм.

Санал болгох бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаагаа боловсруулахдаа яагаад Монголд жуулчид ирдэг, НИТАЖ гэж юу вэ гэдгээ дахин сайн хараарай.



Гадаадын жуулчдын дунд яагаад манай орныг зорьдог талаар 2018 онд хийсэн судалгаанд тэд дараах байдлаар хариулжээ:

- 70 % - Онгон дагшин байгаль
- 50% - Нүүдлийн соёл уламжлал, ахуй амьдрал
- 25% - Монгол орон, Чингис хааны түүхт нутгийг үзэхээр ирдэг гэжээ.

Мөн судалгаанд хамрагдсан жуулчдын 70 орчим хувь нь 14 хүртэл хоногоор хөдөө орон нутгаар аялж, амраад буцдаг байна. Судалгаанд оролцогчдын 62 хувь нь Монгол улсад нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой гэж дүгнэсэн аж.



Дээрх судалгаа жуулчдын дийлэнх нь дан ганц байгаль, нүүдлийн соёлтой танилцах гэж ирдэггүй гэдгийг баталж байна. Үнэн хэрэгтээ жуулчид нүүдлийн малчин ахуйг сонирхож гэрт хонож үзэн, нутгийнхантай ярилцан тэдний нэг хэсэг байж үзэхээр ирдэг байна. Тэд өвөрмөц зүйлийг хайн манай орныг зорьдог.

Жуулчдын энэхүү сонирхол та бүхэнд аялал жуулчлалаар дамжуулж өөрийн нутгийн байгаль, уламжлал, түүх соёлоо түгээн дэлгэрүүлэх боломж өгч, үүний сацуу та жуулчдад тэдний амьдралд ганц тохиох ховор дурсамжийг буй болгож байгаа явдал юм.

Орон нутгийн иргэд, нөхөрлөл, бүлгүүд НИТАЖ-ыг гардан зохион байгуулж хөгжүүлснээр дараах үр дүнд хүрэх боломжтой.

- Орон нутгийн нөөц баялаг болох байгаль, түүх, соёл, уламжлал, зэрлэг амьтан, мал ахуйгаа хамгаалан хадгалж, хойч үедээ өвлүүлээ үлдээнэ.
- Өөрийн нутаг орон, хүмүүсийн өвөрмөц ахуйг илтгэсэн аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлж түгээнэ. Нутаг орныхоо онцлогийг тусгасан аяллын сонирхолтой хөтөлбөр боловсруулахад аймаг сумын энэ чиглэлээр ажилладаг бүлэг, хүмүүстэй хамтран ажиллана.
- Айл өрхүүд нэмэлт орлогын эх үүсвэртэй болох боломжтой. Эх болсон байгаль дэлхийн хишиг хэмээн үзэж орсон орлого, ашгаа эн тэнцүү хуваан авна.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа, хөтөлбөр боловсруулах

НИТАЖ-ын аяллын хөтөлбөрийг нутгийн иргэдийн аж амьдрал, соёл, түүх, өвөрмөц онцлогт тулгуурлан бүтээдэг. Та эдгээр үнэт зүйлсээ дотоод, гадаадын зочид, жуулчдад танилцуулж үзүүлнэ гэсэн үг. Бүлэг, нөхөрлөлийн гишүүд НИТАЖ-ыг өөрсдөө удирдаж, эрхэлдэг тул өөрсдийн ахуй амьдрал, төрөлх нутгаа дэлхий дахинд хэрхэн харуулахаа сонгож шийддэг.

Юуг сонгож үзүүлэхээ шийдэхийн тулд бидэнд үзүүлэх ямар сонирхолтой, сайхан зүйлс байгаа вэ гэдгээ ярилцаж шийдэх хэрэгтэй:

Байгаль - Үзэсгэлэнт тогтоц, газрын үзэмжит байдал, уул хад, агуй, хөвч ой мод, эмийн ургамал, нуур голын ай сав гэх мэт.

Соёл - Уламжлалт хувцас, хэрэгсэл, орон нутгийн идээ ундаа, итгэл үнэмшил, дуу, хөгжим, хөгжмийн зэмсэг, уламжлалт ахуй амьдралын ёс заншил, уламжлалт гэр сууц, онцлог баяр наадам, арга хэмжээ гэх мэт.



Хүмүүс - Нутгийн уламжлалт ухаан, түүх, удирдагч/манлайлагчид, бүлэг, нөхөрлөлийн гишүүд, эв нэгдэл, мужаан, дархан, гар урлалын ур чадвар гэх мэт.

Жуулчдад зориулж үйл ажиллагаагаа төлөвлөхдөө анхаарах ерөнхий зарчмууд

НИТАЖ-ын аяллын хөтөлбөр, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг амжилттай хөгжүүлэхийн тулд дараах зарчим болон удирдамжийг мөрдөх боломжтой:

- Таны санал болгож буй арга хэмжээ, үйл ажиллагаа хөгжилтэй, аюулгүй, мэдлэг мэдээлэл олгодог байх хэрэгтэй.
- Сонирхолтой зүйлсийг харуулах, түүх соёлын өвийн газруудаар аялуулах, туршлага хуримтлуулах аялал зэргийг хослуулан хийх хэрэгтэй.
- Ажиглаж харахын оронд "гараар хийж үзэх" үйл ажиллагааг хөгжүүлэх нь зөв. Таван мэдрэхүй болон төсөөллийг ашиглаад үзээрэй.
- Үйл ажиллагаа, үйлчилгээгээрээ нутгийн иргэд, соёл, байгаль хоорондын харилцааг харуулахыг зорих хэрэгтэй
- Жуулчдад нутгийн иргэдтэй уулзаж, ярилцах боломж олгох нь тааламжтай харилцаа үүсгэдэг гэдгийг бодолцоорой.
- Үйл ажиллагаа нь зорилтот жуулчдад тохирсон байх ёстой. Жуулчдынхаа нас, биеийн байдал, сонирхлыг бодолцож үзээрэй.
- Тухайн үйлчилгээ, үйл ажиллагааг хөгжүүлэхэд өөрсдийн нөөц боломж, багийн гишүүдэд шаардлагатай ур чадвар байгаа эсэхээ бодолцоорой. Хэтэрхий өндөр стандарт, аюулгүй байдал шаардсан өөрсдийн боломж бололцооноос хэтэрсэн зүйл бүү төлөвлөөрэй.
- Жилийн турш, улирлын чанартай хийж болох үйл ажиллагаагаа боловсруулахыг хичээгээрэй.
- Хагас, бүтэн өдрийн, хэд хэдэн өдрийн аяллын үйл ажиллагаа бодож төлөвлөөрэй. Ялангуяа нэлээд хэдэн өдөр, хоногоор хийх аялалд юу хэрэгтэй бол гэдгийг сайтар тооцоолоорой. Учир нь унаа, хоноглох байр, хоол унд гээд олон зүйлийг төлөвлөж зохицуулах хэрэгтэй болдог.
- Хэрвээ та аль хэдийн аялал жуулчлал эрхлээд эхэлсэн бол юу нь болж, юу болохгүй байсан болоод жуулчид юуг илүү сонирхсон, явал илүү сайжруулж болох тухай өөрийн туршлагаа бичиж тэмдэглэвэл их хэрэгтэй. Мөн ирсэн зочид санал хүсэлтээ бичих "Жуулчны дэвтэр" ажиллуулбал зүгээр.



- Нутгийн хөтчөө сайн сургаж дадлагажуулснаар тэд үнэн зөв, нягт нямбай, сонирхолтой мэдээллийг жуулчдад өгч сурдаг.
- Аяллаа төлөвлөж, хийхдээ аюулгүй байдал (17-р хэсэг), цагийн зохицуулалт зэргийг байнга санаарай.

Аяллын хөтөлбөр боловсруулах

Аяллын боломжит хувилбарууд, үзүүлэх газрын жагсаалт, жуулчдыг оролцуулан хийх үйл ажиллагаа, арга хэмжээгээ тохирч гаргасны дараа хөтөлбөр, хуваариа боловсруулах хэрэгтэй болно.

Хөтөлбөрөө сайн боловсруулахад хэрэгтэй зөвлөмжийг орууллаа.

- Зочдоо халуун дотноор угтан хүлээн авч багийн гишүүдээ танилцуулаарай.
- Аяллын хөтөлбөр нь НИТАЖ-ын бүлэг, нөхөрлөлд байгаа аялал жуулчлалын хамгийн чухал газруудаас эхэлснээр жуулчид 'том зургаар' ерөнхийд нь харж мэдэрч эхэлдэг. Тухайлбал, малчны гэрт зочлон, нутгийн хоол идэх гэх мэт.
- Үүний дараа илүү нарийвчилсан мэдээлэл өгч, туршлага болох арга хэмжээ рүүгээ ороорой. Нутгийн бусад хүмүүстэй уулзаж, гар урчуудаар зочилж, хөгжмийн зэмсэг, урлагийн бүтээлүүдээ танилцуулан, тахин шүтдэг уул усаа үзүүлж болно.
- Бүтээлч байгаарай. Та бүхний өдөр тутмын амьдрал гадаад жуулчдад сонирхолтой байдаг. Иймээс сум, багийн төвийн дэлгүүр мухлагуудаар оруулж үзүүлсэн ч болно.
- Мал хариулах, хоол хийх, ноос боловсруулах, дээс томнох зэрэг гар урлалын ажлуудыг жуулчдаараа хийлгэж үзүүлж болно.
- Хөтөлбөр, хуваарьтаа чөлөөт цаг оруулж өгөхөө битгий мартаарай. Нэг өдрийн дотор хэт их зүйл үзүүлж, хэт хол битгий яваарай.
- Хаана хэзээ хоол идэхээ сайтар төлөвлөөрэй.
- Ариун цэвэр, бие засах газар зэргийг сайтар бодолцоорой. Боловсон эсвэл байгалийн бие засах газраа сайн зохицуулаарай.
- Аяллын хөтөлбөр боловсруулсан жишээг Хавсралт 15-аас харна уу.

Бэлэг дурсгалын зүйлс хийх, худалдан борлуулах

Аяллын үйлчилгээгээ хөгжүүлэхийн хажуугаар өөрсдийн хийдэг бүтээгдэхүүнээ жуулчдад зарж борлуулан орлого олж болно. Та бүхэн өөрсдийн тарьж, хийж, хэрэглэж заншсан бүтээгдэхүүнтэй шүү дээ. Тухайлбал, чацаргана, зөгийн бал, борц, ааруул цагаан идээ гэх мэт. Сав баглаа боодолтой болговол эдгээр бүтээгдэхүүнээ бэлэг дурсгалын зүйл болгон шууд худалдах боломжтой.



Гэвч өөр олон боломж байгаа гэдгийг санаарай. Танай нутагт гарын уртай эрчүүд, эмэгтэйчүүд байдаг биз дээ. Гар урчууд нутаг орныхоо онцлогийг тусгасан бүтээгдэхүүн хийж, түүнээ жуулчдад худалдаж болно. Гэхдээ худалдан авах бүтээгдэхүүн нь авсаархан, овор багатай байвал гадаадын жуулчид их авна.

Бэлэг дурсгалын зүйл гэж юу вэ?

Бэлэг дурсгалын зүйл гэдэг нь жуулчид танилцсан хүмүүс, үзсэн газар орныхоо талаар санан дурсаж явах үүднээс худалдан авдаг бүтээгдэхүүн юм.



Үүнд өөрийн очсон жижиг нуураас олсон чулуунаас аваад эсгий шаахай, арьсан цүнх, шагай, араг, савар ч байж болно.

Дараах бүтээгдэхүүнүүдийг бид ерөнхийд нь бэлэг дурсгалын зүйлс гэж нэрлэдэг:

- » Бээлий, гэрийн шаахай, цамц, малгай, ороолт, хүрэм, футболк гэх мэт хувцас
- » Орон нутгийн цай, зөгийн бал, чанамал, чихэл, бяслаг, архи гэх мэт идэж уух зүйлс
- » Хүзүүний зүүлт, бугуйвч, ээмэг зэрэг гоёл чимэглэлийн зүйлс



- » Чихмэл, эсгийгээр хийсэн амьтдын дүрс гэх мэт тоглоомууд
- » Ном, бичиг хэргийн зүйлс, хөгжмийн зэмсэг
- » Хөргөгчин дээр наадаг соронзтой дүрсүүд, түлхүүрийн оосор, уламжлалт хүүхэлдэй гэх мэт цуглуулгын зүйлс
- » Саван, тос, уруул өнгөлөгч зэрэг гоо сайхны бүтээгдэхүүнүүд
- » Цүнх, арьсан түрийвч, хутга, эсгий улавч
- » Уран зураг, баримал зэрэг урлагийн бүтээл

Бэлэг дурсгалын зүйлээ хэрхэн бүтээх вэ?

Олон бүтээгдэхүүн хийх санаа байгаа ч та хэдхэн зүйлийг эхний ээлжид хийж болно. Бүтээгдэхүүнээ хийж эхлэхдээ зарна гэсэн бодлоосоо илүү чанартай, нарийн нямбай хийхээ урьтал болгохыг хичээгээрэй.

Зөвлөгөө:

1. Таны хийсэн бүтээгдэхүүнийг хэн худалдаж авах талаар нарийн бодож төлөвлөөрэй. Гадаадын болон дотоодын аялагчдын сонирхол өөр гэдгийг та мэдэж байгаа шүү дээ. Үүнээс гадна боломжит худалдан авагчийн нас, хүйс, сонирхол, хаанаас ирсэн гэдгийг сайтар бодолцох нь зүйтэй. Дотоодын жуулчид өөрсдийнхөө унаагаар аялдаг учир ямар нэгэн том оврын зүйл худалдан авахад төвөггүй ачаад явах боломжтой. Харин гадаадын жуулчид хол газраас ихэвчлэн онгоцоор ирдэг учир хэлбэр, хэмжээ, хүнд хөнгөнийг их хардаг. Дотоодын аялагчид хүнсний зүйлс, цагаан идээг ихээр сонирхон авдаг бол гадаад жуулчид хэрэглэж болохоор дулаан ноосон оймс, арьсан цүнх, эсхүл чимэглэлийн зүйлс болох хээ хатгамал бүхий дэрний уут, манай орны байгалийн зураг зэргийг сонирхон худалдан авах их сонирхолтой байдаг.
2. Танайд зочилж буй нь жуулчдын аяллын зөвхөн нэг хэсэг гэдгийг санаарай. Олон улсын жуулчид аяллаа ихэвчлэн Улаанбаатараас эхлээд тэндээ дуусгадаг. Хотод олон төрлийн бэлэг дурсгалын дэлгүүрүүд байдаг. Иймээс ч тэд аяллын төгсгөлд бэлэг дурсгалын зүйлээ тэндээс авдаг. Гэвч тухайн орон нутгийн онцлог шингэсэн бүтээгдэхүүн байвал очсон газраасаа авахыг хүсдэг.
3. Тухайлбал, Ховд аймаг тарвасаараа алдартай. Тиймээс Ховдоор аялагчид тарвастай холбоотой бэлэг дурсгалд өөрийн эрхгүй татагддаг. Олон сарлагтай нутгийнхан сарлагийн ноосоор хийсэн оймс зэргийг хийж борлуулж болно. Тухайн бүтээгдэхүүний онцлог гэхээсээ илүү нутаг орны өвөрмөц байдал, ялгарах онцлогийг шингээсэн байвал бэлэг дурсгалын зүйл болж чадна.



4. Жуулчид манай орны хөдөө нутгийн сайхан, хүн ардын ахуй амьдралыг харан бахдан баясдаг учраас нутгийнхны хийсэн бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлийг худалдан авч дэмжихийг хүсдэг. Гэхдээ мэдээж үүнийн хувьд боломжийн байх хэрэгтэйг санаарай.
5. Манай орны өөр хаанаас ч авах боломжгүй тийм бэлэг дурсгалын зүйл байх нь их чухал. Эсгий гэрийн шаахай хийх нь одоо үед тийм ч сайхан санаа биш болов уу. Улаанбаатарын дэлгүүрүүдээр олон төрлийн өнгө, хэлбэр, хэмжээ, загварын эсгийн шаахай, гутал зарагддаг учир түүнтэй өрсөлдөн хийж зарна гэдэг нэлээд хэцүү.



6. Харин гар урлалын зүйлс хийж байгаа үйл явцад жуулчдыг оролцуулах нь тэднийг энэ талаар туршлагатай болгоод зогсохгүй, худалдан авах хүслийг ч төрүүлдэг давуу талтай. Баян-Өлгий аймаг уран хатгамал бүхий орны аравч, бүтээлгээрээ алдартай бол Увс чацаргана жимсээрээ, Хөвсгөлийн тайгынхан цаа бугийн эврээр хийсэн зүйлсээр танигдаад байна.
7. Аль болох орон нутагт байдаг материалаа ашиглаж хийгээрэй. Арьс, савхин эдлэл их сайхан бэлэг дурсгалын зүйл болдог. Гэхдээ үнэхээр сайн элдсэн савхийг та хот суурин газраас худалдан авах шаардлагатай бол унаа, түүхий эдийн зардал нэмэхээр бүтээгдэхүүний үндсэн үнэ өсдөг. Хэрвээ үнэхээр таны хийж буй бүтээгдэхүүний чанар сайжирна



гэж үзвэл та өөр газраас түүхий эдээ авч болно.

8. Үндэс угсаагаа тусгаарай. Монгол олон ястан үндэстний орон бөгөөд дээл хувцаснаас гадна өөр олон зүйлээрээ ялгаатайг бид сайн мэднэ. Эдгээр онцлогуудыг харгалзан хийвэл илүү их утга учиртай сайхан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн болно. Зарим аялагчдын хувьд эдгээр онцлогуудыг хадгалсан зүйлсийн цуглуулга хийдэг байж болно шүү дээ.
9. Өөрийн нутгийн дэлгүүрүүдтэй холбогдож ажиллаарай. Аялал жуулчлалын улирал богино учир бүтээгдэхүүнээ зараад олох орлого ч бас бага байдаг. Нутгийнхаа дэлгүүр, цайны газар, кофе шоп, зочид буудлуудтай хамтран ажиллавал борлуулалт сайн байх талтай.
10. Бэлэг дурсгалын зүйлийн үнээ зөв, боломжийн байдлаар тодорхойлоорой. Бүтээгдэхүүнд орсон түүхий эдийн үнэ, зарцуулсан цаг, хөлсөө нарийн тооцож үнээ гаргаарай. Хэтэрхий бага үнэ хэлбэл түүхий эдээ хангалттай авч чадахгүйд хүрнэ. Үүнтэй ижил их үнэтэй байвал зарагдахгүй болж эргэлт удаашрах нь ойлгомжтой.





11. Нутагтаа болж буй баяр наадам, арга хэмжээтэй уялдуулан бүтээгдэхүүнээ хийж болно. Иймэрхүү арга хэмжээнүүдийг алдалгүй мэдэж, тохирсон бүтээгдэхүүн хийж борлуулах боломж байдаг. Ховдод болдог цайны баярын үеэр цайны багц идээ барьсан чихмэл амьтад, цай тээж буй тэмээн цуваа зэрэг бүтээгдэхүүн зарсан нь сайхан санаа байсан. Мөсний баяр, Сарлагийн баярын үеэр иймэрхүү бүтээгдэхүүнүүд хийж зарвал эрэлттэй байх болов уу.
12. Шошго, сав, баглаа боодол. Хийсэн бэлэг дурсгалын зүйлээ ууталж савлавал худалдан авагчдаа тухайн бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөхөөс гадна нутгийнхаа үүх түүхийг таниулах боломж гардаг. Ялангуяа хоол хүнс, гоо сайхны бараанд шошго, танилцуулга зайлшгүй хэрэгтэй. Сав, баглаа боодлын материал нь байгальд ээлтэй байх хэрэгтэй бөгөөд даавуун торонд савлаж өгөхөд гадаадынхан их дуртай байдаг. Мөн авч явахад хялбар шүү дээ.
13. Байгалиас санаа авсан байвал их сайн. Манай орон өргөн уудам тал нутаг, онгон байгалиараа жуулчдыг татдаг. Байгалийн амьтан, ургамлын бэлэг дурсгалын зүйл байвал өөрийн эрхгүй байгальд хайртай жуулчдын сэтгэлийг татна. Гэвч зэрлэг, ховордсон амьтны хэсгүүдийг явч хэрэглэж болохгүй.
14. Энгийнээс эхлээрэй. Бэлэг дурсгалын зүйлийнхээ санааг олж, хийхэд цаг хугацаа ордог. Хэрвээ та санаагаа олсон бол эхний удаа хэдхэнийг хийж, туршиж үзээрэй. Жуулчид сонирхон үзэж, худалдан авч байвал та бүтээгдэхүүний тоогоо нэмж үйлдвэрлэж эхлээрэй.
15. Үргэлж сайн чанарын бүтээгдэхүүн хийж, чанараа хадгалаарай. Бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмжийг хадгалах нь борлуулалтаа өсгөх хамгийн гол шалгууруудын нэг байдаг. Цаашдаа бүтээгдэхүүнээ сайжруулж, шинэ санаагаар баяжуулан хөгжүүлээрэй.



ХЭСЭГ 13. ОРОН НУТГИЙН ИДЭЭ УНДАА, ЭРҮҮЛ АХУЙН СТАНДАРТ

Гадны болон дотоодын жуулчдын хувьд аяллын хамгийн чухал хэсэг нь хоол, идээ унд байдаг. Тэр ч байтугай зөвхөн хоолны соёлоор дагнасан аяллын төрлүүд олон улсад ихээхэн хөгжиж байна. Манай орон нүүдлийн соёл уламжлалд түшиглэсэн аж ахуйтай тул бидний өвөрмөц ахуйг сонирхон хоолны амтыг үзэхийг гадаад жуулчид илүүтэй хүсдэг. Хамгийн гол нь идээ ундаа тань хүний биед харшил өгөхөөргүй, элдэв сөрөг нөлөөгүй, ариун цэврийн хувьд шаардлага хангасан байхад анхаарах нь зүйтэй.

Хайрцагт оруулсан доорх мэдээллээс гадаадын жуулчид Монгол хоолны талаарх өөрсдийн бодлыг хуваалцсаныг уншаад тэднийг хоолоор дайлахдаа юуг анхаарах хэрэгтэйг олж мэднэ гэж бодож байна. Эдгээр жуулчид бүгд өөр өөр орноос ирсэн бөгөөд өөрсдийн сэтгэгдлийг ний нуугүй хэлсэн байгаа. Бидний өдөр тутмын хэрэглэж заншсан хоол хүнсийг ихэнх гадаадын жуулчин идэж чадахгүй байдаг шалтгааныг тэд дурджээ.





Жуулчид идсэн хоолныхоо талаар илгээсэн санал хүсэлтүүдийг харвал:

Гэр баазаар үйлчлүүлсэн жуулчдын сэтгэгдэл:

- Хоолны нэр төрөл ихэнх баазууд дээр давтагддаг.
- Жуулчны баазын ресторанууд ангийн үсээр гоёсон байсан нь эвгүй сэтгэгдэл төрүүлсэн.
- Хоолны мах маш их өөхтэй.
- Ногооны салат идээд гэдэс өвдсөн.
- Ус солигдоод эвгүйрсэн.
- Нэг төрлийн цай, кофе санал болгодог. Амттаны төрөл зүйл адилхан.
- Замд идэхээр боож авч явсан хоол тохиромжгүй, хөрсөн байсан.
- Олон аймгаар дайран өнгөрч явсан боловч тухайн газрын онцлох хоолыг идэж үзээгүй.

Хээрийн аялалд явсан жуулчдын сэтгэгдэл:

- » Олон төрлийн салат, хоолны сонголттой байсан.
- » Хуванцар хоолны хэрэгсэл өгсөн, 1 удаагийн аяга таваг их ашигладаг. Жижиг савтай ус их авч явдаг.
- » Лаазалсан, нөөшилсөн бүтээгдэхүүн их хэрэглэсэн.
- » Хэт их махтай хоол идсэн тул шөнө шингэхгүй тухгүй унтсан.

Малчны гэрт хоносон жуулчдын сэтгэгдэл:

- Маш найрсаг зочломтгой байсан.
- Монгол архиар их шахуулсан. Монголын ёс 3 гээд том аягаар шимийн архи уулгасан. Өглөө нь толгой өвдөж сэрсэн.

Жуулчдын хооллох зуршлыг ойлгож мэдэх

Юун түрүүнд цаг агаар, газарзүйн онцлог, шашин шүтлэг зэргээс хамаарч жуулчдын идэж заншсан хоол биднийхээс нэлээд өөр байдаг гэдгийг ойлгоорой. Хоол хүнс нь хүний эрүүл, эрч хүчтэй байхын үндэс учир ихэнх жуулчид хүнсэндээ ихээхэн ач холбогдол өгдөг. Бид жуулчдыг хэт ерөнхийлж болохгүй ч гэсэн дараах хэдэн зөвлөгөө танд зочныхоо хоол ундыг бэлтгэхэд хэрэг болох байх гэж бодож байна.

Чийглэг дулаан уур амьсгалтай бүс нутгаас ирсэн жуулчид ихэнхдээ төрөл бүрийн ногоо, жимс, загас, тахиа голдуу хэрэглэдэг. Хооллох нь тэдний хувьд гэр бүлээрээ ярьж хөөрч суух сайхан үе бөгөөд олон төрлийн хоол бэлтгэн хэрэглэж заншсан байдаг. Испани, Франц зэрэг газар дундын тэнгисийн орнуудад хоолны үеэрээ дарсыг түгээмэл хэрэглэдэг.



Цөөн жуулчид мах иддэггүй цагаан хоолтой, бүр зарим нь амьтны гаралтай ямар ч төрлийн бүтээгдэхүүн хэрэглэдэггүй ногоон хоолтой байх нь бий. Харин мах, өөх орсон хоолыг илүүд үзэж, огт гурилан бүтээгдэхүүн хэрэглэдэггүй хүмүүс ч байдаг. Жуулчид хэт боловсруулсан хүнсийг эрүүл биш хэмээн хэрэглэх дургүй байдаг. Мэдээж лаазалсан бүтээгдэхүүнийг аялалд авч явахад амар ч гэсэн жуулчид тийм ч дуртай биш байдаг.

Урьд нь дурдаж байсанчлан харшилтай хүмүүс байдаг гэдгийг санахад илүүдэхгүй. Зарим харшил амь насанд хүртэл аюултай бөгөөд дэлхийн хэмжээнд харшилтай хүмүүсийн тоо улам бүр нэмэгдэж байна. Зарим хүмүүс сүү цагаан идээ, гурил, гоймон, талх, жигнэмэг зэргийг шингээх чадваргүй байдаг.

Мөн шашин шүтлэг, уламжлалт соёлтой холбоотой горимууд байна. Тухайлбал, лалын шашинтнууд гахайн мах иддэггүй, Энэтхэгчүүдийн зарим нь үхрийн мах амсдаггүй гэх мэт. Харин хойд Америкаас ирсэн хүмүүс адууны мах хэрэглэдэггүй. Гэвч хүн бүрийн хооллох зуршил өөр учир жуулчдаасаа энэ талаар асууж мэдэх хэрэгтэй.

Биднийг алс хязгаарт танихгүй улсад аялж байхад идэж чадахгүй, эсвэл эрүүл мэндийн хувьд зохицохгүй, шингээж чадахгүй хоолыг өдөр бүр өгөөд байвал тухайн аяллаас бид хэрхэн таашаал авах билээ. Мэдээж тухайн нутгийн алдартай эсхүл брэнд хоолыг амсаж үзэхийг хүсдэг ч таалагдахгүй байгаа хоолыг байнга санал болгох нь зохимжгүй юм.

Зочдод хоол хийж, үйлчлэх

Магадгүй та бүхэн дээрх зүйлсийг уншаад "Тэгээд бид зочдоо юугаараа дайлах болж байна?" гэж асуух байх. Энэ нь тийм ч хэцүү биш. Дээр хэлсэнчлэн аялж буй орныхоо хоол хүнсийг сонирхон үзэхгүй жуулчид гэж байхгүй. Дараах зүйлсийг анхаарахад илүүдэхгүй.

Болохгүй зүйлс:

- Ямар нэгэн хоол, ундыг ид уу гэж шахахгүй байх
- Амсаад идэхгүй орхивол битгий гомдоорой

Болох зүйлс:

- Тэдний уламжлал, шашин шүтлэг, хувийн дэг жаяг, сонирхлыг хүндэтгэн үзээрэй.
- Тэднээс тухайн хоолноос харшилтайг асуугаарай.

Айраг, ингэний ундаа зэргийг амсуулаад уухгүй гэвэл битгий дахин



өгөөрэй. Сүүтэй цайгаа уугаагүй үлдээвэл бүү гомдоорой. Эрэгтэй, эмэгтэй ямар ч зочин байсан архиар шахаж сайхан уур амьсгалыг эвдэх хэрэггүй.

Хамт хоол хийж үзэх

Ихэнх жуулчид орон нутгийн хоолыг идэж, хэрхэн хийдгийг нь их сонирхдог. Зочдоо дайлах олон сайхан хоолтой учир та бүхэн тэдэнтэй хамт хийж үзээрэй.

Жуулчид хоол хүнсээ хэрхэн бэлтгэн хийдгийг харах тун дуртай. Ялангуяа аялалд явахдаа хүнсээ хэрхэн муутгалгүй хадгалдаг гэдэг нь тэдний хувьд их сонин учир борцлох, шуузлах аргуудыг сонирхуулаарай. Нэлээд хэдэн хоол, унд бэлтгэх аргуудыг харуулж, хамт хийх боломжтой. Цагаан идээ, мах бэлтгэх зэрэг уламжлалт хоол хүнс бэлтгэхэд тэднийг оролцуулбал их сонирхож талархан хүлээн авна.

- Цагаан идээ бэлтгэх олон аргуудыг харуулж хамт хийх боломжтой. Сүүгээ саахаас эхлээд сүү хөөрүүлэх, өрөм загсаах, тараг бүрэх гэх мэт
- Гүүгээ зэлэн дээрээ саан гэрт оруулж, бүрхээрт хийн бүлэн айраг хийх аргыг харах нь тэдэнд яах аргагүй тун сонирхолтой байх болно.
- Хорхог хийж идэх нь их сонин учир хийх явцыг харуулж болно. Боорцог хайрах, мах шуузлах, бууз, хуушуур, банш чимхэх, цуйван, шөлтэй хоол хийж үзүүлэх хэрэгтэй.
- Архи нэрэх үйл явцыг хараад үнэхээр гайхах нь мэдээж. Зөөлөн амттай боловч согтууруулах чадалтай учир хамаагүй их бүү уулгаарай.

Хэрвээ зөвхөн танай орон нутагт хийдэг хоол, хүнс байвал хийж үзүүлбэл их сайн. Хийж үзүүлэхдээ тэдний оролцох эсэхийг асууж, сонирхож байвал хамт хийлцээрэй.

Хоол хүнсний гарал үүсэл, хадгалалт

Болж өгвөл нутагтаа бэлтгэсэн мах, сүү, ногоогоороо хоол хийж өгөх нь жуулчдад сайхан сэтгэгдэл төрүүлнэ. Өнөөдөр дэлхий дахинд хамгийн өндөр үнэлэгдэж байгаа хоолны газрууд өөрийн аж ахуйдаа бэлтгэсэн хүнсээр хоолоо хийдэг. Энэ нь зөвхөн аялал жуулчлалд ч биш хоол хүнсний эрүүл ахуйн хувьд хамгийн чухал зүйл болоод байна.

Дэлгүүр хоршооноос хүнсээ авах хэрэг гарах ч аль болох зайлшгүй хэрэгтэй гэснээ худалдан аваарай. Хүнсний зүйлийг шинэхнээр нь аюулгүй нөхцөлд хадгалах хэрэгтэй. Хэрвээ та ногоо тарьдаг бол зоорь



шаардлагатай болно. Тэрчлэн хоол хүнсээ цуглуулахдаа хог бага гаргах үүднээс аль болох баглаа боодол хэрэглэхээс зайлсхийгээрэй.

Хоолны цэсээ зохиох

Орон нутгийн хоол энгийн бөгөөд өвөрмөц байдаг. Зарим гэр кэмпүүд тансаг гадаад хоолоор дайлахыг хичээдэг ч заавал ингэх шаардлагагүй. Та болон танай тогооч гадаад хоолны жор хэрэглэж болох ч өөрийн хийдэг хоолоо л голлож хийгээрэй. Хоолны цэсээ зохиохдоо ямар хоол юутай сайн зохицдог гэдгийг сайтар бодолцоорой. *Тогоочоо сургалтад хамруулж, цэс зохиох, жор гаргах, аюулгүй, ариун цэврийн стандартуудыг баримтлах талаар 9-р хэсгээс танилцаарай.*

Хоолны цэсний загвар жишээ

Өглөөний цай

Өглөөний цайнд орон нутгийн хоол оруулах

- Боорцог, өрөм, сүү, бяслаг, ааруул (шинэхэн, хатуу биш), тараг, чанамал (өөрсдөө хийсэн), жимс
- Ази жуулчид өглөөний цайнд шөл идэх дуртай бол, барууны орнуудаас ирсэн хүмүүс тийм ч дуртай биш байдаг
- Эдгээр зүйлсийг худалдан авч зөв хадгалж хэрэглэх хэрэгтэй.
- Талх
- Овьёос
- Хатаасан жимс, самар
- Хиам, зайдас
- Өндөгийг чанаж, хуурч, шарж өгч болно. Шинэхэн байх нь чухал гэдгийг санаарай



Цай, кофе

Ихэнх жуулчид өглөөний цайнд сүүтэй цай уухгүй л болов уу. Харин түүний оронд кофе, цайгаар дайлаарай. Мөн байхуу цай нь хар, ногоон, жимстэй, ургамлын гээд хэд хэдэн төрлөөр байвал сайн.

Найруулдаг кофены хувьд шил, лаазтайг сонгож, ирсэн зочдод тааруулан жижиг тагтай саванд таслан гаргаж өгөх боломжтой. Хэрвээ та өөрийн үйлчилгээг



давуу талтай, мэдрэмжтэй болгохыг хүсвэл чанадаг кофе ашиглах боломжтой. Чанадаг кофены хувьд нэрэх, чанах зэрэг аргууд байдгаас өөрт тохирохыг ашиглаарай. Орон нутгийн дэлгүүрт элбэг байдаг чанадаг кофег худалдан авч хэрхэн хэрэглэх талаар судлан мэдэх хэрэгтэй. Хэрэв цахилгаан хэрэглэх боломжтой бол энгийн кофе чанагч ашиглаж болно.

Кофе нэрэх арга нь энгийн бөгөөд хэрэглэхэд хялбар байдаг. Буталсан нунтаг кофег зориулалтын шүүгч цаастай аяган дээр байрлуулан буцалсан халуун ус дээрээс нь бага багаар нэмж хийх энгийн арга байдаг. Тэрчлэн зориулалтын мока (moka pot) саванд бага хэмжээний ус хийн кофе нэмж хийж буцалгадаг арга ч байдаг.

Мока пот ашиглах аргыг
QR CODE-оор орж үзнэ үү.



Өдрийн хоол

Шөл, цуйван, хуушуурыг болгосон ногоо эсхүл салаттай хамт өгвөл болно. Өдрийн хоолонд шөл, салаттай хамт идэх нь бусад оронд маш түгээмэл. Хорхгийг орой биш өдрийн хоол тааруулан хийвэл сайн. Хуушуур, цуйванг авч явахаар хоолны халуун саванд хийж болно.

Хавчуургатай талханд зайдас, жимс, ногоо, бяслаг ч байж болно. Саями хиаманд жуулчид дуртай бөгөөд хадгалалт удаан даадаг. Хэрвээ өдрийн хоолоо авч явах бол гялгар сав, уут зэрэг нэг удаагийн хэрэглээнээс аль болох зайлсхийгээрэй.

Оройн хоол

Жуулчид тань хол замд алхан, морь унаад ядраагүй л бол оройн хоолоо хөнгөн байдлаар бэлтгээрэй. Оройн хоолонд шөлтэй хоол тохиромжтой байдаг. Ялангуяа алхаад хөлс их гарсан бол тэжээлтэй.

Хуушуур, буузыг орой өгөхөөр бол хуурч амталсан ногоогоор шанз бэлтгэн хийж болно. Боломжтой бол гуляш, бифштекс хийж өгөөрэй.

Ногоотой хоол бэлтгэх, салат хийх

Хүнсний ногоог хэт их болгож, нялцгайруулах хэрэггүй. Болж өгвөл шинээр нь, үл ялиг хатуу зажлууртай байхад болно. Салатанд хийх ногоогоо сайтар угааж хэрэглээрэй. Майонез аль болох хэрэглэхгүй



байхыг хичээгээрэй. Салатаа оливийн тосоор амталбал тохиромжтой бөгөөд даршилсан өргөст хэмх холих нь сайхан амт оруулдаг.

Махтай хоол бэлтгэх

- Ихэнх жуулчид өөхгүй мах иддэг учир махтай хоол бэлтгэхдээ өөхнөөс нь салгах хэрэгтэй.
- Хоол бэлтгэхээсээ өмнө ямар махаар хийх гэж байгаагаа хэлж, зочдоосоо саналыг нь асуугаарай. Ялангуяа адууны махыг сайн асууж байж бэлдээрэй. Хонины махны үнэр гадаадынхан хурц санагддаг учраас байнга хонины махаар хоол хийхээс татгалзаарай.
- Мал төхөөрсний дараа гэдэс дотор, толгой шийрийг нь чанаж өгөхгүй байсан нь дээр. Учир нь жуулчид тийм ч дуртай биш. Зарим нэг нь амсаж үзэхийг хүсэж болох ч болгоомжтой байхад илүүдэхгүй.
- Тарваганы мах өгч огт болохгүй. Хууль бус ан, тэгээд ч аюултай учир жуулчид дургүй байна. Хэрэв та ан хийх хууль ёсны зөвшөөрөлтэй л биш бол ангийн махаар дайлсны хэрэггүй.
- Махаар хоол хийхдээ хальс, үсийг нь сайн цэвэрлээрэй. Мах шинэхэн байх хэрэгтэй

Тусгай хэрэгцээ

Цагаан хоолтнууд мах иддэггүй. Зарим нь загасны мах иддэг байж болно. Ногоон хоолтнууд амьтны гаралтай ямар ч хүнс хэрэглэдэггүй. Тухайлбал, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, хэт их амтлагч гэх мэт. Тэд ногоо, будаа, жимс, гоймон, төмс, талх иддэг.

Лактозны харшилтай бол сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж болохгүй. Цардуул орсон бүтээгдэхүүн идэж чадахгүй хүн улаан буудай, арвай, талх, жигнэмэг гэх мэт гурил орсон бүтээгдэхүүн хэрэглэдэггүй. Цардуул нь кетчуп, шар буурцагны цуу (сояа/соевые соус), нэг удаагийн кофе, гоймон, шар айраг, лаазалсан бүтээгдэхүүн зэрэгт агуулагддаг. Ийм төрлийн хүмүүс жимс, ногоо, шош, бор будаа, овьёос, өндөг, мах, тараг, загас, шинэхэн бяслаг, самар, үр зэргийг иддэг.

Газрын самар, самар, үнээний сүү, өндөг, улаан буудай, шар буурцаг, загас, зарим нэг жимс, ногооноос харшилтай хүмүүс байдаг. Харшил нь амь насанд хүртэл аюултай байдаг бөгөөд зарим нэг нь харшилдаг зүйлээ үнэртэх, тухайн зүйл аяга, таваг, халбага, сэрээнд наалдах төдийд шууд харшилж эхэлдэг. Харшил ихтэй хүмүүс ихэнхдээ өөрийн эм, хэрэглэгдэхүүнээ авч явдаг. Гэсэн ч харшилсан үедээ эмчид үзүүлэх хэрэгтэй болдог. Энэ талаар дэлгэрэнгүйг анхан шатны тусламжийн тухай Хавсралт 16-аас харна уу.



Ундны усны аюулгүй байдал

Ундны усны тухай мартаж болохгүй. Ихэнх гадны жуулчид бидэнтэй харьцуулахад ус их уудаг бөгөөд ихэнхдээ өөрсдөө усны савтай явдаг. Цэвэршүүлсэн ус эсвэл буцалгасан усыг зориулалтын саванд хийж жуулчны гэрт байлгавал тохиромжтой.

Усаа буцалгах нь хамгийн аюулгүй ба хэдхэн минут буцалган хөргөхөд л болно. Цэвэр төмөр хувин, саванд хийж тавиарай. Ус ариутгагч төрөл бүрээрээ байдаг. Ширээн дээр байрлуулж, нарийн шлангаар гоожуулж хэрэглэдгээс аваад аялалд авч явахад зориулагдсан ч байдаг. Сайн чанарын ус цэвэршүүлэгч тийм ч хямдхан байдаггүй.

Байгаль орчны бохирдолд үүсэхээс зайлсхийж хуванцар савтай ус худалдан авахдаа том савлагаатайгаас авч байгаарай. Хэрвээ цахилгааны эх үүсвэртэй газар байрладаг бол усаа том баллоноор нь авч тавихад хаягдал бага гарна. Ихэнх жуулчид байгаль орчинд ээлтэй үйл хийхийн төлөө байдаг учир энэ үйлдлийг тань хараад талархах болно. Тэр бүү хэл "хуванцрын эсрэг жуулчид" гэсэн хөдөлгөөн ч өрнөж байсан. *Ундны усны аюулгүй байдлын тухай 17-р хэсгээс хараарай.*

Гал тогооны ариун цэврийн асуудал, аюулгүй байдал

Гал тогооны хэсэгт ажиллахдаа хормогч зүүх, үсээ хойш самнан сайтар боосон байх хэрэгтэйгээс гадна хөл ил гаргасан гутал болон хөл нүцгэн явахгүй байхыг анхаараарай.

Гарын ариун цэврийг байнга сахих ба гар угаах зориулалтын угаалтуур бэлдсэн байна. Гар ариутгагч хэрэглэн, зааврын дагуу гараа сайтар угаана.

Мах ногоо хэрчих модон гамбанз, хутга заазуур, хоол хутгагчийг тусад нь хадгална. Сав суулга цэвэрхэн байхад анхаарч, элдэв хөө тортгийг дор бүр нь арилгаж байх хэрэгтэй.

Угаалгын бодис бага ашиглахыг хичээж гарын доорх элбэг олдоцтой хужир, давс, сод, халуун ус ашиглан аяга тавгаа угааж ариутгах ёстой. Хэрвээ угаалгын бодис хэрэглэсэн бол сав суулгаа усаар сайтар зайлаарай.



Аюулгүй байдал

Уламжлалт яндантай зуух ашиглаж хоол хүнс бэлтгэдэг бол бүрэн бүтэн байдал, битүүмжлэлийг сайтар шалгаж угаарын хий болон галын аюулгүй байдлыг хангаарай.



Хийн зуух ажиллуулдаг бол найдвартай газраас худалдан авч, зааврын дагуу нээж, хаах, засвар үйлчилгээг хийлгэх, баллоны лац тэмдэглэгээ, тээвэрлэлт, хадгалалтад тавих журмыг биелүүлээрэй. Нөөц газын баллоныг заавал бэлэн байлгаж, аюулгүй газар хадгалж заншаарай.

Жижиг газын зуух ашигладаг бол аюулгүй газар байрлуулах, хэрэглэж байхад гулсахгүй байхаар байрлуулж, хэрэглэсэн баллоныг жижиг газар цоолж ил задгай хаяхгүйгээр төвлөрсөн хогны цэгт хаяна. Мөн халуун зуухнаас сэргийлж жийрэглэх зориулалтын зузаан бээлийг оёж урьдчилан бэлдсэн байна.

Хэрвээ цахилгаан хэрэглэдэг бол шалбарсан утсыг яаралтай засах хэрэгтэй бөгөөд нэг залгуурт хэт олон зүйл залгахгүй байх хэрэгтэй.

Хүнсний хадгалалт

- Хүнсний бүтээгдэхүүнийг даавуун уутанд болон хайрцагт хийж хадгална. Хүнсээ хольж нийлүүлэхгүй байхад анхаарч зориулалтын хайрцагт хийж хэвшээрэй.
- Цэвэр ус хадгалах саваа байнга цэвэрхэн байлгах хэрэгтэй.

Хог хаягдал

- Хогоо хуванцар, төмөр, шил, цаас, хоол хүнсний, дахин боловсруулалт хийгдэх зэргээр ангилж хаяарай. Энэ талаар 15-р хэсгээс дэлгэрэнгүй үзээрэй.
- Жимс ногооны хальсыг тусад нь авч бордоо хийх эсхүл малын тэжээл хийхэд хэрэглэж болно.
- Хоолны үлдэгдлээр хээрийн амьтан, шувуу хооллож дасгах хэрэггүй.



Аяллын гал тогоо

- Майханд гал тогооны хэсэг байх бол хоол хийх, хүнсээ хадгалах, хананаас зайтай зуух байрлуулахуйц хангалттай зайтай байх хэрэгтэй.
- Хүчтэй шуурга, салхи, бороонд тэсвэртэй бат бөх байх, татлагаа бүрэн татсан байх хэрэгтэй.
- Хийн (газын) зуухыг аюулгүй тээвэрлэх, нээх, хаахдаа анхаарч, засвар үйлчилгээг дор бүрд нь хийх, илүү сэлбэг хэрэгсэл байнга авч явах нь зайлшгүй. Модон хайрцагт хийж шланкыг нугалахгүйгээр ороож авч явах.
- Газын баллоныг зориулалтын дагуу ашиглах, мэргэжлийн албан ёсны газраар баллоноо шалгуулж газ авах, солих, зориулалтын очлуур ашиглах.
- Жижиг нэг удаагийн газын плитк авч явдаг бол хэрэглэсэн газын саваа буцаан авчирч хаях.
- Хийн зуухыг газраас хөндий байрлуулах.
- Гал тогооны хэрэгслүүдийг гэмтээхгүйгээр төрөлжүүлэн ачиж баглаж сурах.
- Усаа зөвхөн зориулалтын саванд хийж занших.
- Хоол хүнсээ даавуун уутанд авч явах.
- Хоол хүнсээ нарны шууд тусгалаас хол байлгах.
- Борц, шууз зэргийг бэлтгэн авч явах.
- Хоол идэх майхан, асар нь зочид хоолоо тайван идэхээс гадна ярьж суухад таатай уур амьсгал бүрдүүлдэг.
- Гал тогоонд хуванцар сав хэрэглэх бол зузаан бат бөх байхаас гадна хоол хийхэд аюулгүй байх хэрэгтэй.
- Гал тогоо, кэмпийн ойр тойрныг цэвэр байлгаж, хоолны үлдэгдлээ хол байлгахгүй бол зэрлэг амьтан ирэх аюултай.



- Хоолны үлдэгдлээс бусдыг буцаан авч явахаа битгий мартаарай. Байгаль орчинд ээлтэй аялах талаар 15-р хэсгээс, аюулгүй байдлын талаар 17-р хэсгээс тус тус хараарай.

Гал тогоог жуулчид өөрсдөө хэрэглэж болохоор бэлтгэх

Та өөрөө хоол хийхгүйгээр жуулчид таны бэлтгэсэн зүйлүүдийг ашиглан өөрсдөө хоолоо хийж идэхээр гал тогоогоо зохицуулах хувилбар бас байдаг. Энэ нь тур операторууд жуулчин авчирч тэмээ морь унуулах, малчдын амьдрал ахуйг сонирхуулах зорилгоор хийх нэг өдрийн аяллын үед тохиромжтой.

Мөн дотоодын аялагчид өөрийн хүнсээ авчирч хоолоо хийх үе ч байдаг. Энэ үед гал тогоо тань цэвэр, аюулгүй байх хэрэгтэйг анхаараарай.



ХЭСЭГ 14. АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ, БИЕ ЗАСАХ ГАЗАР

Аюулгүй, ариун цэврийн шаардлага хангасан жорлон

Манай оронд явуулсан судалгаагаар жуулчдын хувьд жорлонгийн асуудал хамгийн хүндрэлтэй байдаг гэж гарсан. Жуулчид манай оронд аялахдаа бидний нөхөрсөг зочломтгой зан, байгалийн үзэсгэлэнт газрууд, Монголын түүх, соёлоос суралцсан сайхан дурсамжуудыг өвөртлөн буцдаг. Энэ бүх сайхан дурсамжууд шаардлага хангаагүй бие засах газраас болж үгүй болбол хайран юм. Тэрчлэн орон нутгийн эрүүл ахуйд эрсдэл учруулж хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөөд байна.





Нүхэн жорлонгийн эрүүл мэндэд учруулах аюул

Ариун цэврийн байгууламжийг сайжруулах нь зөвхөн зочдод төдийгүй орон нутгийнханд ч хамгийн чухал.

Хот, хөдөөд түгээмэл хэрэглэгддэг ил задгай жорлон нь хижиг, цусан суулга, гепатит А зэрэг халдварт өвчний тархалтыг ихэсгэдэг. Монголд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааны 6 %-ийг суулгалт өвчин эзэлж байна²⁷. Ил жорлонгийн хамгийн эрсдэлт сөрөг нөлөө нь хөрсний гүнд бохирдол үүсгэж агаарт шууд ууршдаг тул ундны усны эх үүсвэрт аюул учруулдаг. 2017 онд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүйгээс Монгол Улсын эдийн засагт 35.5 тэрбум төгрөг (26 сая ам. доллар) буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний хохирол учирсан гэсэн тооцоо гарчээ²⁸.

Ил задгай жорлонгийн бохирдол, түүнийг хэрхэн бууруулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг “Хөрсний бохирдлыг бууруулах тухай” гарын авлагаас авч болно. Энэ гарын авлагыг НҮБХХ-ийн Орхон аймагт хэрэгжүүлж буй төслөөс²⁹ хэвлэн гаргасан ба Монгол улсын эко жорлонгийн MNS 5924:2015 стандартын дагуу иргэдэд цэвэр, аюулгүй ариун цэврийн байгууламж, бий болгохоор зорьж байна.

MNS 5924: 2015 стандартыг
QR CODE-оор татаж авна уу.



²⁷UNICEF, <https://www.unicef.org/mongolia/stories/improving-childrens-well-being-through-innovative-solutions-sanitation>

²⁸<https://www.unicef.org/mongolia/press-releases/sanitation-cold-climate-meeting-held-mongolia>

²⁹<https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/blog/2021/OrkhonSoilProject.html>



Тусгай хамгаалалттай газар нутгийн дотор байгуулах жорлонгийн зөвшөөрөл ба батлагдсан стандартууд

Хөрсний бохирдлоос сэргийлэх үүднээс 2018 онд ТХГН-т стандартын бус ариун цэврийн байгууламж ашиглахыг хориглох шийдвэр³⁰ гарч, мөн оны 6-р сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахаар заасан байна. Ариун цэврийн байгууламжийн хэд хэдэн загварыг "стандарт" болгон ашиглахыг зөвшөөрсөн байна. Үүнд:

- а) Бохирыг хөрсөнд шингэхээс хамгаалсан доторлогоотой соруулдаг жорлон
- б) Байгальд ээлтэй хуурай жорлон
- в) Зөөврийн жорлон
- г) Агааржуулагчтай сайжруулсан жорлон

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2015 оны 12-р сарын 24-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор "Нүхэн жорлон, угаадасны нүх"-ийн MNS 5924:2015 стандартыг баталж 2016 оны 2-р сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн. Энэхүү стандартын зорилго нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчныг бохирдлоос хамгаалах, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд оршино. Энэ нь төвлөрсөн болон шугам хоолойн системд холбогдоогүй айл өрх, байгууллагын бохирын нүх, нүхэн жорлонг угсрах, ажиллуулах, засварлах, зураг төсөл боловсруулахад хамаарна. Жорлонгийн загварыг сонгохдоо дээрх стандартын шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна тухайн орчныхоо байдлыг харгалзан үзээрэй.

Эко жорлон

Эко жорлонг өдөр бүр цэвэрлэж, багийн нэг гишүүнд хариуцуулж ажиллуулах шаардлагатай. Зөв ашиглах зааврыг үйлчлүүлэгчид мэдэж байх ёстой. Хэрэв эко жорлонг зөв ашиглаж, цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийхгүй бол эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг учраас худалдан авахаасаа өмнө эко жорлонг шаардлагын дагуу ашиглаж хэрэглэж чадахаа ахин нэг бодож үзээрэй.

³⁰БОАЖ-ын сайдын 2018 оны А/73 тушаалд MNS 5924:2015 "Нүхэн жорлон, угаадасны нүхний техникийн шаардлага", MNS 6426:2013 "ТХГН-ийн орон сууц, орон сууцтай холбоотой эко аялал жуулчлалын зонхилох шаардлага" стандартуудын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж, нүхэн жорлонг цаашид ашиглахыг хориглосон. БОАЖ-ны Тусгай Хамгаалалттай Бүс Нутгийн Удирдлагын Газар энэхүү тушаалд хяналт тавьж, зохих арга хэмжээг авч ажиллаж байна.



Сайжруулсан нүхэн жорлон

Сайжруулсан нүхэн жорлон ашиглах нь илүү тохиромжтой, бодитой шийдэл байж болох юм. Сайжруулсан нүхэн жорлонг барихдаа суурь нүхний ханыг хөрсний бохирдлоос сэргийлэн зориулалтын материалаар доторлох, үнэр гаргах агааржуулагч хоолойтой, агааржуулалтын цонх нь ялаанаас хамгаалсан тортой байхаар хийнэ. Ихэнх тохиолдолд жорлонгийн хажууд муу усны нүх ухдаг нь эрүүл ахуй, аюулгүй байдалд эрсдэл учруулдаг.




Зураг 1. Жорлонгийн нүх хааш хаашаа 1 м өргөн, гүн 3 м ухагдсан байна. Хэрэв хөрсний ус доор бол 3 м-ээс ч гүн ухаж болно. Хөрс нуранги биш бол доторлох шаардлагагүй. Нүх том биш байх тусмаа өтгөн шингэн бага талбайд тархаж ялгаруулах үнэр тэр хэмжээгээрээ бага гарах үндэслэлтэй. Агаарын яндан суултуурын нүхэнд аль болох ойрхон, доороос ирэх бохир үнэрийг дээш гаргахгүйгээр сорохоор тооцож байрлуулах.

Зураг 2. Алдаатай хийгдсэн жорлон. Нүхийг хэтэрхий том ухсан. Өтгөн шингэн их тарж үнэр ялгаруулах талбай том болсон. Агаарын хоолой суултуурын нүхнээс хол байрласнаас үнэрийг бүрэн татаж чаддаггүй. Нүхний арыг онгорхой, завсар ихтэй хийснээс битүүмжлэл алдагдаж агаарын хоолой жорлонгийн нүхнээс үнэрийг татахаасаа илүү гаднах агаарыг татдагийг сумаар дүрсэлснийг харна уу.


Зураг 3. Агаарын хоолойг суултуурт шууд холбож өгвөл үнэр дээшээ гарах магадлал бүр багасна. Агаарын хоолой суултуурын тагаар жорлонгийн доторх агаарыг сорж доороос ирэх үнэрийг дээш гаргалгүйгээр сорж жорлонг үнэргүй, эсвэл маш бага үнэртэй болгоно.



Хэрвээ танай жорлон 2 хаалгатай бол нэг нь суултууртай, нөгөө нь суултуургүй байж болно. Суултууртай жорлонгийн өндрийг зөв тохируулах хэрэгтэй. Орон нутагт суултуургүй нүхэн жорлон ариун цэврийн хувьд тохиромжтой. Гэхдээ гадны жуулчдын хувьд хагас суун бие засч сураагүй байдаг. Тиймээс жорлонд явган суухад дөхөм болгож бариул суурилуулахдаа аюулгүй, бат бөх эсэхийг шалгаарай.



Хэрэв та жорлонгийн суултуур суурилуулахаар шийдсэн бол цэвэрлэхэд хялбар хуванцар байх нь хамгийн тохиромжтой. Ариун цэвэр эрүүл ахуйн үүднээс аль даавуу нийллэг материалаар бүрэхгүй байх нь дээр.



Жорлонд гар ариутгагч байрлуулж, цаасны тавиур хийж байнгын цаастай байлгахад анхаараарай. Жорлонгийн ойролцоо газар шон хатгаж гар угаах усны савыг тогтоож савангийн тавиурыг байрлуулж өгнө. Жорлон дотор гаднаасаа цоожтой, хаалга нь салхинд онгойж эвдрэхээргүй байна. Шөнийн цагаар нарны эрчим хүчээр ажилладаг хөдөлгөөнт гэрлийг жорлон хүрэх замд байрлуулж, жорлон дотроо заавал гэрэл байрлуулаарай.



Жорлон байрлах газар нь усны эх үүсвэрээс хангалттай хол байж ухсан нүх нь гүний усны түвшинд хүрэхгүй байх ёстой.


Сайжруулсан болон хуурай нүхэн жорлонгийн практик, загварууд

Өмнөговь аймагт нүхэн жорлонгийн зураг төсөл хийж туршиж үзсэн нь бодит байдалд нийцсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

Эко жорлонгын туршилтын загварыг QR CODE-оор орж танилцана уу.



Туршилтаас харахад говийн бүсэд жорлонгийн нүхний ханыг модоор доторлох шаардлагагүй байдаг бол хангайн бүсэд модоор доторлох хэрэгтэй байна.





Халуун усны газар

Нэг хоноод буцах жуулчин шүршүүрт орох шаардлагагүй байж болно. Гэхдээ хялбараар усанд орох майхан эсвэл брезентээр халхалсан газар гаргаж өгөөрэй. Ингэхдээ хувинтай бүлээн ус, шанага, саван, шампунь, цэвэр алчуураар зочноо хангаарай. Ингэж усанд ороход тогтоол ус үүсгэхгүйн тулд ус урсах боломжтой шал, резинэн шаахай бэлтгэхэд болно. Мөн зочдыг нэг өдрийн аяллаас ирэхэд бүлээн нойтон, цэвэр алчуур бэлтгэн өгвөл дуртай байдаг.

Нарны эх үүсвэрээр халдаг ууттай шүршүүр бүхий газар бэлтгэж болох ба хувийн орон зайг хамгаалж чадах орчин бүрдүүлээрэй.

Хээрийн аяллын жорлон, ариун цэвэр

Морин аялалд олон хоногоор явахад аюулгүй, байгаль орчинд ээлтэй бие засах газар чухал бөгөөд энэ талаар аялагчдад заавар зөвлөмж өгөх нь таны үүрэг юм.

Буудалласан газрын ойр орчимд ил задгай бие зассан үлдэгдэл, хог хаягдал, ариун цэврийн цаас, нойтон салфетка, эмэгтэйчүүдийн хэрэглэл зэрэг зүйлс олох нь огиудас хүрэм төдийгүй байгаль орчныг сүйтгэж, зэрлэг амьтдад халтай.

Хөрсөнд задрах хог хаягдлаа булж хаях нь тохиромжтой бөгөөд булахаас өмнө хогийг ангилах нь зүйтэй. Хээрийн аялалд нүх ухах тусгай хүрз болон аялагчдад хэрхэн хог хаягдлаа булах тухай дүрмийг зааж өгөөрэй.

- Булаг шанд, гол зэрэг ундны усны эх үүсвэрээс 100 метрээс илүү хангалттай зайд буудаллаж, тохирох газар нүх ухах хөрсөнд задрах хог хаягдлаа булна.
- Ойролцоогоор 20x20 см өргөн, 15–20 см гүнтэй нүх гаргана. Энэ хэмжээний гүнд хөрсний фермент, бактерийн идэвхжил хамгийн идэвхтэй байдаг тул өтгөн ялгадас хамгийн хурдан задардаг. Нүх гүехэн байвал амьтад хаягдлыг ил гаргах эрсдэлтэй, харин хэт гүн байвал задрахад урт хугацаа шаарддаг.
- Хэрэглэсэн ариун цэврийн цаасыг цуглуулж АЮУЛГҮЙГЭЭР шатаах хэрэгтэй.
- Хэрэв та хүрэээр сэндийлэн нүх ухсан бол ухаж авсан зүлэг, өнгөн хөрсийг буцааж таглаж тавих нь зүйтэй.
-



Хээрийн аялалд гарахдаа аялагчдад ариун цэврийн цаас, асаагуур, гар ариутгагч зэргээс бүрдсэн багц өгөөрэй. Аялагчдад бие засах үедээ ашиглах том эсвэл цэцэрлэгжүүлэлт хийхэд ашигладаг жижиг хүрз өгч болно. Мөн эмэгтэй жуулчдад нойтон салфетка, ариун цэврийн цаас, хэрэглэлээ ил задгүй хаяхгүй байхад зориулан хогны уут гаргаж өгөөрэй.

Зарим тохиолдолд буудалласан газартаа усны эхээс хангалттай хол зайд тохиромжтой газрыг сонгон түр зуурын нүхэн жорлонг барьж болно. Түр зуурын нүхэн жорлонг ашигласны дараа шороо асгах хэрэгтэй бөгөөд жорлонгийн хажууд шороо тавьж өгөх хэрэгтэй. Мөн хувийн орон зайг нь хангаж жорлонг тойруулсан хаалт босгож өгөх хэрэгтэй. Тухайн газраас явахын өмнө нүхэн жорлонг шороогоор хангалттай булж таглан ойр орчмын газрын хог хаягдлыг сайтар шалгаарай.

Уулын авиралт, мөсөн гол зэрэг аялалд хог хаягдал, бохирдол үүсгэхгүй байх дүрмийг чандлан мөрдөх хэрэгтэй. Учир нь цас, мөсөн дээр хүний хог хаягдал үлдэх ёсгүй. Ийм тохиолдолд аялагчид өөрсдийн бий болгосон бүх хог хаягдлаа орхилгүй авч явна.

Ямар ч тохиолдолд өөрсдийн хог хаягдал /ялгадас/-г авч явах бөгөөд зориулалтын гялгар уутыг хэрэглэж болно. Тухайлбал "Био уут" бөгөөд байгальд ээлтэй хурдан задардаг материалаар хийгдсэн байна.

Био уутыг хэрхэн хэрэглэх тухай Монголын уулчдын хийсэн танилцуулгыг QR Code-оор орж үзнэ үү.



Манай орны уламжлалт ёсонд усны ундаргыг хэрхэн дээдлэн хамгаалж, ямар зан үйлийг хориглодог тухай зочиндоо тайлбарлаж өгөх хэрэгтэй. Уламжлалт ёсны тухай мэдээллийг гэр кэмп болон өөрсдийн бусад танилцуулгад оруулж болно. Гарын авлагын Хавсралт 17-оос жишээ харна уу.

Хээрийн аяллын үеэр отоглох хэсэгтээ бүх хүмүүс ашиглаж болох гар угаах тохиромжтой газар сонгож цэвэр сав, хувинд эсвэл зориулалтын цорготой уут, саванд ус хийж байршуулаарай. Гар угаах хэсэгтээ саван, сойз, нэмж хийх том савтай ус гэх мэт зүйлсийг мартаж болохгүй. Түүнчлэн гар ариутгагчийг хоол идэх, хоол хийх хэсэг, гар угаах газар, түр ашиглах нүхэн жорлон зэрэгт заавал байлгах ёстой.




Хэрэв аялагчдад ямар нэг зүйл угаах эсвэл усанд орох шаардлага тохиолдвол аль болох байгальд ээлтэй саван, шампунь хэрэглэхийг зөвлөж, гол, нуурын усанд шууд угаалга хийж болохгүйг сануулаарай. Мөн гол, нуурын уснаас хол том хувин савыг байрлуулан ашиглахыг зөвлөөрэй.



ХЭСЭГ 15. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ба БАЙГАЛЬ ОРЧНЫ БУСАД АСУУДЛУУД

Хог хаягдлын асуудал нь дэлхий дахинд тулгарч буй хамгийн том бэрхшээлүүдийн нэг юм. Далай, тэнгист хөвөх уул овоо шиг овоорсон хуванцар хаягдлууд нь далайн болон хуурай газрын амьтдын амьдрах орчинд сөргөөр нөлөөлөхөөс гадна тэд гялгар уут залгих, янз бүрийн хуванцар зүйлд орооцолдсоноос гэмтэн үхэж байна. Хуванцрын бичил жижиг хэсгүүд бидний өдөр тутмын хоол хүнс, уух ус төдийгүй хүн амьтны биед ч агуулагдах болсон байна.





Манай оронд хориод жилийн өмнө хог хаягдал нь нэн тэргүүний тулгамдсан асуудал биш байсан бол харин одоо хот хөдөө бүү хэл тусгай хамгаалалттай газар ч хогны асуудалтай нүүр тулаад байна. Харамсалтай нь орчноо нүд халтирам болтол бохирдуулсан хогон овоо дээр мал бэлчиж түүнийг идэж байгаа нь энгийн үзэгдэл болжээ. Мал муулахад гэдэс дотроос нь хог гарах, хог хаягдал идсэнээс үүдэн үрэгдсэн ан амьтадтай таарах тохиолдол их байна.

Хог хаягдлыг буруу аргаар устгаснаар ус, хөрс, агаар бохирдож газрын өнгө төрхийг үзэмжгүй болгодог. Жил бүр нэмэгдэж байгаа хог хаягдал нь үзэсгэлэнт онгон байгальд аялахаар зорин ирдэг жуулчдын нүдэнд их анзаарагдах болсон. Тухайлбал Горхи Тэрэлжийн БЦГ, Хан Хэнтийн ДЦГ-т жил бүр ирдэг жуулчдад отоглох газар, зам харгуй, гэр кэмпийн орчинд хог хаягдлын бохирдол хэт ихэссэн нь жуулчдын дахин ирэх сонирхлыг бууруулахад нөлөөлдөг байна. Хүрээлэн буй орчны бохирдол нь зөвхөн хүнд төдийгүй зэрлэг амьтдад хор хөнөөлтэй. Байгалийн сайханд аялж зугаалахдаа уут дүүрэн хоол унд авч очоод сав, баглааг нь үлдээгээд ирдэг нь санаанд багтамгүй зүйл юм!

Хаягдлаа багасга, дахин ашигла, дахин боловсруул

Та хаягдлаа багасга, дахин ашигла, дахин боловсруул гэсэн уриа хаа нэгтээ сонсож байсан нь лавтай. Эдгээр үгс нь зөвхөн уриа төдий бус төрөөс баримтлах хог хаягдлын талаарх бодлогын бичиг баримтын үндсэн зарчим юм.

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөртэй QR CODE-ыг уншуулж танилцана уу.



Хаягдлаа багасгах нь

Хаягдлаа багасгахыг хүсвэл худалдан авалт хийхдээ анхаарч, зөвхөн зайлшгүй хэрэгтэй зүйлээ сонгохоос эхэлдэг. Манай оронд 2019³¹ оноос эхлэн 0,035 мм-ийн нимгэн гялгар уут буюу хальсан “арвын” уутыг хэрэглэхийг хориглосон. Энэхүү шийдвэр нь дэлгүүр, худалдааны төвүүд цаасан уут, хайрцаг, даавуун уут гэх мэт байгальд ээлтэй олон сонголттой болоход нөлөөлсөн.

³¹Нэг удаагийн гялгар уутыг импортлох, худалдах, үйлдвэрлэх, ашиглахыг хориглосон Засгийн газрын 189-р тогтоол 2019 оны 3-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд нэг удаагийн 0.035 мм-ээс нимгэн гялгар уутыг хориглосон.



Таныг өдөр тутмын худалдан авалтандаа даавуун уут эсвэл удаан эдэлгээтэй материалаар хийгдсэн тор, хайрцаг ашиглахыг зөвлөж байна. Энэ нь жимс, хүнсний ногоо гэх мэт өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг савладаг жижиг гялгар уутны хэрэглээг багасгах боломжтой.

Төрөл бүрийн хэмжээтэй даавуун уутыг аялал зугаалгад ашиглахаас гадна хүнс хадгалах, тээвэрлэх гэх мэтэд нэн тохиромжтой учраас ийм уутыг гэрийн бүрээсний цагаан даавуугаар ч хийж болно. Өөрийн логотой чамин дизайнтай даавуун уутаа урлаж зочдод худалдах нь танай үйл ажиллагааг сурталчлах сайхан боломжтойгоос гадна жуулчид таны байгальд ээлтэй үйл ажиллагааг талархан хүлээн авах болно.

Хуванцар савны хэрэглээгээ багасгах нь

Хурал цуглаан, аяллын үед жижиг савлагаатай ус тараах нь хуванцар савны хэт их хэрэглээг өөхшүүлдэг. Иймд хуванцар савны хэрэглээг хэрхэн танаж болох талаар хэд хэдэн жишээ дурдлаа. *Мөн ундны усны аюулгүй байдлыг хангах талаар 13-р хэсгээс дахин танилцаарай.*



Ихэнх жуулчид усны зориулалтын савтай аялдаг учраас тухайн жуулчны саванд буцалгасан ус эсвэл цэвэршүүлсэн ундны ус хийж өгөхөд хангалттай байдаг. Иймд НИТАЖ-ын гал тогооны хэсэг, зочдын байрлах гэрт ундны ус хадгалах зориулалтын том саванд ус буцалгаж тавьснаар хуванцар савны хэрэглээг багасгах төдийгүй зочдод таатай сэтгэгдэл төрүүлдэг. Зарим жуулчид усны савгүй эсвэл зориулалтын бус савтай аялах нь бий. Энэ тохиолдолд аль болох том (2 л) савтай ус өгөөрэй.

Хэрэв танд савласан ус хэрэглэхээс өөр арга байхгүй бол аль болох нарны шууд тусгалгүй газарт хадгалж хэвшээрэй.

Гадаад жуулчинд булаг шандны уснаас шууд уухаар өгч болохгүйг анхаараарай. Тухайн орчинд дасаагүй байдаг учраас гэдэс нь эвгүйрхэж аяллын хугацаанд бие нь тавгүйрхдэг.



Хуванцар савтай усыг нарны шууд тусгалд удаан хугацаанд хадгалж болохгүй. Учир нь хуванцрын бичил хэсгүүд усны чанарыг өөрчилж бохирдуулдаг байна. Хэдийгээр энэ нь аюулгүй сонголт биш ч хоолны хордлого, ил задгай уснаас болж өвдөхөөс илүү дээр байдаг.

Нэг удаагийн хэрэглээнээс зайлсхийх

Нэг удаагийн хоолны хэрэгсэл ашиглахаас зайлсхийх хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд илүү бат бөх, цэвэрлээд дахин ашиглах боломжтой биетэй материалаар хийсэн хэрэгсэл сонгох нь зүйтэй. Ялангуяа аяллын хоол хүнсийг боохдоо нимгэн нэг удаагийн гялгар уут, сав ашиглахаас татгалзаарай.

Нэг удаагийн хэрэглээг орлох хатуу цаасан сав, зөгийн лаваар өнгөлсөн цаас зэрэг дахин хэрэглэх боломжтой бүтээгдэхүүн худалдаж аваарай.

Дахин боловсруулах

Таны НИТАЖ-ын үйл ажиллагаа явуулж буй аймаг, суманд хог хаягдлыг дахин боловсруулах журам, хөтөлбөртэй эсэх, энэ талаар дэмжиж ажилладаг талаар судалж үзэх хэрэгтэй.

Тухайлбал Өмнөговь аймгийн хог хаягдлын менежментэд аялал жуулчлалаас бий болсон хог хаягдалд тусгайлсан журам гаргаж орон нутгийн хогийг сумын төв рүү зөөж нэгдсэн цэгт хаях журам гарган ажилладаг байна.

Орон нутгаас хэрэгжүүлж байгаа хог хаягдал дахин боловсруулах журмын дагуу үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Хуванцар сав, шил, төмөр лааз, хатуу цаасан хайрцаг зэрэг нь дахин боловсруулах боломжтой байдаг учраас тусад нь ялган хаяж хэвшээрэй. Мөн хоол, хүнсний үлдэгдлийг нэг дор цуглуулж органик хаягдлыг бусад хаягдалтай хольж болохгүй. Хогоо ангилж хаядаг талаар зочдодоо мэдээлэл өгч байгаль орчиндоо сөрөг нөлөө багатай үйл ажиллагаа явуулж буйгаа сурталчлах боломж юм.


Хог хаягдлын тухай хуультай
QR CODE-оор орж танилцана уу.





Хог хаягдлыг ангилж, ялгах

НИТАЖ-ын гэр кэмгийн хог хаягдлыг ангилж сураарай. Хот, аймгийн олон нийтийн газар байдагтай ижил хогоо ялгаж хийхэд хялбар өнгө өнгийн, тэмдэглэгээтэй хогны савнуудыг худалдаж авч болно. Дараах байдлаар хогийг ангилан хаяж хэвшээрэй.



- » Цаас
- » Шилэн сав, лонх, хөнгөн цагаан лааз
- » Төрөл бүрийн хуванцар сав, төмөр хаягдал
- » Дахин боловсруулах боломжгүй хаягдал (төрөл бүрийн материалтай сав баглаа боодол, пластик болон тугалган бүрэлттэй сав, баглаа, дахин боловсруулах боломжгүй хуванцар сав буюу "дахин боловсруулах" тэмдэглэгээгүй савнууд)

НИТАЖ-ын дотоод нөөц боллоцоондоо тохируулан хогийг дээрх ангиллын дагуу ялган хаях сав зохион бүтээж болно. Ингэхдээ аль ч хогны сав салхинд хийсхээргүй хүнд эсвэл газарт сайтар тогтоож бэхэлсэн, таглаа хийж мал ухаж түнхэн онгойлгож дийлэхээргүй байхаар бодолцох хэрэгтэй.



Органик хүнсний хаягдал болон саарал ус


Органик хаягдлыг сайн ашиглах хэрэгтэй. Таны ашигласан ногооны хальс малын тэжээл болох боломжтой бөгөөд малд өгөхөөс өмнө бөөнөөр овоолж, өмхийрүүлж муутгалгүй цуглуулаарай. Органик хаягдлыг хамгийн сайн ашиглах арга бол тусгай саванд хадгалан бордоо болгон хүлэмж, ногооны талбайд цацаж ашиглаарай.

Хэрэв хүнсний болон шингэн хог хаягдлаа булах бол зочдын гэрээс зайтай газарт мал олж хивэх боломжгүй болтол сайтар далдлан хаях хэрэгтэй. *Тэрчлэн гарын авлагын 14-р хэсэгт дурдсанчлан гэр кэмпэд эко жорлон байрлуулахдаа хүнсний хог хаягдал, бохир усыг жорлонтой нэг нүхэнд хийж болохгүйг анхааруулж зөвлөсөн.*

Хогны нэгдсэн цэг

Хогны нэгдсэн цэгийн байршлыг сонгохдоо зочдын нүднээс аль болох далд, ерөнхий салхины чиглэлийн доор, хаяхад хялбар байхыг бодолцох хэрэгтэй.

Хогны цэгт хэд хэдэн сав байрлуулж сум руу хог хаягдлыг зөөх боломжтой байхаар байршуулна. Зурагт тайлбартай танилцаарай. Энэ арга нь чингэлэгт хог дүүрсний дараа машинд холбож сумын төв рүү авч явахад хялбар болгодог. Энэхүү аргыг хэрэглэх бол хог хийсэж хаягдахааргүй, зөөвөрлөж хаяхад амархан, мал амьтан унахааргүй, аюулгүй тээвэрлэх талаас нь бодолцоорой.



Шатааж болох хаягдал

НИТАЖ-ын гэр кэмп болон танай гэрийн зууханд зөвхөн цаас, хатуу цаас, модны үлдэгдлийг шатааж болно. Хэрэв гадаа хог шатаах хэрэг гарвал салхигүй үед төмөр торх эсвэл тусгай саванд шатааж хэвших хэрэгтэй. Гадаа хог шатаах үед оч үсэрч гал алдахаас сэргийлж хог шатаж дуустал хажууд нь байх, нурам унтарсан эсэхийг сайтар шалгах, боломжтой бол төмөр савыг таглах хэрэгтэй.



Ямар ч төрлийн хуванцар савыг шатааж болохгүй! Энэ нь таны эрүүл мэндэд хортой бөгөөд байгаль орчинд сөргөөр нөлөөлдөг.

НИТАЖ-ын ойр орчим хог үлдээхгүй байхыг сануулах

Танай нутгийг зорин ирсэн гадаад, дотоодын жуулчдад байгальд болон гэр кэмпийн ойр орчим ил задгай хог хаяхгүй байх талаар нөхөрсөг зөвлөгөө өгч өөрсдөө үлгэр дуурайлалтай байгаарай. Байгалийн үзэсгэлэнд аялахаар ирсэн хэн ч бай хогоо түүж цуглуулан аймаг, сумын төв дээр зориулалтын хогны цэгт хаяж сурах хэрэгтэй.

Явган болон хүлэгт аяллын үерх хаягдал

Өмнөх хэсэгт дурдсанчлан аль болох бага хаягдал гаргахыг эрмэлзээрэй. Аяллын үеэр ч хуванцар, шилэн сав, лааз зэрэг хаягдлыг бага гаргахад анхаарах хэрэгтэй. Мөн аяллын үед хог хийхэд тохиромжтой уут эсвэл зориулалтын сав авч яваарай. Хэрвээ та энгийн уламжлалт аргаар хоол хийдэг бол аяллын үеэр хоолны хаягдал бага гардаг.

Авчирсан бол аваад яв

Орон нутаг болон тусгай хамгаалалттай газар аялахдаа хогоо ангилж ялгалгүй булж хаях нь байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөөтэй байдаг. Аяллын туршид цугларсан хоосон сав, хаягдлын хэмжээг бага байлгахад анхаарах хэрэгтэй. Аяллын нөхцөл байдалдаа тохируулан өдөр бүрийн хогоо тухай бүрт нь ангилж өөр өөр уут эсвэл саванд хийж болно. Хээрийн аяллын хог цуглуулах уут, савны амыг сайтар зангидаж салхинд хийсэхгүй, нохой болон зэрлэг амьтан орохгүй байхаар бэхэлсэн эсэхийг сайтар шалгаж байгаарай. Ингэж аяллын турш хогоо цуглуулснаар байгальд хог үлдээлгүй нэгдсэн газарт хаях нөхцөл бүрддэг.

Хөрсний бохирдлыг бууруулах шийдэл, арга зам гарын авлагыг QR CODE уншуулж татаж авна уу.



Зэрлэг амьтад хог хаягдал, хоол хүнсэнд ойртохоос урьдчилан сэргийлэх

Хэрэв та баавгай амьдардаг газраар аялах бол хог хаягдал, хүнсний зүйлсийг амьтан хүрэхгүй газар тавих хэрэгтэй. Цөөхүүлээ явж байгаа бол хурц үнэртэй хоол унд, хог хаягдлаа өндөр модноос өлгөөрэй.

Тухайлбал кэмпэд аялагчдын үлдээсэн хүнсээр хооллож дассан баавгайнууд АНУ, Канад зэрэг оронд гарчээ. Манай оронд баавгайн



тоо толгой (Горхи Тэрэлж, Хан Хэнтий орчмоор) нэмэгдвэл ийм зүйл тохиолдох ч магадлалтай.

Байгаль орчинд ээлтэй бусад сайн туршлага

Цэвэрхэн цагаан хэрэглэл

Зочдоо үдэж мордуулсны дараа цагаан хэрэглэлийг сольж хэвших хэрэгтэй. Дараагийн зочдод солилгүй орхисон бохир ор дэрний даавуугаар үйлчилж хэрхэвч болохгүй. Мөн угаасан ч бүрэн хатаагаагүйн улмаас эвгүй үнэр орж, эсвэл толбо тогтсон байх нь таагүй сэтгэгдэл төрүүлдэг.

Танай гэр кэмпэд олон хонох зочноос ор дэрний хэрэглэлийг өдөр бүр солихгүй байж болох эсэхийг асуух хэрэгтэй. Ихэнх зочид буудал, баазууд байгаль орчинд ээлтэй, гэрэл цахилгааны хэмнэлттэй, угаалгын нунтгийн хэрэглээг бууруулах зорилгоор үйлчлүүлэгчээс нөхөрсгөөр асуудаг болсон байна. Энэ тохиолдолд жуулчид хэмнэлт гаргаж байгаа биш байгаль орчинд ээлтэй ажилладаг газар гэж талархаж сайнаар хүлээн авдаг.

Цагаан хэрэглэл заавал цагаан өнгөтэй байх албагүй харин даавуун материалтай, тухтай байхад л хангалттай. Мөн заавал индүүдэхгүйгээр, нар салхинд хатаасан байхад л хангалттай.

Хээр отоглох үеийн ариун цэврийн асуудлууд

Хээр отгоор явахдаа Монголын ёсонд усны эхийг хамгаалж, ус руу юу хийж болохгүй талаар зочдодоо танилцуулаарай.

Гэр кэмпэд ажилчид, зочдод зориулсан гар угаах хэсэг байвал сайн. Энгийн хувин, түмпэнг ашиглах эсвэл модонд өлгөсөн савтай ус байрлуулж саван, алчуур бэлтгээрэй. Мөн гар ариутгагчийг гар угаах цэг, хоолны асар, майхан зэрэгт байрлуулах хэрэгтэй.

Хэрэв аялагчид ямар нэг зүйл угаах эсвэл усанд орох шаардлага тохиолдвол аль болох байгальд ээлтэй саван, шампунь хэрэглэхийг зөвлөж, гол, нуурын усанд шууд угаалга хийж болохгүйг сануулаарай. Мөн гол, нуурын уснаас хол том хувинд ус зөөж усанд орох хэсэгт хаалт байрлуулах хэрэгтэй. Энэ тухай 14-р хэсгээс дэлгэрүүлж хараарай.



Аюулгүй түүдэг гал

Хээрийн аяллын үед болон гэр кэмпийн ойр орчим ил гал гаргахгүй байвал их сайн. Хуурай улиралд гардаг гал түймрийн аюулаас сэргийлэх дүрэм, журмыг судалж, гэр кэмпэд болон аяллын турш даган мөрдөх хэрэгтэй.

Хоол унд хийх, дулаацах, цэнгэх зэрэгт гал гаргах хэрэгтэй бол ил галыг төмөр саваар тойруулан оч үсрэхээс хамгаалах эсвэл газраас хөндийрүүлж доор нь төмөр дэвсэж өгвөл сайн. Ингэж гал алдахаас сэргийлнэ.



Хөрсөн дээр шууд ил гал гаргасан бол дараа нь сайн цурамдаж унтраана. Гал тойруулж тавьсан чулуунуудаа буцааж байранд нь тавина. Хуванцар, шилний үлдэгдэл зэрэг хаягдлыг авч явах хэрэгтэй. Гал түлж харласан хэсэгт өөр газраас хөрс, хөвд зэрэг ойн ургамал гэх мэтийг авчирч хучаарай. Ингэвэл шатсан хэсэг дээр ургамал амархан ургаж, төлждөг.

Урьд нь хэн нэгэн гал түлж харласан газар болон чулууг дахин хэрэглэвэл сайн бөгөөд зайлшгүй шаардлагатай биш л бол шинэ газар бүү гал гаргаарай. Хүн их буудалладаг голын ойролцоо ил гал түлж, түүнийгээ цэвэрлэхгүй орхин явдаг замбараагүй явдал байсаар байна. Та өмнө нь ашигласан ил гал гаргасан хэсэгтээ дахин гал гаргасан бол өмнө дурдсан аргаар нөхөн сэргээх арга хэмжээ авах эсвэл дараагийн хүнд зориулж цэвэрлээд орхиорой.

Гэр кэмпийн сэргээгдэх эрчим хүч

Ихэнх гэр кэмп гэрэлтүүлэг эсвэл гоёлын зориулалтаар ашиглах нарны эрчим хүчний үүсгүүртэй байдаг. Энэ нь урт хугацаандаа үр ашигтай зөв хөрөнгө оруулалт бөгөөд аюул багатай нарын эрчим хүч, салхин сэнс зэргийг кэмпэдээ ашиглаж гэрэл цахилгаан гаргах нь зочдод маш их таалагддаг.



ХЭСЭГ 16. ХӨТӨЧ ХИЙХ

Орон нутгийн хөтөч таны үүрэг

Орон нутгийн хөтчийн үүрэг хариуцлага нэлээдгүй их бөгөөд тэр хэрээр хөтчөөс ур чадвар, мэдлэг, авьяас шаарддаг. Хөтөч нь жуулчдыг нутгийн иргэд, цаашлаад нутгийн байгаль, соёлын өвийг таниулан холбоход гүүр болдог бөгөөд бүгдийг нэгтгэх үүрэг түүнд оногддог. Тиймээс хөтөч нь уламжлал соёлоо түгээн дэлгэрүүлэх соёлын элч төдийгүй нутгийн иргэд, тэдний үнэ цэнэ, зан байдал, дуу хоолойг илэрхийлдэг гэж жуулчид үздэг.

Энэ утгаараа ч хөтөч нь нутаг орноо танилцуулж буй нэгнээс хамаагүй их үүрэг хариуцлагатай. Газар нутгаа үзүүлж, морь тэмээ унуулах зэргээр хөтчийн ажил хязгаарлагддаггүй. Сумын төвөөр жуулчнаа дагуулан орон нутгийн музей, дэлгүүр хоршоогоог ч танилцуулдаг. Тиймээс танай бүлэг, нөхөрлөл үйл ажиллагааны хэлбэр бүрээр хэд хэдэн хөтөчтэй байж болно.



Жуулчид нүүдлийн ахуй соёлоос суралцахын хажуугаар нутгийн малчид хэрхэн өдийг хүртэл энэ сайхан уламжлалаа хадгалж ирснийг ихээхэн сонирхдог. Жуулчид таны амьдралын хэв маяг, гэр бүл, хүүхдүүдийн тань боловсрол, чухал тэмдэглэлт өдрүүд, хурим найр зэргийг сонирхож, энэ талаар аль болох их зүйл мэдэхийг хүсдэг. Түүнчлэн үнээ саах, нутгийн



хоол бэлтгэх, гэр барихад туслах гэх зэргээр таны хийдэг ажилд гар бие оролцож мартагдахааргүй сайхан дурсамж хуримтлуулахыг зорьдог.

Тиймээс өөрсдийн хийдэг өдөр тутмын ажлаа энгийн нэгэн зүйл мэтээр харж жуулчдад сонирхолгүй байх гэж бүү бодоорой. Тухайлбал, сумын төвийн дэлгүүрээр орж үзэх нь тэдний хувьд сонин содон байж болно. Жуулчид та бүхний бодит амьдрал, нөхцөл байдлыг эндээс л харна. Сумын дэлгүүрийн худалдагчийн хувьд ч бараагаа борлуулах сайхан боломж шүү дээ.

Иймээс нутгийн хөтөч хийнэ гэдэг нь олон талын авьяас чадвар шаардсан ажил болох нь харагдаж байна. Хөтөч нь жуулчдадаа үнэн зөв мэдээллийг сонирхолтой байдлаар өгдөг байх хэрэгтэй. Заримдаа таны мэдлэг, мэдлээс хавьгүй их зүйлийг жуулчид хүсдэг бөгөөд үүнд санаагаа бүү чилээгээрэй. Ажлаа сайн хийхэд тань хэрэг болох ур чадвар, туршлагыг та өөрөө олж хуримтлуулж чадна. Өдөр тутмын хийдэг ажлаасаа та олон төрлийн мэдлэг, туршлагыг хуримтлуулсан байдаг болохоор өөртөө итгэлтэй, өөрийнхөөрөө эерэг хандлагатай байхад л болно.

Сайн хөтчид байх ёстой ерөнхий ур чадвар, зан харилцаа, хандлага цаашлаад ажлаа хэрхэн зохион байгуулах, жуулчдаа хэрхэн сайхан авч явах талаар зөвлөгөөг доор орууллаа.

Төлөвлөлт, цагийн менежмент

Ажлаа сайтар төлөвлөн, цагаа зөв зохицуулах ур чадвартай байх нь ажлаа сайн гүйцэтгэхэд хамгийн чухал. Төлөвлөгөө гаргаж цагаа зөв зохицуулахад хэрэгтэй хэдэн зөвлөгөөг дурдвал:

- Бүгдээрээ хамтдаа ажлаа төлөвлөх нь хүн бүр өөрийн үүрэг, цагийн хуваариа мэдэхэд сайнаар нөлөөлдөг. Ялангуяа зочид ирэх, аялалд гарах зэргээс нэлээд хэдэн өдрийн өмнө хийх ажлуудаа цаасан дээр буулган, хуваарь гарган ажиллах хэрэгтэй. Бүх гишүүд хамтран хуваариа сайтар шалгах хэрэгтэйг санаарай.
- Аялал болон төлөвлөсөн үйл ажиллагаанд хэр их хугацаа хэрэгтэйг зөв тооцоолоорой.
- Замын нөхцөл байдлаас болж өөрчлөлт гарахыг бодолцоорой.
- Ажлаа төлөвлөхдөө хийх дэс дарааллыг сайтар гаргаарай.
- Аялалд авч явах зүйлийн жагсаалтаа гаргаарай. Тухайлбал, хувийн эд зүйлс, морь, тэмээн аяллын хэрэглэл, майхан, гал тогоо гэх мэт.



Гадаад байдал, хандлага, чадвар

Сайн хөтөч байхад ур чадвар, мэдлэг хэрэгтэй ч таны мэдрэмж их чухал. Ямар ч үед тайван, хүлээцтэй, нөхөрсөг зан хамгийн чухал бөгөөд аливаа асуудал, бэрхшээл гарахад жуулчдаа тайвшруулж, урам өгч дэмжиж байх хэрэгтэй. Энэ нь танаас аливаад байнга сонор сэрэмжтэй, тайван амгалан байх хоёрыг хослуулах чадварыг шаардана гэсэн үг.

Та цагаа сайтар тооцоолж байх нь чухал ч зарим гэнэтийн санаанд оромгүй сайхан зүйл эсхүл саад учрахад та мөн л уян хатан байх хэрэгтэй болно. Санамсаргүй сонин содон зүйлтэй таарвал үүнийг аяллын хөтөлбөр, үйл ажиллагаандаа эвтэйхэн байдлаар оруулж өгөх хэрэг гарна. Мөн төлөвлөсөн замаар явах боломжгүй тохиолдолд та өөр арга олох хэрэгтэй. Тиймээс хөтчийн ажил танаас аливааг байнга урьдчилан харж, тайван амгалан байдлаар асуудлыг шийдвэрлэх, гарах арга замаа олдог чадварыг шаардана.

Сайн хөтөч нь хүмүүстэй нийцтэй, эрч хүчтэй, хөгжилтэй, хошин шогийн мэдрэмжтэй байдаг. Тэрчлэн нөхөрсөг, өгөөмөр, зочломтгой зан чухал. Цаашлаад аливааг нухацтай хийхийн хажуугаар найрсаг, даруу байж идэвх санаачилга гарган, баримтад тулгуурлаж мэдээллээ өгдөг, мэдрэмжтэй, хашир байх хэрэгтэй.

Жуулчдын хүсэн хүлээлтийг ойлгож, Монголд аялах гэж ирсэн шалтгаанд нь нийцүүлэн ажиллавал тун сайн байдаг. Жуулчдаа идэвхжүүлэн, зарим нэг зүйлийг хамтран хийх боломжийг тэдэнд өгөөрэй. Ингэхдээ хүнд ойлгомжтой, тодорхой ярьж тайлбарладаг байх хэрэгтэй.

Хөтчийн хийж болох, болохгүй зүйлс

- Боломжтой бол үндэсний хувцсаа өмсөж байх
- Цэвэрхэн хувцаслан, биеэ зөв авч явах
- Цаг баримтлах
- Аяллын бэлтгэл болон аяллын үеэр архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх
- Жуулчдын дэргэд тамхи татахгүй, шүлсээ ил задгай хаяхгүй байх
- Морь тэмээний нурууг холгуулахгүй байж, уналга ачлагаа амьтанд



аль болох ээлтэй байдлаар тааруулаарай. Ихэнх жуулчид амьтдыг хайрлаж, хамгаалдаг учир аяллын сэтгэгдэл, хамтран ажилласан аяллын компаниа үүн дээр үндэслэн дүгнэх тохиолдол бишгүй их.

Мэдлэг

Хөтчийн мэдлэгийн нэг хэсэг бол морь унах, унуулах, аяллын замыг сайтар харгалзан үзэж, буудаллах газраа сонгох байдаг. Үүнээс гадна, орон нутгийнхаа түүх, уламжлал соёл, домог үлгэр, ардын дуу хуур, зэрлэг амьтан, ургамал, газар нутаг, түүний тогтоц зэргийг сайн мэдэж байх хэрэгтэй.

Дээрх мэдлэгээ байнга баталгаажуулан арвижуулж байх нь чухал. Гарын авлагын 4 ба 9-р хэсэгт ардын өв, мэдлэгийг өвгөд хөгшдөөсөө сураглан мэдэж цуглуулах, түүх дурсгалт газруудын мэдээллийн сан бүрдүүлэх талаар дурдсан байгаа.

Тур операторуудтай хамтран ажилладаг бол зэрлэг амьтан ургамлын талаарх гарын авлагуудыг асууж лавлан, өөрсдөө энэ талаарх ном, товхимол олж, интернэтээс мэдээлэл хайн мэдэж болно. Нутаг орныхоо талаарх мэдээллийг аймаг, сумын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнээс лавлаарай.

Өөрийн хийж буй ажлаа урам зоригтой хийж, үргэлж өөрийн мэдлэг чадвараа сайжруулахын төлөө ажиллаж, ажлаараа байнга бахархах хэрэгтэй. Учир нь та гадаадын жуулчдын өмнө орон нутгаа төлөөлж байгаа шүү дээ. *Гарын авлагын 9-р хэсгээс сургалт явуулдаг байгууллагуудын талаар олж мэдээрэй.* Зарим нэг мэдээллийн эх үүсвэрээс дурдвал GIZ SPACES төслөөс зэрлэг амьтан ургамлын тухай гаргасан апп, БОАЖЯ-аас FEEL Mongolia апп-ыг гар утсан дээрээ татан авч сонирхоорой.

GIZ SPACES төслөөс гаргасан Baigali апп-г QR CODE-оос татаж авна уу.



БОАЖЯ-аас FEEL Mongolia апп-г QR CODE-оос татаж авна уу.



Жуулчдыг угтан авч, үдэн мордуулах

1. Жуулчдаа угтан авах

- Жуулчид ирэхэд баг хамт олноороо угтан авч, өөрсдийгөө танилцуулах нь нөхөрсөг уур амьсгал бүрдүүлдэг учраас урьдчилан дадлага хийж болно.
- Энгийн хөгжилтэй байдлаар угтан авах нь жуулчдад сайхан сэтгэгдэл төрүүлээд зогсохгүй тэднийг тайвшруулж, тэдний сонирхлыг татдаг.
- Танилцуулах үеэр жуулчдын санал сэтгэгдлийг асууж хүсэн хүлээж буй зүйлийг нь яриулах сайхан боломж байдаг.
- Тэдэнд гэр кэмп болон бусад байгууламжаа танилцуулаарай.
- Бэлтгэсэн хөтөлбөрөө товч танилцуулж, хоолны цагийг нь сануулж хэлээрэй.
- Тэдэнд та нараас асуух зүйл байгаа эсэхийг лавлаарай.
- Жуулчны хийж болох болохгүй зүйлийг жагсаан гэрт байрлуулаарай. Жишээг Хавсралт 17-оос харна уу?
- Жуулчдадаа гэртээ орж амрах хувийн орон зайг олгоорой.

2. Аялал эхлэхийн өмнө

- Жуулчдынхаа Монголд өмнө нь ирж байсан эсэх, урьд нь иймэрхүү аялал хийж байсан талаар олж мэдээрэй.
- Жуулчдадаа хөтөлбөрөө нэг өдрийн өмнө танилцуулаарай. Ямар хувцас өмсөх, юу анхаарах, өглөө хэдэн цагаас бэлэн байх зэргийг сайтар тайлбарлаж өгөх нь зүйтэй.
- Жуулчид аялал болон төлөвлөсөн үйл ажиллагаа хэр удаан үргэлжлэх, биеийн хүчний ажил орсон эсэхийг мэдэж байх хэрэгтэй. Өдөржин гадаа байвал зүгээр эсэхийг асууж, жуулчдынхаа чадах эсэхийг сайтар ажиглаарай. Хэрвээ шаардлагатай бол сонирхолтой, тохиромжтой амрах цагийг хөтөлбөртөө оруулж өгөөрэй.
- Аливаа үйл ажиллагаанд хангалттай цаг тавиарай. Хэт их яарсан, цагтаабагтах гэж хичээгээд жуулчдаа ядрааж болохгүй. Тэдэнд тайван хамтдаа алхаж, харж, үзэх цаг өгөөрэй. Хөтөлбөртөө завсарлагын цаг гаргаж, тэдэнд амрах хувийн орон зай олгоорой.
- Бүх үйл ажиллагаанд бүгдийг оролцуулж, мэдээлж бэлтгээрэй. Тухайлбал, үнээ саах цагаар айлд авчрах бол урьдчилан айлдаа мэдэгдэн, цаг тохирсон байх хэрэгтэй.
- Гэр бүлийн ажлаа сайтар зохицуулж, таныг жуулчидтай завгүй байх хойгуур өөрийн ажлаа хуваарилж өгөөрэй.
- Жуулчид танаас хамааралтай байдаг учир өөрийнхөө сэтгэл санаа болон гадаад байдалдаа анхаарч бэлтгэлээ сайтар базаагаарай.
- Жуулчны улирал эхлэхээс өмнө хэрэгтэй зүйлс болох морь унуулах тоноглол, машин тэргээ шалгаж сайтар базаах зэрэгт цаг гарган



бэлтгэх хэрэгтэй. Хэрэглэх зүйлсийн жагсаалтыг урьдчилан гаргаснаар жуулчин ирчхээд байхад юмаа хайн сандрахгүй байхад ихээхэн тустай.

- Хөтчийн аялалд авч явах зайлшгүй зүйлс: Таны өөрийн хувцас, цув, дулаан гутал, малгай, хувийн аяга, халбага, гар чийдэн, гар утас, цэнэглэгч, өөрийн хоноглох майхан, аяны хөнжил, хутга, чүдэнз, дуран, анхны тусламжийн хэрэгсэл, саван, сойз, сам гэх мэт нэн түрүүнд хэрэгтэй зүйлсээс гадна аяллын төрлөөс хамаарч бусад зүйлс нэмэгдэж болно.
- Аяллын тоног төхөөрөмж: Машин, ачаалсан морьд, морь унах хэрэгсэл, буудаллахад хэрэгтэй зүйлс, гал тогоо хэрэгсэл, хүнсний зүйлийн баглаа, боолт гэх мэт
- Жуулчдын цүнх сав бүрэн бүтэн, эвдэрч хэмхрэхгүй байдлаар ачаалсан эсэхийг шалгаарай.

3. Аяллын үеэр жуулчидтайгаа харилцах

- Төлөвлөгөөгөө байнга хэлж сануулах нь зүйтэй. Онцын зүйл гарахгүй л бол төлөвлөгөөнийхөө дагуу яваарай. Өөрчлөгдвөл шууд хэлж, шалтгаанаа дурдаарай.
- Жуулчидтайгаа сайхан харилцах хэрэгтэй ч хэт хувийн орон зай руу нь орохгүй байхаар ярилцаарай.
- Тэдэн рүү байнга харж, хэт удаан ширтэж болохгүй ч тэдний аюулгүй, тав тухтай байгаа эсэхийг ажиглаж яваарай. Санаа зовсон шинжтэй байвал асуухад илүүдэхгүй ч гэсэн жуулчиндаа аль болох ганцаараа байж сайхан байгаль харан баясах боломж олгоорой.
- Тэдэнд зарим нэг Монгол үг зааж өгч, өөрөө ч тэдний ярьдаг хэлийг асууж, нийтлэг үг хэллэгээс суралцаж болно шүү дээ. Тэрчлэн нийтлэг хэрэглэгддэг хэдэн англи үг цээжилсэн байхад хэзээд хэрэг болно. Монгол, Англи хэлний ярианы дэвтэр авч явахад илүүдэхгүй.
- Өөрийн орны соёл уламжлалаас хуваалцаарай. Уламжлалын хувьд зарим нэг хийж болохгүй зүйлийг найрсгаар хэлж өгөх хэрэгтэй. Тэд мэдэхгүй байгаад алдаа гаргавал засч залруулаарай. Хайхрамжгүй, үл хүндэлсэн байдал гаргавал тайван итгэлтэйгээр энэ талаар нь хэлж ойлгуулаарай.
- Тэдний хувьд хачин санагдах зүйлийг нь урьдчилан хэлээрэй. Тухайлбал, нэг гэрт бүгдээрээ хамт унтдаг гэхээр тэдэнд их сонин санагдаж магад.
- Орон орны соёл уламжлалыг хүндэтгэн сонирхоорой. Бүх жуулчидтайгаа үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө, нас хүйс үл харгалзан эрх тэгш харьцаарай.
- Жуулчдаа мордуулах, гол гаргах зэрэгт та тэдний биед хүрэх хэрэг



гарах үед болгоомжтой байгаарай. Учир нь гаднынхан бэлгийн дарамт учруулах гэх мэт зүйлсээс шалтгаалж ялангуяа эсрэг хүйсийнхээ хүний биед хүрэхдээ маш болгоомжтой ханддаг. Иймээс аюулгүй байдлаа урьтал болгохдоо дээрх зүйлийг давхар анхаараарай.

- Айл өрхөөр зочилсон бол тэр гэрийн аливаа ажилд оролцуулж болно. Юу хийж байгааг нь тайлбарлан, хамт хийхийг уриарай.
- Өдрийн аялал бүрийн төгсгөлд жуулчдаасаа сэтгэгдлийг нь асууж, хөтөлбөр хэт удаан байсан эсэхээс аваад төвөгтэй санагдсан болон өөрчлөх хэрэгтэй зүйлийг тэднээс асууж саналыг нь сонсоорой.
- Биеийн байдлыг асуун ус хангалттай уусан эсэх зэргийг нь лавлаарай.

4. Багтайгаа ажиллах

- Багийн бүх гишүүд тус тусынхаа ажил үүргийг сайтар мэдэж байх үүднээс бэлтгэлээ хамтран хийгээрэй.
- Хэрвээ багийн гишүүдийн дунд маргаан гарвал тайван байж, жуулчдын хажууд иймэрхүү үйлдэл бүү гаргаарай.

5. Өөр аяллын багтай тааралдвал

- Хэрвээ аяллын өөр багийнхантай тааралдвал мэндчилэн, найрсаг хандаарай. Ойрхон буудаллахаар болбол бусад хөтөчтэй нийлж чанга дуу гаргаж, орой үдшийн цагаар зочдынхоо амгалан байдлыг алдуулж болохгүй.
- Хэрвээ өөр нэг морин аялалтай таарвал морьдоо ойртуулалгүй холуур мэндчилэн өнгөрвөл зүгээр.

Аяллын дараа

Хөтчийн ажил дараах зүйлсийг хийж байж л дуусдаг:

- » Бүх жуулчдаа дараагийн аялал эсхүл тур компани руу нь үдэн мордуулах
- » Бүх жуулчдын цүнх савыг бүрэн бүтэн хүлээлгэн өгөх
- » Бүх морьдоо амраах
- » Бүх хэрэгсэл тоног төхөөрөмжөө ангилан, цэвэрлэн хураах
- » Бүх хогоо ангилан ялгаж, хогийн цэг дээр хаях
- Аяллын ахлагчдаа мэдээлэх зүйл байвал хэлж танилцуулах. Засах, солих тоног төхөөрөмжөө засах.
- Дараагийн аялалдаа анхаарах, сайжруулах санаа байвал бусадтайгаа хуваалцах



Орон нутгийн хөтчөө сонгон, сургах


- Танай багаас хэн хамгийн сайн хөтөч хийж чадахаа ярилцах: Морь тэмээн аялал хийх, машин тэргээр аялах, айлд жуулчдыг дагуулж очих, зэрлэг амьтан ургамал харуулах, сумын төвөөр авч явах, түүх соёлын дурсгалт газруудаа тайлбарлан ярих гэх мэт зүйлийг сайн хийх чадвар, боломжтой нэгнээ сонгох
- Та бүхэн тур оператортай хамтран ажилладаг бол орон нутгийн хөтөч юу хийхийг нь асууж, тохирох. Тэрчлэн тур оператортай ярилцан, жуулчны улирал эхлэхээс өмнө хөтчөө сургах талаар тэднээс зөвлөгөө аваарай.
- Нутгийн хөтчөө тэдний ур чадвар, авьяасыг нь харгалзан сонгоорой. Зөвхөн морь, тэмээ сайн унадгийг нь харж сонговол өрөөсгөл зүйл болно. Хэрвээ морь, тэмээ унуулдаг хүн хөтөч хийхээр бол дээр дурдсан бүхий л зүйлсийг сайтар мэдэж, ойлгосон байх хэрэгтэй. *Морь, тэмээн аялал хийх зааварчилгааг 17-р хэсгээс олж уншаарай.*
- Аяллын үйл ажиллагаагаа харгалзан үзэж хөтчөө сонгон, сургаж, дадлагажуулж аваарай. *Хөтчийн сургалтын талаар 9-р хэсгээс олж мэдээрэй.*



ХЭСЭГ 17. АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ

Анхан шатны тусламжийн мэдлэг, баталгаажуулах гэрчилгээ

Танай багийн гишүүд нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх талаар суурь мэдлэг, чадвар эзэмшсэн байх ёстой. Манай улсад албан ёсны эрхтэй Монголын улаан загалмай нийгэмлэг, Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгүүд богино хугацааны болон ахисан шатны сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгодог.



Дээрх сургалтад бүх гишүүд ээлж дараалан хамрагдаж сургалтаар олсон мэдлэгээ сэргээж, дээшлүүлж байх нь чухал. Энэ нь та бүхэн дан ганц сурсан мэдсэн зүйлээ ахин сэргээх үүднээс биш харин тасралтгүй хөгжиж буй анагаах ухааны шинэ арга, мэдлэг, эм, тоног төхөөрөмжийн талаар цаг алдалгүй мэдээлэл авч, мэдлэг хуримтлуулж байхад тань хэрэгтэй юм.

Хэрвээ дээрх байгууллагуудаас анхан шатны тусламжийн сургалт авахад үнэтэй бол ийм сургалт шаардлагатай байгаа бүлэг хамт олонтой нэгдэн хүсэлт гарган зохион байгуулж болох ба энэ талаар сумынхаа эрүүл мэндийн ажилтнаас нэмэлт мэдээлэл авч болно.



Монголын улаан загалмай нийгэмлэгийн цахим хуудсыг QR CODE-ыг уншуулж танилцана уу.



Дараах тохиолдлуудын үед хэрхэн тусламж үзүүлэх талаар дэлгэрэнгүйг Хавсралт 16-аас хараарай.

- Бэртэл гэмтэл, цус тогтоох
- Ясны цууралт, чиг барих
- Цус алдалт, цусны эргэлтийг шалгах: тухайн хүн амьсгалж буй эсэх, биеийн бусад хэсгээрээ цус алдаж байгаа эсэх, зүрхний цохилтыг шалгах гэх мэт
- Амин үзүүлэлтүүдийг шалгах: амьсгал, зүрхний цохилт, биеийн дулаан, даралт гэх мэт
- Хиймэл амьсгал хийх
- Нуруу нугасны гэмтэл шалгах, хэрхэн өвдөлттэй хэсгийг хөндөхгүй өргөх, хөдөлгөх гэх мэт

Яаралтай тусламжийн үед доорх зүйлсийг санаж байх хэрэгтэй:

- Анхан шатны тусламж үзүүлэхийн өмнө та өөрөө гэмтэж бэртээгүй гэдгээ сайтар шалгах
- Тайван байх. Хариуцлагыг гартаа авч бусад гишүүддээ юу хийх хэрэгтэйг хэлж бусдыгаа тайвшруулах
- Хүнд гэмтэл бэртлийн үед уламжлалт арга хэрэглэхээс зайлсхийх

Гэр кэмп, аяллын анхан шатны тусламжийн хэрэгсэл

Анхан шатны тусламж үзүүлэх сургалтаар олж авсан мэдлэгтээ суурилан анхан шатны хэрэгслээ сайтар бэлтгэн байнга бэлэн байлгах хэрэгтэй. Энэ талаар мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч болно. Анхан шатны тусламжийн бэлэн багцыг худалдан авч шаардлагатай нэмэлт зүйлсээ өөрсдөө бэлтгээрэй. Анхан шатны тусламж үзүүлэх хэрэгслийг гарын доор тогтмол газар байлгах хэрэгтэй ба бүх гишүүдэд мэдэгдэж хэрхэн хэрэглэхийг зааж өгөх хэрэгтэй. Жуулчны улирал эхлэхээс өмнө хэрэгслийн бүрэн бүтэн эсэхийг сайтар шалгаж, хэрэгтэй зүйлсийг нэмж хийхдээ дуусах хугацааг хянаарай.





Анхан шатны тусламжийн цүнхэнд байх ёстой хэрэгслүүд: том, жижиг шархны туузан наалт, боолт, гар ариутгагч, чиг барьж боох гурвалжин хэлбэрийн боолт, ороолт, аюулгүйн зүү, нэг удаагийн бээлий, хайч, ариутгагчтай арчуур, жижиг скоч, халдварын эсрэг тос, халууны шил гэх мэт

Голлох эмнүүд: парацетамол, аспирин, ибупрофин, харшлын эм, шингэн нөхөх уусдаг таблет гэх мэт. Эмийн хайрцаг, бүрэн бүтэн байдал, хадгалалт, хугацаа хэтэрсэн эсэхийг шалгаж, ямар эмийг юунд хэрэглэдгийг мэдэж байх хэрэгтэй.

Анхан шатны тусламжийн заавар, зөвлөгөө бүхий гарын авлага авч явбал сайн. Яаралтай тусламж үзүүлэх газар, эмнэлэг, цагдаатай холбогдох дугаар, байршлыг тодорхойлсон газрын зураг авч яваарай.

Онцгой байдлын үед холбогдох дугаарыг аялалдаа заавал авч явахаас гадна жуулчдынхаа дараах бичиг баримтыг бэлэн байлгахыг анхааруулаарай:

- » Харьяалагдах элчин сайдын яам
- » Машин, гэнэтийн ослын даатгал гэх мэт.

Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудаст QR CODE-оор орж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.



Онцгой байдал, яаралтай тусламжийн үед мэдээлэл хийх

Гэнэтийн осол, яаралтай тусламжийн үед мэдээлэл өгөхдөө тайван тодорхой ярьж, доорх холбогдох мэдээллийг үнэн зөв өгөх хэрэгтэй.

- Нэр, хэн болох, утасны дугаараа хэлэх
- Осол болсон газар, баг, сумын нэрийг тодорхой хэлэх, боломжтой бол GPS-ийн заалтыг өгөх
- Юу болсон талаар, цаг хугацаатай нь тодорхой тайлбарлах. Тухайлбал машины осол, мориноос унасан гэх мэт
- Гэмтсэн хүний талаар мэдээлэл өгөхдөө нас, хүйс, биеийн байдлын талаар нарийвчлан хэлж харшилдаг зүйлийг нь мэдэгдэх
- Гэмтлийн талаар тодорхой тайлбарлахдаа өвчтөний шинж тэмдэг, амин үзүүлэлтүүд болох зүрхний цохилт, амьсгал, биеийн дулаан, хэрхэн өөрчлөгдөж байгаа тухай хэлэх
- Анхан шатны ямар тусламж үзүүлснээ сайтар тайлбарлаж хаана, ямар байрлалаар хэвтүүлж байгаагаа хэлэх



Нийтлэг гэмтэл бэртлийн үед анхаарах зүйлс

- Машины ослоос гадна морь, тэмээ унаж байгаад бэртэх нь жуулчдын дунд элбэг тохиолддог.
- Гэрийн хаалга, тотгонд толгойгоо цохих нь элбэг байдаг учир зочдодоо анхааруулж хэлээрэй. Анхааруулга бичиг өлгөж эсвэл тэр хэсэгт зөөлөвч хийж өгөөрэй.
- Жуулчид нохойд хүрч, илэх тохиолдол их. Учир нь тэдний гэрийн тэжээмэл амьтанд хандах хандлага өөр байдаг. Иймээс ганц нэгээрээ явж байгаад нохойд хүрэхээс болгоомжлох хэрэгтэйг хэлж, манайд нохой орон байраа хамгаалах үүрэгтэй байдгийг сануулаарай.
- Ихэнх жуулчид халуун зуух, янданд хүрч түлэгдэх тохиолдол байдаг. Тиймээс энэ талаар сануулж, халуун зуухтай ойр хувцас хэрэглэлээ тавихгүй байхыг хэлж өгөөрэй. Норсон хувцсаа хатаахаар зуухтай хэт ойр тавьснаас хувцсаа түлэх тохиолдол байдаг.

Галын аюулгүй байдал

Гэр кэмп, хээрийн аяллын галын аюулгүй байдлыг хангаж энэ талаар мэдлэгтэй байх нь чухал. Бүх гишүүдээ галын аюулгүй байдлыг сахих сургалтад хамруулаарай.

1. Гэр кэмгийн галын аюулгүй байдал

- Гал унтраах хэрэгслийг гэрт, тогтсон газар байрлуулаарай.
- Гал унтраах хэрэгслийн ажиллаж байгаа эсэхийг тогтмол шалгаарай.
- Хээрийн түймрийн үед хэрэглэх өрхийн гал унтраах хэрэгслээ бэлэн байлгаарай.
- Гал гарсан үед цуглах газраа урьдчилан тодорхойлоорой.
- Галын үед хэн юуг хаанаас авч, хэрхэн хэрэглэхийг сайтар төлөвлөөрэй.
- Лаа асаахдаа болгоомжтой байж, лааны тавиурыг битүү байлгах хэрэгтэй.
- Гал хэрхэн түлэхийг зочдодоо тайлбарлан, зуухны ойр шатамхай зүйл тавихгүй байхыг сануулаарай.

2. Аяллын үеийн галын аюулгүй байдал

- Ил задгай гал гаргахгүй байх, тодорхой заасан саруудад хээр гал түлэхгүй байх
- Хээр гал түлэхээр бол төмрөөр халхавч хийж, зүлэг ногоонд хүргэхгүй хөрснөөс хөндий байрлуулах хэрэгтэй.
- Зүлэг ногоо, мод бут, майханд оч үсрэхээс болгоомжлоорой.
- Ус асган галаа бүрэн унтрааж, үнсийг газар булах хэрэгтэй. *Гал түлсэн газраа нөхөн сэргээх талаар 15-р хэсгээс хараарай.*
- Гал түлэхэд хэрэглэсэн тулганы чулуугаа өвс, өөр бусад түлэгдэх зүйлээс хол байлгаарай.



- Тамхины ишийг зориулалтын саванд сайтар унтрааж хаяарай.
- Шилэн савыг галын ойр болон нарны шууд тусгалтай газар удаан байлгавал халж ойр хавийн зүйлээ түлж, гал гаргах аюултай.

Машин, жолоочийн аюулгүй байдал

Машины осол нь аяллын үед гардаг хамгийн нийтлэг осол байдаг.

Хариуцлагатай, чадварлаг жолооч

- Зочдод үйлчилж байгаа жолооч үнэмлэхтэй, туршлагатай, замаа сайн мэддэг, хариуцлагатай байх
- Механикийн талаар мэдлэгтэй байж, зарим нэг энгийн зүйлийг засчихдаг байх
- Аяллын үеэр согтууруулах ундаа хэрэглэхгүй байх
- Машинаа аюул осолгүй, бүрэн бүтэн, цэвэрхэн байлгах

Машинаа аюулгүй, бүрэн бүтэн байлгах

- Машин хэвийн сайн ажиллагаатай байх хэрэгтэй.
- Дугуй сайтай байж, нөөц дугуйг байнга авч явах ёстой.
- Машины багаж түлхүүр бүрэн байх хэрэгтэй
- Машины аюулгүйн бүс ажиллагаатай байх ёстой.

Жолоочийн аюулгүй байдал, зөвшөөрөл

- Замд явах хугацаагаа сайтар төлөвлөж, жолоочийг хэт ядрааж болохгүй. Хол замд амарч, завсарлага авч байх
- Машин тэрэгтэй холбоотой зөвшөөрөл, жолооны үнэмлэхээ байнга авч, замын дүрэм, аюулгүй байдлыг хангах

Зочны гэрийн аюулгүй байдал

Зочны гэр, аюулгүй байдлыг бүрэн хангасан байх хэрэгтэй бөгөөд гарч болзошгүй аюул осол, хулгай дээрэм зэргээс сэргийлнэ. Жуулчид орон нутаг, уламжлалт байдлыг мэдэхгүй учир өчүүхэн зүйл ч хачин жигтэй санагдаж болно. Тиймээс жуулчдад сайтар тайлбар өгч, анхааруулж, тайван амгалан байлгах нь юу юунаас ч илүү чухал. Монгол гэрт гадаадын жуулчид юуг хийж болох, болохгүйн тухай Хавсралт 17-д нэмэлт тайлбарыг англи хэл дээр оруулсантай танилцана уу.

Зочны гэр

- Гэрийн хаалга гадна дотроосоо цоожтой байх
- Үйлчлэгч орох бол заавал тогшиж орох
- Гэрийн хаалганы мод өргөсгүй байх
- Тотго, босгонд анхааруулах зүйл хадсан байх



- Нарны гэрлээр ажилладаг эсвэл аккумуляторт залгадаг гэрэлтэй бол залгуурын аюулгүй байдлыг шалгаж байх
- Зуух, яндан нь битүүмжлэл сайтай байх
- Зуухны амнаас оч үсрэхэд гал авалцахааргүй хулдаас, төмөр тавцантай байх
- Өрх янданд хүрч шатахааргүй байх
- Халтирахааргүй шалтай, хуйларсан хулдаасанд бүдрэхээс сэргийлэх
- Гэрлийн унтраалга үүдэнд байх
- Аюулгүй байдлын зааварчилгаа, галын хор ил байрлуулах
- Унь унахааргүй бөхөлж эсвэл нэмэлт уяа гүйлгэх

Жуулчдаа орон нутгаар авч явахдаа анхаарах зүйлс

- Тэдэнд аюулгүйн зөвлөгөө өгч, харж халамжлаарай.
- Жуулчдад олон хүний өмнө мөнгөө ил тоолохгүй байхыг хэлэх
- Цүнх саваа хааж, анхааралтай харж явахыг сануулах
- Орон нутгийн бааранд жуулчдаа дагуулж орохгүй байх
- Согтуу хүмүүсээс жуулчдаа хол байлгах
- Элдэв хэрүүл маргаантай газар, хүмүүсээс хол байх
- Гадны хүн ирж хэт ойртох, яриа өдөх зэргээс болгоомжлох
- Жуулчдадаа архи санал болгож, согтоож огт болохгүй.

Эд зүйлээ хулгайд алдсан, айж сандарсан жуулчныг тайтгаруулах

Жуулчид хэрэгтэй бичиг баримт болох паспорт, билет, банкны карт зэргээ алдсан үед сэтгэл санаа нь тогтворгүй болж стрессдэх нь ойлгомжтой. Энэ үед тэднийг зохих газартай нь холбож өгөхөөс гадна тайтгаруулаарай. Тэд дассан газраасаа хол, танихгүй хүмүүсийн дунд очиж үзээгүй нутагт яваа тул аливаа зүйлд эмзэг ханддаг. Тухайлбал машин замаасаа гарахад л төөрчихлөө гэж айдас түгшүүрт автах нь ч байдаг. Байн байн зам, цаг асуухад нь төвөгшөөлгүй хариулаарай. Зочны гэрийн хаалга цоожтой эсэх, буусан майхныг харж хандах зэргээр санаа тавиарай.

Жуулчин тань паспортоо алдсан тохиолдолд тухайн орны элчин сайдын яам руу яаралтай холбогдож мэдэгдээрэй. Мөн банкны картаа гээсэн бол холбогдох газар, тур операторуудтай холбогдож тусламж хүсээрэй.



Хууль бус үйл ажиллагаа



Зарим тохиолдолд жуулчид өөрсдөө хууль бус ажиллагаанд оролцох магадлалтай. Тухайлбал хууль бус ан хийлгэх санал тавих, зэрлэг амьтны эд эрхтэн олж өгөхийг шаардах, биеэ үнэлэгч олж өгөхийг хүсэх, хар тамхи мансууруулах бодис татах гэх мэт асуудлууд гардаг. Энэ үйлдлийг цаг тухайд нь таслан зогсоож харьяа байгууллагад мэдээлэх нь та бүхний үүрэг бөгөөд өөрийн аюулгүй байдлаа ханган сэрэмжтэй байх хэрэгтэйг санаарай.

Ажилчдын болон ажлын байрны аюулгүй байдал

- Хамтран ажилладаг аяллын компаниасаа даатгалд хамруулж өгөхийг хүсч, энэ талаарх гэрээндээ тусгахыг шаардаарай.
- Бусад нэмэлт даатгалд хамрагдаарай.
- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдан, ямар нэгэн осол эндэгдлийн үед халамжийн үйлчилгээг хуулийн дагуу авч байх хэрэгтэй. Хавсралт 18-д ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлүүд, шийдвэрлэх арга замуудыг орууллаа.

Аялалд гарахаас өмнө аюулгүй байдлаа хангаарай

1. Аяллын төлөвлөгөөгөө хэлж үлдээгээрэй

Хэдэн ч өдрийн аялал байсан хаагуур явах, хэзээ ирэх аяллын маршрутаа найдвартай хүнд хэлж үлдээгээрэй. Та бүхнийг төлөвлөсөн хугацаандаа ирэхгүй бол сум орон нутаг, цагдаа, Онцгой байдлын ерөнхий газар, Хамгаалалтын захиргаа зэрэг авран хамгаалах байгууллагад мэдэгдэх ёстой. Мөн аялалд бэлтгэх зарим зөвлөгөөг Хавсралт 19-с харна уу.

2. Яаралтай үед холбогдох утасны дугаар, авах арга хэмжээ

Та онцгой байдал, яаралтай үед хаана хандахаа мэдэх үү? Эмнэлэг, яаралтай тусламж, аврах анги гэх мэт газруудын утасны дугаар, холбогдох хаягийг аялалдаа авч явах хэрэгтэй. Гэр кэмпэд болон гэрт үлдэж байгаа хүн энэ талаар бас мэдэж байх ёстой. Осол гэмтлийн үед машин ирж авахад дөхөм байх үүднээс явган болон морин аяллын үеэр хаагуур машин зам өнгөрч байгааг анзаарч байх хэрэгтэй.



Утасны сүлжээтэй газраар аялж байхдаа утсандаа ЖиПиЭс (GPS) суулгаснаа харж, хаана яваагаа тэмдэглэж байх хэрэгтэй. Тэрчлэн хэрхэн ашиглахыг сайн сурч авбал хэрэг болсон үед байгаа газрынхаа координатыг хэлэхэд л болно.

3. Аюулгүй аялахын тулд тохиромжтой хувцас, хэрэглэлээ базаагаарай

Жуулчид болон аяллын ахлагч, хөтчөө хувцас, хэрэглэлээ сайн базаасан эсэхийг асуугаарай. Хүйтэн, халуун, салхи, нар, борооноос хамгаалалттай хувцас хэрэглэлээ сайтар бэлдэж тухайн аялалд тохирсон гутал өмсөхийг сануулаарай. Жуулчид замын ая дааж чадах эсэхийг шалгаарай.

4. Цаг агаараа шалгаарай

Цаг агаарын урьдчилсан мэдээг зурагт, радио, цахимаар болон нутгийн туршлагатай хүнээс асуугаарай. Гол гатлах эсвэл буудаллах газарт тань үер усны аюул болох эсэхийг сайтар шалгаарай.

Уулын аялал хийх бол газар усаа сайн мэддэг, туршлагатай нутгийн хөтөчтэй хамт явж, аяллын хэрэгслээ бэлтгэн цаг агаар цас, мөсний байдлаа сайн харгалзан үзээрэй.

Морь, тэмээн аяллын үеэрх аюулгүй байдал

Улаанбаатарын эмнэлгүүдэд ирж буй гэмтсэн хүмүүсийн ихэнх нь мориноос унаж бэртсэн байдаг. Хэрвээ морь тэмээ хөлсөлж авсан бол жуулчдадаа заавар зөвлөмжийг сайтар өгч, байнга хараа хяналтдаа байлгаарай. Хэт олон групп жуулчин нэг дор авахаас зайлсхийгээрэй.

1. Морь унах ачаалахад бэлтгэх, морио сонгох

Морин аяллын хамгийн хүндрэлтэй зүйл нь морьд өөр өөр сүргээс ирж нийлсэн байдаг учир бие биеэ өшиглөх, тангарах зэрэг аягүй зүйл гардаг. Үүнээс үүдэн жуулчид айж сандран хөтчийн ажлыг хүндрүүлдэг.

Харин аялалд явж уналга, ачлагад гаршсан морьд нь номхон, бууж мордоход хөдөлгөөнгүй байж, мордсон хүн дохио өгөхөд хөдөлгөөнд орж сурсан байдаг. Мордох үед морь тэмүүлж торгоход төвөгтэй байдаг учир хөтөч жуулчнаа мордоход заавал туслах хэрэгтэй.

Манай адуучин залуус давхиж байхдаа бууж мордох зэрэгт гаргууд сайн ч иймэрхүү чадвараа гайхуулах нь тайван байдлыг бусниулж, морьд үргээж жуулчдаа айлгадаг.



Ихэнх жуулчид морь унах туршлагагүй байдаг. Туршлагатай гэгдэх гадаадын жуулчдын морь унах, эмээллэх, морио жолоодох зэрэг нь манайхаас их өөр.

Монгол хүн бүр морь унадаг гэж битгий шууд дүгнээрэй. Зарим нэг хотын хүмүүс морь унах ямар ч туршлагагүй байдаг. "Чи Монгол хүн юм чинь морь унаж чадна" гэж хэлээд тааралдсан морио эмэгтэй хөтчид өгдөг тал нэлээдгүй байдаг.

2.Амьтан хайрлах

Жуулчинд унуулж буй морь нь тэжээл сайн авсан, эрүүл чийрэг байх хэрэгтэй. Тохомгүй эмээллэх, таараагүй эмээл тохсоноос нуруу нь холгосон эсэхийг сайтар анхаарах хэрэгтэй. Гадаадын жуулчид морины эрүүл чийрэг байдал, таны мориндоо хэрхэн хандаж байгааг их ажигладаг.

3.Эмээл, олом, жирэм

Монгол уламжлалт эмээл, олом, жирэм нь хийц сайхантай байдаг ч гадаадынханд тухгүй байх нь элбэг. Морины олом, жирэм, жолоо зэрэг нь бат бөх, найдвартай эсэхийг шалгаарай. Жуулчныхаа өмссөн гутлыг сайн ажиглаарай. Гутал нь том бол дөрөөнд тулдаг учир урт түрийтэй, бага зэрэг өсгийтэй гутал морь унахад тохиромжтой. Харин пүүз эсвэл өсгийгүй гутал нь дөрөөнд хальтардаг учир мориндоо унаж чирэгдэх аюултайг санаарай.

Морины тоноглол бүрэн бүтэн байгаа эсэхийг шалгаарай. Гадаадын жуулчид чийрэг, хэрийн юманд ажирдаггүй Монгол морины чансааг сайн мэдэхгүй учир эмээл, олом нь морийг нухаж тухгүй байгааг анзаарч санаа нь зовдог. Мэдээж морио хэт ядрааж болохгүй ч Монгол морины хатуужил замын аян даадаг гэдгийг тэдэнд ойлгуулаарай. Харин хоноглох газраа ирээд ус ууж, өвс идэж амарч байгаа морьдыг хараад жуулчдын сэтгэл баясдаг.

4.Морины хурдыг тохируулах

Морь унан салхин татуулах давхих адал явдаг хайгч биш л бол ихэнх жуулчид морио зөөлөн алхуулан, манай орны үзэсгэлэнт байгалийг шимтэн харж сэтгэлээ баясгадаг. Морио давхиулж, цогиулах нь бусад морьдыг уруу татаж аюулд оруулах талтай. Харин морь сайн унадаг жуулчин бол бусдаасаа жаахан зайдуу явж давхиулж болно.

Дээр дурдсан зүйлс тэмээ унахад ч хамаарна. Аль болох номхон тэмээ жуулчдад унуулж, хэрэглэл, тоногоо шалгаж, тайван уур амьсгал бүрдүүлж, жуулчдадаа заавар зөвлөгөөг сайн өгч, байнга харж халамжлаарай.



5.Гол гатлах

Монгол морьд хүч чадал, зориг ихтэй учраас гол усыг чадварлаг туулан гардаг. Гэвч гол гатлахын өмнө усны түвшин, урсгалын хурдыг сайтар тооцоолох хэрэгтэйг санаарай.

Хэрвээ усны түвшин их бол жуулчдадаа ус татартал хүлээн байгаа газраа хоноглохыг санал болгоно. Гэхдээ бүхий л талаас нь сайтар бодон, нөхцөл байдалдаа тааруулан шийдвэр гаргах нь чухал.

Гол усаа сайн мэдэж хаагуур гаталбал аюул багатайг мэдэж байх нь чухал. Тэрчлэн нутгийнхаа сайн мэддэг хүмүүсээс давхар асууж лавлаж үгийг нь дагаарай.

Морь, тэмээн аялал хийх зааварчилгааг Хавсралт 20-с дэлгэрэнгүй хараарай.

6.Буудаллах газраа сонгох

Салхины нөмөр газрыг бараадан, голоос зайдуу өндөрлөг газар буудаллаарай. Мөн цаг агаарын мэдээг сайтар шалгаарай. Үерийн аман дээр буухаас сэрэмжилж, үер уснаас болгоомжлоорой.

Ойд буудаллахаар бол хуурай, өгөршсөн ургаа мод салхинд унах аюултай тул ийм газар майхнаа барихаас зайлсхийгээрэй. Мөн сул чулуутай эгц хадны хажууд буудаллахгүй байсан нь дээр.

Зэрлэг амьтан ирж ус уудаг эсвэл мэрэгч амьтантай газраас холхон буудаллах хэрэгтэй. Үүнээс гадна нутгийн онгон тахилгатай газар, бэлчээр усанд сөргөөр нөлөөлөхөөр бол буудаллаж болохгүйг анхаараарай.

Адал явдалт, спорт аялал

Спорт аялал, ууланд авирах, завиар явах зэрэг адал явдалт аялалд мэргэжлийн хөтөч авч явах зайлшгүй шаардлагатай.

Ууланд авирахад уяа, авирах хэрэгсэл байсан ч хангалтгүй. Учир нь та эдгээр хэрэгслээ хэрхэн ашиглах, авирах арга, туршлага байхгүй учраас хүндрэлтэй байдаг. Тиймээс уулын аялал хийхэд маш болгоомжтой хандаж мэргэжлийн хөтөч, нутгийн байгаль хамгаалагчтай хамтран ажиллаж, цаг агаарын мэдээг сайтар сонсох шаардлагатай.

Ууланд аялахад гэнэт цаг агаар өөрчлөгдөх, цас, бороо орох зэрэг гэх мэт эрсдэл учирч болзошгүй. Тухайлбал өглөө орсон цас үдээс хойш хайлахад мөс тогтож уулнаас бууж ирэхэд аюултай байдаг бол дулаан цаг агаар уулын нуранги үүсгэх аюултай.

Завиар аялах бол хамгийн хүндрэлтэй аялал юм. Учир нь энэ чиглэлийн мэргэжилтэн, сайтар бэлтгэсэн тоноглолтой завь, туршлагатай чадварлаг хөтөч зэрэг ховор байдаг.





ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ 1. Олон улсын аялал жуулчлалын ёс зүйн хэм хэмжээ Олон улсын аялал жуулчлалын ёс зүйн хэм хэмжээ нь дэлхийн аялал жуулчлалыг хариуцлагатай, тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор боловсруулагдсан баримт бичиг юм. Энэ нь аялал жуулчлалын салбарынханд зориулсан багц зарчмуудыг багтаасан. Тэрчлэн засгийн газар, аялал жуулчлалын салбар, олон нийт, жуулчдад хандаж, дэлхийн хэмжээнд байгаль орчин, соёлын өв, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын зэрэгцээ салбарын ашиг тусыг нэмэгдүүлэхэд туслах зорилготой юм.

1-р зүйл. Нийгэм болон хүмүүс хоорондын харилцан ойлголцол, хүндэтгэлд аялал жуулчлалын оруулсан хувь нэмэр

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Шашин, гүн ухаан, ёс суртахууны олон талт итгэл үнэмшил, үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, нийтлэг ёс зүйн үнэт зүйлсийг ойлгож, сурталчлах нь хариуцлагатай аялал жуулчлалын үндэс ба үр дүн юм. Аялал жуулчлалыг хөгжүүлэгч талууд, жуулчид нь бүх ард түмний, тэр дундаа үндэстний цөөнх болон уугуул иргэдийн соёл уламжлал, зан үйлийг анхаарч, тэдний үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

2-р зүйл. Аялал жуулчлал нь хувь хүний болон олон нийтийн сэтгэл ханамжийн хэрэгсэл юм.

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь хүйсийн эрх тэгш байдал, нийгмийн цөөнх, хүүхэд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, үндэсний цөөнх, уугуул иргэд болон хувь хүмүүст хүндэтгэлтэй хандаж хүний эрхийг дээдлэн, түгээж байх ёстой.

Хүмүүсийг аливаа хэлбэрээр ашиглах тэр дундаа насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах нь аялал жуулчлалын үндсэн зорилгуудтай зөрчилдөж байгаа явдал бөгөөд аялал жуулчлалыг үгүйсгэж байгаа хэлбэр болно. Олон улсын хууль тогтоомжид тусгагдсанаар улс болгон ийм төрлийн гэмт хэрэгтэй хүчтэй тэмцэж, хамтран ажиллах ёстой бөгөөд энэ төрлийн хэрэг үйлдсэн этгээдийг тухайн улсын хуулийн дагуу шийтгэх хэрэгтэй. Цаашлаад гадаадад зугтан гарсан тохиолдолд тухайн орны хуулиар шийтгэх нь зүйтэй.

3-р зүйл. Аялал жуулчлал нь тогтвортой хөгжлийн хүчин зүйл болох нь

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оролцогч талууд нь өнөөгийн болон ирээдүй хойч үеийн хүсэл эрмэлзэл, тэдний эрэлт хэрэгцээг хангах



тогтвортой, тасралтгүй эдийн засгийн өсөлтийг дэмжиж, байгаль, хүрээлэн буй орчноо унаган төрхөөр нь хамгаалж үлдээх хэрэгтэй.

Байгалийн нөөц баялгийг хадгалан хамгаалж ус, эрчим хүчийг хэмнэн, хог хаягдал үйлдвэрлэхээс зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын хөгжилд хувь нэмрээ оруулж буй бүх хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэгчдийг орон нутгийн болон төрийн захиргааны байгууллагуудад давуу тал олгон урамшуулан дэмжих ёстой.

4-р зүйл. Аялал жуулчлал нь хүн төрөлхтний соёлын өвийг хэрэглэгч болоод хөгжүүлэгч юм.

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Аялал жуулчлалын нөөц нь хүн төрөлхтний соёлын өвд хамаарна. Нутгийн иргэд өөрийн газар нутгийн өвтэй хамааралтай эрх эдлэхийн зэрэгцээ үүрэг хүлээдэг.

Аялал жуулчлалын үйл ажиллагааг уламжлалт соёлын бүтээгдэхүүн, гар урлал, ардын аман зохиолыг доройтуулж, стандартчилахад хүргэх бус харин оршин тогтнох, дэлгэрүүлэх, тодотгох боломжийг олгохоор төлөвлөх ёстой.

5-р зүйл. Аялал жуулчлал нь гадны аялагчдыг хүлээн авч буй улс орон, нутгийн иргэдэд хүртээмжтэй байх

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Орон нутгийн ард иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаа, тэдгээрээс гарах эдийн засаг, нийгэм, болоод соёлын, тэр дундаа шууд болон шууд бус ажлын байрнаас бий болох ашгийг тэгш хүртэх ёстой.

Аялал жуулчлалын бодлого нь тухайн бүс нутгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, тэдний хэрэгцээг хангахад чиглэгдэн хэрэгжих ёстой. Аялал жуулчлалд зориулсан амралтын газар, байрны төлөвлөлт, тэдгээрийн архитектурын хандлага, ашиглалт нь бүхий л байдлаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хүрээллийг хамруулсан байх шаардлагатай. Ур чадвар эн тэнцүү байгаа тохиолдолд орон нутгийн ажиллах хүчинд давуу эрх олгох хэрэгтэй.

6-р зүйл. Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оролцогч талуудын хүлээх үүрэг

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Аялал жуулчлалын мэргэжилтнүүд аялагч, жуулчдыг хариуцах хугацаандаа тэдний аюулгүй байдал, ослоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдалд төрийн байгууллагуудтай



хамтран анхаарал хандуулах ёстой. Тэд мөн даатгал, тусламжийн тохиромжит тогтолцоогоор хангагдах ёстой. Төр засгийн журмаар тогтоосон тайлагнах үүргээ хүлээн зөвшөөрч, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд шударгаар нөхөн төлбөр төлдөг байх хэрэгтэй.

7-р зүйл. Аялал жуулчлалын эрх

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Гариг эрхсийн нөөц баялгийг нээж олох, ашиглахад дэлхийн хүн бүр адил тэгш нээлттэй эрхтэй. Үндэсний болон олон улсын аялал жуулчлалд өргөн цар хүрээтэй оролцох нь чөлөөт цаг тогтвортой өсч буй хамгийн сайн боломжит илэрхийлэл гэж үзэж, түүний замд саад тотгор учруулах ёсгүй.

8-р зүйл. Аялагчийн эрх чөлөө

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Жуулчид болон аялагчид олон улсын эрх зүй, үндэсний хууль тогтоомжийн дагуу Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13-р зүйлд зааснаар өөрсдийн улс орондоо болон нэг улсаас нөгөө улс руу шилжих эрх чөлөөнөөс ашиг хүртэх ёстой. Тэд хэт албан ёсны болон ялгаварлан гадуурхалгүйгээр дамжин өнгөрөх, буудаллах газрууд болон, аялал жуулчлал, соёлын газруудад нэвтрэх эрхтэй байх ёстой.

9-р зүйл. Аялал жуулчлалын салбарын ажилчид, бизнес эрхлэгчдийн эрх

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшсэн аливаа иргэн, хуулийн этгээд нь одоо мөрдөгдөж буй үндэсний хууль тогтоомжийн дагуу аялал жуулчлалын чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй байх ёстой. Ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид аялал жуулчлалын салбарт хууль эрх зүйн болон захиргааны хамгийн доод хязгаарлалтаар чөлөөтэй нэвтрэх эрхтэй байх ёстой.


10-р зүйл. Дэлхийн аялал жуулчлалын ёс зүйн дүрмийн зарчмуудыг хэрэгжүүлэх нь

Зарчмын зарим нэг хэсгээс дурдвал:

Аялал жуулчлалын хөгжилд оролцогч төрийн болон хувийн хэвшлүүд нь энэхүү зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс хамтран ажиллаж, үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай.



ХАВСРАЛТ 2. Монгол улсад ирсэн жуулчдын тоо. (Улс орноор)



| 2015 – 2019 онд Монголд ирсэн жуулчдын тоо | | | | | | | |
|--|---------|---------|---------|---------|---------|-------------|--------------------------------|
| | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2019 Хувиар | 2015 – 2019 оны жуулчдын тоо % |
| Бүгд | 386.204 | 404.163 | 469.309 | 529.370 | 577.297 | 100.0 | 49 % |
| Хятад | 145.029 | 131.312 | 142.481 | 163.979 | 168.298 | 29.2 | 16 % |
| ОХУ | 70.668 | 84.065 | 106.885 | 129.095 | 141.927 | 24.6 | 101 % |
| Солонгос | 47.213 | 57.587 | 74.921 | 84.184 | 101.279 | 17.5 | 115 % |
| Япон | 19.277 | 19.985 | 22.519 | 20.990 | 24.419 | 4.2 | 27 % |
| АНУ | 14.420 | 15.859 | 16.667 | 17.838 | 18.838 | 3.3 | 31 % |
| Казакстан | 14.434 | 13.370 | 14.234 | 16.144 | 16.264 | 2.8 | 13 % |
| Герман | 8.992 | 9.709 | 10.582 | 10.819 | 12.405 | 2.1 | 38 % |
| Франц | 7.989 | 9.026 | 10.038 | 9.773 | 10.572 | 1.8 | 32 % |
| Австрали | 4.804 | 5.631 | 7.287 | 7.495 | 7.014 | 1.2 | 46 % |
| Англи | 6.148 | 6.161 | 5.996 | 5.905 | 5.931 | 1.0 | -4 % |
| Тайван | 2.810 | 3.732 | 4.452 | 5.233 | 5.930 | 1.0 | 111 % |
| Хонконг | 1.848 | 1.583 | 2.808 | 3.121 | 4.311 | 0.7 | 133 % |
| Итали | 2.853 | 3.000 | 2.971 | 3.192 | 3.655 | 0.6 | 28 % |
| Нидерланд | 2.495 | 2.876 | 3.099 | 3.777 | 3.613 | 0.6 | 45 % |
| Канад | 2.566 | 3.052 | 3.430 | 3.578 | 3.594 | 0.6 | 40 % |



| | | | | | | | |
|----------|-------|-------|-------|-------|-------|-----|-------|
| Сингапур | 1.755 | 2.064 | 2.485 | 2.649 | 3.010 | 0.5 | 72 % |
| Швейцар | 2.378 | 2.627 | 2.767 | 2.665 | 2.927 | 0.5 | 23 % |
| Беларус | 1.078 | 1.329 | 2.107 | 2.210 | 2.902 | 0.5 | 169 % |
| Тайланд | 962 | 1.100 | 1.492 | 2.259 | 2.631 | 0.5 | 173 % |
| Энэтхэг | 1.478 | 1.713 | 1.874 | 2.298 | 2.478 | 0.4 | 68 % |
| Испани | 1.309 | 1.461 | 1.647 | 1.969 | 2.080 | 0.4 | 59 % |
| Турк | 2.421 | 2.209 | 2.189 | 2.999 | 1.874 | 0.3 | -23 % |

*Дэлхийн банк (2021). Монгол Улс
Fostering Inclusive Tourism Development in the Aftermath of COVID-19*

ХАВСРАЛТ 3. Тусгай хамгаалалттай газар нутаг дах аялал жуулчлал, аялагч жуулчдад үзүүлэх удирдлага зохион байгуулалтын (менежментийн) олон улсын шилдэг туршлага, зарчим

IUCN-ийн¹ "ТХГН-ийн аялал жуулчлал ба жуулчдын менежмент – Тогтвортой байдлын удирдамж" (2018)-д тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын шилдэг туршлагын гол шинж чанаруудыг тодорхойлсон. Эдгээр шинж чанарууд нь бүх улс орнуудад хамааралтай бөгөөд Монгол улсад болон тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлэх боломжтой. Шилдэг туршлагуудыг нэгтгэн дүгнэвэл:

Тусгай хамгаалалттай газар нутагт зохион явагдах аялал жуулчлал нь:

(i) байгалийг хамгаалахад хувь нэмэр оруулах (байгаль орчны үнэ цэнэ);

(ii) менежментийн зардлыг дэмжихэд туслах зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн эрх баригчид болон эзэмшигчдэд эдийн засгийн үр өгөөжийг бий болгох, мөн орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг бий болгох (эдийн засгийн үнэ цэнэ);

(iii) нийгэм, соёлыг (нийгмийн үнэ цэнэ) баяжуулахад хувь нэмэр оруулдаг байх

- Аялал жуулчлалыг байгаль хамгаалал болон нөхөрлөлийн хөгжилд үр дүнтэй хэрэгсэл болгохын тулд жуулчдыг өндөр чанартай хүлээн авдаг байх туршлага чухал юм. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж буй менежерүүд болон аялал жуулчлалын операторуудын үзүүлж буй туршлага нь бусад чиглэлд санал болгож буй туршлагаас ялгаатай байх ёстой. Тэд байгаль хамгаалах ёс зүйг төлөвшүүлэх зорилготой байх хэрэгтэй. Жуулчид тухайн тусгай хамгаалалттай

¹IUCN нь байгаль хамгаалах олон улсын холбоо бөгөөд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр судалгаа, хээрийн төсөл, дэмжлэг, боловсрол олгох чиглэлээр идэвхтэй ажилладаг олон улсын байгууллага юм.



газар нутагт хэрхэн, яагаад байгаль хамгаалалын үйл ажиллагаа явагдаж байгааг мэдэж байх ёстой.

- Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын сөрөг нөлөө, ашиг тусыг хоёуланг нь нээлттэй хүлээн зөвшөөрөх ёстой. Аялал жуулчлалтай холбоотой нийгэм болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөг үндэслэн гаргаж буй аливаа шийдвэрийг зарлаж, дүн шинжилгээ хийж, хянадаг байх ёстой.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал нь нутгийн иргэдийн онцгой хэрэгцээг хүндэтгэх ёстой. Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын үр өгөөжийг орон нутгийн иргэдээс эхлээд бусад үйлчилгээ үзүүлсэн бүх талууд хүртэх ёстой. Аялал жуулчлалын сөрөг нөлөөлөл нь орон нутгийн нөхөрлөлүүдэд дангаар үлдэх ёсгүй.

Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал, жуулчдад зориулсан менежментийн 10 зарчим:

1. Аялал жуулчлалын болон жуулчдын менежментийн зорилгыг боловсруулахдаа байгаль хамгаалах үнэт зүйлстэй холбож тодорхой гаргасан байх
2. Арилжааны аялал жуулчлалын болон хувь жуулчдад зориулсан аялал жуулчлалын үйл ажиллагааг хөгжүүлэх, ажиллуулах, ашиглалтаас гаргах зорилгоор ирээдүйд гарах өөрчлөлтийг урьдчилан харж, идэвхтэй төлөвлө. Арилжааны аялал жуулчлал, дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд бодлогын хамрах хүрээг бий болгох, гэрээ байгуулахад бэлэн байх, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг (БОНБУ) хийсэн байх, байнгын хяналт тавьдаг байх.
3. Жуулчдын үзэх бүтээгдэхүүнд болон тусгай хамгаалалттай газарт зохион явагдах олон янзын үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно. Эдгээр өөрчлөлтүүд нь нэг талаар сорилт боловч байгаль хамгаалахад чиглэгдсэн шинэ бүтээгдэхүүн бий болгох боломжийг бүрдүүлдэг. Монгол улсын Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын бүсчлэл нь ашиглалтын төрөл бүрийн хэлбэрийг хэдийн чиглүүлдэг боловч тодорхой газар нутагт хийгдэх үйл ажиллагааг бүсчлэлээс илүү нарийвчлан төлөвлөж болно.
4. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь байгалийн нөөц, нийгмийн



нөхцөл байдалд ямар нэг байдлаар үр нөлөөг зайлшгүй үзүүлж байдаг. Нөлөөллийг үнэлэх, удирдах арга аргачлалд “Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар” болон ТХГН-ийн удирдлагын чанарын шалгуур үзүүлэлтүүдийг тохиролцох замаар аялал жуулчлалын даацыг тодорхойлох зэрэг багтдаг. Удирдамжид эдгээр ойлголт, аргуудыг нарийвчлан тусгасан болно.

5. ТХГН-т аялал жуулчлал, жуулчдын үзүүлэх нөлөөллийг бууруулах дөрвөн төрлийн стратеги байдаг: а) нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (зочдын үзэх бүтээгдэхүүн), б) ашиглалтын нөлөөллийг багасгах, в) аялал жуулчны бүтээгдэхүүн/нөөцийн бат бөх чанарыг нэмэгдүүлэх, г) ашиглалтыг хязгаарлах. Аялал жуулчлалын нөлөөллийг зохицуулах хамгийн түгээмэл хэрэглүүр бол бүсчлэл гаргах, норм тогтоох, дүрэм, журмыг хэрэгжүүлэх юм.
6. Сөрөг нөлөөлөл нь тээврийн хэлбэр, групп жуулчдын хэмжээ, аль улиралд аялаж байгаа зэрэг олон хүчин зүйлээс үүдэн гардаг. Үйлчилгээний үнийг ялгавартай байлгах (отоглох газрын гоо үзэмжийн үнэ цэнэ, улирлаар гэх мэт) мөн жуулчдын үйл ажиллагааны шийдвэрт нөлөөлөх зэрэг нь шууд хязгаарлаж хориглосон шийдвэрээс илүү оновчтой урт хугацааны стратеги байх болно.
7. Тогтвортой хяналт-мониторинг нь удирдлагын үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх, ямар зохицуулалт хийх шаардлагатайг мэдэхэд тусладаг ТХГН-ийн удирдлагын зайлшгүй чухал элемент юм. Хяналтын тогтолцоог бий болгоход анхаарах гол асуултууд нь: Яагаад хяналт тавих ёстой вэ? Юуг хянах вэ? Хаана, хэзээ хяналт тавих вэ? Хэн хяналт тавих вэ? Мэдээллийг хэн шинжлэх вэ? Мэдээллийг хэрхэн ашиглах вэ? Монгол улсад хяналтын тогтолцоог ажиллуулахад сайн дурын судлаач эрдэмтэд, ялангуяа орон нутгийн иргэдийн оролцоо маш чухал. Удирдамжид тусгай хамгаалалттай газар нутагт хяналтыг (мониторинг) хэрхэн хийдэг тухай олон улсын жишээнүүдийг багтаасан болно.
8. Удирдлага зохион байгуулалтын шийдвэр гаргахдаа техникийн тодорхойлолт үзүүлэлтийг үнэ цэнийн үнэлгээнээс тусгаарлах ёстой.
9. Тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд жинхэнэ зөвшилцөл, түншлэл чухал байдаг тул бүх бүлгүүд (оролцогч талууд, эрх эзэмшигчид) төлөвлөлтөд идэвхтэй оролцох ёстой.
10. Талуудын түншлэлийг амжилттай байлгахын тулд менежерүүд



дараахь зүйлийг баталгаажуулах ёстой:

- Бүх түншүүд өөрсдийн үүрэг, хариуцлагыг шийдэж, ойлгож, зөвшөөрч, бичгээр баримтжуулах;
- Оролцогч бүх хүмүүс үүрэг, амлалтаа адил тэгш хариуцах;
- Түншлэл нь харилцан ашигтай байх;
- Түншлэлийн амжилт, үр ашгийг үнэлэх механизм бий болгох;
- Нээлттэй, шударга харилцааг эн тэргүүнд эрхэмлэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад, ТББ-ууд, уугуул иргэд, орон нутгийн иргэд, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь маш их үр өгөөжтэй боловч бүлэг тус бүр өөр өөр зорилго, түүнд хүрэх арга замуудтай байдаг тул маш их бэрхшээл тулгардаг. Менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оролцооны аргаар төлөвлөн хамтран ажилласнаар оролцогч талууд орон нутгийн иргэдтэй үр дүнтэй түншлэлийг бий болгож чадна. "(ТХГН-ийн аялал жуулчлал ба жуулчдын менежмент, Тогтвортой байдлын удирдамж, 2018, IUCN хуудас 50).

Хавсралт 4. Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)

1993 оны 12-р сард хүчин төгөлдөр болсон Биологийн олон янз байдлын тухай конвенц нь биологийн олон янз байдлыг хамгаалах, биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтвортой ашиглах, удамшлын нөөц ашигласны үр шимийг тэгш хүртэх тухай олон улсын гэрээ юм. Энэ бол 193 талууд нэгдсэн даян дэлхийн конвенц.

Энэхүү конвенц нь биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд учирч буй аюул заналыг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэх, бууруулах арга хэрэгсэл, урамшуулах арга замыг хөгжүүлэх, технологи, сайн туршлага нэвтрүүлэх, уугуул болон нутгийн иргэд, залуучууд, ТББ, эмэгтэйчүүд, бизнесийн хүрээнийхэн зэрэг холбогдох талуудын идэвхтэй оролцоог эрэлхийлдэг.

2010 онд болсон Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын багахурлын 10 дугаар хуралдаанаас 2011-2020 онд хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлын Стратегийн Төлөвлөгөөнд багтдаг стратегийн таван зорилт, "Айчи-20" зорилтыг шинэчлэн найруулсан. Энэхүү төлөвлөгөө нь биологийн олон янз байдлын тухай бусад конвенцууд төдийгүй НҮБ-н бүхэл тогтолцоонд хамааралтай бичиг баримт юм.

Одоогийн байдлаар 2020 оноос хойшхи дэлхийн биологийн олон янз



байдлын ерөнхий хамрах хүрээг боловсруулж байгаа бөгөөд 2022 оны 3-р сард (Женев) болон 2022 оны 4 дүгээр сард (Кунмин, Хятад) хуралдахаар төлөвлөж буй Талуудын бага хурал (COP 15)-аар 2030 он хүртэлх шинэ зорилтуудыг тохиролцохоор төлөвлөж байна.

Монгол Улс нь Биологийн олон янз байдлын тухай конвенцэд нэгдэн орсон 2030 он гэхэд газар нутгийнхаа 30 хувийг хамгаалалтад авах үүрэг хүлээсэн Өндөр амбицтай эвслийн бүлгийн гишүүн улс юм.

ХАВСРАЛТ 5: Компани, нутгийн иргэдийн байгууллагын хэлбэр
(хүснэгтээр)



ХАВСРАЛТ 5: Компани, нутгийн иргэдийн байгууллагын хэлбэр (хүснэгтээр)

| № | Аж ахуйн нэгжийн төрөл | Хэлбэр | Зорилго | Үүсгэн байгуулах баримт бичиг | Тусгай зөвшөөрөл лиценз шаардлагатай эсэх | Хамтын оролцоо | Давуу тал | Сул тал |
|------------------|--|---|--|----------------------------------|---|---|---|--|
| | | | | | | | | |
| 1. | Компани | А. Хувьцаат компани ХК Б. Хязгаарлагдмал хариуцлагатай компани | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж ашиг олох , Хуримтлал бий болгох | Дүрэм | Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. Бие даан жуулчин хүлээн авах үйл ажиллагаа явуулах бол МАЖХолбоноос ангиллын гэрчилгээ авна. | Бие дааж болон бусадтай хамтран байгуулж болно. Бүгд хариуцлагаа оруулсан хөрөнгийн хэмжээгээр хүлээнэ. | Бизнесээ өргөжүүлж зах зээлээ тэлэх амархан | Аялал жуулчлалын чиглэлээр их дээд сургууль төгссөн бакалавр бүхий ажилтантай байх, тусгай оффис, гадархой хаяг, цахим хаягтай байх. Оператор хийх түвшний боловсон хүчин шаардлагатай болно. Гадаад хэлний өндөр ур чадвар шаардагдана. |
| 2. | Ашгийн төлөө нөхөрлөл | А. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл -ББН Б. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл -ЗБН В.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл | | Үүсгэн байгуулах гэрээ | Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. | Гишүүн бүр төлөөлөх эрхтэй. Удирдлага бүх гишүүний саналаар сонгоно. | | |
| Ашгийн төлөө бүс | | | | | | | | |
| 3. | Төрийн бус байгууллага | А. Нийгэмд үйлчилдэг ТББ Б. Гишүүддээ үйлчилдэг ТББ | | Дүрэм | Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. | ТУЗ сонгоно. | | Зөвхөн дүрэмд заасан зорилгыг хэрэг-жүлэхийн төлөө ажиллана. |
| 4. | Хоршоо | Гишүүддээ үйлчилнэ. 9 өөс доошгүй хүн хамтарч байгуулна. | Үйл ажиллагаагаа нэгтгэж хоршоолж ажиллах | Дүрэм | Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. | Гишүүн бүр саналын эрхтэй оролцоно. | | |
| 5. | Сан | Нийгэмд үйлчилнэ. | | Дүрэм | Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. | | | |
| 6. | Байгалийн нөөцийн хамтын менежментийн Нөхөрлөл | Нөхөрлөл (эочин хүлээн авах, ангийн отогт үйлчлэх) Ойн нөхөрлөл Гэр буудал ажиллуулах нөхөрлөл г | Байгалийн нөөцийг хамгаалах, түүнээс ур шим хүртэх | Гэрээ , Менежментийн төлөвлөгөө, | Багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулна, ИТХУрлын шийдвэрийг үндэслэн Сум дүүргийн засаг дарга гэрчилгээ олгоно. | Нөхөрлөл гишүүдтэй байна. | Байгалийн баялгийг хариуцан хамгаална. Гишүүд тэгш эрхтэй ур шим хүртэнэ. | Хуулийн этгээдийн бүртгэлд хамрагддаггүй тул банканд данс нээхгүй, тамга байхгүй. Зөвхөн БОАЖЯ-ны эрх мэдлийн хүрээнд шийдэгдэнэ. Хуулийн цоорхой ихтэй. Гэрээг жил бүр сунгуулах шаардлагатай. |



ХАВСРАЛТ 6. Бизнес төлөвлөгөө боловсруулах тухай

Бизнесийн төлөвлөгөө боловсруулахдаа дараах хэсгүүдийг бүрдүүлнэ. Мөн зөвхөн өөрт тохирсон хэсгүүдийн сонгон авч төлөвлөгөөгөө зохиож болно.

Хураангуй

- Компани товч танилцуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаа яагаад амжилттай болох талаар дурдах
- Эрхэм зорилго, бүтээгдэхүүн үйлчилгээ, удирдлага, ажилтан, нөхөрлөлийн гишүүд, байршлынхаа талаар товч оруулах
- Хэрвээ санхүүгийн тусламж хүсч буй бол санхүүгийн мэдээлэл, хэрхэн амжилттай ажиллах төлөвлөгөөг оруулах

Компани эсвэл Нөхөрлөлийн танилцуулга

- НИТАЖ-ынхаа талаар тайлбарлах. Нарийвчилсан мэдээлэл оруулж, боломжит үйлчлүүлэгч нараа жагсаан бичээрэй.
- Өөрийн давуу талаа түлхүү оруулах. Бодит, боломжийн зүйлсээ дурдаж итгэл төрүүлэхүйц байх
- Бизнесийнхээ өрсөлдөх чадварыг сайтар тайлбарлаарай.
- Өөрсдийн туршлага, ур чадвар, онцгой ур чадваруудаа тайлбарлаарай. Тэрчлэн байршил, онцгой татах үйлчилгээ, бүтэлдэхүүнээ дурдаарай.

Зах зээлийн судалгаа

- Зах зээл, зорилтот зах зээлээ багтаах. Монгол орны аялал жуулчлалын хандлага, хөдөө болон танай орон нутаг дахь аялал, жуулчдын НИТАЖ-ыг сонирхох байдал зэргийг тусгах
- Өрсөлдөгч нарынхаа тухай мэдээллийг оруулж өгөх: Бусад ижил төстэй бизнесүүд, тэдний давуу тал. Амжилттай яваа өрсөлдөгч нар тань юуг яаж хийж байгаа талаар оруулаарай.
- Та хэрхэн тэднээс сайн эсвэл тэдэнтэй хэрхэн өрсөлдөх санаагаа тусгах

Байгууллага ба Менежмент

- Танай компани эсвэл нөхөрлөл хэрхэн байгуулагдсан, хэн удирддаг талаараа
- Байгууллагынхаа бүтцийн талаар, эсвэл цаашид ямар бүтэцтэй ажиллах талаараа (бүтцээ графикаар оруулах).
- Үүрэг хариуцлагуудаа, шийдвэр хэрхэн гаргадгаа дээрх графикт оруулж өгнө. Хэн юуг хариуцдаг болоод танай хүмүүсийн ямар мэдлэг чадвар амжилт дагуулах талаараа
- Багийнхаа гишүүдийн ажил, туршлагын намтрыг оруулах



- Танай багийн талаар мэдээлэл өгч чадах хүмүүс, албаныхан, урьд ажилладаг байсан удирдлагуудынхаа мэдээллийг оруулах

Бүтээгдэхүүн үйлчилгээ

- Бүтээгдэхүүн үйлчилгээгээ нарийвчлан тайлбарлаж, үйлчлүүлэгчид яагаад дуртай байх талаар

Зах зээл, борлуулалт

- Үйлчлүүлэгчдээ хэрхэн татахаа тайлбарлах. Борлуулалтаа хэрхэн хийх, яг яаж жуулчдадаа хүрэх, энэ талаар хэд хэдэн аргуудаа оруулах
- Зах зээлийнхээ стратегийг буюу жуулчдаа хэрхэн олох аргаа тусгаарай. Санхүүгээ төлөвлөхөд тань энэ хэрэг болно.

Санхүүгийн хүсэлт

- Хэрвээ санхүүжилт хүсч байгаа бол яагаад гэдгээ сайтар тайлбарлаарай.
- Хэдий хэрийн санхүүжилт, юунд, хэдий хугацаатай хэрэгтэй гэдгээ сайтар тайлбарлаарай.

Санхүүгээ төлөвлөх

- Санхүүжилт хүсч байгаа бол төлөвлөгөөгөө үзүүлээрэй. Үүгээр та уншигчаа танай бизнес амжилттай, тогтвортой ажиллахыг ятгах юм.
- Хэрвээ аль хэдийн эрхэлдэг бизнестэй бол орлогын мэдээлэл, баланс, бэлэн мөнгөний гүйлгээгээ харуулах хэрэгтэй.
- Зээл авахын тулд юу барьцаанд тавих боломжтойгоо жагсаагаарай.
- Дараагийн 5 жилийн санхүүгийн төлөвлөгөөгөө, орлого зарлагатай нь хамт дэлгэн тайлбарлаарай. Эхний жилийн төлөвлөгөөгөө нарийвчлан сараар гаргавал сайн. Санхүүгийн төлөвлөгөөгөө хүсч буй санхүүгийн хэмжээтэйгээ сайтар харгалзуулаарай.
- НИТАЖ-ын үйл ажиллагаа явуулаад эхэлсэн бол хүснэгт, графикаар санхүүгээ тайлбарлан харуулах хэрэгтэй.

**ХАВСРАЛТ 7.** Аймгуудын аялал жуулчлалын холбоодын холбогдох хаягууд

| № | Аймгийн аялал жуулчлалын холбооны нэр | | Хариуцсан захирал, гүйцэтгэх захирлын нэр | Холбоо барих дугаар |
|----|---------------------------------------|------------------------------------|---|---------------------|
| 1 | Архангай | Эртний Нүүдэлчдийн Өлгий | Д.Дашцэрэн | 99112499 |
| 2 | Баян-Өлгий | Баян-Өлгий аймгийн АЖХ | Х.Досжан | 99422006 |
| 3 | Баянхонгор | Баянхонгор аймгийн АЖХ | С.Шинэцэцэг | 89167728 |
| 4 | Булган | Булган аймгийн АЖХ | Г.Чимгээ | 99053139 |
| 5 | Говь-Алтай | Говь-Алтай аймгийн АЖХ | Б.Энхболд | 88882530 |
| 6 | Говьсүмбэр | Говь-Сүмбэр аймгийн АЖХ | Т.Болдбаатар | 94310703 |
| 7 | Дархан-Уул | Дархан-Уул аймгийн АЖНХ | Д.Азбилэг | 95013541 |
| 8 | Дорноговь | Дорноговь аймгийн АЖХ | Н.Баярманлай | 99093449 |
| 9 | Дорнод | Дорнод аймгийн АЖ-ын нэгдэл | Р.Зоригтбаатар | 99582626 |
| 10 | Дундговь | Дундговь аймгийн АЖХ | П.Мөнхбат | 99119148 |
| 11 | Завхан | Завхан аймгийн АЖХ | Б.Жавхлан | 94064466 |
| 12 | Орхон | Орхон аймгийн АЖХ | Б.Айлтгүй | 99079591 |
| 13 | Өвөрхангай | Дэлхийн өв – Орхон голын нүүдэлчид | Ч.Бат-Эрдэнэ | 99088605 |
| 14 | Өмнөговь | Гайхамшигт говь АЖХ | Н.Ариунсанаа | 95144470 |
| 15 | Сүхбаатар | | | |
| 16 | Сэлэнгэ | Сэлэнгэ аймгийн АЖХ | Н.Мөнх-Оргил | 91997763 |



| | | | | |
|---------------------------|---------|--|-------------|----------|
| 17 | Төв | Төв аймгийн АЖХ | Л.Оюунбилэг | 90228888 |
| 18 | Увс | Төгс цэнхэр хязгаар | Ж.Батсүх | 99136772 |
| 19 | Ховд | Цаст Алтайн Угсаатан | П.Амарсанаа | 95936707 |
| 20 | Хөвсгөл | Хөвсгөлийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо | Я.Отгонбаяр | 99080416 |
| 21 | Хэнтий | Гурван голын нүүдэлчид АЖХ | Ц.Ууганбаяр | 99060001 |
| Бусад холбоо, байгууллага | | | | |
| 1 | МАЖХ | Монголын аялал жуулчлалын холбоо | Д.Отгонбаяр | 99072779 |
| 2 | ЗБХ | Зочид буудлуудын холбоо | Н.Батцэнгэл | 99235150 |
| 3 | УБАЖХ | Улаанбаатар аялал жуулчлалын холбоо | Д.Гэрэлтөв | 99113799 |
| 4 | МХТХ | Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо | Э.Орхон | 86083131 |




ХАВСРАЛТ 8. Гүүгл газрын зураг (Google map)-т байршлаа оруулах Хэрвээ та өөрийн гар утас, ухаалаг төхөөрөмждөө Google map суулгаагүй байгаа бол дараах QR Code-г уншуулаарай.

Андройд үйлдлийн утастай бол дараах алхмуудаар өөрийн байршлаа оруулна.

1. Google maps апп-аа нээнэ.
2. НИТАЖ байршлаа олж "Contribute" хэсгийг дарна.
3. "Add place"-г сонгож НИТАЖ-ын мэдээллээ оруулна.



QR Code-г уншуулаарай.



4. Нэр, хаяг, холбоо барих дугаар гэх мэт өөрсдийн үйл ажиллагааг тодорхойлох боломжит мэдээллүүдээ оруулж "Submit" дээр дарж хадгална. Мэдээллээ оруулахдаа сайтар шалгаж, боломжтой бол англи хэл дээр эсвэл латинаар галиглан оруулаарай.

× Add a place

Add your business to Google for free
Is this your business?

Place details
Provide some information about this place. If this place is added to Maps, it will appear publicly.

Place name (required)*
cbt

Homestay >

Address (required)*
Buregkhangai - Dashinchilen Road, Mongolia

Edit map location

Cancel Submit



5. Мэдээлэл өөрчлөгдсөн даруйд холбоо барих мэдээлэл, байршил, утасны дугаараа шинэчлээрэй.

iOS үйлдлийн системтэй төхөөрөмж эсвэл iPhone утастай бол дараах алхмуудыг дагана.

1. Google maps апп-аа нээнэ.
2. Өөрийн байгаа газраа хайх хэсэгт оруулж олно.
3. Хайлтын үр дүнд дэлгэцийн доод хэсэгт мэдээлэл гарна.



QR Code-г уншуулаарай.

X Add a place

Add your business to Google for free
Is this your business?

Place details
Provide some information about this place. If this place is added to Maps, it will appear publicly.

Place name (required)*
НИТАЖ

Tourist attraction >

Address (required)*
J2X2+G7M, Durvuljin, Mongolia

©2022 Google Map data ©2022

Located within

Cancel
Submit

4. Мэдээлэлтэй хэсгийг дээш татан "Add a missing place"-г сонгож НИТАЖ-ЫН мэдээллээ оруулна.

▼ Durvuljin
 ...

Restaurants

Gas

Hotels

Groceries

Attractions

Parks

Coffee

More

Dörvöljin is a sum of Zavkhan Province in western Mongolia. In 2005, its population was 2,323. Wikipedia

● 27°C Sunny

Measure distance

8MVQJ2X2+G7

(47.6488265, 95.0006732)

Add a missing place



5. Нэр, хаяг, холбоо барих дугаар гэх мэт өөрсдийн үйл ажиллагааг тодорхойлох боломжит мэдээллүүдээ оруулж "Submit" хэсэг дээр дарж хадгална. Мэдээллээ оруулахдаа сайтар шалгаж, боломжтой бол англи хэл дээр эсвэл латинаар галиглан оруулаарай.

Мэдээлэл өөрчлөгдсөн даруйд холбоо барих мэдээлэл, байршил, утасны дугаараа шинэчлээрэй.

ХАВСРАЛТ 9. Баянсонгинот бүлгийн хамт олны дундын сангийн журам

1. Хамт Олны Дундын Сан (ХОДС) байгуулах, арвижуулах
 - 1.1. Эхний удаад бүлгийн гишүүн өрх бүр ХОДС-д 10,000 төгрөг нийлүүлж санг байгуулна.
 - 1.2. Гишүүн өрх бүр сард нэг удаа 1,000 төгрөгийг ХОДС-д төвлөрүүлж байна.
 - 1.3. Хамт олноороо хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас олсон орлогын 30 хувийг ХОДС-д хандивлана.
 - 1.4. Хамт олны дэмжлэгээр сургалтад хамрагдаж сурсан зүйлээ ашиглан бүтээгдэхүүн хийж борлуулсан гишүүд олсон орлогынхоо 3-5 хувийг ХОДС-д хандивлана.
 - 1.5. Гишүүд өөрсдийн сайн дураар ХОДС-д хандивлана.
2. Дундын санг зарцуулах
 - 2.1. ХОДС-аас зарцуулах хөрөнгийн хэмжээг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж батална.
 - 2.2. ХОДС-н хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулж болно.
 - А. Хамт олны бүх гишүүдэд ашиг нь хүртэх үйл ажиллагаа
 - Б. Бүлгийн аль нэг гишүүнд зайлшгүй тусламж шаардлагатай үед 20,000-50,000 хүртэлх тусламж өгөх
 - В. Тодорхой хөрөнгө зарж ашиг олж санг арвижуулах үйл ажиллагаа
 - 2.3. Сангаар гишүүдэд жижиг зээл олгож болно. Зээлийн хүүгийн хэмжээг бүх гишүүдийн хурлаар тогтооно.
 - 2.4. Сангийн хөрөнгийн 50 хүртэлх хувийг зээлээр олгохыг зөвшөөрнө.
 - 2.5. Гишүүд зээл авахдаа зохих барьцаа тавьж гэрээ байгуулна.
 - 2.6 ХОДС-г хамт олны зөвлөлийн аль нэг гишүүнд хариуцуулна.
3. ХОДС-д тавих хяналт
 - 3.1. Сан хариуцсан гишүүн сар бүр ХОДС-н хөрөнгө түүний зарцуулалтын талаар бүх гишүүдийн хурал дээр танилцуулна.
 - 3.2. ХОДС-н үлдэгдэл хөрөнгө болон зарцуулалтад бүлгийн гишүүн бүр хяналт тавих эрхтэй.
 - 3.3. ХОДС-н хөрөнгөнд 2 сар тутам хамт олноос томилсон комисс тооллого хийж дүнг бүх гишүүдэд танилцуулж хэлэлцэнэ.



ХАВСРАЛТ 10. Олон улсын байгууллагууд

| Байгууллагын нэр | Хаяг, холбоо барих дугаар | Сошиал хаяг | Имэйл хаяг |
|--|--|--|--|
| Монгол улс дахь Канад сан | Улаанбаатар хот 14200, Сүхбаатарын талбай Сэнтрал Тауэр, 607 тоот Утас: 11 332500 | canadafundmongolia.mn/ www.facebook.com/CanadaMongolia | canadafundmn@gmail.com |
| Австралын элчин сайдын яам, Австралын Сайн дурын тусламжийн хөтөлбөр | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А Шангри Ла Бизнес цамхаг 20 давхар Утас: 70133001 | mongolia.embassy.gov.au/ulnbmongolian www.facebook.com/AustraliaInMongolia | mongolia.embassy@dfat.gov.au |
| АНУ элчин сайдын яам | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Денверийн гудамж #3 11-р хороолол Утас: 70076001 | https://mn.usembassy.gov/mn/ www.facebook.com/USEmbMongolia | pao@usembassy.mn |
| Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яам | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу – 2, НУБ гудамж 16 Утас: 70133900 | https://ulan-bator.diplo.de/ www.facebook.com/GermanEmbassyUlaanbaatar | |
| Бүгд Найрамдах Чех Улсын элчин сайдын яам | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Элчингийн гудамж, Чех элчингийн байр | https://www.mzv.cz/ulaanbaatar/mn | |
| Каритас Чех байгууллага /ТББ/ | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Дельта Центр байр 503 тоот Утас: 70135899 | https://mongolia.charita.cz/ https://www.facebook.com/CaritasCzechRepublicInMongolia | ccr.mongolia.office@caritas.cz |
| Бүгд Найрамдах Турк улсын элчин сайдын яам | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Элчингийн гудамж, Турк элчингийн байр Утас: 11 329545 | ulanbator.be.mfa.gov.tr https://www.facebook.com/ulanbatorbe | embassy.ulaanbaatar@mfa.gov.tr |





| | | | |
|--|---|---|--|
| Их Британий Элчин сайдны яам | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Шангрилла оффисын байр, 1-3А Утас: 11 45 8133 | gov.uk/world/mongolia www.facebook.com/ukinmongolia | Enquiries. Mongolia@fcdo. gov.uk |
| КОЙКА – Монгол Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг | Улаанбаатар хот хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж-4, MCS Плаза, 2 давхар Утас: 11 311774 | http://www.koica.go.kr/sites/mng_ en/index.do www.facebook.com/KOICA.Mongolia | mongolia@koica. go.kr |
| ЖАЙКА – Монгол Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага | Улаанбаатар хот хот, Сүхбаатар дүүрэг, Бодь тауэрын 7 давхар Утас: 11 325939 | https://www.jica.go.jp/mongolia/ english/index.html www.facebook.com/jicamongo/ | |
| Даян Дэлхийн Байгаль Орчны Сан (ДДБОС)-гийн Жижиг Төслийн Хөтөлбөр (ЖТХ) /UNDP GEF SGP/ | Улаанбаатар хот хот, Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн үндэсний гудамж – 14, НҮБ байр, Хөгжлийн хөтөлбөрийн 604 тоот Утас: 11 327585 -1141 | http://sgp.undp.org | ganbaatar. band1@undp.org |



ХАВСРАЛТ 11. Онлайн орчинд байгаа мэдээлэл

| # | Агуулга | QR code |
|---|--|---------|
| 1 | НАЖГ-аас гаргагсан Хөтөч тайлбарлагчийн анхан шатны мэдлэг олгох цахим сургалт | |
| 2 | Аяллын хөтчийн анхан шатны мэдлэг олгох хичээл - НАЖГ, Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо | |
| 3 | Үйлчилгээ, зочлох үйлчилгээний тухай сургалт - Аялал Жуулчлалын Ур Чадварын Төв, НАЖГ | |
| 4 | Жуулчны баазын үйлчилгээ - Аялал Жуулчлалын Ур Чадварын Төв, НАЖГ | |
| 5 | Малчдад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн гарын авлага | |



| | | |
|---|--|--|
| 6 | XXI ЗУУНЫ МАЛЧИН /9 модульт гарын авлага/ |  |
| 7 | Ур чадвар хөгжүүлэх бие даан суралцах гарын авлага |  |

Хавсралт 12. Бортын Мандал нөхөрлөлийн НИТАЖ-ын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт

| Загвар жишээ | | | | |
|---|--------------------|---------------------------|-------------------|---|
| Ховд аймгийн Мөнххайрхан сумын Бортын Мандал нөхөрлөлийн аялал жуулчлалын чиглэлээр явуулах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт | | | | |
| Нөхөрлөлийн ахлагч нөхөрлөлийн 12 гишүүний хамт 6 сарын 1-ээс 8 сарын 25 хүртэл ажиллана. Нийт 12 ортой 3 гэр болон морь тэмээгээр үйлчилнэ. Дараах хуваарийн дагуу ажлаа хуваарилан авч ажиллана. Үр дүнг жил бүрийн 5, 11 сард хэлэлцэнэ. Сар бүр орлого зарлагын тайлан гаргаж нөхөрлөлийн гишүүдэд танилцуулна. | | | | |
| № | Нөхөрлөлийн гишүүд | Албан тушаал | Хавсарч хийх ажил | Хийх ажил |
| 1. | Б.Соёлмаа | Менежер | Тогооч | Ирэх хүмүүсийн Захиалга авна, бүртгэл хөтөлж мэдээлэл хүргэнэ. |
| 2. | Б.Баярхүү | Морь, тэмээн аяллын хөтөч | | Морь, тэмээн аялал зохион байгуулах, Морь, тэмээ бүртгэх, олж ирэх, эмээл болон бусад хэрэгслийг хариуцах |
| 3. | Г.Анх-Эрдэнэ | Морь, тэмээн аяллын хөтөч | | |
| 4. | У.Батаа | Морь, тэмээн аяллын хөтөч | | |
| 5. | Б.Шагдарсүрэн | Морь, тэмээн аяллын хөтөч | | |



| | | | | |
|-----|---------------|-----------------|-------------------|--|
| 6. | О.Чойжилжав | Санхүү | Жолооч | Нөхөрлөлийн данс болон орлого, зарлага бүртгэх, бэлэн мөнгөний тайлан тооцоо гаргана |
| 7. | Б.Ганболд | Гэрийн үйлчлэгч | Жолооч | Гэр барих, хураах, цэвэрлэх |
| 8. | Я.Цэрэндорж | Гэрийн үйлчлэгч | | |
| 9. | О.Чойжилсүрэн | Гэрийн үйлчлэгч | | |
| 10. | О.Гантулга | Ээлжийн жижүүр | Туслах ажил хийнэ | Цэвэрлэгээ, хоол, морин аялалд тусална. |
| 11. | О.Ганчимэг | Ээлжийн жижүүр | | |
| 12. | Г.Гантулга | Ээлжийн жижүүр | | |
| 13. | Цогт-Эрдэнэ | Ээлжийн жижүүр | | |

ХАВСРАЛТ 13. Бортын Мандал нөхөрлөлийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| Загвар жишээ | | | |
|---|--|---|--|
| Мөнххайрхан сумын Бортын Мандал нөхөрлөлийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | | | |
| № | Хаанаас эрсдэл бий болох эсэх ? | Эрсдэлийн төрөл | Эрсдэлийг даван туулах арга зам |
| 1. | Нийлүүлэгчийн зүгээс учрах эрсдэл | Нийлүүлэгч үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, хангалттай сайн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхгүй байх. | Гэрээгээр зохицуулах, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнээс учрах хохирлыг нөхөн төлүүлэх, Өөр нийлүүлэгчтэй гэрээ байгуулах |
| 2. | Харилцагч байгууллагын зүгээс учрах эрсдэл | Харилцагч байгууллагын үйлчилгээний чанар, стандарт муу байх, хамтын ажиллагааны үл ойлголцол | Хамтын ажиллагааны гэрээ байгуулах , гэрээг дүгнэдэг байх, хамтарсан уулзалт ярилцлага хийх, хохирлыг баримтжуулах. |
| | | Харилцагч байгууллага үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, гэрээ зөрчих, чанаргүй үйлчилгээ үзүүлэх | |



| | | | |
|----|---|--|--|
| 3. | Мэдээллийн технологийн эрсдэл | Сүлжээний доголдол, гэмтэл, аюулгүй байдал алдагдсанаар цахим хуудсаар дамжуулан аяллын захиалга тасалдах, сүлжээгүй болох | Харилцагчтай мэдээлэл солилцдог тогтмол өдөр, цаг гаргах. Зочдод нөхцөл байдлыг урьдчилан анхааруулж холбоо барих өөр арга зам зааж өгсөн байх. |
| 4. | Дэд бүтцийн эрсдэл | Замын нөхцөл байдал муу байх, эвдрэх, цасанд боогдох, тэмдэг тэмдэглэгээгүй байх, төөрөх, осолд орох | Замын нөхцөл байдлыг улирал улирлаар нь харилцагч байгууллагад мэдээлэх, байршлаа өөрчлөх, солих бүртээ урьдчилан мэдээлэх. Тээврийн зардал өссөн тухай урьдчилан мэдээлэх. Тэмдэглэгээ тавих. |
| 5. | Улс нийтийн, орон нутгийн нөхцөл байдал, баяр ёслолоос шалтгаалсан эрсдэл | Улс нийтийн баяр, нийтийн ус, цахилгааны хязгаарлалтын хуваарь, хилийн асуудал, хүн, малын өвчин гэх мэт. | Гэрээнд эдгээр эрсдэлийн тухай заалт оруулж, авах арга хэмжээг тусгах. |
| 6. | Санхүүгийн эрсдэл | Төлбөр тооцоо гуйвуулга, бэлэн мөнгө гаргалт саатах, ханшийн зөрүүний алдагдал хүлээх, | Нөхөрлөлийн дундын сангаас зохицуулах |
| | | Бараа бүтээгдэхүүний үнэ ханш нэмэгдэх | Нөхөрлөлийн дундын сангаас ашиглах, зарцуулах, зээлэх заалт оруулах |
| | | Онгоцны нислэгийн өөрчлөлтөөс шалтгаалан зочны аялал хойшлогдох, цуцлагдах | Урьдчилгаа авах, төлбөрийн тодорхой хувийг буцаахгүй байх талаар гэрээнд тусгах |



| | | | |
|----|--|--|---|
| 7. | Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл | Агаарын температурын хэт өөрчлөлт, хүчтэй салхи шуурга, ширүүн бороо, газар хөдлөлт, өвчин эмгэг гэх мэтээс шалтгаалан аялал цуцлагдах | Урьдчилгаа авах, төлбөрийн тодорхой хувийг буцаахгүй байх талаар гэрээнд тусгах |
| | | Үйлчлүүлэгч нарын дунд танай үйлчилгээний тухай худал мэдээлэл цацагдах | Нийгмийн сүлжээ ашиглаж үнэн зөвийг мэдээлэх |
| | | Жуулчдын хүлээлттэй нийцэхгүй байх Аюулгүй байдал алдагдах | Мэргэжлийн сургаалтанд хамрагдах, стандартыг мөрдөх |
| | | Хүний нөөц дутмаг | Хүнээ сургах, хөгжүүлэх |
| | | Өдөр тутам мэдээлэл солилцоогүйн улмаас үл ойлголцол үүсэх | Байгууллагын дүрмийн тухай хамт олондоо сануулж, мөрдүүлэх |
| | | Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал сул, шатахууны олдоц муу | Машиныхаа бүрэн бүтэн байдлыг тайлагнахыг жолоочдод сануулах |



ХАВСРАЛТ 14.1 Захиалгын хуудасны загвар жишээ

| | | | | | | | | |
|-----------------------------|---------------------------|-------------------|----|----|----|----|----|--|
| Захиалгын хуудас | Хүний тоо | Жуулчин | 2 | 3 | 4 | 5 | | |
| | | Орчуулагч | 3 | 4 | 5 | | | |
| | | Жолооч | 4 | 5 | | | | |
| | | Бүгд | 5 | | | | | |
| | Хоног | Орх өдөр, цаг | 6 | 7 | 8 | | | |
| | | Гарах өдөр, цаг | 7 | 8 | | | | |
| | | Бүгд өдөр | 8 | | | | | |
| | Байр | Бүгд ор хоног | 9 | 10 | 11 | 12 | | |
| | | 2 ортой гэр | 10 | | | | | |
| | | 3 ортой гэр | 11 | | | | | |
| | | Ажлынцагч байрлах | 12 | | | | | |
| | Хоол | Бүгд гарийн тоо | 13 | 14 | 15 | 16 | 17 | |
| | | Өглөө | 14 | | | | | |
| | | Өдөр | 15 | | | | | |
| | | Орой | 16 | | | | | |
| | | Тусгай захиалга | 17 | | | | | |
| | Унаа | УАЗ | 18 | 19 | 20 | 21 | | |
| | | Фургон | 19 | | | | | |
| | | Land | 20 | | | | | |
| | | Бүгд | 21 | | | | | |
| Бусад | Иргэншил | 22 | 23 | 24 | | | | |
| | Орчуулагчийн нэр, утас | 23 | | | | | | |
| | Тусгай захиалга тэмдэглэл | 24 | | | | | | |
| Компанийн нэр (группын нэр) | | 1 | | | | | | |



ХАВСРАЛТ 14.2 Ваучерын загвар жишээ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООЦООНЫ ХУУДАС №.....
(ваучер - voucher)

Нөхөрлөлийн нэр:

Аяллын группийн нэр / код.....

Буух өдөр:.....оныр сарынөдөр

Гарах өдөр:оныр сарынөдөр

| № | огноо | Гэрт байрлах | | | | | өглөөний цай | өдрийн хоол | оройн хоол | морь/тэмээ, сарлаг, цаа унах |
|-----------------|-------|--------------|-------|-------|-------|-------|-----------------|----------------|---------------|---------------------------------|
| | | 1 ээр | 2 оор | 3 аар | 4 өөр | 5 аар | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| НИЙТ ДҮН | | | | | | | | | | |

Нэмэлт үйлчилгээ.....

| № | Үнэлэх зүйл - Хөтөч тайлбарлагч бөглөнө | Маш сайн | Дунд зэрэг | Анхаарах шаардлагатай | Тайлбар |
|---|--|----------|------------|--------------------------|---------|
| 1 | гэрийн ариун цэвэр, цэвэрлэгээ | | | | |
| 2 | 00 цэвэрлэгээ | | | | |
| 3 | шүршүүр цэвэрлэгээ | | | | |
| 4 | хоолны чанар | | | | |
| 5 | гал тогооны ариун цэвэр | | | | |
| 6 | ажилчдын харилцаа | | | | |
| 7 | нэмэлт үйлчилгээ | | | | |

Зөвшөөрсөн :

Компаний санхүүгийн менежер:нэр.....гарын үсэг / **тамга тэмдэг**

Аяллын ахлагч, хөтөч тайлбарлагчнэр.....гарын үсэг

Нөхөрлөлийн менежер, ахлагчнэр.....гарын үсэг

Энэхүү үйлчилгээний хуудас нь төлбөр тооцоо хийх үндэслэл бүхий албан ёсны баримт бичиг юм.

**ХАВСРАЛТ 15.1.** НИТАЖ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн загвар жишээ /хүснэгтээр/

Шаргалжуут-сарлагийн буян нөхөрлөлийн үйл аялал жуулчлалын ажиллагааны хөтөлбөр

Хугацаа (өдрөөр): 2 хоног, 3 өдрийн

| Цаг | Үйл ажиллагаа | Газар | Хариуцах эзэн |
|------------------|--|--|--------------------|
| 1 дэхь өдөр | | | |
| 17:00 – 18:00 | Зочдыг угтаж байрлуулах/Халх үндэсний хувцастай, алд цэнхэр хадаг, аяга дүүрэн сүүн хамт/ | Малчин айлд /Монголчуудын өдөр тутмын уламжлалт монгол гэр/ | Нөхөрлөлийн гишүүд |
| 19:00 – 20:00 | Оройн хоол /Монголын уламжлалт хоол бууц, гурилтай шөлөөр дайлна/ | Малчин айлд | Алтанцэцэг |
| 20:00 – 22:00 | Чөлөөт цаг /Хонь, үхэр хотлуулах, шатар, даам тоглох гэх мэт/ | Малчин айлд | Алтанцэцэг |
| 22:00 | Амрах | Малчин айлд | Должинсүрэн |
| 2 дахь өдөр | | | |
| 08:00 – 08:30 | Өглөөний цай /Гэрийн боорцог, мэхээртэй, мэхээргүй тос, өрөм, сүүтэй цай/ | Малчин айлд | Байгальмаа |
| 08:30 – 09:00 | Үнээ саах /Хангайн уулархаг нутагт дасан зохицсон сарлаг үхрийг сааж сонирхож болно/ | Малчин айлд | Алтанцэцэг |
| 09:00 – 09:30 | Малаа бэлчээх /Өглөө эрт үхэр малаа саачхаад малаа хол, ойрын бэлчээрт нь бэлчээх, ингэхдээ төл малыг авч үлддэг/ | Малчин айлд | Сэрээнжав |



| | | | |
|------------------|---|---|--------------------------|
| 09:30 – 11:30 | <ul style="list-style-type: none"> • Тогоо нэрэх /Монголчуудын уламжлалт идээний дээж монгол архийг нэрж хэрэглэх заншил/ • Дуутай хуруу гаргах /Тухайн бүс нутагт хадгалагдан үлдсэн соёлын биет бус өв/ | Малчин айлд | Должинсүрэн Батбаатар |
| 11:30 – 12:30 | <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Сарлаг унах <input type="checkbox"/> Сарлаг самнах <input type="checkbox"/> Сарлаг булгиулах <input type="checkbox"/> Сарлаг унаж зураг даруулах | Малчин айлд | Энхбаатар |
| 12:30 – 14:00 | Өдрийн хоол /Борцтой мантуу, таван цулын шөл, цай, айраг, цагаа/ | Малчин айлд | Алтанцэцэг |
| 14:00 – 14:40 | Шаргалжуутын тосгоны байгаль орчны мэдээллийн төвтэй танилцана. /Тус газрын амьтан, ургамал, чулуулаг, онцлог төрх байдалтай танилцах/ | Шаргалжуут тосгон | Хүрэлбаатар |
| 14:40 – 16:40 | Шаргалжуутын халуун рашаантай танилцана. /Хамгийн сайн рашаан болох Лхамын рашаан уух, Хоолойн утлагаар утаж, Ууц нурууны луужин тавих, Бөөрний халуун жин тавих, эр, эм бэлгийн рашаан хүртэх гэх мэт олон рашаантай танилцаж, өндөг чанаж идэн 5-10 насаар залуужна/ | Дэлхийд хосгүй Шаргалжуутын халуун рашаан | Алтанцэцэг |
| 16:40 – 18:00 | <ul style="list-style-type: none"> • Сураар бэлэг дурсгал, сарлагийн эдлэл хэрэгсэл, түлхүүрийн оосор хийх /Үхрийн ширийг боловсруулж бэлдсэн сурыг ашиглан бэлэг дурсгал, гар урлалын зүйл хийнэ/ | Малчин айлд | Сэрээнжав |



| | | | |
|------------------|---|-------------|--------------------|
| 18:00 – 19:30 | <ul style="list-style-type: none">Оройн хоол бэлтгэх /Монголчуудын уламжлалт хоол Хорхог хамтран хийх, чулуу халаах, төмс ногоо арилгах гэх мэт / | Малчин айлд | Байгальмаа |
| 19:30 – 21:30 | <ul style="list-style-type: none">Оройн хоол /Үндэсний хоол хорхгоор дайлах, цутан шөл, дуутай хуруу гаргах, нутгийн соёл уламжлалт ардын урлагийн үзүүлбэр үзэх/ | Малчин айлд | Алтанцэцэг |
| 21:30 – 22:00 | <ul style="list-style-type: none">Чөлөөт цаг | Малчин айлд | Энхбаатар |
| 22:00 | <ul style="list-style-type: none">Амрах | Малчин айлд | - |
| 3 дахь өдөр | | | |
| 08:00 – 08:30 | Өглөөний цай /Бантан, өрөм, Боорцог, цай/ | Малчин айлд | Байгальмаа |
| 09:00 | Зочдыг үдэх /Зочдыг нөхөрлөлийн бүх гишүүд үдэж мордуулна. Зочдын араас сайн явахыг бэлгэдэж сүүн цацал өргөнө./ | Малчин айлд | Нөхөрлөлийн гишүүд |



ХАВСРАЛТ 15.2. Нөхөрлөлийн хөтөлбөр бэлдэх явц (зургаар)

Хяналт:
Алтанцэцэг.

09:00
13:00

Аялалын
ХӨТӨЛБӨР

В-?

| Цаг | Үйл ажиллагаа | Газар | Хөтөч |
|----------------|--------------------------------------|--------------------------------|----------------------|
| 08:00 08:30 | Өглөөний цай | Амралтын газар | Д.Самд |
| 08:30 09:00 | Амралтын газраас Малчин айлд очих | Малчин айл Сэрээний жав | Алтанцэцэг. |
| 09:15 09:30 | Үнээ сорох | Малчин айл | Байгалийн |
| 09:30 09:40 | Аргал түүх ☺ | Малчин айл | Цэцэгээ |
| 09:40 10:25 | Гэр барих ☺ | Малчин айл | Сэрээний жав |
| 10:35 11:35 | Сарлаг унах Сарлаг самнах ☺ | Малчин айл | Энхболотор |
| 11:35 11:45 | Амралтын газар ирнэ. | Малчин айл Шаргалтүүх аймаг | Алтанцэцэг |
| 11:45 12:15 | Өндөг чанах түүх ярих | Рашаан дээр | Цэвэлсэнд |
| Цаг гарвал | Рашаан танилцуулга | Рашаан дээр | Цэвэлсэнд Дүгнэлт |



ХАВСРАЛТ 16. Аюулгүй байдлаа хангаж, түүнд бэлтгэлтэй байх талаарх ерөнхий ойлголтууд

Зорилго: Анхан шатны тусламж үзүүлэхтэй холбоотой суурь мэдлэг, чадвар эзэмшихэд нэмэр болох үүднээс зөвлөгөө, мэдээлэл, мэдээллийн эх сурвалжуудыг өгөх. Тэрчлэн түргэн тусламжийн үеэр авах арга хэмжээ, орон нутаг дахь холбогдох газрын хаяг, мэдээлэл гэх мэт Анхны тусламжийг яаралтай, зөв үзүүлснээр:

- Амь нас аварна
- Эдгэрэлтийг түргэсгэж, хүндрэлээс сэргийлнэ
- Хөдөлмөрийн чадвар алдалтыг багасгаснаараа хүмүүсийн амьдралд эдийн засгийн дэмжлэг болно.
- Эмчилгээ сувилгаанд зарцуулах зардлыг багасгана

Хамгийн түрүүнд юуг анхаарах вэ?

1. Сандарч болохгүй. Та нөхцөл байдлыг зөв дүгнэн, хүмүүст сэтгэл санааны дэмжлэг үзүүлж , тусалж чадна гэдэгтээ өөртөө итгэлтэй бай. Сэтгэл санааны дэмжлэг чухал ач холбогдолтой.
 - Амьсгал, зүрх судасны ажиллагааг анхаар.
 - Амьсгалын замыг шалгаж , цэвэрлэн чөлөөтэй болго. (гарыг ариутгасан байх, эсвэл 1 удаагийн бээлий өмсөх)
2. Гэмтэж өвчилсөн хүн өөрөө цусны эргэлт мэдэгдэхгүй, зүрхний цохилт мэдрэгдэхгүй, амьсгалж чадахгүй байвал хиймэл амьсгал *CPR* хийж аврах ажиллагааг яаралтай эхэлнэ.
3. Цус алдаж байгаа эсэхийг анхаарна.
4. Яс хугарсан эсэх, шокийн шинж тэмдэг байгаа эсэхийг анхаарна.
5. Амьсгал, цусны эргэлтэд саад болж магадгүй учир, энгэр захны товчийг тайлж , хувцсыг чөлөөтэй болгоно.
6. Ухаангүй хүнд амаар нь ямар нэгэн юм уулгахгүй байх.
7. Гэмтсэн хүнийг хамаагүй хөдөлгөж болохгүй. Толгойгоос авхуулаад бүтэн гараар тэмтрэн хугарал байгаа эсэхийг шалгаж үзнэ. Нуруу нугасыг онцгой анхаарах. Ясны хугарал байвал чиг тавьж боогоод тээвэрлэхэд бэлдэх.
8. Тээвэрлэх боломжтой бол шуурхай эмнэлэг явах
9. Биед гадны биет зоогдсон бол яаран сугалж авахгүй байх.

Морь болон тэмээн аяллын үеэр нийтлэг тохиолдох гэмтлүүд:

Амь наснаас хол хөнгөн гэмтлүүд

Эгмийн чагтан холбоос мултрах, хугарах

Ясны гэмтлүүд / хугарах, цуурах, хавдах, тулах, зөөлөн эд гэмтэх, мултрах



/Шалбарах , шарх үүсэх Шарханд анхны тусламж үзүүлэх Арьс салстын бүтэн байдал алдагдахыг шарх гэдэг. Шарх нь үүсгэгдсэн шалтгаанаасаа хамаарч урагдсан, огтлогдсон, хатгагдсан, түлэгдсэн, галт зэвсгийн гэх мэт олон ангилалтай. Энэ бүгд нь шархны эдгэрэлт, хүндрэл үүсэхэд нөлөөлдөг. Ямар ч шарханд анхны тусламж үзүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- Цус алдаж байвал дээрх аргуудаар цус тогтооно.
- Шархны гадаргыг ариутгалын уусмалаар ирмэгийг тойруулах юм уу ирмэгээс гадагш нь чиглүүлэн арчиж цэвэрлэнэ. Шархыг арчих угаахыг хориглоно.
- Цэвэл марль, даавуу тавина. Бинт, гурвалжин алчуур болон гарын доорх материалаар бооно. Боолтыг тавихдаа чанга, сулыг нь тааруулан, боолт хөдөлж унахгүй байхаар бооно.

Шархыг арчлах аргууд

Жижигхэн эсгэлт, урагдтал ч гэсэн тусламж үзүүлэхгүй бол бохирдож халдвар аван хүндэрч болно. Иймээс шархыг арчлах дараах зөвлөмж аргачлалыг мөрдвөл халдвараас сэргийлж, хүндрэлээс хамгаалж болно.

1. Гараа угааж цэвэрлэх, ариутгах, нэг удаагийн бээлий өмсөх.
2. Анхны тусламж зөв үзүүлэхийн тулд цэвэр, халдвар авахгүй газар бэлтгэнэ. Тусламж үзүүлэх үед ийм боломжгүй бол шарханд хүргэхгүй, бохир зүйлээр бүтээж боохгүй байх хэрэгтэй.
- 3.
4. Шарх болон анхны тусламжийн бүх материалыг цэвэр байлгах бөгөөд ариутгасан материалын уутыг онгойлгох, боолтын материалыг задлахдаа зөвхөн ирмэгээс нь барьж, шарханд хүрдэг хэсэгт хүрэхгүй байхыг эрхэмлэх.

Шархны гадаргуу:

1. Шархыг цэвэрлэхдээ ирмэгийг нь тойруулан савантай болон цэвэр ус, ариутгалын уусмалаар зөөлөн болгоомжтой арчина. Шархыг угаах буюу шархан дээр нь арчиж болохгүй.
2. Шарханд хандахдаа бохирдохоос хамгаал.
3. Шарханд тавих ариутгасан жийргэвч, боолт зэргийг задлахдаа түүний бариул утас эсвэл ирмэгээс нь барь.
- Огтлогдсон, зүсэгдсэн, том шарханд наалдамхай боолт (шархны лент) хэрэглэнэ. Нэг удаагийн боолт нь хэрэглэхэд тохиромжтой зэрэгцээ шархыг бохирдохоос хамгаалахдаа сайн байдаг.
- Ариутгасан жийргэвчийг эсгэлт, халцралд болон бусад жижиг шарханд хэрэглэнэ.



- Шархны эдгэрэлтийг саатуулах нөлөө үзүүлж болохгүй.
- Хуйлсан бинтийг ариутгасан жийргэвчтэй хамт шарх бооход хэрэглэнэ.
- Туузан боолт- Анхны тусламжийн туузан боолт нь шарханд халдвар орж нян үржихээс хамгаална.

Боолт

Яаралтай хийгдэх боолтыг гарын доорх цэвэр материалаар (алчуур, ороолт, бүс, оймс, даавуу зэрэг) хийж болно. Боолтыг тогтвортой байхаар хийх боловч цусны эргэлтийг саатуулахгүй байхаар тохируулж хийнэ.


а. Гар, хөлд чиг болон боолт тавьсан үед гар хөлийн хурууны үзүүрийг ил орхино.

б. Гар, хөлийн хурууны үзүүр чинэрэх, хөхрөх, өнгө нь өөрчлөгдөх, хавдаж шинж илэрвэл боолтыг суллах буюу түр авна.

в. Нэрвэгдэгчийн хүзүүнд цусны эргэлт саатуулах боолт хэзээ ч тавьж болохгүй.

Боолт хийх аргууд гар сойх


Гарт шарх үүсэх, бугалга шуу, сарвууны яс хугарсан, мөр, тохой мултарсан үед үенд буцааж оруулсны дараа гарын хөдөлгөөнийг түр хязгаарлах, гарыг унжуулахгүй байлгаж хавдахаас сэргийлэх зорилгоор гарыг зурагт үзүүлснээр сойж бэхэлнэ. Сойлтыг нарийн даавуу, бүс, зангиа зэргээр нь хийж болохоос гадна, гурвалжин алчуураар хийх нь илүү тохиромжтой.






Гурвалжин алчуураар дух гавлыг боох

Ердийн алчуур ашиглан толгойн оройн хэсгийг боож болно. Боохдоо шархыг цэвэрлэн ариутгасан жийргэвч тавиад зурагт үзүүлснээр болно.



ДУХ, ЧИХ, ХАМАР, ЭРҮҮГ БООХ


Эдгээр хэсгүүдийн шархны үед цуулбартай боолт илүү тохиромжтой. Бинт, тууз, даавуугаа тухайн хэсгийг боож хүрэх урттай таслан хоёр үзүүрийг нь цуулна. Шархаа журмын дагуу цэвэрлэн цэвэр жийргэвч тавиад зурагт үзүүлснээр бооно. Ийм боолт нь хялбар, тогтвортой, материал хэмнэлтэй байдаг.






Өвдөг, тохойг боох

Өвдөг, тохой, шагайн үений боолт тогтвор муутай байдаг. Иймээс наймын тоо хэлбэрийн боолт хийвэл тогтвортой, үений хөдөлгөөнийг саатуулахгүй. Боолтыг эхлэхдээ шархны ойролцоо мөчний нарийн хэсэгт 2-3 удаа бэхэлгээ ороолт хийж эхлэн гүйцэтгэнэ.



Шуу, шилбэ, гарын хуруунд ороомог хэлбэрийн боолт тохиромжтой.





Ясны хугаралд үзүүлэх тусламж

Юманд цохигдох, хөшигдөх, дарагдах зэргээс яс хугардаг. Хугаралтыг ил (шарх үүссэн, далд шарх үүсээгүй) гэж ангилдаг. Гэмтсэн хүнийг болгоомжгүй хөдөлгөснөөс далд хугарал ил болох, зөрөөгүй нь зөрөх, өвдөлтийн шок үүсэх зэрэг хүндрэл гарч болно.

Шинж тэмдэг: Яс хугарах нь өөрт нь мэдрэгдэх юм уу сонсогдох, тэр хэсэгт хүрэхэд өвдөх, хавдах, хөхрөх зэрэг шинж ясны хугаралт байж болзошгүйг илтгэнэ. Мөн мөчний байрлал өөрчлөгдөх хөдөлгөхөд маш их өвдөх, хөдөлгөөн хязгаарлагдах, уй ажиллагаа нь алдагдах, хугарсан хэсэг шажигнаж мэдрэгдэх гэмтсэн хэсгийн өнгө өөрчлөгдөх шинж илэрнэ.

ТУСЛАМЖ: Яс хугарсан үед цусыг тогтоож, шархыг цэвэрлэж бооно. Дараа нь чиг тавьж хөдөлгөөнгүй болгоно. Чиг тавихад банз, бургас таяг, нарны хаалт гэх мэт нугарч тахийхгүй хатуу материалыг ашиглаж болно. Ямар ч материал олдохгүй үед эрүүл мөч, их биетэй нь баглан бэхэлж болно. Чиг тавихдаа ойролцоох 2-3 үеийг заавал хамруулна.

- Нэрвэгдэгчийг тайван дулаан байлгаж, шаардлагатай бол шокийн эсрэг арга хэмжээ авах ба чиг тавих хүртэл хөдөлгөж болохгүй, гал, хордлого, живэх зэрэг бусад гэмтэл байвал түүнээс аврах ажиллагаа явуулах

- Хэрэв хугаралтын сэжигтэй боловч арьс нь цоороогүй бол (битүү хугарал) хамаагүй хөдөлгөж болохгүй, хугарсан хэсгийн дээд доод үеийг хамруулан чиг тавих.

- Хэрэв хугарсан хэсэг арьсыг цоолсон бол (ил, нийлмэл хугарал) цус алдаж байгаа эсэхийг шалгах, мөчийг сунгаж татаж болохгүй ердийн байрлалд байлгах эсвэл бага зэрэг нугалах буюу ясны хэлтэрхийг байранд нь эвтэйхэн оруулна :

Харин шарханд хамаагүй хүрч, угаахаас болгоомжилж цэвэр даавуу юм уу ариутгасан боолт тавина. (зангиа, бөх бинт, тайлсан хувцас зэргээр нь)

- Хэрэв нэрвэгдэгч хөдлөх шаардлагатай бол чиг тавьж, гарч болзошгүй гэмтлээс сэргийлнэ. Чигт самбар, хатуу хуйлсан цаас, шүүрний мод, таяг зэрэг нугарахгүй хатуу зүйлийг ашиглаж болно. Чигийг хөвөн хувцас, орны даавуу зэргээр зөөллөнө. Хэрэв нэрвэгдэгч зовуурьтай байвал (мэдээ алдах, чинэж бадайрлаа гэсэн зовуурьтай байвал) чигийг суллана.

- Эмнэлгийн тусламжийг яаралтай авна .



Наранд түлэгдэх

Шинж тэмдэг: Арьсны өнгө өөрчлөгдөж улайх, бага зэрэг хавдах, цэврүүтэж, хорсож өвдөх, толгой өвдөх, толгой эргэх, бөөлжис цутгах, ухаан балартан муужрах

Тусламж:

- Түлэгдэлтийн I, II зэргийн тусламжийг үзүүлэх
- Шаардлагатай бол шокийн эсрэг тусламж үзүүлэх
- Нэрвэгдэгчийг хурдан сэрүүцүүлж, түлэгдсэн хэсэгт чийгтэй даавуу тавих, хэт хүйтэн биш усанд дүрэх
- Шингэн зүйл сайн уулгах
- Хүнд үед мэргэжлийн эмнэлгийн тусламж яаралтай авах

Амьтанд хазуулах

Аль ч орон нутагт элбэг тохиолддог хаздаг, хатгадаг, амьтад гэвэл нохой, могой, зөгий, шумуул, хилэнцэт хорхой зэрэг амьтад байдаг. Амьтанд хазуулахад хавдаж өвдөх төдийгүй хордож улмаар шоконд орж, гар хөл үхжиж болно. Амьтанд хазуулж хатгуулсан үед халдвар орох, галзуу өвчин тусах аюул ч тохиолдож болзошгүй. Морь, тэмээ хазаж хайрах тохиолдол элбэг тохиолддог.

Нохойд хазуулах : Хазсан нохой галзуу эсвэл сэжигтэй эсэхийг сайн нягтал Өөр хүнийг дахин хазахаас сэргийл.

ТУСЛАМЖ : Нохойд хазуулсан хүний шарханд анхны тусламж үзүүлж, галзуугийн эсрэг вакцин хийлгэхийг зөвлөх буюу мэргэжлийн эмнэлэгт хүргэ.

Могойд хатгуулах:

Шинж тэмдэг: Хатгасан газар хавдаж, өвдөж өнгө нь өөрчлөгдөх, судасны цохилт түргэсэх, дотор муухайрах, бөөлжих, бие сулрах болон хүнд үед амьсгал, зүрхний ажиллагаа алдагдаж шоконд орох шинжүүд илэрнэ.

Тусламж:

Хор тархалтыг удаашруулах зорилгоор хатгуулсан хүнийг хөдөлгөөнгүй хэвтүүлж, хатгагдсан гар хөлд чиг тавьж бооно.

- Хатгагдсан гар хөлийг өндөрлөж байрлуулна.
- Хатгасан могойг барьж эмнэлэгт аваачна. (Хорыг тодорхойлоход чухал)
- Шингэн зүйл уулгана.
- Эмнэлгийн тусламж яаралтай авна.

ТУСЛАМЖ : Хүйтэн жин тавина. Тайван дулаан байлгана. Хатгагдсан хэсгийг боломжтой бол толгойноос доор түвшинд байлгана .



АНХААР. Амьтанд хазуулсан, хатгуулсан тохиолдолд шархыг сорж болохгүй. Хэрэв аманд шарх байвал хор танд дамжих болно. Чангалуур тавьж болохгүй, үүнээс болж мөч үхжин тайруулж ч болно.

ХҮНД ГЭМТЛҮҮД

Тухайн бэртсэн хүнээс ямар нэгэн хариу үйлдэл байхгүй, нэрээр нь дуудахад хариугүй байвал ухаангүй байна гэж үзнэ. Энэ үед ямар нэгэн сэгсрэх, гулдрах, босгохыг оролдож болохгүй юм. Сандарч тэвдэлгүй дараах зүйлсийг шалгана.

Зүрхний цохилт яаж сонгогдох вэ?

Эрэгтэй хүн, хүүхдийн зүрхний цохилтыг цээжний зүүн талд “хөх мах”-ны доохно талд, эмэгтэй хүний хөхний доохно талд чихээ наалдуулж чагнана. Зүрхний цохилт насанд хүрсэн хүнд 1 минутад 70-80 удаа цохилох бөгөөд хүүхдэд хурдан байна. Халуурах, биеийн хүчний ажил, дасгал хийх, сэтгэл хөдлөх үед зүрхний цохилт түргэснэ.

Судасны лугшилтыг яаж мэдэх вэ?


Шууны урд эрхий хуруу талд долоовор болон дунд хуруугаараа дарж мэдэрнэ. Эрхий хуруугаараа дарвал өөрийн судасны цохилттой андуурч болзошгүй.

Хэрэв шуунд судасны цохилт мэдрэгдэхгүй бол гүрээний (мөгөөрсөн хоолойн хоёр талд, гүрээний булчингийн урд ирмэгт) болон гуяны (цавины) судсанд дээр дарж мэдэрнэ.

Судсыг нэг цэг дээр дарж 15 секундэд тоолж 4-өөр үрүүлж болох боловч судасны цохилт удаан, эсвэл жигд бус байвал 60 секундэд тоолно. Судасны лугшилтын тоо тухайн хүний биеийн байдлаас шалтгаалан өөр өөр байх боловч дунджаар насанд хүрсэн эрэгтэй хүнд 1 минутад 60-70 удаа, эмэгтэй хүнд 70-80 удаа, нялх болон бага насны хүүхдэд бараг хоёр дахин олон байдаг.

Ухаангүй байгаа хүнийг байрлуулах байршил

Ухаангүй байгаа хүний амьсгалын замыг сайтар шалгаж цэвэрлээд зохиомол амьсгал, зүрхний иллэг хийх шаардлагагүй бол дараах байрлалаар хэвтүүлнэ.



Ингэж байрлуулах нь амьсгал, зүрхний ажиллагаанд саад болохгүйн зэрэгцээ ухаангүй байгаа хүний хэл арагш унах, бөөлжсөндөө цацах, хахах зэргээс хамгаална.

Гэмтсэн хүнийг зөөвөрлөх

Нэрвэгдэгсэд, өвчтөнг зөөвөрлөхдөө богино хугацаанд зовуурь шаналгаагүй, гэмтэл өвчнийг хүндрүүлэхгүй хүргэх зорилго тавина. Зориулалтын дамнуурга байхгүй тохиолдолд гарын доорх материал ашиглан дамнуурга хийх буюу гар, сандал дээр суулган зөөвөрлөнө.

Зөөвөрлөх аргыг сонгохдоо тухайн хүний гэмтлийн шинж байдлыг анхааран ямар байдалд хэрхэн зөөвөрлөхөө сонгоно.

Сээр нуруу гэмтэх

Шинж тэмдэг: Нуруу , хүзүү гэмтэхэд хөл мэдээгүй болж хуруугаа хөдөлгөж чадахгүй болно.

Хүзүү хугарсан үед гарын хуруунууд хөдлөхгүй болох, мөрний орчмоор бадайрч мэдрэлгүй болох


Үзүүлэх тусламж: Мэргэжлийн эмнэлгийн үйлчилгээг яаралтай дуудна. Энэ хооронд гэмтсэн хүний толгойг хөдөлгөж болохгүй , хөдөлгөөнөөс



сэргийлж мөр, хүзүү, толгойны эргэн тойронд хөнжил гудас, хувцас зэргээр нь хүрээлж хөдөлгөөнийг нь хязгаарлана. Хүзүү бэлхүүсний хувцсыг чөлөөтэй болгоно. Гэмтсэн хүнийг тайван байлгана. Дулаан байлгана. Хэрэв амьсгал нь төвөгтэй байвал толгойг бага зэрэг хазайлгаж амьсгалын замыг чөлөөтэй байлгана.


Гүнзгий шарх, аюултай түлэгдэл

Гүнзгий шарх хүнд түлэгдэлтийг цэвэрлэх ажлыг зөвхөн эмнэлгийн мэргэжлийн хүмүүс гүйцэтгэж, цус алдалт, шокийг эмчилнэ. АНХААР! Халуурах, гэмтсэн хэсгийн эргэн тойронд улайх, өвчин орох, халуун оргих, хавдах, чимчигнэх зэрэг нь халдвар орж байгаагийн дохио. Энэ тохиолдолд эмчийн зөвлөгөөг түргэн ав. Таны гэр бүлийнхэн татрангийн эсрэг вакциныг 5 жил тутамд хийлгэж байх хэрэгтэй. Ямар ч шарх татран үүсэх нөхцөлийг үүсгэж болох учир эмчид үзүүлж шаардлагатай бол вакцин тариулах хэрэгтэй.




Осол гэмтэл, өвчлөлийн улмаас тухайн хүн өөрөө амьсгалж чадахгүй болж амьсгал зогсох үед зохиомол амьсгал хийнэ. Зохиомол амьсгал хийх олон арга байх боловч дэлхий нийтэд хамгийн түгээмэл арга нь амнаас ам руу, эсвэл амнаас хамар руу үлээх аргаар амьсгалуулах арга байдаг. Зохиомол амьсгал хийхийн тулд нэрвэгдэгчийн амьсгалын замыг сайн шалгаж аманд

байгаа зүйлийг хуруугаараа гарган, хэлийг, зөөлөн урагшлуулж толгойг бага зэрэг гэдийлгэж байрлуулна.





Тусламж үзүүлэгч ам руу нь үлээх бол хамрыг чимхэж, хамар руу нь үлээх бол амыг хаагаад өөрөө уртаар амьсгал авч түгжээд тусламж авагчийн ам, эсвэл хамар амьсгал авч түгжээд тусламж авагчийн ам, эсвэл хамар руу аажим үлээж амьсгалаа гаргана. Амаа ам хамарт завсаргүй наалдуулж агаар алдахгүй байхыг анхаарна.




Амьсгал өгсний дараа өөрөө дахин уртаар амьсгал авч түрүүчийн адил үлээнэ. Амьсгал авах, үлээх явцдаа тусламж авагчийн цээжний хана хөдөлгөөнд орж байгаа эсэхийг ажиглах хэрэгтэй. Цээжний хана хөдлөхгүй байвал зохиомол амьсгал өгч чадахгүй байгааг гэрчилнэ. Зохиомол амьсгалыг насанд хүрсэн хүнд 1 минутанд 16-20 удаа,

нялх хүүхдэд 30-40 удаа гэх мэтчилэн насны байдалд тохируулан хийнэ. Зохиомол амьсгал өгөх ажиллагааг тусламж авагч өөрөө амьсгал авч эхлэх хүртэл үргэлжлүүлэн хийх шаардлагатай.

Зүрхэнд шууд бус иллэг хийх

Гэнэтийн осол гэмтэл, өвчний улмаас зүрх зогссон үед зүрхний шууд бус иллэгийг цаг алдахгүй зөв хийх нь амь насыг аварна. Тусламж авагчийг гэдрэг харуулан, хатуу гадаргатай зүйл дээр, (газар, шалан дээр) хэвтүүлнэ. Тусламж үзүүлэгчийн газрын хүч төвлөрч болохуйцаар түвшинд хэвтүүлэх буюу газар шалан дээр хэвтүүлсэн тохиолдолд тусламж үзүүлэгч өвдгөн дээрээ сөхөрч суух нь илүү тохиромжтой.





Тусламж үзүүлэгч гараа зөрүүлэх юм уу давхарлан, тусламж авагчийн өвчүүний зүүн талд 5-р хавирганы түвшинд алгаараа цээжинд наалдуулан тавьж насанд хүрсэн хүнд нэг минутад 65-75 удаа жигд хэмээр дарж зүрхийг цээжний ар, урд хананы хооронд шахаж цусыг эргэлтэд оруулна. Нялх хүүхэд нэг гараар эсвэл 1-2 хуруугаар дарна.

Цус алдалтанд тусламж үзүүлэх зарчим

Осол гэмтлийн үед судасны хана гэмтсэнээс цус алдалт үүсдэг. Ямар судас гэмтсэн, хаанаас цус алдаж байгаагаар нь цус алдалтыг ангилж үздэг.

- Артерийн цус алдалт
- Энэ нь артерийн судас гэмтэхэд үүсэх ба илүү аюултай, богино хугацаанд их цус алдах боломжтой. Гарч байгаа цус нь тод улаан өнгөтэй, оргилж бургилах байдлаар олгойдож гарна.
- Венийн цус алдалт
- Венийн судас гэмтэхэд үүснэ. Энэ үед цус нь улаан хүрэн өнгөтэй, урсаж нэлийж гарна.
- Артер, венийн хялгасан судасны цус алдалт нь нарийн судасууд гэмтэхэд үүсэх ба цус шүүрэх, дуслах маягаар гарна. Үүнээс гадна цус алдалтыг гадуур дотуур гэж ангилна. Биеийн гадна хэсгээс цус гарч байгаа нь харагдахгүй боловч дотор эрхтний хөндийд цус гарна. Энэ үед царай цонхийх, дотор муухайрах, нүд эрээлжлэх, толгой эргэх, судасны цохилт түргэсч сулрах, даралт буурах зэрэг ерөнхий шинжүүд илэрдэг. Цус алдаж байгаа үед анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлэх ёстой.
- Тусламж үзүүлэхдээ:

Цус тогтоох цэгүүд дээр хүчтэй дарна.

Чангалуур тавих - даралттай боолт тавих, мөчийг нугалж бооно. Чангалуурыг сунамгай, чангалж болох материалаар эсвэл даавууг эрчлэн мушгиад тавьж болно. Чангалуурыг мөчинд цус гарч байгаа хэсгийн дээд талаар тавьж, тавьсан цаг, минутаа цаасан дээр бичиж хавчуулна.

Хэрэв чангалууртай 1 цаг 30 минутаас илүү болбол чангалуурыг суллаж цусан хангамжийг сэргээсний дараа түрүүчийн ормоо зайлуулан дахин давтана. 2 дахь суллалтаас хойш суллах хугацааг улам богино болгоно. Түүнчлэн хүйтний улиралд энэ хугацааг анхаарч чангалуур тавьсан мөчинд хяналт тавьж байхгүй бол хөдлөх, үхжил үүсэх хүндрэл тохиолдож болзошгүй.

Тархины яс хугарах (гавал)

Шинж тэмдэг: Нэрвэгдэгч хагас юм уу бүрэн ухаангүй болно .

Анхаар: Тархины ямар ч гэмтлийн үед наад зах нь 24 цаг хүртэл болон



цаашид гарч болзошгүй аюулыг ажиглаж тодорхойл (ухаан алдах, бөөлжих, толгой өвдөх, шоконд орох, нойрмоглох, бөөлжис цутгах гэх мэт)

ТУСЛАМЖ :

- Хажуугаар нь хэвтүүлж , толгойг бага зэрэг хөдөлгөх боломжтой байлгах
- Хэрэв нэрвэгдэгч бөөлжих эсвэл амнаас нь цус гарвал толгойг маш зөөлөн эсрэг тал руу нь эргүүлнэ
- Амьсгалын замыг чөлөөтэй байлгах
- Дулаан байлгах , бариу хувцсыг тайлах
- Цус алдалтыг шалгаж зөөлөн дарж үзэх
- Хэрэв шаардлагатай бол зохиомол амьсгал хийх , шокоос сэргийлэх арга хэмжээ авах
- Мэргэжлийн эмнэлгийн тусламж яаралтай авах
- Хөхрөх (битүү гэмтэл) нүд хөхрөх
- Дотуур цус алдалттай битүү гэмтэл, зөөлөн эдийн гэмтлийн үед хөхрөх, хавдах, гэмтсэн хэсгийн өнгө нь өөрчлөгдөх шинж тэмдэг илэрнэ .

ТУСЛАМЖ :

- Гэмтсэн хэсэг дээр чийгтэй хүйтэн жин тавих
- Хэрэв өвдөлт хэвээр намдахгүй байвал мэргэжлийн эмнэлгийн тусламж зөвлөгөө авах
- Анхны тусламжийн иж бүрдэл
- Та гэртээ болон аян замд явахдаа анхны тусламжийн иж бүрдэлтэй явах нь тусламж шаардлагатай үер үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Та анхны тусламжийн бүрдэлтэй байснаараа бусдын амь насыг аварч энэрэнгүй үйлс бүтээх болно.
-

Бүрдэлд дараах үндсэн зүйл зайлшгүй байх шаардлагатай. Эдгээрийг та өөрийн боломжоороо авч явахад тохиромжтой жижиг хайрганд хийгээрэй.

| | |
|--------------------------|---------|
| Денатрат спирт | 10.0 гр |
| Иодын ханд | 10.0 гр |
| Мохоо хайч | 1 шир |
| Гурвалжин алчуур | 1 шир |
| Ариутгасан бинт (Өргөн) | 2 шир |
| Ариутгасан бинт (Нарийн) | 2 шир |
| Хөвөн | 40.0 гр |
| Шархны лент | 1 хайр |
| Саван | 1 шир |



| | |
|----------------------------------|------------|
| Резин бээлий | 1 хос |
| Хоросол | 1-2 уут |
| Тэмдэглэлийн цаас, харандаа | |
| Лаа, чүдэнз, бээлий | |
| Нарийн резин, нарийн даавуу | |
| Өвчин намдаах, халуун буулгах эм | 2-3 боодол |
| Өргөн үйлчилгээний антибиотик | 10 шир |
| Гэдэсний халдварын эсрэг эм | 2-3 боодол |
| Анхны тусламжийн лавлах ном | 1 шир |

Эх сурвалж: Монголын улаан загалмай нийгэмлэгийн гарын авлагаас ашиглав.

ХАВСРАЛТ 17. Монгол гэрт гадаадын жуулчид анх удаа зочлохдоо гаргадаг зарим алдаа

Гадаад жуулчин соёлын ялгааны улмаас буруу сэтгэгдэл төрүүлэхээс сэргийлээрэй. Энэхүү хэсгийг хэвлэн авч зочны гэртээ байрлуулж болно.

Do's and Don'ts for Guests¹

The Mongolian Ger

Mongolian gers are set up so the door is always facing south. So when you step into the ger, you are facing the north side, and this is the most honored place, where the family's altar usually is. Very honored guests will be asked to sit at the north side.

The west side of the ger is the mens' side and where saddles and other equipment will be stored. The east (right) side of the ger is usually where women sit and work. The stove door is always facing east, and cooking/kitchen equipment is stored on the east side.

When You Visit A Family in their Ger

Entering the Ger

- Do not to step on the threshold when entering
- Usually, guests entering the ger go to and sit at the left (west) side.
- Do not to stop at door with one foot inside and one outside ger
- You don't need to wait to be invited to sit down. Sit down on the bed or stools, or on the floor. Don't squat, rather touch the ground sitting cross legged with one or both legs.
- Don't sit with your feet pointing to the altar
- It is nice to bring a gift – candy is common as a gift. Hand it to the woman upon entering.

¹Some of the content of this guideline was adopted from https://notesofnomads.com/mongolian-gers/?utm_source=pocket_mylist



Snuff Bottles for Greeting Guests

It is a common ritual that the man of the household will offer a snuff bottle to guests, to one after the other.

- When he offers it to you, receive it with your right hand, while your left hand supports your right elbow.
- Open the bottle and try a little of the snuff, (careful it can be powerful and make you sneeze or burn) best by putting a little on your fingers and carefully sniffing a bit.
- Hand it back to the host, with the "lid" NOT closed down, with your right hand, left hand supporting your right elbow.

Accepting Food and Drink

The family will offer you drink and food. Most likely milk tea, home made, deep fried bakery (bortsog) and curd (aruul).

- Don't turn down the tea.
- But if you don't want to finish any drink or food, its ok, place it down.
- Receive the tea bowl with two hands, or with your right hand, your left hand supporting your right elbow

Vodka, homemade milk vodka or Airag (fermented mare's milk) is commonly offered to guests. You do not HAVE TO drink alcohol if you don't want. But if you can, at least take a sip or try it. The procedure is this:

- The host will pour the drink and pass it to you. Receive it as described above
- Drink/taste and then pass the cup back to the host who refills it and then passes it to the next person. Don't pass it to the next person, always pass it back to the person who gave it to you.
- You can observe a Mongolian custom and dip the ring finger of your right hand into the vodka, and then sprinkle some vodka into all four directions, by flicking ring finger against your thumb. This is a symbolic offering.
- If you don't want to drink, you can do the offering as described above without drinking, or by only touching the vessel to your mouth, and pass it back. This is also a sign of accepting their gesture of hospitality.

Inside the Family's Ger

- Do not walk over bowl, cups, food, or anything in the ger
- Do not walk between the two main center poles, and do not lean against them
- Do not whistle in a ger
- Do not throw trash directly into the fire/stove



- If you accidentally touch someone's feet/legs with your feet/legs, it is customary to do a handshake/touch hands (anywhere, not just in ger)

When sleeping in a Ger as Guest of Family

- Do not sleep facing your feet to altars
- Do not step over someone sitting or lying on the floor.

In Your Ger at the Camp or Homestay

- Watch your Head when entering !!
- Do not hang things from the red (sometimes it's not red) rope that is placed in loops between the roof poles and the roof cover. It has a special meaning as a symbol for the family's happiness and long life.
- Do not sit on threshold (and don't step on it or stop over it)

Receiving and giving gifts and other Items

- Do not receive or give things with your left hand
- In general, do not point fingers at anything or anybody. Show a direction or point to something or somebody with your whole, open hand.
- When giving something to somebody (money, gift, etc.) hold and offer it with both your hands. Do not hold, for example, a bank note between fingers of one hand, and present it with fingers pointing at the receiving person.
- Have your sleeves rolled down when giving and receiving.

Handling Knives and other Sharp Items

- Do not point at someone with a knife or sharp tools
- Do not hand sharp tools to someone with the sharp end pointing at them.
- Do not stir food with knife
- Do not use knife for picking up things from stove

Other Rules to Observe

Household and Livestock

- Don't step over a saddle or any other gear for herding and livelihood
- Do not hit the head of a horse or any other livestock
- In lightning thunder storm horse bridle (bit) should be removed

Visiting monastery and temple:

- Do not wear a hat in a monastery and temple.
- Do not enter monastery or temple without shirt. Wear modest clothes.

At places of workshop, sacred mountains and ovoos

- Do not pick up any stones, plants or other items
- Do not hunt, or kill any animal/ insects
- Do not urinate near Ovoos (or close to any water source)

**ХАВСРАЛТ 18.** Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал

| № | Гарч болох эрсдэл | Шийдвэрлэх арга замууд , урьдчилан сэргийлэх |
|--------------------------|--|---|
| Төвлөрсөн газар | | |
| 1. | Цахилгааны бүрэн мэдлэггүйгээс тогонд цохиулах | Мэргэжлийн цахилгааны инженер дуудаж холболтыг мэргэжлийн үүднээс шийдэх, янзлуулах |
| 2. | Гал түймэр тавих | Галын аюулгүй байдлыг хангах дүрэм журмыг холбогдох байгууллагаас авч, зөвлөгөө авах, гал унтраах хэрэгслийг бүрэн дүүрэн байршуулж, тоноглох |
| 3. | Тогооч нар түлэгдэх, гар хөлөө эсгэх | Хоол үйлдвэрлэлийн технологийн журмыг мөрдөх, ойр зуур хэрэглэх анхны тусламжийн хайрцгийг бэлдэж тавих, түлэгдэлтийн тосыг бэлэн байлгах , шарх цэвэрлэх ариун боолт бэлэн байлгах |
| 4. | Газтай буруу харьцсанаас угаартах, хордох | Ахуйн газ болон, газын баллон ашиглалтын дэвтэр, тэмдэглэгээг мэргэжлийн байгууллагаар хөтлүүлэх, баллоны бүтэн байдлыг шалгуулах, тогтмол шалгах |
| 5. | Халдвар хамгааллын дэглэм бариагүйгээс халдварт өвчин тусах. | Эрүүл ахуй, халдвар хамгаалал, ариун цэврийн дотоод дүрэм журмыг баримтлах, ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь зөв орц найрлагатай хийж сурах |
| Хөдөө хээр явж байх үед: | | |
| 1. | Морь , тэмээ , цаа буга, эсвэл уул хаднаас унаж бэртэх | Эрсдэлтэй аялал явахад хэрэглэгдэх хувцас хэрэглэл, малгай, гутал , тоног хэрэгслийг өмсөж хэвших Аюулгүйн заавар зөвлөмжийг өөрсдөө дагаж мөрдөх, үлгэрлэх. Гэнэтийн ослын даатгалд хамрагдах Аялалд урьдчилан бэлдэж морь, тэмээ, цаагаа уналга, ачилганд сургах Тоног хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг шалгах, засварлах Аяллын компанид шаардлага тавих. Нөхцөлөөр хангаж өгөхийг хүсэх. Гэрээ байгуулах |



| | | |
|----|--|---|
| 2. | Байгалийн гамшигт өртөх. Хүчтэй салхи бороо, үер, цасанд боогдох | Цаг агаарын мэдээг урьдчилан мэдэх, тэмдэглэж авах, өөрсдийн хаана яваагаа тогтмол мэдээлэх. Яаралтай үед холбоо барих онцгой, түргэний дугааруудыг авч явах, холбоо барих хэрэгслийг цэнэг, нэгжтэй байлгах |
| 3. | Хоолны хордлого авах | Хоол хүнсний аюулгүй байдлыг хангаж явах, зохицолгүй хүнс хэрэглэхгүй байх. Цэвэр ус сайн уух. Баталгаагүй булаг шандын усыг буцалгахгүйгээр хэрэглэхгүй байх. Шууд хэрэглэх хүнсийг буцалсан усаар угааж хэрэглэх. |
| 4. | Хэт халуун наранд буруу хувцас эсвэл зориулалтын тос түрхэхгүйн улмаас арьс түлэгдэх | Аль болох биеэ ил гаргасан хувцас өмсөхгүй байх. Нар, салхинаас хамгаалах тосыг байнга тогтмол хэрэглэх. |
| 5. | Малгайгүй явснаас нарших, ус уухгүй байснаас шингэн дутагдах | Олон цагаар наранд явахдаа нарны малгай, шил зүүж хэвших, ус байнга уух |
| 6. | Дулаан хувцас өмсөөгүйгээс болж хөлдөх, хайрагдах | Зориулалтын хувцас өмсөх. Дулаацах арга барилд суралцах. Түүдэг асаах, халуун баригч авч явах. Хэт олон цагаар хоол ундгүй явахгүй байх. Осголтын талаар мэдлэгтэй байх. |
| 7. | Баталгаагүй замаар зорчиж автомашины осол аварт орох | <ul style="list-style-type: none"> • Машины бүрэн бүтэн байдлыг шалгах – явах эд ангийн доголдол, машины илүү дугуй, дугуй нөхөх хэрэгслээ шалгах • Жолоочийн нөхцөл байдлыг шалгах – биеийн байдал хэвийн эсэх, даралт ихдэх, нойр хүрэх, хэт ядрах, нойргүй хоносон эсэхээ шалгах • Зам болон жолоодлогын бүрэн бүтэн байдлыг шалгах - Орон нутгийн зам дээр хурд хэтрүүлэхгүй явах, машины суудлын бүс зүүж хэвших, эрсдэл ихтэй халтиргаа гулгаатай замаар зорчихгүй байх, |
| 8. | Зэрлэг ан амьтны үүр эсвэл амьдардаг газарт дураар очиж хазуулах, бариулах, | Эрсдэлтэй алхам хийхгүй байх. Нутгийн сайн мэдэх хүнээр газарчлуулах, холоос ажиглах |
| 9. | Морь, тэмээндээ хазуулах, өшиглүүлэх | Анхны тусламжийн хайрцгийг заавал ойр авч явах. Сургалтад сууж үзүүлэх тусламжийг мэдэж авах. Зааврын дагуу эм хэрэглэх. |



| | | |
|-----|------------------|--|
| 10. | Төөрөх | Өөрсдийн аяллын төлөвлөгөөгөө ар гэртээ хэлж үлдээх. Холбоо барихгүй бол орон нутгийн аврах байгууллага эсвэл онцгой байдлын албаны утсыг зааж өгөх. Аль болох батлагдсан маршрутын дагуу явах, зам товчлохгүй байх, айлаас зам асуух. Төөрсөн тохиолдолд холбоо яаралтай барих, тусламж дуудах, байршлаа тодорхой хэлсэн мессежийг явуулах. Утас, станцыг цэнэглэх, илүү баттерей авч явах, усаа нөөцлөх, |
| 11. | Гал түймэр тавих | Тамхиа бүрэн унтраах, ишийг тусдаа саванд авч явах, түлсэн галаа бүрэн унтраах, хэт хуурайшилтын үед машины яндангаас унах очийг анхаарах. |

ХАВСРАЛТ 19. Аялалд бэлтгэх зүйлс

Аялал эхлэхийн өмнөх бэлтгэл

Хөтчийн хувийн бэлтгэл:

- 2 – 3 ээлжийн үндэсний хувцас бэлдэж борооны цув заавал авч явах
- Холбоо барих утсаа цэнэглэх, илүү зай бэлдэх
- Ариун цэвэр сахих
- Малгай нь бүчтэй байх
- Богцоо бэлдсэн байх
- Хэрэгцээт ойр зуурын эм, бэлдмэл, боломжтой бол анхны тусламжийн хэрэгслээ авсан байх
- Морьдоо аялалд бэлдэж 2-3 өдрийн өмнөөс адуунаас нь барьж уналгад бэлдэх. Шууд адуунаас нь бариад унах нь бэлтгэлгүй, хэнэггүй байгааг харуулна. Морьд унаж яваа хүн нь дохио өгөхөд хөдөлгөөнд орж сурсан байх хэрэгтэй юм.
- Тэмээг аялалд бэлдэж 2-3 өдрийн өмнөөс жуулчдын тоогоор цуглуулан, тохом, бурантгийг шалгаж бэлдэх
- Чөдөр, ногт, уяа, гадас, олс, сур, дээс зэргийг тааруулан бэлдсэн байх нь аяллыг амжилттай болгодог.

Жуулчдад урьдчилж өгөх мэдээлэл:

Морь тэмээнээс унаж бэртэх зэрэг нь байнга тохиолддог бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх хамгийн зөв арга бол зааварчилгааг сайн өгөх байдаг.



- Олон жуулчинтай томоохон группүүдийг хянаж болох хэмжээгээр баг болгон төлөвлөж авч явах нь аяллыг илүү үр дүнтэй, хялбар болгодог. Олон хүнд зэрэг өгөх зааварчилгаа нь нэг хоёр жуулчинд өгөх зааварчилгаанаас хэцүү тул сайтар бэлтгэх шаардлагатай. Аяллын хөтөч, ахлагч болон жуулчдын группийн ахлагчтай аяллын хөтөлбөрийн талаар сайтар ярилцаж нэгдсэн ойлголттой болоорой.
- Хичнээн туршлагатай морь, тэмээ, цаа унадаг хүн байсан ч гэлээ орон нутгийн хөтчийн зааварчилгааг заавал сонсох ёстой.
- Туршлагатай морь унадаг, анх унахаар ирсэн жуулчдын аль алинд нь таарсан зааварчилгаа өгөөрэй. Монгол хүн гээд хотоос ирсэн хүнийг морь унаж чадна эсвэл мэддэг гэх мэтээр тоохгүй байж болохгүй.
- Өөрийн сургасан, унаж яваа морь тэмээнийхээ ааш зан, онцлогийг хөтөч өөрөө сайн мэдэж байдаг тул онцлогуудыг хэлж өгөөрэй.
- Жуулчдад тохирох морь, тэмээг унуулж олом жирэм, дөрөөг тааруулан хүн тус бүрийг шалгах нь эрсдэлийг багасгадаг.
- Мөн олон жуулчинтай аялалд өөр өөр айлын адуу, морь нийлэх тохиолдолд онцгой сонор сэрэмжтэй байх хэрэгтэй. Учир нь тэд нэгнээ тангарах, өшиглөх, хазахыг оролддог. Энэ нь жуулчдад айдас түгшүүр төрүүлдэг. Тиймээс уналгад хэрэглэх морь тэмээг аль болох хэдэн өдрийн өмнөөс урьдчилан бэлдээрэй.

Моринд ачаалах:

- Ачааны богцыг тааруулсан байх. Морины нуруунд ачааг тэнцүүлэн ачна.
- Ус ундаа, ойр зуурын хэрэгцээт зүйлс, борооны цув хийх жижиг богцыг хүн тус бүрд өгнө. Аль болох том үүргэвчгүйгээр морь унуулахад анхаараарай.
- Ачааны морьд болон уналганы морийг хэмнэж цөөн тооны хөтөч явуулах нь элбэг тул морь унах бэлтгэл болон ачаа ачих цагийг онцгойлон анхаараах хэрэгтэй. Тухайлбал урд өдөр нь ачааг эмхлэн, хүнд хөнгөнийг тааруулан бэлдсэн байх нь аяллын цагийг хэмнэхээс гадна жуулчдын морийг үргэж бусгахаас давхар сэргийлнэ.

Амьтныг хайрлах

- Жуулчинд унуулж буй морь нь тэжээл сайн авсан эрүүл чийрэг байх хэрэгтэй бөгөөд таараагүй эмээл тохсоноос болж нуруу нь холгох, тохомгүй эмээллэсэн зэргийг сайтар анхаар.
- Гадаадын жуулчид таны морины эрүүл чийрэг байдал, таныг



морьдоо унах болон ачаалахдаа тэдэнтэй хэрхэн харьцаж байгааг ямагт ажиглаж байдгийг санах хэрэгтэй.

- Тэмээг уналгад явуулахаас өмнө боломжоороо цэвэрхэн байхад анхаараарай. Гадаад жуулчид цуваагаар явах үед тэмээний биед наалдсан хоргол бааснаас их цэрвэдэг.

Жуулчдын хувцаслалтын талаар нөхөрсөг зөвлөгөө өгөх:

- Морь тэмээ унах өдрийн цаг агаарт тохируулан хувцаслалтыг маш нарийн хэлж өгөх.
- Аль болох урт ханцуйтай даавуун цамц өмсөх
- Морины тусгай өмд байхгүй бол даавуун өмд аль болох өмсүүлэх. Бага зэргийн бороо дайран өнгөрөх нөхцөлд амархан хатдаг гэдгийг тайлбарлаж өгөөрэй.
- Гутлын сонголтод арзгар ултай гутлыг аль болох өмсүүлэхгүй байх. Түрийтэй гутал эсвэл түрий өмсүүлэх
- Каскан малгай өмсүүлэх, толгойд нь таарах эсэхийг шалгах
- Бээлий өмсүүлэх эсвэл ажлын бээлий байсан ч болно
- Хэт их шажигнасан, тод өнгөтэй эсвэл хэт бариу хувцас өмсөхгүй байхыг зөвлөх
- Үүргэвч, цүнх нь модонд огло татагдахгүй уяа, холбоос, чимэглэлгүй байх
- Хэт их хурц үнэртэй ус эсвэл биеийн тос түрхэхгүй байхыг анхааруулах
- Морь, тэмээ унаж байхдаа ямар нэгэн цацлага, элдэв үнэртэн хэрэглэж болохгүйг анхааруулах

Маршрутын талаар зөвлөгөө өгөх :

- Морь, тэмээтэй аялах маршрутын талаар мэдээллийг тодорхой өгөөрэй. Хэдэн өдөр аль чиглэлд, ямар орон нутгаар явах эсвэл өдөртөө хэдэн цаг явахыг тодорхой хэлж өгнө. Хэзээ, хаана амрах, өдөр, оройн хоол хэрхэн, хаана идэх талаарх мэдээллийг хуваалцаарай.
- Өдөртөө үзэж, таарч болох сонирхолтой зүйлс /түүх соёлын дурсгалт газар, цэцэг, ургамал, ан амьтан, шувуу/-ийг урьдчилан хэлж өгөөрэй. Жуулчид зэрлэг амьтныг алсаас олж харж дасаагүй байдаг учраас аль болох тайван зогсож байгаа амьтныг олж харахад нь туслаарай.
- Бууж амарч болох газруудаа оновчтой сонгож, аялал удаан явах нөхцөлд буудаллах газруудаа зөв сонгоорой. Амралтыг хэт удаан, хэл хол байлгаж болохгүй.
- Жуулчдыг морь, тэмээнээс буух бүрт нь олом жирмийг чангалах,



тохмыг шалгаарай.

- Давааны уруу болон хэт өгсүүр хэсэгт мориноосоо бууж, хөтлөн яваарай.
- Шавар, намагтай үед морь зоогдох эрсдэл гарахыг анхааруулаарай.
- Уулын сул чулуу, ургаа хадтай газраар ахлагч явсны дараа гарахыг хэлж өгөөрэй.

Дараах зааварчилгааг морин дээр харуулж биеэр зааварчлан үзүүлэх:

- Морь руу ойртон очих, хойгуур нь ойрхон гарвал өшиглөх, эгц урдаас нь яваад очвол хазах, хөлөөрөө цавчих, хүзүүн доогуур нь шурган гарвал цоройж самардан цавчих аюултай зэргээр Монгол морины ааш байдлыг тайлбарлах;
- Моринд мордохдоо зөвхөн зөв талаас нь аядуухан алхан очиж зүүн хөлийг дөрөөн дээр мөчидхөн тавьж эмээлээс дэмнэн мордох, хөлийн өлмий хэсгээр дөрөөлөх, өөрийн биеийн байрлалд тохируулан дөрөөг тохируулах хэрэгтэйг сануулах;
- Хэрвээ бие чинь намдаж байвал газрын өндөр хэсэг, модны хожуул дээрээс ч мордож болох юм гэдгийг үзүүлэх,
- Морь унаж байх үедээ эмээлийн байрлал өөрчлөгдсөн тохиолдолд морио зогсоож, морин хөтөч эсвэл хөтөч-тайлбарлагчид мэдэгдэх ёстойг сануулах;
- Жолоо, цулбуураар гараа ороолгүйгээр атган, жолоог тэгш, мөчидхөн барьж морийг жолоогоор, бие, хөлөөрөө давиран удирдан зогсоох, явуулах, эргэх тойрох, давхих зэргийг биечлэн үзүүлэх;
- Морийг унаж явах үед биеэ хэрхэн авч явах, газрын өөд, уруу, хазгай газруудад явахад эмээлээс хэрхэн дэм авахыг тайлбарлан хэлж зөвлөх;
- Морь унаж явах болон зогсох үед морин дээрээс буулгүй хувцсаа тайлах буюу өмсөх, зураг авах, тамхи татах, юм уух, үүргэвч, цүнхээ авах, уудлах, хөлөө хэт дээр өргөх, хамаагүй давиран хөдөлгөх, орилж хашхирах зэрэгт морь үргэх аюултай ба түүнээс урган гарч болох аюулыг хэлж тайлбарлах;
- Жуулчдыг мориноос дураараа буух, мордох, зөвшөөрөлгүй давхих, хоорондоо уралдахыг хориглох.
- Мориноосоо хэрхэн буух зааварчилгааг өгөх. Ядарсан, чилсэн хөл, өвдгийг хэрхэн хөдөлгөх, буухдаа анхаарах зүйлсийг дурдах,
- Заавал хөтчийн тусламжтай эсвэл хяналтад мориноосоо буух, бөөн морьд дунд буухгүй байх, мориноосоо үсрэн буухгүй байх, дөрөөндөө чирэгдэхээс болгоомжлох, яаран олон хөдөлгөөн хийхгүй байх зэргийг анхааруулж хэлэх,



- Чанга хашхирах, чангаар дуу дуулах зэрэг нь морийг хөөргөх, ам булааж авч давхих зэрэг аюул гарч болохыг анхааруулах.

Аяллын явцад өгөх зааварчилгаа

- Аяллын замын нийт урт болон бартаа саад зэрэг анхаарах зүйлсийг хэлж өгөх;
- Ахлагчийн дохиогоор хөдлөх, зогсох, буухыг зөвлөх,
- Морь унаад явж байх үед хүмүүс хооронд 2-оос 3м-ийн зайтай цуваагаар явах ба хөтчийн удирдлагын дагуу группийн хурдыг тохируулах;
- Морин аяллын үед группийн хэмжээнээс хамааран нэг өдөрт туулах замын бартаа, явалт нь 30 км-ээс ихгүй замыг туулах;
- Аяллын дундуур 2 цаг тутамд мориноос буулгаж амраах, сэргээх, биеийн чилээг гаргах зэргээр тав тухтай байдлыг хангахад анхаарах;
- Морин аяллын үед аюулгүй байдлыг хангах үүднээс машинаар зайтай дагалдах;
- Жуулчдын унасан морь, эмээлийг солихгүй байх, боломжтой бол эмээл бүрт дугаар тавих;
- Жуулчид моринд мордох, буух үед хөтөч-тайлбарлагч болон морин хөтчийн зүгээс туслах;
- Жуулчдын морийг явж өгөхгүй байна гэх шалтгаанаар бусад хөтөч үргээж, ороолгох, ташуурдахыг хориглох;
- Жуулчдыг морь унаж явах үед хөтөч-тайлбарлагч, морины хөтөч нар эмээлийн байрлал, оломны чанга сул, эмээл хазаарын бүрэн бүтэн байдлыг хянаж, эмээл хөдөлсөн байвал даруй хэвийн байдалд оруулах;
- Жуулчныг давхиулах үед хөтөч ойрхон дагаж явах буюу морийг байнга хянаж байх;
- Ургаа, нялх залуу модноос морьдыг уяхгүй байхад анхаарах;
- Жуулчдыг зөвшөөрөөгүй үед морийг алхах, шогшуулахаас илүү хурднаар явахыг хориглох;
- Хурдыг нэмэх тохиолдолд жуулчдад урьдчилан анхааруулах;
- Гол ус гатлах үед усны гүнийг анхаарч, бартаа багатай, морины гэдсээр татахгүй гүехэн, урсгал багатай гарам хэсгээр гатлах;
- Урьд нь ачаанд хөлөглөж байсан морьдыг уналгад явуулахаар бүдчээд байдаг, мөн байн байн өвс идэх гээд тонгойдог учраас морины амыг сайн татаж явахыг зөвлөх;
- Аяллын үеэр гол гатлах явцад ус уулгах эсэхийг хүртэл зааж өгөх
- Аяллын үеэр гарсан аливаа асуудлыг шийдвэрлэх тохиолдолд аяллын группийн ахлагч хөтөч, хөтөч-тайлбарлагч нар протокол



- хөтөлж явах;
- Жуулчдыг мордуулж өгөх, буулгахдаа биед нь хамаагүй хүрэхгүй байх;

Аяллын төгсгөлд өгөх зааварчилгаа

- Жуулчдаас түрүүлж буугаад нэг бүрчлэн морийг нь барьж байгаад мориноос нь буулгах болон буухад нь туслах.
- Морьдоо аюулгүй газарт тусад нь аваачиж, уяанд нь уях.
- Жуулчид аяллын төгсгөлд морьдоо тэврэх, илэх болон алим жимс өгөх зэрэг хүсэлтэй байдаг тул аюулгүй байдлыг нь хангах, эсвэл ингэж дасаагүй байдгийг хэлж ойлгуулах.
- Ачаа, богц, үүргэвч зэргийг нь буулгаад, дөхүүлж өгөх.
- Цуг явсандаа тэдэнд талархал илэрхийлж аяллаа дуусгаарай.

Монгол морь нь морин тойруулгын морьдыг бодвол уналгад бага хэрэглэдэг, ихэнхдээ адуундаа сул явж байдаг тул омголон биеэр жижиг ч олон км явах чадалтай байдаг. Иймээс хурд, хүч шандасны талаар сайхан түүх, домог, хууч яриаг жуулчдадаа хэлж өгөөрэй. Тэд нутгийн хөтөчтэй хөөрөлдөх дуртай байдаг бөгөөд адуучин залуусын ид хав, адуугаа хэрхэн хайрлан хүндэлж байгааг бахдан биширдэг хүмүүс олон бий. Морин аяллын явцад өөрсдийн хийж болох жижиг үзүүлбэрийг бэлтгэн үзүүлэх нь жуулчдын сэтгэлийг ихэд хөдөлгөдөг.

ХАВСРАЛТ 20.1. Морин аялал хийх зааварчилгаа

Энэхүү морин аялал хийх зааварчилгаанд GIZ SPACES төслийн зүгээс Орхоны Хөндий БЦГ-т морин аялал, морин хөтчийн үйлчилгээ эрхлэхэд мөрддөг журмаас иш татлаа.

НИТАЖ-ын үйл ажиллагаанд морин аялал, морин хөтчийн үйлчилгээ эрхлэх түгээмэл байдаг. Иймд уналгын морьд номхон, аюулгүй байдлыг хангах эдлэл хэрэгслээр тоноглогдсон, жигд байх ёстой. Морин хөтөч нь НИТАЖ эрхэлж байгаа нөхөрлөл эсвэл бүлэгт гишүүнээр бүртгүүлсэн, нөхөрлөлөөс гаргасан хуваарийн дагуу морин үйлчилгээг чанартай үзүүлж ажиллана.

Морь унуулах, морин аялал хийхээс өмнө жуулчинд дараах зүйлсийг заавал анхааруулах ёстой.

- Морин аяллын үед хувцсыг хэрхэн тохируулах талаар зааварлах, хэт том үүргэвч, цүнх үүрч явах нь аюултай гэдгийг хэлж сануулах



- Морины хойгуур ойрхон гарвал өшиглөх, эгц урдаас нь очвол самардах, хүзүүн доогуур нь шурган гарвал цоройж самардах аюултай зэргээр Монгол морины ааш байдлыг тайлбарлах
- Моринд мордохдоо зөвхөн зөв талаас нь зөөлөн очиж, зүүн хөлийг дөрөөн дээр мөчидхөн тавьж эмээлээс дэмнэн мордох, хөлийн өлмий хэсгээр дөрөөлөх, өөрийн биеийн байдалд тохируулан дөрөөг тохируулах хэрэгтэйг сануулах
- Морь унаж байх үедээ эмээлийн байрлал өөрчлөгдсөн тохиолдолд морио зогсоож, морин хөтчид мэдэгдэх ёстойг сануулах
- Жолоогоор гараа ороолгүйгээр жолоог тэгш, богино барьж морийг жолоогоор удирдан зогсоох, явуулах, эргэх тойрох, давхих зэргийг биечлэн үзүүлэх
- Морийг унаж явах үед биеэ хэрхэн байрлуулах, газрын өөд уруу хазгай газруудад явахад эмээлээс хэрэн дэм авахыг тайлбарлан хэлж зөвлөх
- Морь унаж явах үед болон зогсох үед морин дээрээс буулгүй хувцсаа тайлах, өмсөх, зураг авах, тамхи татах, юм уух, үүргэвч, цүнхээ авах, уудлах, хөлөө хэт дээр өргөх, хамаагүй давчин хөдөлгөх, орилж хашхирах зэрэгт морь үргэх аюултайг тайлбарлах
- Жуулчдыг мориноос дураараа буух, мордох, зөвшөөрөлгүй давхих, хоорондоо уралдах зэргийг хориглоно гэдгийг сануулах
-

Морин аяллын хөтөч, хөтөч тайлбарлагч нарын аяллын үед баримтлах, анхаарах дараах зүйлсийг сахиж ажиллана. Үүнд:

- Согтууруулах ундаа хэрэглэж болохгүй
- Зөв талаас мордож мөн тэр тал руугаа буудаг болохыг анхааруулах
- Аяллын өмнө анхааруулах санамж зөвлөмж болон орчны байдлын талаар мэдээлэл өгөх
- Түүх соёлын болон байгалийн талаар сайн мэдлэгтэй байх
- Морин аяллын хөтөч, аяллын хөтөч тайлбарлагч нар морины хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хамтран хариуцан ажиллах ба анхны тусламж үзүүлэх эм хэрэгсэл, сэлгээ морьд, морины хэрэгслийн нөөцтэй байх
- Морин аяллыг эхлэхээс өмнө хагас өдрөөс доошгүй хугацаагаар монгол морины ааш араншин, морьтой хэрхэн харьцах, морины тоног хэрэгслийн тухай зааварчилгаа өгч, жуулчдаар дадлага хийлгэх
- Морин аялал эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө унах морьдыг хөтөч тайлбарлагч, морин аяллын хөтөч нар эмээлэн бэлэн болгох
- Морь унаж буй 5 жуулчин тутамд нэгээс цөөнгүй морин хөтөч ажиллуулах



- Жуулчин морь унахад тохиромжтой гуталтай эсэхийг шалгах
- Морин аяллын үед морин хөтөч аяллыг удирдан түрүүнд явах ба хөтөч тайлбарлагч аяллын сүүлд цоожилж явах
- Морь унаад явж байх үед бүх хүмүүс хоорондоо 2-3 м-н зайтай цуваагаар явах ба хөтчийн удирдлагын дагуу группийн хурдыг тохируулах
- Морин аяллын үед нэг өдөрт 45 км-ээс ихгүй зам туулах
- Аяллын дундуур 2 цаг тутамд мориноос буулгаж амраах, сэргээх, биеийн чилээг гаргах, зэргээр тав тухтай байдлыг хангах
- Морин аяллын үед аюулгүй байдлыг хангах үүднээс автомашин дагалдах
- Жуулчдын унасан морь, эмээлийг солихгүй байх
- Жуулчид морь моринд мордох, буух үед хөтөч тайлбарлагч болон морин хөтчийн зүгээс туслах
- Жуулчдын морийг үргээж, ороолгох, ташуурдахыг хориглох
- Жуулчдыг морь унаж байх үед хөтөч тайлбарлагч, хөтөч нар эмээлийн байрлал, олмын чанга, сул, эмээл хазаарын бүрэн бүтэн байдал зэргийг хянаж, эмээл хөдөлсөн байвал даруй хэвийн байдалд оруулах
- Жуулчныг давхиулах үед хөтөч ойрхон дагаж явах буюу морийг хөтлөх
- Жуулчдыг зөвшөөрөөгүй үед алхах, шогшуулахаас илүү хурдаар явуулахыг хориглох
- Хурд нэмэх тохиолдолд жуулчдад урьдчилан анхааруулах
- Гол, ус гатлах үед усны гүнийг анхаарч, бартаа багатай, морины гэдсээр татахгүй гүехэн, урсгал багатай гарам хэсгээр гатлах
- Эгц өөд уруу, хад асга ихтэй газраар явахаас зайлсхийж, хэт их бартаатай газраар мориноос буулгаж хөтлүүлэх
- Аяллын үеэр аливаа асуудал гарч шийдвэрлэх тохиолдолд аяллын группийн ахлагч, хөтөч, хөтөч тайлбарлагч нар протокол хөтөлж явах

ХАВСРАЛТ 20.2. Тэмээн аялал хийх зааварчилгаа

Тэмээн аяллаар аялахдаа юу анхаарах вэ

Тэмээн аялал хийхдээ жуулчдад Монгол тэмээ нь хэдийгээр гэрийн тэжээмэламантан боловч заримдаа үргэх, занаш нь өөрчлөгдөх тохиолдол гардаг учир зааварчилгаа сайн өгч осол гэмтлээс сэргийлээрэй.

Тэмээн аялал эхлэхийн өмнө тэмээг унах жуулчнаар нь хөтлүүлж 500 орчим метр орчим явган алхвал аль аль нь орчиндоо аялал тань амар болно. Мөн тэмээг унах үедээ хэлдэг хэллэг, аялга болох "сөөг сөөг"



гэж зөөлөн дуудаж бурантгийг доош нь дарж хэвтүүлэх, босгохдоо "чүү чүү" гэж хэлэх, тайван явж байгааг илтгэх "хөөг хөөг" гэж дохио өгдгийг сайтар тайлбарлаж өгөөрэй. Харин тэмээг зогсоох, үргэсэн үед нь тайвшруулах бол бурантгийг эгц хойш нь аядуу татаж "Хаа Хаа" гэж чанга, тод, захирангуйгаар хашгирах хэрэгтэйг ч мөн хэлнэ.

Бид морь, тэмээнийхээ зүүн гар талаар нь хандаж, ойртож, эдэлдэг учир морь, тэмээ нь тэр талдаа дассан байдаг. Үүнийг зөв тал хэмээн тайлбарлан зүүн талаас нь хандахыг зөвлөөрэй. Мөн дараах санамжуудыг тэмээн хөтөч жуулчдад өгөөрэй.

- Тэмээн дээр аль болох ачаа бага ачих
- Тэмээнийхээ бөхнөөс элдэв юм зүүх, юм унагах нь тэмээг үргэнэ гэдгийг анхааруулах
- Таны хувцас, эдлэл хэрэглэл шажигнасан элдэв содон чимээтэй бол тэмээг дастал түүнээ хэрэглэхээс татгалзах
- Тэмээний араас шууд гэнэт ойртож болохгүйг тайлбарлах. Учир нь зарим цочсон тэмээ тийрч болох тул араас нь 2м-ээс дотогш ойртох хэрэггүй.
- Тэмээний дөрөөг жуулчдын хөлний уртад сайн тааруулах. Дөрөөн дээрээ өндийхөд тохомноосоо 4 хуруу орчим хөндий зай гарч байхаар тааруулаарай.
- Дөрөөн дээр зөвхөн өлмийгөөрөө гишгэж шаардлагатай үед хөлөө дөрөөнөөс хурдан авах боломжтой байхыг сайтар сануулах
- Хамгийн чухал зүйл бол цуваагаар явж, цуваанаас гарахгүй байхыг анхааруулах. Анх тэмээ унаж байгаа жуулчдад дасах хугацаа өгч тэмээ цуваагаар аялах хэрэгтэй.
- Жуулчдыг тэмээгээ унаж суртлаа зураг авахыг тэвчих, хэрэв авах бол тэмээгээ зогсоогоод авахыг зөвлөөрэй. Харин унаж сурсан эсвэл цуваан дундаа явж дассан үед зураг авах нь аюулгүй гэдгийг ойлгуулаарай.
- Тэмээ газрын уруу орохдоо шогшдог учраас бурантгаа богиносгон татаж "хаа хаа" гэж аядан аажуухан алхуулж орж болно гэдгийг урьдчилан сануулах
- Тэмээгээ цуваагаар явж байхад аль болох хооллуулахгүй байх. Учир нь хооллуулаад сурчихвал замын хажуугийн өвс, бут зулгаах зэргээр жуулчдад тэмээгээ удирдахад хүндрэл учирдаг.
- Тэмээн аялал нь намдуу, тогтуун аялал бөгөөд тэмээ таныг хүүхэд мэт бүүвэйлэн алхах учир жуулчдадаа унтахгүй байхыг зөвлөх. Тэмээн дээрээс байгалийн сайхныг ажин сэтгэл санаа тайвширдаг учраас аль болох тал газраас эхний өдрийн аяллыг эхлүүлээрэй.







Та бүхэн зогдоо уудам дэмэр нутаг,
мөнх хөх тэнгэрийн таван сая одтой нутагтаа хүлээн аваарай.